



Б. Шүндэрбузар

СУВДАН ДАРУУЛГА

Сувдан даруулга
Зохиолч: Б.Шүүдэрцэцэг

ISBN: 978-99962-4-071-3

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Сувдан даруулга

\Өгүүллэг\

Голдоо эрхийн чинээ хөх сувд суулгаж, тойруулан самрын идээний хэртэйгээс эхлээд шар будаан чинээ дөчин найман ширхэг цагаан сувд шигтгэж, хөвөөгөөр нь монголчууд тэр бүрий хэрэглээд байх нь ховор гоёмсог талст гарган зассан арван найман ширхэг гэрэлт усан биндэрьяа чулуугаар эмжсэн, алтан хүрээтэй нүд булаам гоё сувдан даруулга ланз хээтэй алшаа хивсний захад хөсөр хэвтэнэ. Даруулганаас сөөм хэрийн зайд хөрч амжаагүй булбарай гар эзэнгүй мэт унжина.

-Эзэнтээн Хулан авхай... юу... яагаад... босч ирдэггүй...

-Тэгээд Хулан яасан хэрэг вэ?

-Юу... Авхай таалал болчихсон юм шиг...

-Юу гэнээ! Юу донгосов чи! Ухаан санаа чинь солиороогүй биз?

-Өршөө намайг! Юу... Авхай... амьсгалахгүй байх шиг байна... хэмээн бүрэг номой шивэгчин хүүхний ээрэхэд:

-Замаас зайлаадах чи! гэнгүүт Чоймчиг гүнтэн түүнийг түлхчихээд уяаны шузганы дэргэдээс гэр рүүгээ ухаан малгайгүй гүйлээ. Ямагт хөмсөг зангидан, морь руугаа ихэмсгээр алхах буюу, жороо морь сэлгэн унаж жавхалзтал хагируулж явах, эсвэл гэртээ зочин цуглуулан их найр цэнгэл хийж, ирсэн зочдод охиныхоо ятга шанз наадах, үлгэр түүх хуучлах зэргийг үзүүлэн гайхуулах дуртай омог бардам эзнээ ийн харц барлаг хүн шиг хөлийн хурдаар сандран гүйхийг халцархай зүлгэн дээр сөхрөн унасан шивэгчин хачирхан харсаар арай ядан босч хойноос нь ухасхийлээ.

-Охин минь, эрдэнэ болсон үр минь! Босоод ирээч дээ. Даанч яав даа. Тэнгэр намайг ниргэхгүй яав. Алив маарамба дуудаач малнууд аа!

Амьсгаа ч үгүй, хөдөлгөөн ч үгүй хөшсөн охиныхоо үзэсгэлэнт тэргүүнийг өвдөг дээрээ тавин, сандарч бачуурахдаа яахаа мэдэхээ больсон гүнтэн ийн хашгична.

Хулангоо охиных нь атганд багтамгүй өтгөн алтлаг хүрэн гэзэгний сүлжээ задран эцгийнхээ өвдөг, хивсэн дээгүүр асгарлаа. Ердөө л хэдхэн хормын өмнө хошуу тамгын газар явах аавыгаа үдэн:

-Орой хоёулаа шатар наадна шүү аав аа! Тамган дээр очихоороо Да туслагчтай ваар ёроолдоод удчихав аа хэмээн хөөрхөн инээн суусан арван тавтай алдрай хонгор охин нь хэдийн энэ тоост хорвоогоос халин одсон гэдэгтэй эцэг нь хэрхэвч эвлэрч чадахгүй байлаа.

Тэгэхэд нь тэрбээр охиныхоо духан дээр үнэрлээд гарахдаа “Тэгнэ тэгнэ. Миний хүү тэмээний “шээс” уухгүйгээ л бод” гэсэн сэн.

-Алив, ус, ус авчрах сэхээтэй мал байна уу? хэмээн арга тасарсан эцэг хашгираад салхи савир үзүүлэх санаатай охины ягаан торгон тэрлэгний энгэрийн шүрэн товчнуудыг тас татан ярлаа. Сандарч бачимдсандаа гүнтний гүрээний судас гүрэлзэн гар нь салганан чичирч, яах учраа үл олно. Охины үүрийн туяа шиг ягаан хацар зэвхийрэн, шүдээ тас зуурч, дөрвөн мөч нь сарвайн хөшсөн байх агаад, саяхан инээд хөөр цалгиж байсан уужим саруулхан өргөөнд үхлийн хүйт даах мэт аймшиг шингэж амжжээ.

Эзнийхээ хойноос гэрт чив чимээгүйхэн орж ирсэн аягачин Санжид хүүхэн зэс шанагаар дүүрэн цэв хүйтэн ус цэлэлзүүлэн авчирсан ч:

-Энэ гэрт балга ус хийчих аяга алга уу, мал аа! хэмээн зандчуулаад холдов.

Энэ агшинд гэрийн эсгий үүд сэвхийтэл нээгдэн гүнгийн итгэлт хиа Довчин орж ирэн:

-Авхайд одоо юу ч тус болохоосоо өнгөрчээ эзэн минь. Нэгэнт хэрэг ийм болсон тул хойдын буяныг нь бодох нь дээр болов уу гэж мунхаглана хэмээн нам дуугаар зөрж зүтгэхийн эрхгүй эрсхэн хэлээд баруун хатавчны тушаа хоёр том гараа элгэндээ эвхэн номхон дуулгавартай дүр эсгэн зогслоо. Гүнтэн эргэн тойрондоо юу гээч болж буйг ухаж сэхээрэх тэнхэлгүй болчихсон ч:

-Үр минь дээ. Аавыгаа яажшуухан энэ хорвоогийн тоосыг хөдөлгөнө гэж орхиод яваад өгөв. Ямар гээчийн гай дайрах нь энэв? Хөөе Дунгаржид! Юу харснаа хэлээдэх! гээд охиныхоо гантиг мэт гөлгөр саруулхан магнайг үнэрлэн нүд нь гүн гашуудалд манантан суусаар байлуга.

Эзтэй юм шиг охиныг өргөөндөө үхэтхийн унасан байхыг хамгаас түрүүнд үзсэн, ам хэлийг нь сугалах шахан асууж шалгаахгүй л бол ямагт таг дуугүй газар шагайж явдаг, аймхай, ядруу дорой төрсөн Дунгаржид гэдэг залуухан шивэгчин аргалын дөрөлжний доохно нусаа татаж, сөхрөн сууж байснаа эзнийхээ хашгирах дуунаар цочин гүнтэн рүү гөлөлзөн харснаа хиртэй хуруунууд нь чичирч салганан байж:

-Намайг юу... өргөөнд орж ирэхэд юу... авхай үсэндээ юу...даруулгаа зүүх гэж байснаа гэнэт л тас гэдрэгээ саваад унасан...Тэгээд би юу... авхай өөд гүйгээд очсон чинь гар нь хөшөөд уруул нь татвалзаад байсан юм. Юу... тэгээд л амьсгаа нь тасарсан...хөөрхий доорд бүсгүй эзнийхээ өөдөөс эгцлэн харж ч чадахгүй нарийхан гээгнийхээ үзүүрээр оролдон нусаа татан, ээрч мууран байж энэ хэдэн үгийг арай ядан хэлэв.

“Даруулгаа зүүх гэж байснаа тас гэдрэгээ саваад унасан” гэсэн түүний үг сая л өнөөх гайт даруулганы зүг гэрт байсан хүмүүсийн анхаарлыг татав.

Тийм ээ. Өчигдөрхөн гүнтний Хүрээнээс охиндоо авчирч өгсөн тансаг бэлгийн дээж болсон энэ чамин эд арван тавхан настай, алия хөөрхөн Хулангоо авхайн аминд хүрлээ гэж үү?

“Миний гээг өтгөн болохоор ижийн даруулганууд багадаад зүүж болохгүй юм. Аав аа, та надад Хүрээнээс гоё сувдан даруулга авчирч өгөөрэй. Тэгвэл би шинэ даруулгаа зүүгээд Усан зүйлийн хүрээн дээр очиж Майдар эргэхийг үзнэ” гэж шулганаад байхаар нь Хүрээний зах

дээгүүр явж, харагдсан үзэгдсэн аль дөнгүүр гэмээр даруулгануудыг голж шилж явсаар, урьд хожид үзээгүй том хөх сувд, нүд гялбам гялтганасан жижигхэн олон усан биндэрьяа шигтгэсэн зэргээс гадна, охиных нь бүдүүн гэзэг багтмаар дориун овор ихт эд санагдахаар нь нас гүйцсэн арван атны үнээр авсныг яана.

“Даанч дэндүү ховор чамин эд байсан юм аа. Охиныхоо аминд хүрэх чивэлт эдийг өөрийн гараараа авчирлаа гэж үү? Шүд нь хөхөрч, үе мөч нь хөшсөнийг үзэхэд хордсоноос зайлахгүй. Хэн энэ үнэтэй эдлэлд хор шингээсэн байдаг байна? Үнэтэй цэнэтэй эд зүүх нас нь боллоо гэж мунхагласандаа л газар дээрх ганц амин эрдэнэ болсон охиндоо ийм юм авчирч өгсөн хар толгойгоо шаахаас өөр яалтай билээ?” ёстой л цэврүү шиг ганц охиноо алдсан эцгийн толгойд ийнхүү элдвийн бодол, хар, сэр, харуусал, шаналал зэрэгцэн үймэрнэ.

-Наад ёдрын юмаа галд шатаа!

Үхэл далласан тэр даруулганд хүрэх зүрх зоригтон энэ өргөөний зарц барлагуудын дунд байсангүй. Довчин хиа л хөх хилэн нударгаараа жийрэглэн авч, орон дээр эвхрэн унасан дурдан алчуурт боож өвөртөллөө.

Оройдоо До маарамба залагдан ирж хөл гар нь тас хөшин, эрүү нь зуурсан бүрлээч авхайн цогцсыг үзэж “Гарцаагүй хордсон байна. Ямар ч хүчтэй ерөндөгт үл дийлдэх зургаан давхар найрлагатай хятад хор эд зүйлээс дамжин цусыг нь хордуулсан болов уу.” хэмээгээд ар дагзанд нь үүссэн нүдэнд үл үзэгдэх шархнаас өчүүхэн цус шүүрснийг олж Довчин хиад үзүүлэв. Харин гүнтэнд булбарай охиныхоо цогцсонд хүрэх аюумшиггүй зүрх, гэнэт нөмрөн ирсэн их уй гашуугаа даах хүч чадал үлдсэнгүй ээ. Бичгийн гэртээ орон таг бүгчихээд хэнийг ч үл оруулна. Чоймчиг гүнгийн хот айлынхныг үхлийн аймшиг нөмөрч, зарц, шивэгчингүүд чангахан дуугарахаас ч айх мөртөө, сав л хийвэл ажлаа хийдүүлэн:

“Үнсний хонхрын тэрүүгээр эхнэр үстэй эм хүний сүнс үүрийн цагаан гэгээнээр явж байна гэнэ. Үнэтэй сувдан даруулгандаа хоргодсон шуналт эмийн сүнс юм гэнэ.”

“Худал байлгүй. Хэн тэгнэ?”, “Адуучин Данзангийн авгай шээх гэж яваад харсан гэх чинь билээ.”

“Арай бүрлээч авхай босоо ороолон болчихсон яваа юм биш байгаа?”

“Бүү үзэгд. Тийм бяцхан авхай юу гэж эхнэр үстэй байдгийн? Амаа мэдээрэй. Тэгж байж эзэнд дуулдчихвал Довчин хиад наад арьсаа хууртал ташуурдуулах юм болов оо” гэхчлэн амны зоргоор цуурцгааж байлаа.

Гүнгийн өргөөнд зарц нарыг ахлан, гэрийн бойдаагийн бүх ажлыг нугалдаг няхуур, чамбай, ухаан сийрэг Довчин хиа л тэднийг захиран, хонь малын бэлчээр зааж, охины хойдхыг унших сайн лам нар залж авчран, энэ айлын үхэх, төрөх, өвдөх зэрэгт залагдан ирдэг Лувсанчойжид гавжтанаар бүрлээчийн алтан хайрцгийг нээлгэн, гаргах зүг чиг, цаг нарыг асуух зэргээр уй гашууд унасан эзнээ орлон бүхнийг хөдөлгөж байлаа.

Намрын эхэн сарын налгар сайхан өглөө бүрлээч авхайг баруун урд хөтлийн цаадтай, арваад

жилийн өмнө талийгч эхийг нь тавьсан нарлаг энгэрийн өөдөөс харсан налуу ухаад хөдөөлүүлээд, зарц шивэгчин, хамаатан садны хориод хүнд будаа идүүлэв. Гүнгийн их зургаан ханат өргөөнд гурван өдрийн турш охины хойдын буяны ном гүрэм унших лам нарын гүнгэнээн, хонх дамрын дуу тасарсангүй ээ.

Хөөрхий эрх жаахан авхайг хөдөөлүүлээд буцахдаа энэ хот айлын зарц нар эр, эмгүй л харамслын нулимс унагав. Үе дамжсан хур хөрөнгөтэй, нутаг усандаа нэртэй Чоймчиг гүнтний ганц охин Хулангоо хичнээн энхрий зөөлөн сэтгэлтэй, энэ гэр хот айлыг инээд хөөрөөр бялхааж байсныг санах тусам харамсмаар, басхүү үхэл дандаа хүний сорыг нь авч оддог гэх хууччуулын үгний ортойг илтгэх мэт. Чоймчигийн их хүү Дамдин хэмээх ухаан санаа мөхөс, эргүүдүү эр Хүрээний нэг баян айлд хүргэн орж, хадмын хаяа бараадан амь зуудаг ажгу.

Талийгч авхай өргөөнийхөө аягачин, шивэгчин, саальчин авгай хүүхнүүд, өрлөг эх нь болсон Дулам чавганцад аль өнгөтэй өөдтэйгээ өгөх гэж зүтгэдэг. Манай хотны бүх эмэгтэйчүүд гоё дээл өмсч байвал сайхан гээд жил бүрийн наадам, сар шинэдээр дээлийн чисчүү, даалимба өгдөг, тийм жаахан охины хаанаас гарнав гэмээр ухаантай, өрөвч нинжин байсныг нь дурсан тэртээ налуу ухаад тэр үеийн заншлаар хадгаар нүүрий нь бүтээж ил тавьсан алдрай бяцхан авхайн цогцос өр өмлөмөөр бүртийн хоцорсныг хэдэн өдөртөө л зарц нарын хэн нь ч мартаж чадахгүй байж билээ. Бурхан болсон хүнийг хээр тавиад буцахдаа эргэж харж болдоггүй юм гэсэн балар заншилд баригдсандаа тэдний хэн нь ч хээр торойн хоцорсон хөөрхий охины турьхан цогцос руу харж чадалгүй хурдлан буцаж ирцгээсэн билээ. Ядахад охиныг бие барсан энэ үеэр өрлөг эх нь хамаатныхаа хөгшинтэй золгохоор яваад эзгүй байж таарчээ.

Охиноо зуурдын үхлээр алдсан тэр өдрөөс хойш бичгийн гэрээсээ бараг цухуйгаагүй Чоймчиг гүнгийн зүрхний архаг хууч хөдлөн хэдэн өдөр өвчин, уй гашуу хоёрт баригдан орноосоо боссонгүй.

“Үнсний хонхороор эхнэр үстэй хатан хүний сүнс тэнүүчилж байгаад үүрийн гэгээнээр алга болчихдог болов” хэмээн өргөөний аягачин шивэгчин хүүхнүүд цуурсаар л байлаа.

Харин Довчин хиа авхайг хөдөөлүүлсний маргаашаас эхлэн эзнийхээ зарлигаар үхэл далласан сувдан даруулганы учрыг олохоор ийш тийш нь хүн зарж, сураг ажиг тавьсаар нэлээд хэдэн учиг атгаж авчээ.

Нутгийн Гончиг дарханы ярьснаар усан биндэрьяаг цавуудан алтан утсаар угалз сүлжсэн нарийн хийц нь монгол дархных биш байлаа. Нөгөөтэйгүүр даруулганы голд шигтгэсэн эрхийн чинээ том, ховорхон тохиолдох хөх сувдны голыг урнаар ухаж, өндөгний хальс мэт хөндийлөөд хороор дүүргэж, нүхийг нь алтан өргөсөөр таглан хорыг нь гоожуулах нүдэнд үл үзэгдэх өчүүхэн сүв гаргаж орхисон байсныг хашир дархан олж илрүүлжээ. Зориуд хүнийг хордуулах гэж хийсэн нүгэлт энэ чимгийг хэн нэгэн бүсгүй зүүх гэвэл нэг бол гар хуруугаа санаандгүй тэр өргөст хатгуулах, эс бөгөөс гэггэндээ зүүх гэж байгаад дагзаа хорт зүүнд шивж хорддог ажээ.

Хүрээний ганган Дариймаа, торгоны наймаачин Ляо данжаадын амраг хүүхэн Бадамлянхуа гээд олон эзнээ үхэлд хүргэсэн зартай эд байсныг нь ч хожимдож дууллаа. Хаа байгаа газраа

эзнийхээ аминд хүрдэг энэ даруулгын хамт эхнэр үстэй эмийн сүнс дагалдан явдаг ч гэсэн үс босом сураг ч байх ажээ. Охиноо энэ даруулганаас болж амь тавьсан тэр өдөр “Наад ёдрын юмаа галд шатаа!” хэмээн гүнтний хашгирдаг ч буруу байсангүй. Олон эмэгтэйн аминд хүрсэн энэ чивэлт даруулгыг шуналт хүмүүс гар дамжуулан худалдсаар өнөөдрийг хүрсэн байлаа.

-Ямар үйлийн үрээр заавал би энэ нүгэлт даруулгыг авч таарав аа? Хүрээний тэр олон инжааны газар, алт мөнгөний наймаачдын нүд эрээлжлэм их бараа таваар, үнэт эдлэл байсаар байтал. Би гэж үйлтэй толгой очиж очиж ийм чивэлт эд авчирч эрдэнэ болсон охиндоо өгсөн байгаа юм хэмээн гүн охиныхоо хорин нэг хоногийг хурааж хот айл, нутаг хошууны бүх л хүүхэд багачууд нархамба, нанжин чавга, чихэртэй ааруул, үзэмтэй будаагаар хишиг түгээгээд гэртээ ирсэн оройгоо мөнөөх Довчин хиад гашуудан ярьж суулаа.

Гадаа үхэр тугал мөөрөлдөн, тэргэл саран мишээсэн намрын сайхан үдэш болж байлаа. Гэрийн зүүн талд байх цэцгэн хээтэй торгон аравчтай, алтан зүмбэртэй улаан ор эзнээ үгүйлэх мэт шашир хоргой дэр нь шалчийн хэвтэнэ.

Гүн охиныхоо эзгүй ор руу харж, уйтай гэгч нь гүнзгий санаа алдсанаа:

-Бүрлээч минь гэнэт инээд алдан ороод ирэх ч юм шиг. Аав аа, хоёулаа шатар наадъя гэж цангинатал хэлэх шиг санагдах юм. Ганц сэтгэл тайвшруулах юм гэвэл тэр минь бэтгэртлээ санасан эхтэйгээ тэнгэрийн оронд учран элгээ дэвтээж суугаа болов уу гэж санах юм даа гэж хиадаа яриад ваартай хятад архианаас хуруувчин хундганд хийн хөнтөрлөө.

Довчин хиа ширвээ хар сахлаа шувтран бодлогошрон сууснаа эзэн рүүгээ хянамгай харц чулуудан:

-Нөгөө даруулганаас хортой сувдыг нь Гончиг дарханаар сугалуулаад Усан зүйлийн хүрээний цогчин дуган бариулах хандивт өргөчихлөө. Тэр даруулгыг өргөлд барьснаас хойш өргөөний эмс элдэв цуу ярих нь ч татарлаа. Харин сониноос хөх сувдтай үхэл дагуулсан даруулганы сургаар зүүн хошууны Мижид хөгшин таныг ирээч гэж хэл өгүүлжээ. Өөрөө нарийнтаад хэвтэрт өдөр хоногоо хүлээж байгаа тул яаравчлаарай гэж хэлүүлсэн байна, эзэнтээн. Мижид гуай таны бүрлээч ээжийн итгэлт хиа явсан юм гэнэ лээ. Би явах уу, та очих уу, яахав? гэлээ.

Хар архи балган хүрлийж суусан гүнтэн энэ үгийг дуулаад хөмсгөө тэнийлгэн харцанд нь итгэл найдварын оч гийгээд ирэв.

-Юун сайн хэрэг вэ. Нээрээ тэр хөгшин чинь ижийн минь үнэнч албат байсан юм гэсэн шүү. Би өөрөө явна гэснээ:

-Тэр чивэлт эдийг чухам хэн ямар учраас хаана хэрхэн хийлгэснийг олж мэдэхээс наана сэтгэл санаа амрахгүй нь. Бөрт сайварыг бэлчээрээс авчруулж чөдөрлөөд хоноорой гээд бүсээ ч тайлсангүй бүхлээрээ хэвтээд өгөв.

Маргааш нь нар битүү байхад харваас нойр дутуу улаан нүдэлсэн ч ядарсан шинжгүй

харагдах Чоймчиг гүн хурднаараа хошуундаа зартай бөрт сайвар морио унаж, Бадрах нэртэй залуу хиагаа бараа болгон дагуулаад Мижид хөгшинтэй уулзахаар мордлоо.

Зам зуур Чоймчиг гүн “Манай удмын бүсгүйчүүд ижийгээс хойш наслахаа болилоо. Энэ юуных юм бол? Ижийгээсээ би дөнгөж таван настайдаа өнчирсэн. Хөөрхий ижийгээ бүүр түүрхэн л санадаг. Аавын бага хатан гэж байснаа ижийгийн өмнөхөн бас гэнэт өнгөрчихсэн. Хүүгийн эх, анхны хатан минь ч гуч хүрэлгүй нас барсан. Дараа нь авсан бага хатан минь ч надад нар шиг ганц охин үлдээгээд яваад өгсөн. Одоо би сэтгэлийн минь нар сар болсон охиноо бас хар нялхаар нь алдчихлаа. Удам дамжсан хараал ширээл хүрээгүй байгаа даа. Уг нь манайхан доорд зарц нартаа хатуурхалгүй, дээдэст нүүр тал алдалгүй, хүнд мууг хийлгүй, нэр төрөө хичээж явдаг, нутагтаа нэр хүндтэй улс юм сан. Ижийн хиа байсан энэ өвгөн харин надад юу хэлэх гээ юм бол? Өдий олон жил таг дуугүй явж, явж гэнэт ийм явдал болсон хойно дуудуулсаныг бодоход учир жанцан ихтэй л юм ярих нь дээ” гэхчлэн алдсан хүний арван тамыг эдлэн олон хоногийн уй гашуу, нойр дутуу шөнүүдэд ядарсан бие моринд агсагадахыг юман чинээнд бодохгүй царай хүрлийлгэн бодлогоширсоор явлаа.

Гүнтэнг бүтэн өдөрчийн газар зогсолтгүй довтолгосоор Мижид хөгшнийд очиход нар хойд уулын цаагуур тонгойж байлуга.

Мал цөөтэй хоёр гэр нэг их том том хөх чулуудтай сайрын цаахна намаржиж байв. Хөтөлгөө морьтой, хиа дагуулсан луун хээт магнаг дээл, хөх үйтэнхуар хантааз, отго жинс болсон ихэсийг үзээд хоёр гэрийнхэн сандран бужигналдав.

Гүнтнийг гадаа эгнэн зогссон хүүхэд, хүүхэн голдуу хэдэн хүнтэй мэнд мэдээд баруун гэрт орвол баруун орон дээр нь нэгэн хөгшин халуун намраар баахан дээл хувцасны навтсаар хучаастай хэвгэж байгаа үзэгдэнэ. Энэ айлын эзэгтэй дунд хэр насны туранхай эхнэр аргал зэрэглэн гал түлж сайхан хийцтэй шаргал цай чанан, дугуй ааруул, шинэ өрөмтэй идээ тавин хөл болох зуур царай доош орж нүд ширгэсэн боловч шингэн буурал үсээ цэмцийтэл эмхлэн сүлжсэн настай өвгөн нүдээ алгуур нээж:

-Чой гүн ирэв үү? хэмээн тодхон дуугаар асуух нь тэр.

-Тийм ээ. Би ирээд байна. Та амархан сайн байна уу? гэж гүнг мэнд мэдэхэд :

Өвчтэй байгаа настан нүдээ алгуурхан нээгээд эцсийн хүчээ шавхах мэт сулхан дуугаар:

-Мэнд ээ. Та амгалан морилж явна уу? гэснээ амьсгаагаа дарж, цээж түхэлзүүлснээ:

-Би таны талийгч эхийн шадар хиа байсан хүн. Таны эх Гонгоржав гүнгийн их ахайтан алаг нүдэн Сугар гэж хавь ойрдоо шагшигдсан сайхан зүстэй хүн байсан, хөөрхий. Гэхдээ хөх хулгана жилд Го гүнг Алтанбулаг яваад ирэхдээ орос, буриад цус холиолдсон арван зургаан настай Балжид бүсгүйг авчран бага хатан болгоход нөхрөө харамлаж, хар, хор, атаа жөтөөнд авсандаа нэг том нүгэл хийчихсэн юм. Ахайтны гарын хиа байсны хувьд мөхөс би ч тэр амьдын хар нүгэлд нь гар дүрж насны цөвтэй болсон хүн... гээд хүндээр амьсгаадан хоолой нь цахиртаад чимээгүй болчихлоо.

-Аав маань нарийнтаад их удаж байна. Өдөртөө жижиг тагш хярамнаас өөр юу ч хоолой давуулж чаддаггүй. Дэмий л амыг нь чийглэж суух юм даа хэмээн гэрийн эзэгтэй гүнд хэлээд эцгээ өндийлгөж аманд нь цийдэм дусаан хоолойг нь чийглэлээ.

Хөгшин амьсгаадан хоолой нь хэржигнээд тэр хэдхэн дусал цийдмийг тамшаалан хатсан уруулаа шилэмдэн хэдэн хормыг өнгөрөөхдөө аниастай нүднийх нь үрчлээт зовхи чичигнэн энгэр дээрээ зөрүүлсэн барьсан хоёр туранхай гарынх нь хуруунууд л сарвалзах нь сэтгэл дотроо яриагаа үргэлжлүүлэх мэт. Тэгж тэгж нүдээ нээгээд гүнгийн зүг толгойгоо үл ялиг эргүүлж өвчинд шаналсан хөгшний хаанаас нь гарав гэмээр тодхон дуугаар яриагаа яг зогссон тэр хэсгээсээ чинагш үргэлжлүүлрүүн:

-Балжид хатан маргад гэмээр нов ногоон нүдтэй, их хамартай оросжуу төрхтэй мөрт хэрээний даль шиг гялалзсан сайхан өтгөн хар үстэй, хараад хараад нүд салгамгүй хөөрхөн бүсгүй байсан юм сан. Гүнтэн тэр үед Хүрээнд Богдын шанзавын яамнаа ахлах түшмэлийн алба барьж танайх тэнд суурин байсан. Бага хатан ирсний дараахь хэдэн сар Го гүн их хатныхаа өргөө рүү шагайхаа ч больсон нь Сугар ахайтныг их гомдоосон юм.Тэгээд л нэг өдөр намайг ахайтан... гэснээ үгээ тасалж, амьсгаадан дуугүй болоход “Хэзээ л тэр ёрын сувдан даруулганы учир тайлагдах юм бол” хэмээн тэсгэл алдан суусан Чоймчиг гүн завилан суусаар хоёр хөл нь айхтар их оршсоныг сая мэдэж:

-Хөгшин их л тамирдуу байна даа. Энэ явдлыг надад хүүрнэх гэж сүүлчийн хүч тамираа барчих вий дээ хэмээн охинд нь хэлээд босч хөлөө тэнийлгэн, гадаа гарч гаансаа нэрэв.

Түүнийг галзуу улаанаасаа ганц хоёрхон сорох зуур алсын уулсыг ширтэн “Манан хөшиглөөд хэд хоногоос цас хялмаалах нь дээ. Урьд намар болж манан буухыг ойшоодоггүй сэн. Ингээд бодоод байхнаа буцах цаг гэдэг хүмүүний хувьд өтөл настай л адил юм.. “ гэхчлэн гунигт бодолд дарагдан зогстол гэрийн эзэгтэй үүдээрээ цухуйн “Аав маань таныг дуудуулж байна” хэмээлээ.

Гүнг буцан орж ирэхэд хөгшний тамир нэлээд сэргэчихсэн тооно өөдөө харан хэвтэж байснаа олон таван үг нуршилгүй шууд яриагаа үргэлжлүүллээ.

-Ахайтан намайг дуудаад өөрийнхөө инжинд ирсэн нарийн эдлэлээ хадгалдаг танаар чимсэн хүрэн зандан хайрцгаа уудлан арван цэнгийн алтан ембүү гаргаж “За Мижээ чамайг нэг нууцгай зараалд явуулах боллоо.Чи энэ алтыг авч яваад Хүрээний хятад пүүсүүдээр орж хүнийг газар дээр нь нам үхүүлдэг хүчит хор олж ир.Тэгээд зогсохгүй. Сайн инжаан олж энэ сувдыг ухуулж хороор дүүргэн, эм хүний нүд булаах гоё сувдан даруулга хийлгээдэх. За, харин энэ тухай чи сүүдэртээ ч ам алдах ёсгүй шүү. Хэрэв чи амнаасаа ганц үг унагасан байх юм бол утсан чинээ улаан голоо таслуулна гэж мэдээрэй гэлээ.

Би ч мунхаг ухаандаа ахайтны сэдсэн хэргийн учиг шалтгааныг шууд л ойлгож, гэмгүй хүний алтан амийг бүрэлгэх хэрэгт оролцох болсондоо хиртхийн цочсон юм. Ахайтан айхтар хурц нүдтэй хүн байсан юм. Тэгэхэд харц нь бүүр тонгорог шиг хурц болоод “Энэ эмээс болж би сэтгэл тайван амьдрахаас өнгөрлөө. Эр нөхөртөө нүд үзүүрлэгдэн ингэж хар залуугаараа өнчин дэр сахиж сууж би тэвчишгүй нь. Хожим надад ирэх үйлийн үрээс ч айх юм алга. Чи ч

эмээж зүршээх хэрэггүй. Чиний улаан гараар амийг нь таслуулах гэж байгаа биш. Үйлийн үрээ би л эдлэх биз. Төрхөмөөсөө дагуулан ирж өдий олон жил чамайг тэжээхдээ би мөр нүцгэн, гэдэс өлөн явуулаагүй шүү. За, одоо бушуулж үз. Мөрөө сайн баллахаа мартав” гэж захисан.

Надад эзэн ахайтны өөдөөс үгүй гэх толгой байгаагүй. Наймаа хотын эм тан худалддаг нэг пүүснээс найман давхар найрлагатай, ямар ч ерөндөгт үл хүчрэгдэх айхтар хор олж, нөгөө хөх сувдыг нь бас нэг сайн чулуучин хятадаар хөндийлүүлж хорыг нь хийгээд сувдан даруулга урлах инжаан руу очих хүртэл ердөө гурав хоног л гүйсэн юм даг. Хүрээнд зартай инжаанууд бол тийм ажлыг хийхдээ дургүйцэх эс бол нууц амархан задарч болзошгүй байсан болохоор би Хаалган хот орж байж тэр даруулгыг хийлгэсэн. Гучаад насны уриалгахан инжаан эхлээд хүн хордуулах хорлонт эд хийлгэх гэж байгааг мэдэлгүй хачин сайхан загнаж, шар будаан чинээ тунгалаг усан биндэрьяа шигтгээнүүд гаргаж, цагаан сувднуудын захаар ийм цэнхэр чулуугаар хөвөө хийвэл хөх сувдтайгаа өнгө хоршиж, их гоё болно гээд л үзүүлээд л байж билээ...

Хөгшин энэ хүртэл овоо ярьж байснаа үгээ таслан хүндээр санаа алдав.

-Намайг хөх сувдны нүхийг тагласан алтан зүүг үзүүлмэгц л тэр инжааны царай хувьс хийгээд явчихсан. Хятад хүн мөнгөнд дуртай ч нүглээс айдаг журамтай улс. Тэгээд яахав. Мөнгө цагаан, нүд улаан юм хойно. Таван цэн алт амлаж байгаад хийлгэж дөнгөсөн юм даа. Голдоо хөх сувдтай, дөчин найман цагаан сувд битүү суулгаж, хөвөөгөөр нь арван найман усан биндэрьяа шигтгэсэн, утсан сүлжмэл алтан хүрээтэй тэр даруулга Халх, дөрвөн аймаг, шавь найман хошуунд үзэгдээгүй ганган чамин эд болж билээ. Аймшигтай нь тэр гоё эдийг зүүх гэсэн хүн заавал хөх сувдны ард гаргасан хортой зүүнд гар буюу, хуйхаа шивж нам үхэх ёстой байсан.

Хятад инжаан гуравхан хоногт даруулгыг бэлэн болгоод хэдэн давхар тааранд боож өгөхдөө царай нь зөвхий даасан байж билээ. Тэгээд “Хүний амь хөнөөх их муу, их муу” гэж өвөрлөгч хэлмэрчээр дамжуулан надад байн байн хэлж, толгой сэгсэрч байсан юм.

Би яахав дээ. Ахайтныхаа даалгаврыг гүйцэлдүүлж, нөгөө юмыг авчирч өглөө. “Тэр нүгэлтэй эдээ яаж бага хатанд өгөх гэж байгаа юм бол? Надаас л холуур тэр нь өнгөрөөсэй” гэж би залбирч байлаа. Тэгтэл гүнгийн сайн түнш Ховдын Дао данжаадаас бага хатан авсны бэлэг хүргүүлж ирлээ. Тэр бэлэг нь нэлээд олон хуй торго, цэцэгт цай, чихэр жимс л байсан байх. Сугар ахайтан ухаан сийрэг хүн байсан юм. Тэр бэлэг дунд л өнөөхөө хийгээд хөөрхий бага хатанд өгчилгөсөн юм шиг байдаг. Мунхаг би нарийн учрыг нь мэдээгүй. Намрын манантай өдөр байсан юм. “Балжид хатан осолдлоо” гээд л өргөөгөөр нэг бужигнаан болоод явчихсан.” Манай ахайтан ч сандарч мэгдсэн амьтны дүйвээнээр өнөө сувдан даруулгаа бага хатны өргөөнөөс олж аваад далд хийчихсэн байсан. Муу үйл модон улаатай гэж үнэн шүү. Бага хатан нас барснаас хойш гуравхан сарын дараа сар шинийн өмнөхөн нэг л өглөө Сугар ахайтан гэнэт дайрлагад дайруулаад өнгөрчихсөн. Тэгэхэд та дөнгөж таван настай байсан. Ахайтнаас хойш миний бие ч өөдлөөгүй, дотрын өвчтэй болж нутгаа бараадсан.

Гүнтэн ч ойр ойрхон их бага хоёр хатнаа алдан уй гашууд баригдсан даа, хөөрхий. Тэгээд удаа ч үгүй албанаасаа чөлөө мэдүүлж танайх Хүрээнээс нүүсэн юм даа. Ахайтнаас хойш

хагдынхаа эдэлж хэрэглэж байсан үнэтэй эдлэлүүдийг эзэнтэн худалдахыг нь худалдаж, зарим нэгийг нь хамаатан садан, аягачин шивэгчинд хишиг болгон түгээсэн юм даг. Аз болоход хишигт түгээсэн эд дотор нь нөгөө аюулт хөх сувдтай даруулга байгаагүй. Тийм нүгэлтэй үйлийг гардан хийсэндээ ямагт гэмшин, тэр эд нь хэний охиныг хордуулж байгаа бол гэхээс сэтгэл зовсоор би ч өөд нар үзсэнгүй. Нарийнтах гэж үйлийн үртэй өвчин тусаад удаж байна. Гэтэл ойрмогхон таны охин сувдан даруулганаас болж... тэнгэрт хальсныг дууллаа.”... Ахайтны алтан савыг нээлгэхээр Хүрээний цуутай Балдан гавьжид би бараалхсан юм. “Энэ хүний нүглийн сав нь нэгэнт дүүрчээ. Хийсэн нүглээ нэгэн биеэр үүрч дуусахгүй, хэдэн үеийнх нь бүсгүйчүүдэд хараал дамжин зовлонд унагах юм байна” гэсэн дээ. Энэ хараалыг цайлгахын тулд үр хойч нь сүм суварга бүтээх үйлсэд хөрөнгө харамгүй хандивлаж, өнчин өрөөсөн охин үр өргөн авч өсгөх, жил бүр зуун нохой хооллож, зуун охин хүүхэд баярлуулж явах ёстой юм гэнэ лээ” гээд урт амьсгаа авснаа ”Тэр чивэлт сувдан даруулгыг л үгүй хийгээрэй дээ,та...” гэж хэлмэгц, нүд нь нэг цэлмэснээ элгэн дээрээ зөрүүлсэн хоёр эцэнхий гар нь сулран доошоо унжчихлаа.

Хөөрхий хөгшин цээжиндээ олон жилийн турш тээж явсан хортой сувдан даруулганы нууцыг эзэн ахайтныхаа хүүд ийнхүү хүүрнээд, сэтгэл нь амарч, буцаж үл ирэх аяндаа мордон одсон нь тэр байлуга.

2009 он

Хойд эцэг

Түүнийг сумын төвийнхөн том жижиггүй л Бүрхэг гэгцгээнэ. Эцэг эхээс Аранжин гэж сайхан нэр авсан, өндөр нуруу, өтгөн хөмсөг, алаг нүдтэй, хараа булаам эр атал ийм этгээд гажууд хочоор дуудуудагтаа мань эр огт үл эмзэглэнэ.

Зүс тэгш сайхан төрсөн зарим хүнд заяадаг атаа жөтөөг үл мэдэх бодь цайлган сэтгэл, хэнэггүй зангаасаа болоод Бүрхэг нэр зүүчихсэн энэ эр цэргээс халагдаж ирээд л сумын клубт кино механикчаар орж, хааяа цахилгаан моторчинтой ээлжилж ажиллана.

Эцэг эх нь хүүгээ цэргээс ирэхэд нь шинэ гэр төхөөрч өгөөд утаа гаргаж, өрх татах бэрээ үзэж амжилгүй цувран бурханы оронд одов. Бүрхэг цоо шинэ таван ханатаа айлын амбаарт хураачихаад хөгшдийн хуучин голомтыг сахин ганцаар хоцорсон юм.

Ах эгч хоёр нь түүнийг шилбүүр унан давхиж асан нусгай багад нь хотод суурьшсан улс. Нутгийн зарим хөгшид түүнтэй тааралдахаараа:

-Хүү хэзээ бэр буулгах гэж байна? гэж асуухад өтгөн хөмсөгөө өргөн духаа үрчийлгээд:

-Тэр их бүрхэг хэрэг ээ гэнэ.

Ер нь хүн өөрийнх нь ахуй амьдралын тухай асуухад хар багын л заавал “бүрхэг” гэсэн үг оруулсан иймэрхүү доогтой ч юм шиг, хэнэггүй ч юм шиг хариу хэлдгээсээ болоод “Бүрхэг” хоч авсан эр.

Сайхан чацархаг бие, ханхар цээж, хөө түрхсэн мэт хилэн хар хөмсөг, монгол хүнд ховорхон заяадаг өндөр хамар, хүүхэн хүнд л байвал зохимоор урт сормуустай алаг нүд гээд царайлаг тэгш төрсөн атал түүнээ юман чинээнд үл бодно.

Анх цэргээс ирсэн зунаа аавынхаа бэлдэж тавьсан согоон халиун моринд сайхан мөнгөн хэрэглэлтэй эмээл тохоод шинэ дээл өмсч, саарал бүрх духдуулчихсан, цахиур цагаан шүд яралзуулан айл хэсч явахад нь сумын даргын гадаадад сурдаг охиноос эхлээд хадамд гарсан бэрүүд, сургуулийн сөөсгөр охид хүртэл нүд унагаж, гэрийнх нь гаднаас давхин одоход нь хойноос нь харуулдсаар хоцордог, ёстой л хүүхнүүдийн дурлалын ганц тэнгэр байж.

Ямар азтай хүүхэн Бүрхэг Аранжинтай сууж цайг нь чанах бол? хэмээн ойр хавийн хэдэн сумынхан таамаглан ярилцсаар гурван зуны цэцэг гандав. Таг чиг л байлаа. Ядахад өнөө сайхан эр нь нутгийнхаа аль нэр муутай, царай зүс дорой хүүхнүүдийг олж хоног төөрүүлэх буюу, нүүж суухад нь дэм болж яваа сураг чих дэлсэнэ.

Тэгсээр эцэг эхийгээ нүд аньсны хойтон жил өнөө Бүрхэг маань зэргэлдээ сумын гурван хүүхэд дагуулсан, тэгээд нөхөртэй, өөрөөс нь эгчмэд нус Цэрмаа хэмээх хүүхэнтэй нөхцөж гэнэ хэмээн шуугиулж гарлаа.

“Арай үгүй байлгүй. Тийм сайхан эр байж. Сумын даргын охин ганган Туулыг тоогоогүй мөртөө очиж очиж нус Цэрмаатай...” гэж хүүхнүүд намжир хаяцгаасан ч олны үг ортой

байлгүй яахав.

Бүрхэгийг хажуу сумын нэг айлаар буугаад мордоход нь Цэрмаа бага охиноо аймгийн эмнэлэгт үзүүлээд ирье гээд мотоциклд нь сундлан гарчээ.

Хүний хүүхэд эмнэлэгт үзүүлэх гэж ажлаасаа чөлөө авалгүй хэдэн хоногоор аймаг явлаа хэмээн сарын цалингаараа донгодуулсан Бүрхэг хэд хоногийн дараа Цэрмааг гурван хүүхэдтэй нь гэртээ аваад ирэв. Цэрмаа амбаарт хураалттай байсан шинэ гэрийг нь гаргуулж бариад эзэгтэй нь болчихов.

Нөхөр нь малын хулгай, танхайн хэргээр “хар гэр”-т морилсноос хойш жилийн жилд л оргосон, хүн хутгалсан хэмээн ял нэмүүлсээр бараг л нарсны хүн болсон солгой Галсан гэж зартай эр.Цэрмаа гэж буруу дуулаагүй бол цаашаа гэдэггүйгээрэ цуутай, ажилгүй, анхиа муугаараа нэртэй хүүхэн. Нөхрийнхөө эзгүйд хүнээс хүүхэд хормойлон охин төрүүлснээс болж хадмынхаа хаяанаас хөөгдсөн гэлцэнэ. Цаад Солгой нь гарч ирээд бутач юм гаргалаа гэж Цэрмаагийн тархийг хага цохих вий яана даа хэмээн нутгийнхан нь халаглаж байтал Бүрхэг аваад суучихсанд хичнээн хүүхэн атаархахдаа дэрээ норгож хоносныг бүү мэд.

Сумын халуун усанд ороод хир тоосоо үргээчихээд инээмсэглэн явахтай нь тааралдахад гуниг тайлагдам сайхан эр ийнхүү олон дагуул хүүхэдтэй, харц булаах юм юу ч үгүй, ядахнаа бүтэн нэр ч үгүй, тэгээд айлын авгай нус Цэрмаагийн юунд нь болсныг хэн ч таамаглаж үл чадна.

Удаа ч үгүй ардчилал эхэлж, нэгдэл таран сумын клуб ч хаалгаа барив. Гурил будаа, элсэн чихэр картанд орж өлөн зэлмэн өдрүүд ирэв. Бүрхэг машин техникт дүйтэйн хүчинд хот руу шилжсэн моторчны оронд ажиллан, зурагт радио засах зэргээр Цэрмааг хүүхдүүдтэй нь өлсгөлгүй тэжээгээд л байлаа. “Нөгөө Бүрхэг чинь орой ажлаа тарж хариад хоолоо хийчихээд боорцог хайрч хөлсөө урсгаж суухад нус Цэрмаа нь хоймроо унтаж л байдаг гэнэ. Ажлаасаа ирэхэд нь ч ядаж халуун цайгүйг айл хэсч явдаг юм байх аа. Хайран ч сайхан эр...”

“Тэр юу ч биш. Өө муу Бүрхэг гэрт хоолгүй байхад хоосон ирж явна гээд Цэрмаагийн хоёр тархигүй банди өөдөөс нь чулуу нүүлгэдэг гээч. Хүн тэжээвэл толгой цусданаа гэж” хэмээн хүмүүс хэл амаа билүүдэцгээнэ.

Үнэндээ уг муутын удам муу гэгчээр Солгойгийн хоёр хүү ах зах гэж мэдэхгүй дэндүү зүггүй ч Бүрхэг ингэлээ тэглээ гэж уцаарлана гэж үгүй. “Нялх амьтад ухаан сууна биз л” гэнэ.

-Авгай чинь яасан ажилгүй юм.Битгий эхнэрээ толгой дээрээ гарга гэж хүн хэлэхэд “Зовлон үзсэн бүсгүй амьтан яахав.Сэтгэл түвшин, яс амар байг л дээ” гэнэ.

Хүн гэдэг бусдын аз жаргалд санаатай, санамсаргүйгээр дандаа атаархан, хорсож явдаг амьтан. Нэг талаас нь харахад үнэхээр орон гэрээ авч яваа эр хүнд эхнэр нь халамж муутай байгаа харагдавч, нөгөө талаасаа уужим сэтгэлтэй нэгэн эр зовлон үзсэн бүсгүйг би жаргааж байна даа гэсэн бодолдоо сэтгэл тэнүүн амь зууж байгаа нь бусдад юуны хамаа ч байх билээ.

Харин өнөө аймгийн төвийн эмнэлэгт үзүүлэх гэж авч явсан гурван настай бутач охин нь Бүрхэгт сайн гэж хачин.Өөрийн гэсэн үр хүүхэдгүй энэ эрийн элгийг дэвтгээх гэж ирсэн

гэлтэй өхөөрдөм амьтан байлаа. Уушигны багтраа өвчтэй, биеэр давжаа, тэр охиныг Бүрхэг ч төрсөн үр мэт энхрийлж орой ажлаасаа ирэхдээ гар хоосон харина гэж ёсонд хазгай.

Цэрмааг авчирснаас хойш нэг л мэдэхэд хоёр жил урсан одож гурил будаа элбэгшин картаар хүнс авахаа больж амьдрал дээшлэх үеэр хүүхний хар хүн нь хэцүү нэртэй газраас суллагдаж байгаа сураг сонсогдох болов.

Улаан шороогоор шуурсан хаврын нэг хахирган өдөр Бүрхэг аймаг орж, дизель мотортоо сэлбэг хөөцөлдөж яваад иртэл Цэрмаа таван ханат шинэхэн гэрийг нь ачаад хоёр том хүүгээ аваад нөхөр рүүгээ явчихсан байлаа. Тэгэхдээ эмнэлэгт хэвтэж байсан отгон охиноо, бас Бүрхэгийн хэдэн хуучин хувцастай нь хаяад явсан байв.

Аз болоход Бүрхэгт эцгээс нь үлдсэн халтар манан хөөрөг, пийсүү соруул, мөнгөн эмээл садангийнх нь хөгшний авдарт хадгалаастай байж.

“Өнөө Цэрмаа чинь бутач хүүхдээ Бүрхэгт хаяад гэрийг нь ачаад явчихаж гэнэ. Бүрхэг тэгээд авсан эхнэр ч үгүй, барьсан гэр ч үгүй хүний хүүхэдтэй хоцорч. Ингэх л гээд байсын” гэж улс амьтан баярласан ч юм шиг хэл амаа билүүдэцгээхэд мань эр амандаа ус балгаж, чихэндээ хөвөн чихсэн юм шиг таг дуугүй, юу ч дуулж сонссоогүй юм шиг л явна.

Ингэж нутгийн хүүхнүүдийн хараа булаасан сайхан эр гуч хүрэлгүй, хүүхэдтэй, хаягдмал гоонь эр болов.

Цэрмаа хаяад явсан охиноо ганц удаа амар байна уу ч гэж асуулгүй гурван жил өнгөрөв. Жаал охин долоо хүрч сургуульд орлоо. Бүрхэг хэдэн үе дамжсан пийсүү соруултай гаансаа хямдхан заран охинтойгоо хот орж, багтрааг нь эмчлүүлж, нүдийг нь бүлтэртэл гоёчихсон буцаж ирэв. Хотод суудаг ах эгч хоёр нь наад хүүхдээ эхэд нь өгөөд хотод ирж ажилд ор гэхэд нь уурандаа хаалгыг нь тэс саваад охиноо хөтлөн гарсан сураг дуулав.

Тэгээд сумандаа ирмэгц “Миний амьдрал наддаа л зөв. Бээлийн чинээ энэ нялх амьтан хэнд гай болсон нь бүрхэг байна” хэмээн халамцуудаа ганц нэг хүнд яриад л дахиж ам ангайсангүй.

Уулын хэцээр нутагладаг өндөр Гэндэн гэдэг өвгөний охин Дэлгэрмаа тэр намар багшийн их сургууль төгсөн сумандаа тооны багшаар ирж хөдөөгийн буйд суурингийнхан нэг хэсэгтээ л ярих юмтай болжээ. Дэлгэрмаа сумын засаг даргын урилгаар ирж гэнэ. Засаг дарга сургуульдаа гурван жил ажиллуулах гэрээ хийж, эрээн модтой шинэ гэр, сая төгрөг өгсөн гэнэ. Зүс царай, эрдэм боловсрол нэг хүнд ингэж тэгш заяах гэж... гээд л ...

Засаг даргын өгсөн үлгэрийн юм шиг цасан цагаан гэрт аравдугаар ангийн бүстэй дүүтэйгээ хамт суух болсон Дэлгэрмаа хүүхний өөгүй цэвэрхэн царай, дэрвэгэр сормуус, урсгал ус шиг намирсан задгай үс гээгний тухай хүүхэд томгүй шагшин ярьцгааж, тооны хичээл гэхээр толгой нь дүйрээд явчихдаг төрхгүй хөвгүүд ч хөөрхөн багшдаа хоргодон хичээлдээ тэвчээртэйгээ сууцгаах болжээ.

Гэтэл сумын төвийн эхнэртэй, эхнэргүй хэдэн харцуулын нүд булаасан өнөөх гоё бүсгүй мань

Бүрхэгт талтай юм гэх сураг дуулдах болов.

Хэнэггүй нь дэндсэн ч эрхиш эр хүн юм болсон хойно Бүрхэг ч тэр сайхан хүүхнээс юундаа нүүр буруулах билээ.Тэмээн туйлаадас хаялсан намрын сүүл сарын өдрүүдэд хуучин мотоциклдоо нүд гялбам цагаан хувцастай дэгжин шаавай Дэлгэрмааг сундлан давхих болов.

Гэвч хүүхний эцэг өндөр Гэндэн гэж амаргүй яхир өвгөн байлаа. Хэнийх нь мэдэгдэхгүй тэр хүүхдээ эхэд нь өгдөг юм уу, яадаг санжуу.Охиноо урдахь хойдох амьдралтай, дагуул орхигдмол хүүхэдтэй хүнд өгөхгүй гээд суучихав.

Сумын төвийн ганц бааранд нэг шөнө тасартлаа уусан Бүрхэг “Үхтэл үр харам гэдэг.Нялх амьтны нулимсан дээр би жаргаж суух арилсан дотортой хүн биш ээ.Эвлэхгүй амьдралыг яана гэхэв.Өндөр Гэндэнг царай алдах ч эр биш” гэхчлэн бараг л өөртөө агсан тавьснаар нутгийн сайхан хосын хайрын богинохон түүх төгсөв.

“Энүүнийг хотод аваачаад өнөө Шар хад гэдэг эмнэлэгт нь үзүүлбэл толгойноос нь баараа байхгүй нэг согог гарна вий дээ.Тэр сайхан хүүхэнтэй суучихаад эрдэмтэй хүний гарын цайг хүртэж суухгүй” гэж найзууд нь харуусахад Бүрхэг ганц ч үг үл унаган элдэв зурагт, радионы сэг задалсан болж л сууна.

Хойтон жил нь Дэлгэрмаа хэсгийн төлөөлөгчөөр ирсэн залуу дэслэгчтэй суучихсан хойноо ч Бүрхэгтэй тааралдахаараа үе үе шүүрс алдан гунигладаг хэвээрээ л явсан гэдэг.

Сар жил ээлжилсээр Бүрхэг ганц охиндоо амиа тавин бөөцийлсөн гоонь эрийн амьдралдаа заяаны юм шиг л дасал болжээ.

Амьдрал дэгжихийн хэрээр машин тэрэгтэй хүн улам л олширч, Бүрхэг засварын газартай болов.Өдөржин тостой төмөртэй зууралдсаар орой нь гэртээ харьж, тогоо шанага хангинуулан гэрийн ажлаа амжуулна.Охин нь том болсон ч түүнийг гэрийн хар бор ажилд хүргэнэ гэж номгүй.Охин юм дураараа л өсөг. Бие муутай юм.Номоо л үзэг гээд хар бор ажлаа бас л өөрөө хийнэ.

-Хэр тааруу юмтай толгой холбоод бүсгүй хүний халамж үзмээр юм даа гэж сайн санасан ганц нэг хүн хэлэх юм бол царай нь хүрлийн нөгөө өтгөн хөмсгөө зангидан “Тэр ёстой бүрхэг хэрэг ээ. Нарийндаа бол охиноо хойд эхийн царай харуулахгүй санаатай” гээд халгаахгүй. Гэтэл үнэндээ Бүрхэг өөрөө л тэр охины хойд эцэг шүү дээ.

Охин нэг л мэдэхэд аравдугаар анги төгсөн улсын их сургуульд тэнцэж, хот руу мордох боллоо. Сураг дуулахнаа алтны уурхай руу нүүсэн эх нь охиноо ийнхүү сургууль төгсч оюутан боллоо гээд ганц ч удаа эргэж мэндийг нь мэдсэнгүй. Харин хойд эцэг Бүрхэг л хөөрч догдлон “Миний охин улсын их сургуульд тэнцсэн” хэмээн тааралдсан бүхэндээ ярьж, олон үе дамжсан халтар манан хөөргөө арилжин бэл хийгээд сургалтын төлбөрийг нь төлж, хотод охиноо хүргэж өгөөд ганцаар эргэн ирэв.

Ингээд л гоонь эрийн ганцаардмал амьдрал эхэлсэн юм. Охин нь гэж хөдөө сумын бүсгүй гэмээргүй цэврүү шиг цэмцгэр амьтан жилдээ ганц удаа л зуны амралтаараа эцэг рүүгээ

ирнэ.Тэр тоолонд нь Бүрхэг байдгаа тэмтрэн хэтэвчий нь дүүрэн буцаахдаа “Охин хүүхдийг эдээр дутааж болохгүй. Амьтны олз болно.” гэж ярина..

Тэр хүүхэд хэзээ сургууль соёлоо дуусгаж энэ муу эцгээ өргөх юм бол доо гэж байтал Бүрхэг “Охин онц сураад япон явсан” хэмээн амьтанд гайхуулан ярих болов. Мань эрийн хоёр санчигийг жавар долоосон мэт хэдийн цасан хяруу унан бууралтсан байлаа. Нас нь ч тавь гарчээ.

Сэтгэлийн сайхныг нь алттай ч зүйрлүүлэмгүй энэ хүн одоо л ганц охиноороо хөлөө хучуулан жаргана даа гэтэл тэгсэнгүй. “Миний охин над шиг тэнэг хүний хүүхэд гэхэд толгой сайтай гэж дэндүү. Хэнийгээ дууриасан нь ёстой бүрхэг. Японд эрдмийн зэрэг хамгаалаад тэндээ урилгаар ажиллаж байгаа” хэмээн сумын төвийнхөнд сайрхан ярьсаар дахин арваад жилийг өдөр нь төмөр нүдэж, үдэш нь хүйтэн гэртээ бээрэн галаа ноцоосоор өнгөрөөв. “Тэр охин ч одоо энэ Бүрхэгийг харж хандахаасаа өнгөрсөн биз.Зундаа ганц бараагаа харуулах ч үгүй юм.Хүний хүү хүрэн бөөртэй гэж. Өөрийн гэсэн мах цусных нь тасархай байсан бол юу гэж ингэж эцгээ үнсэнд хаясан шалз шиг орхих вэ” хэмээн айл хөршийнхөн нь халаглана.

“Ойрноос бие тааруухан, хоол шингэхээ болиод..Ямар өвчин туссан нь бүрхэг байгаа юм байхаа. Аймаг орж докторт үзүүл гэсэн” хэмээн ярьж явсан Бүрхэг Аранжин ходоодондоо хавдартай болж гэнэ, хөөрхий. Ирэх зуныг үзэхгүй гэж гэнэ хэмээсэн сураг дуулдав.

“Тэгнээ тэр.Насаараа бүсгүй хүний халамж үзэж, халуун цай хоолтой тохитой сайхан амьдарсан ч биш.Хүний хүүхдийн төлөө амиа тавин хоосон нойтон явсаар энэ. Одоо тэр нус Цэрмаагийн охин гадаадад галуу шувууны мах зооглож яваа хүн муу Бүрхэгийг юу гэж асраа аж. Хүний гарт орохоороо яана даа, чааваас” гэлцэн сумын төвийнхөн хэсэг халаг хоохой болж байгаад мартагнав.

Аймаг явахад нь өрх бүтээлэгтэй хоцорсон муу дөрвөн ханат нь эзнээ үгүйлэн гуних мэт бүртийсээр тэдний хашааны хажуугаар өнгөрсөн зарим хүн муу гэрий нь харахаараа “Өнөө Бүрхэг яагаа бол?Нүд аньсан гэж дуулдаагүйг бодоход гайгүй юм болов уу” гэлцэхээс цаашгүй.

Гэтэл дараа жилийнх нь хавар яргуй цэцэглэх цагаар Бүрхэг цоо шинэ “69” машин уначихсан нутагтаа буцаж ирэв.”Үртэй хүн жарганаа гэж үнэн юм. Эмч докторууд намайг ганц сарын настай,уулзаж учрах хүн байдаг бол дуудуул гэж байтал охин ирж Японд аваачаад өнөө хавдрыг маань авахуулчихсан.Одоо бүр зүв зүгээр. Намайг аав эндээ үлд л гэхийн. Базарваань, япон гэдэг тэр газар халуун жигнүүрт суугаа юм шиг усан хар чийгэнд нь дасна гэж бүрхэг юм билээ.Тэгээд нутгаа бараадаад ирлээ дээ. Охин надад япон жийп авч өгнө гэхээр нь дассан сурснаараа “69”-өө л авчихлаа” хэмээн орсон гарсанд ярьж явжээ.

Хүний сэтгэлийн сайхныг тольдох мэлмий бурханд лав байдаг бололтой.

2009 он Наймдугаар сар

Минийх

Өөртөө буй бүхнийг “минийх” гэж бодоход нэг л сайхан. Ер нь хүн гэдэг болж өгвөл харагдсан үзэгдсэн бүхнээ өмчлөх, өөрийнх болгох гээд байдаг хязгааргүй шуналт амьтан ч юм шиг. Бүсгүйчүүдийн хувьд ялангуяа “миний нөхөр” хэмээн түүнийгээ өмчлөх, түүнийхээ тухай бодох, ярихдаа цээж дүүрэн аз жаргалтай байдаг юм шиг санагддаг. Миний л хувьд тийм. Учир нь би ажлын газрынхаа хориод бүсгүйгээс нөхөртэй зургаан азтаны нэг нь.

Ажлаа тараад хүнсний дэлгүүр гүйх, цэцэрлэгээс хүүгээ авах, хими цэвэрлэгээ, цахилгаан эдлэлийн засвараар ороод гарах, гэртээ ирэнгүүт өглөөний цайны дараа тосгуурт овоолон орхисон аяга тавгийг угаах, хэдхэн цагийн дараа унтах цаг болдог ч гэсэн дайны талбар шиг түйвээж орхисон унтлагын өрөөг цэгцлэн, ор дэрээ хураах, оройн хоолоо хийнгээ нөхрийнхөө хөлийн чимээг чагнан хүлээх нь миний хувьд хэмжээлшгүй аз жаргал байлаа.

-Ээж ээ, нулимс нүдний яг хаанаас нь гардаг юм бэ?

-Матар уйлдаг болов уу?

-Аав дандаа яагаад оройтож ирдэг юм бэ? Ажил нь таныхаас их байдаг юм уу?

Намайг хоол хийх зуур таван настай хүү минь ийнхүү элдвийг шалгааж ээжийгээ тойрон эргэлдэнэ.

Ер нь тэр нэгэн пүрэв гаригийн оройг хүртэл би нөхрөө энэ хорвоо дээрх сая сая хүүхний дундаас ганцхан намайг онцлон хайрласан гагцхүү “миний эр хүн” гэж бодож явсан эндүүрлийн зэрэглээн ордон минь шалан дээр хага шидсэн болор хундага мэт сүйрэн унасан юм.

Тэр орой нөхөр маань оройн найман цагт ажлаасаа ирж, ”гэдэс дотор муу байна. Өчигдрийн тарваганы боодогноос л боллоо” гэнгүүт 00 руу гүйн орлоо.

Түүнийгээ ийм эрт гэрийн бараа харсанд хүүгээсээ дутахгүй баярласан би гэдэг хүн гэрийн өмд, шаахайг нь бариад жорлонгоос гарахыг нь хүлээн тэнэг юм шиг зогсч байтал үүдний тавиур дээр орхисон гар утсанд нь мессеж ирж байнаа. Нөхрөө мөрдөж мөшгидөггүй үлгэр жишээч эхнэрийн хувьд би эхлээд түүнийг нь анзаарсангүй ээ. Хажуугаар нь өнгөрч гал тогоондоо орон хоолыг нь халаахаар богино долгионы зууханд хийлээ. Хожим нь эргэцүүлэн бодож байхад идэш нь ихдээд гэдэс нь эвгүйрхсэн хүнд хоол халааж зогсдог нь “Онгорхойн дотор уужим” гэдэг шиг миний дэндүү тэнэгийнх л байж дээ.

Нөхрийн утас дахиад л дуугарав. Бас л мессеж ирж буй бололтой.

Байз, байз. Найзууд нь түүнд барагтай бол мессеж бичдэггүй. Тэгэхээр өдий орой болсон хойно хэнээс ингэж дахин дахин мессеж ирдэг байнаа? гэсэн сэжиг миний айван тайван зүрхийг гэнэт маажиж эхэлсэн нь овоо “эрүүл”-ээр сэтгэж эхэлснийх байжээ.

Мань хүн гэдэс нь мушгихаар сандарсандаа утсаа түгжихээ мартжээ. Уг нь гэртээ орж

ирэнгүүт утсаа салгах буюу түгжиж орхидог хүн л дээ. Би санаандгүй мессежийг нь үзчихлээ.

“Хайр аа, яаралтай хүрээд ирээч! Уулзах хэрэг байна”

“Гэртээ байгаа юм уу? Хурдлаач ээ...”

Би нүдэндээ ч итгэсэнгүй.

8800...гэсэн дугаараас иржээ. Хаа сайгүй ийм хүүхнүүд хүний нөхөрт санаархаж л байдаг. Үгүй ээ, тэгтэл нөхөр маань өөрөө зүгээргүй юм биш биз? Би гар утсыг нь яаран сандран нэгжлээ.

“Үдийн цайгаар нөгөө газраа шүү хайр аа”

“Татвар руу ярьчихсан. Санаа зоволтгүй ээ. Асуудал гарвал надад л хэлчихэж бай л даа хайр аа. Өнөөдөр уулзана шүү”

“Авгайд хуралтай гээд хэлчихсэн. Би танай гадаа очоод сигналдъя. Үнсье”...

Миний нөхрийн тэр хүүхэндээ бичсэн мессежнүүд. Би хаана байгаагаа , юу хийж буйгаа мэдэхээ больтлоо цочирдон, алмайрч гүйцэв. Эцэст нь би “Нөхөр минь нууц амрагтай юм байна” гэсэн бодолтойгоо аргагүйн эрхэнд эвлэрлээ.

Жорлонгийн ус татах чимээнээр би сэхээ орж, утас тэмдэглэдэг оосортой балаар нөгөө хүүхний дугаарыг гарын шуун дээрээ бичиж аваад сэмхэн холдов. Ийм үед нөхрөө яах, юу хэлэх, юу ярихаа ч мэдэхгүй би гэдэг хүн яг л уснаас гаргасан загас шиг байдалд орчихлоо.

Ямар ч байсан нөхрөө ганцхан “минийх” биш юм гэдгийг л би ухаарсан юм. Тэгээд өөр бүсгүйд хайрын үг хэлж, мессеж бичилцэн, надад ажилтай гэхихээд “тэрэнтэйгээ” энд тэнд уулзан, түүнийхээ ажлыг хөөцөлдөж явдаг энэ хүнд өнөөдрийг хүртэл хичнээн их итгэж явснаа бодохоор халаагч зуухнаас гаргаж тавьсан гар шалзрам халуун шилэн тавагтай хуургыг яг нүүр рүү нь шидчихмээр байсан ч мэдээж би тэгж чадсангүй. Үймэрсэн бодол санаагаа эмхлэх, базлан шимшрэх зүрхээ намжаах, гэр орны амар тайвныг хадгалахын тулд юу ч болоогүй юм шиг байх гэж байдгаараа хичээж байлаа.

Миний нөхрийн хувьд? Жорлонгоос гарч ирээд:

-Би хоол идэхгүй ээ. Гэдэс муу байхад... Алив эм өгөөдөх хүчтэйхэн... гэхихээд миний царай хөрзийн, дуугаа хураачихаад, уртдынх шигээ байх гэж авьяас муутайхан жүжиглэж байгааг ердөө ч анзаарсангүй.

Хүүгээ унтуулж, нөхөртөө гэдэсний эм, будааны шүүс өгөөд орондоо орон ортлоо л би ”Тэр нь ямар хүүхэн бол? Юугаараа надаас илүү болоод нөхөртэй минь наалдаж орхио вэ? Ангалзсан аальгүй л юм байгаа биз. Эсвэл толгой муутай, шуналтай тэнэг, арчаагүй, завхай... Яг янхан шиг хувцасладаг, хөнгөмсөг...” гэхчлэн өөрийн эрхгүй зүс үзээгүй тэр хүүхнийг сэтгэлдээ зүхэж, царай төрхийг нь таамаглах гэж ядан өрөвдөлтэй муу зүрх, үнгэгдсэн цаас

шиг болсон хөөрхий сэтгэлээ тарчлаасаар байлаа. Ямар ч гэсэн би нөхрөө нууц амрагтай, надаас өөр хүүхэнтэй зүрх сэтгэлээ хуваалцдаг гэдэгтэй бүрэн эвлэрч чадахгүй л байлаа.

Маргааш өглөө нь толгой даагдахын эрхгүй хүндрэн, зүрх сэтгэл пивоны хуучин лааз шиг утгагүй хов хоосорчихсон сэрсэн ч хүүгээ цэцэрлэгт хүргэх, нөхөртөө өглөөний цайг нь уулгах, цамцыг нь индүүдэх гэж үүлгэртсээр нэг л мэдэхэд ажилдаа ирлээ.

-Чиний царай яасан цонхигор, нүд чинь бүлцгэр байхын? Нойргүй хоноо юу? гэж хамт ажилладаг хүүхнүүд шалгаацгаана.

-Өчигдөр нөгөө залуутайгаа уулзаад аа.

-Хоёулаа ажил тараад хамт явж хумсаа янзлуулах уу? гэж манай өрөөний булангийн ширээнд зэрэгцэн суудаг нөхөргүй хоёр хүүхэн ярилцан жиг жиг инээлдэхийг сонсоод санамсаргүй тийш харвал харин ч над шиг тарчилж зовсон царайгүй, хэн нэгнийг хардаж сэрдэн зүрхээ шархлуулах хэрэг байхгүй, ганцхан өөртөө л санаа тавьж, гоёж гангалах, урдах ажлаасаа өөр бодох санах юмгүй, харин ч ганц бие хүүхнүүд надаас илүү жаргалтай улс юм биш үү? гэсэн шинэ бодол харван орж ирлээ. Ажил тарангуут хүүгээ цэцэрлэгээс авах, хүнсний дэлгүүрээр орж идэх юм цуглуулах, нөхрийнхөө өмдийг хими цэвэрлэгээнээс авах, гуталд нь зан тавиулах зэрэг ажил урьдынх шиг жаргалтай санагдахаа больсныг мэдэрлээ. Өөр бүсгүйтэй амрагласныг нь мэдсээр байж, тэр хүний хоолыг хийж, хүүхдийг асарна гэдэг там биш гэж үү?

Би хэд хоног ийнхүү тарчилсны эцэст ямар ч гэсэн нөхрийг минь надаас хулгайлсан тэр хүүхнийг харахаар шийдлээ.

-Байна уу?

-Байна. Хэн бэ?

-Би нууц амрагийн чинь эхнэр байна. Хүний нөхөр эргүүлэхээ болиорой.

-Юу яриад байгаан?...

Эрхлэнгүй, аалигүй ч гэмээр ялдамхан дуутай тэр хүүхэн анхандаа уриалгахан, доогтой ч юм шиг дуугарснаа энэ үгийг сонсоод хэсэг чимээгүй болсноо “Юу яриад байгаан?...” гэхдээ хоолой нь сааралтсанаа балмагдсан уу, ичсэн үү утсаа тасалчихлаа.

“Үгүй ердөө. Хүний нөхөр эргүүлчихээд утсаа салгаж маяглаж гэнэ” гэсэн бодол харван орж ирэхэд би түүнд мессэж бичихээр шийдлээ.

“Chamtai uulzah heregtei bna. Irisht udiin tsainii tsagaar hureed ir. Bi tsagaan nooluuran daashinztai haalганii baruun tald suuj baih bno.”

Би нөхрөө нууц амрагтайг мэдсэнээс хойш ердөө л гурав хонож байгаа ч зовлон гуниг дүүрсэн хэдэн жилийг элээсэн мэт санагдана.

Уг нь миний нөхөр надад гутал авч өгөөд, гэх буюу өчигдөр халамцуу ирээд намайг эргүүлж байсан аль дээрийн нэг залуутай хардаад гэхчлэн би өөртөө тохиолдсон бүхнээ хуваалцан сэтгэлээ онгойлгодог багын нэг найз бүсгүйтэй л дээ. Тэр маань саяхан хүүхэд төрүүлсэн тул гэртээ суудаг юм. Хажуу ширээнийхээ нөхөртэй хүүхэнтэй ч гайгүй яриа хөөрөөтэй л байдаг. Гэсэн ч “Миний нөхөр нууц амрагтай болчихож” гээд хүмүүст яриад явалтай нь биш. Хамгаас хайрлаж явсан хүндээ хуурагдана гэдэг зүрхэндээ уйлж, цээжиндээ гунигаа нуун, харахад хосоор юм шиг атлаа ганцаардлын манан дунд бэдэрч явахын нэр л юм даа.

Гэтэл намайг ингэж гутааж доромжлон, сэтгэлийн зовлонд унагасан тэр хүүхэн зүв зүгээр инээж хөхрөн, надаас хулгайлсан аз жаргалдаа умбаж явах гэж үү?

Компьютерээ асаан урдынх шигээ бичиг цаас боловсруулангаа интернет рүү орж мэдээ унших буюу ганц нэг танилуудтайгаа чаатлах ч дур хүрсэнгүй. Асаатай компьютерийн дэлгэцэнд улиг домог болсон цагаан цагаан үүлтэй хөх тэнгэрийн зураг л мэлтийнэ.

-Цайндаа гарахгүй юм уу? гэх хажуу ширээний найзынхаа дуугаар үдийн завсарлага хэдийнээ болсныг мэдлээ.

Манай ажлын газраас холгүй орших Irish зоогийн газар таван хором алхаад хүрэхээр ойрхон л доо. Цувны хормой дэрвүүлэх хөгжөөнт салхи хавар болж байгааг надад сануулав.

Улаанбаатарын шороотой хавар. Ажил дээрээ нарны шилээ мартсанаас салхи хуйсганангуут нүд рүү атга хэрийн шороо чихчихлээ.

Нүднээс нулимс асгарна. Зүрх минь ч цусаар уйлж байлаа.

Болзсон газраа нэг л мэдэхэд ирчихсэнээ ухааран “Нөгөө хүүхэн, нэг үгээр хэлбэл тэр” шулам” хаана суугаа бол? гэсэн бодол орж ирэхэд хаалганы ойр орчмын ширээнүүдийг гүйлгэн харж хэсэг зогсоод тэртээ булан руу очиж суулаа.

“Тэр л нөгөө “шулам болов уу?” гэмээр хүүхэн үнэхээр үзэгдсэнгүй.

Гэтэл час улаан заамшин хүрэм, улаан илгэн гуталтай, төдийлөн хөөрхөн гэмээргүй атлаа нүд булаам ганган, богинохон тайрсан алтлаг бор үс, сэртэгэнэсэн том нүдтэй хүүхэн ороод ирлээ. Ганцаараа яваа бол Нөгөөх байж магад гэж би бодонгуут түүнийг хөлөөс толгой хүртэл нь ажиглав. Тэр хүүхэн орж ирэнгүүт хэн нэгнийг эрэн ийш тийш харан хаалганы дэргэд над шиг хэсэг тээнэгэлзэн зогссоноо хажуугаараа яваа үйлчлэгчээс “Цагаан ноолууран даашинзтай эмэгтэй ирээгүй биз?” хэмээн асуудаг байгаа.

Эргэлзээгүй “нөгөөх” байлаа. Амьдралдаа анх удаа харж буй энэ хүүхэн намайг үзээд танихгүй гэдгийг мэдсээр байж би ваартай цэцэгний араар орон тэр хүүхнийг шинжиж гарлаа.

Үйлчлэгч “Мэдэхгүй ээ. Та ганцаараа яваа юм уу?” гээд ширээнд суухыг урьж байна.

“Баярлалаа” гээд гараад явчих болов уу гэтэл тэгсэнгүй. Цонхны хажуугийн ширээнд сууж

байсан хос хоёртой сайн найзууд бололтой холоос мэндлэнгүүтээ тэдний ширээнд очоод суучихлаа. Дуу нь их ялдамхан юм.

Би гарах гэснээ нэрэлхсэндээ герман зайдас захиалан авчруулсан ч хоолондоо бараг л ам хүрсэнгүй. Цагаан ноолууран даашинз гэнэ шүү. Хэзээ надад тийм даашинз байлаа. Гуч хүрэхэд хоёр жил дутуу байгаа атлаа хүү төрүүлснээс хойш гэдсээ татаж чадаагүйгээс харвин унжуулчихаад яаж ноолууран даашинз өмсөх билээ дээ.

Уг нь би энэ үнэтэй зоогийн газарт үдийн цай уух нь бүү хэл ажил дээрээ өдөрт хоёр мянган төгрөгөөс илүү мөнгө хоолонд зардаггүй хүн.

Би хоолоо идэж чадсангүй нөгөө хүүхнийг ажиглан тэнд хэсэг суугаад ажил руугаа гэлдэрлээ.

Аргагүй ганган хүүхэн юм. Надаас нэг их залуу биш гэдэг нь харваас илт. Хувцас хунарыг нь өөлье гэтэл өнгө, зохицол үнэхээр сайтай юм. Аалигүй ангалзсан, ажилгүй, завхай, бас боловсролгүй хүүхэн л биз хэмээн бодож байсан минь ч талаар боллоо. Харваас сэхээтэн маягийн дүр төрхтэй, дөнгүүр ажил хийдэг нь илт хүүхэн харагдсаныг хүлээн зөвшөөрөхгүй байж чадсангүй ээ.

Тэр хүүхний нүд хөмсгөө сайхан цэвэрхэн будсан, үсээ богинохон дэгжин засуулсан, харваас үнэтэй чанартай цүнх барьсан, биеийн галбир тэгш байсан зэргийг нь би эргэн санаж хөл минь өвдгөөрөө сулран “Би түүнд ялагджээ” гэсэн гуравхан үг л толгойд орж ирсээр байлаа. Ардаа бөөгнүүлэн шуусан ч чихний хажуугаар үргэлж л сул асгарч явдаг эмх замбараагүй үсээ тэр хүүхний гоё будаж, богинохон тайрсан дэгжин үстэй нь харьцуулаад ч яах вэ. Харвин гэдсээ нуух гэж ямагт эв хавгүй хэв загваргүй хувцасладгаа зөвшөөрөхгүй гээд ч яах юм.

Одоо би яах вэ? Нөхөртэйгээ бөөн хэрүүл хийх үү? Юу ч болоогүй юм шиг хуурагдаад яваад байх уу? Салах уу? Бүү мэд. Над шиг ийм байдалд орсон эмэгтэй яах ёстойг хэлээд өгдөг бурхан тэнгэр байдаг ч болоосой.

Хэд хоногийг би бас л үлгэн салган өнгөрүүллээ.

Оройдоо олигтой ч хоол хийхээ болив. Ихэвчлэн лаазалсан мах будаатай, эсвэл бантан, гоймонтой шөл гэсхийгээд л оройн хоолыг аргалах болж, нөхөр ердийнхөөрөө оройтож ирээд хоолны савны таг сөхөж үзэн ярвайчихаад яваад өгөх болов. Ажиглаад байхад хааяа жорлондоо орж байгаад нууцаар утсаар ярих, зурагт үзэнгээ хэн нэгэнтэй, хэн нэгэн ч юу байхав, “улаан гуталт” хүүхэнтэйгээ мессэж бичилцэн маасагнаж суух юм. Тэгэхийг нь хармагц, болдог сон бол утсыг нь булааж аваад цонхоор чулуудчихмаар санагдан цээжээ багтартал уур хүрсэн ч тэсээд л байлаа.

Түүний нууц амрагтайг мэдсэнээс хоёр долоо хоногийн дараа нэг би өдөр үсээ шинээр тайруулж, хумсандаа шигтгээ наалгаж, шинэ хослол авч өмсөөд нөхрийнхөө дуртай гахайн шарсан хавиргатай хуурга хийж “Гэртээ эртхэн ирээрэй хайр аа” хэмээн аргадангуй утасдав. Тэгээд түүнийгээ ирэхээр бүхнийг илэн далангүй ярилцахаар шийдлээ.

Хоолоо хийчихээд толинд харлаа. Үсээ шулуун индүүдэн задгай тавьсан чинь их зохиж байх шиг санагдав. Хумсандаа наасан шигтгээ рүүгээ хяламхийн харав. Гялалзаад гоё юм аа. Аль эртний л ингэж өөртөө санаа тавьж байх минь яав аа? Гэтэл нөхөр ирдэггүй ээ. Гар утас руу нь залгахаар авахгүй байлаа. Би түүнийгээ тэвчээртэйгээр хүлээж гарлаа.

Хүүгээ хооллоод унтуулчихлаа. Нөхөр маань байдаггүй ээ. Утас руу нь залгатал тасалчихаж.

Тэгснээ тээр орой арван нэгэн цагийн үед “Найз нь хөдөө явах ажил гарчихлаа. Та хоёр хаалгаа сайн түгжээд унтаарай” гэхчээд утсаа салгачихдаг байгаа.

“Хөдөө явах ажил” гэнэ шүү. Ойлгомжтой. Нөгөө улаан хувцаст “Яаралтай уулзмаар байна” гэж эртүүдийнх шиг дуудсан биз.

Одоо ингээд бодож байхад нөхөр маань ноднингоос эхлээд ингэж гэнэт ”хөдөө явах” болсон юм байна шүү дээ. Гэтэл би гэж тэнэг амьтан. Хүүхдийн цэцэрлэг, хүнсний дэлгүүр, гэр, ажлын хооронд холхисон тэнэг “үнээ” байжээ.

“Өөдгүй амьтан. Завхай хог!” би нэг л мэдэхэд гахайн хавиргатай хуургаа хайруулын тавагтай нь ширээн дээрээс түлхэн унагаж, гарт тааралдсан аяга тавагнуудыг шалаар нэг хага шидэн уйлж гарлаа. Үнэндээ энэ хэдэн хоногийн гомдол цөхрөл цээжнээс дэлбэрэн гарах нь тэр. Мэдээж нөхөр ирсэнгүй. Би нойрны эм давхарлаж уугаад унтсан болов.

Маргааш өглөө нь миний тархиар хатгуулан орноосоо босч чадахгүй байсан тул дүүгээ дуудан хүүгээ цэцэрлэгт хүргүүллээ. Их сургуульд сурдаг эрэгтэй дүү минь хагархай аяга таваг, хоолны шавхруу хөглөрсөн гэр, уйлж сэлхэрсэн зовхийг минь гайхан харсан ч надаас юу ч асуугаагүйд нь би баярласандаа үнсээд авмаар байлаа.

Тэр өдөржингөө би орноосоо ч боссонгүй. Ажил руугаа утасдан “өвчтэй” гэж хэлчихээд дахиад л нүдээ хавдтал уйллаа. Тэгсээр бага зэрэг тайтгарч орой цэцэрлэг тарахын өмнөхөн босч хувцаслан нүдэндээ хар шил зүүгээд хүүгээ авлаа.

Тэгээд гал тогооны өрөөгөө жаахан цэгцэлсэн болж, хүүдээ бантан хийн сууж байтал нөхөр нэг хайрцаг чихэр барьчихсан малилзтал инээсээр ороод ирдэг байгаа.

“Наадхаа тэр улаан гуталтай, улаан хүрэмтэй банзал хүүхэндээ аваачиж өгөхгүй юу!”

Ингээд л хэрүүл эхэллээ. Миний нөхөр барагтай бол хэрүүл өдөөд байдаггүй ч үгийн хариу хоосон буцаадаггүй хэлэмгий эр.

-Юу гээд өвчигнөөд байгаан? Чи наад нүүр царай, гэр орон, хийсэн хоолоо нэг харчих даа гэж байна.

-Тэр шулам руугаа зайл! гээд би хувцас хунарыг нь шүүгээнээс гарган шидэллээ. Хүү айж уйллаа.

-За яахав, зайлаад өгье л дөө гэж нөгөөх чинь тайван гэгч нь хэлдэг байгаа.

Би чихэндээ итгэсэнгүй.

“Чи тэр завхай хүүхэн рүүгээ явахгүй юу!”

-Тэгье л дээ. Чи хүсээд байгаа бол.

Ингэж хэлэнгүүтээ хааяа нэг найзуудтайгаа заал авч гар бөмбөг тоглохдоо биеийн тамирын хувцсаа хийдэг дунд зэргийн хөх цүнхэндээ ойр зуурын цамц энэ тэрээ чихээд гараад явчихдаг байгаа, миний нөхөр. Үгүй ээ, “минийх” байснаа одоо улаан гуталт хүүхнийх болсон нөхөр.

Би түүнийг арай ч “Зайл” гэнгүүт ингээд яваад өгөхийн чинээ санаагүй юм.

Орой ирэх бүрд миний эзгүйд нөхөр маань гэртээ ирж хувцас хунарнаасаа аваад явсан байдаг болов. Тэгэхдээ хааяа хүүгээ цэцэрлэгээс авч тоглоом, жимс авч өгөөд хүргэж өгчихөөд явахаас бус надтай бараг дуугарахаа ч болив.

Би түүнийг цаг минут бүр үгүйлэн зүйрлэшгүй ихээр шаналж байсан ч хүрээд ирэхэд нь хүйтэн царайлан дуугаа хураана. Өөрөө намайг араар тавьчихаад, уучлал гуйхын оронд “За яахав, зайлаад өгье л дөө” гээд яваад өгдөг байна шүү. Арай ч дээ.

-Нөхөр чинь нэг ганган хүүхэнтэй хөтлөлцчихсэн их дэлгүүрийн гэр ахуйн барааны тасагт буйдангийн бүтээлэг үзээд явж байна лээ хэмээн нэг өдөр ажлынхаа хамгийн хэл амтай бүсгүйгээс сонсоод хэлэх үг ч олдсонгүй.

Энэ үгийг сонмогц л “Тэр хүүхэнд би нөхрөө алдчихсан” гэдгээ тов тодхон ухаарсан юм. Тэр өдрийг хүртэл би нөхрөө алдсантайгаа эвлэрч чадахгүй, нэг л өдөр гэртээ буцаад ирнэ хэмээн гэнэхнээр хүлээсээр явснаа мэдэрч, одоо нэгэнт нөхрөө эргүүлэн авах горьдлого тасарсныг ч ойлголоо.

Нөхрөө явснаас хойш би ихийг эргэцүүлэн бодож, нүд минь ч нээгдэх шиг л болсон юм.

Би хүнтэй суухаасаа өмнө уран зурагт дуртай, хүүхэд байхдаа бүүр зураач болохыг мөрөөддөг, хурц тод өнгөөр хувцасладаг байснаа эргэн санав. Одоо би гуч хүрээгүй атал дөчөөд насны эмэгтэй шиг уйтгартай, хэв загваргүй хувцасладаг болсноо анзаарлаа. За тэгээд нөхөртэй болмогц уран зураг сонирхохоо больж, үзэсгэлэнгийн танхимаар шагайдаг ч үгүй болж, бийр будгаа ахынхаа хүүд бэлэглэсэн нь хичнээн том алдаа байгаа вэ? Би гэдэг хүн хүнтэй суумагцаа л сонирхдог ч юмгүй, олигтой хувцасладаг ч үгүй, ердөө л гэрийн ажлаар хөөцөлдсөн “ахуй үйлчилгээний комбинат” болсон байж. Урлагийн менежер мэргэжилтэй мөртөө худалдаа, үйлчилгээний компанид хичнээн жил нэгэн хэвийн ажил хийж, цаг хугацаа өнгөрөх тусам уйтгартай эмэгтэй болон хувирсаар байснаа мэдсэнгүй.

Ингээд юуны түрүүнд ажлаа сольж, нэгэн телевизийн шоу нэвтрүүлгийн продюссер боллоо. Үсээ урт ургуулж, усанд сэлэлтээр хичээллэж эхэллээ. Мэдээж хөгжилтэй залуучууд, уран бүтээлчидтэй ажиллах болсноор хамгийн сүүлийн үеийн моодоор хувцаслах болов.

Хүү бид хоёрт үлдсэн цорын ганц эд хөрөнгө болсон нэг өрөө байраа зарж, ажлынхаа хажууд байрлалтай шинэ байранд орлоо.

Энэ хооронд нөхөртэйгээ утсаар л хааяа хүүгийнхээ тухай ярилцахаас биш нүүр тулан уулзсангүй. Мэдээж амьдралынхаа арав шахам жилийг хамтдаа өнгөрүүлсэн болохоор өнгөрсөн дурсамж бүхэн түүнийг сануулан гунигласаар байсан. “Аятайхан залуутай танилцаач” гэж найз хүүхнүүд хэлэх боловч сэтгэл зүрхэнд нөхрөөс минь өөр эр хүн багтах зай гарахгүй л байлаа.

Бурхан минь, өнгөрсөн есөн жил, бидний хамтын амьдралын тэр жилүүд бид хоёрын л мэдэх элдэв сайхан дурсамжууд, инээд хөөр, баяр, гуниг хосолсон тэр гурван мянган өдрийг ой дурдатгалаасаа хэрхэн арчин хаях юм бэ? Хааяа нэг ганцаардахдаа түүнийгээ санан нулимс дуслуулах ч өдөр хоног урсан өнгөрсөөр л нэг жил болчихсон байлаа.

Хүүгийн минь зургаан насны төрсөн өдөр хаяанд тулаад ирэв.

-Аав, ээжтэйгээ хамт явж пицца идээд, дараа нь удирдлагатай машин авна хэмээн эрх бяцхан зулзага маань зүтгэлээ.

Ингээд хүүгийнхээ орох дуртай пиццаны газар уулзахаар хуучин нөхөртэйгээ тохиролцонгуут би анхны болзоондоо очих гэж байгаа охин шиг л догдолж буйгаа мэдэрлээ.

Цэнхэр цамц, болор ээмэг...биш ээ, алтлаг өнгийн дашинз шармал ээмэг, арай л хөгшин харагдах биз. Нарийхан жийнс, “Zara”-ийн сул цамц, бас л биш. Цав цагаан ноолууран дашинз, сувдан ээмэг. Сул намирсан шулуун үс, дэрвийлгэн будсан сормуус. Би сормуус хийлгэх болоод нэлээд удаж байгаа л даа. Бас өнгөрсөн нэг жилд нэлээд турж илүү махаа гээсэн тул ноолууран дашинз намайг гоолиг, эрхэмсэг харагдуулж байгаад сэтгэл хангалуун толиноос холдсон юм.

Хүү бид хоёр зориуд хожимдож очлоо. Тэр намайг хармагц цочих шиг болохыг би анзаарлаа. Би ч гэсэн түүний ширүүвтэр үс, өтгөн хөмсөг, хүүгээ хараад дүрсгүйтэн зүүн нүдээ ирмэдгийг нь их санажээ.

Бид гурав пицца идээд тоглоомын дэлгүүр хэсч, дараа нь хамтдаа театрт хүүхэлдэйн кино үзээд гарч ирэхэд нэлээд орой болжээ. Хаврын сайхан орой байлаа.

-Аав аа, та битгий яв л даа. Гурвуулаа хамт гэртээ харья гэж хүү хэлэн аавынхаа гарыг тас зуурна.

-Аав нь явахгүй бол болохгүй ээ гэж тэр хэлэнгээ над руу горьдлогын оч хаялсан харц чулуудав.

-Одоо заавал гэртээ хоноод яв! Өнөөөдөр чинь миний төрсөн өдөр. Би аавтайгаа унтана хэмээн хүү хошуугаа унжууллаа.

-Юу ч гэсэн аав нь та хоёрыг хүргэж өгье дөө хэмээн тэр хэлэхдээ дуртай байх шиг

надад санагдав.

Гэтэл утас нь дуугарлаа. Дахиад л нөгөө хүүхэн. Улаан цүнхтэй, улаан хүрэмтэй тэр хүүхэн.

-Хүүтэйгээ жаахан байж байгаад очноо.

-Энэ чинь хүүхэд ш дээ. Би эцэг нь юм байгаа биз дээ!

-Хэзээ очихоо би өөрөө мэдье ээ... тэр хоёр маргалдаж, цаадах нь хурдан ирсэнгүй, энэ тэр гэж байгаа бололтой. Мань хүнийг ингэж хорьж цагдан, зааж зааварлах гээд эхэлбэл улам гөжүүдэлчихдэгийг нь мэддэггүй л юм байх даа, тэр хүүхэн нь...

Түүнийг хоолны ширээнд суулгаад идэх дуртай мөөгтэй салатыг нь таваглаж байхдаа би нөхрөөсөө салаагүй, энэ хүн “минийх” хэвээр байгаа юм шиг санагдаад байлаа.

Нэг л мэдэхэд үдэш болж би хүү, нөхөр хоёртоо ор засч өгөөд орондоо орлоо.

Аавтайгаа сансрын хамгаалагч Вольтрон, “Тоглоомын ертөнц” хүүхэлдэйн төмсөн эр зэргийн тухай хөгжилдөн ярьж байсан хүү минь нэг л мэдэхэд жигдхэнээр шуухитнан амьсгалсаар унтчихсан байв.

Бид хоёр хэн хэн нь унтаж чадахгүй орондоо хөрвөөсөөр намайг дөнгөж зүүрмэглэж эхэлтэл... Уруул дээр минь зөөлхөн үнсэх шиг болоход хүнд, зууранги нойрны захаас би эргэн ирлээ. Тэр хажуугаар минь ороод хэвтчихжээ. Би түүнийхээ үнэрийг шунаглан сорж, цээжинд нь эвхрэн наалдлаа...

Хоёр хоноод тэр бас л хүрээд ирэв. Тэр өдрөөс хойш бид хоёр энд тэнд яг л нууц амрагууд мэт болзон уулзах болж, нөгөө хүүхнийг утасдахад нөхөр минь уцаарлан утсаа салгадаг болов. Би ч дахин дурласан бүсгүй шиг аз жаргал дүүрэн явах болтол нэг өдөр нөгөө хүүхэн над руу утасддаг байгаа.

-Байна уу?

-Байна. Хэн бэ?\Тэр мэдээж өөрийгөө эхнэр нь байна гэж хэлж чадсангүй\

-Та хоёрыг би мэдэж байгаа шүү. Хүний... нөхөр эргүүлэхээ болиорой.

-Чи бид хоёрын байрлал солигдчихжээ. Гэхдээ тэр чинь одоо ч миний нөхөр хэвээрээ байгааг сануулчихъя. Би өөрийнхөө юмыг эргүүлээд авчихсан. Тэр чинь миний нөхөр, минийх!

Тэр оройдоо л би нөхрөө гэртээ эргүүлэн авчирсан юм. Миний юм бол “Минийх” л шүү дээ.

Одоо би тэр улаан гуталтай, улаан хүрэмтэй хүүхэн бидний амьдралд байгаагүй юм шиг л санадаг.

Хамтын амьдралд аль даваа нугачаа тохиолдохыг тэр гэхэв дээ.

Явахын өмнө...

Тэр бөх гэгч нь нойрсч байлаа. Нөхрөөсөө салаад ганцаараа нэг өрөө байр хөлслөн суудаг бүсгүй. Хажуу айлынх нь эхнэр нөхөр хоёр хэрэлдэж, зодолдон бөөн орилоон, чарлаан, бужигнаан пижигнээн болж байхад ч тэр сэрэлгүй нам унтаж л байдаг юм. Гүн шөнөөр хаа нэгтээ нохой хуцалдан, нам гүм гудамжаар оройтсон хүмүүс дүнгэр дангар ярилцах нь нээлттэй салхивчаар тодхон сонсогдох боловч, золбин тэр иймхэн чимээнд үл сэрнэ.

Юу ч зүүдлэхгүй, нялх хүүхэд, эсвэл, дөнгөж төрсөн амьтны зулзага эхийнхээ халуун хэвлийд наалдан нойрсох мэт бөх унтдагт нь эгч нь түүнд их л атаархана. Түүнийг бодвол өнөр өтгөн гэр бүл, нөхрөөсөө тусдаа өөрийн гэсэн машин, сайхан байр, үнэт эдлэлээр хучаастай мэт явдаг эгч нь гагцхүү нойргүйдлээр л шанална.

Гэтэл ийн нам унтаж байтал нь нэг юм түүнийг чангахан нудраад авах шиг болж, гэнэт сэрчихлээ. Нойрноос нь хэн нэгэн татаад сэрээчих шиг болсонд гайхсандаа бүсгүй хэдэн мөч хэвтсэнээ бүрэн сэрлээ. Өрөөнд нь зэргэлдээ сууцны гэрэлтүүлэг ташуу бүүдгэр гэрлийн зурвас үүсгэж, босоо шөнийн чийдэн, зурагтын тавиурыг үл мэдэгхэн гийгүүлнэ. Гадаа салхи ч үгүй, хааяа газарт хөглөрсөн навчис сэржигнэн хийсэхээс өөр чимээ ч үгүй гүн шөнийн нам нүм ноёрхож, гал тогооны өрөөний тосгуурт ус удаан гэгч нь дуслах нь хүртэл сонсогдоно.

Намрын дунд сарын дулаахан шөнө. Байрных нь халаалт эхэлж, өрөөнд дулаан бүгчим байх атал хаа нэгтээгээс хачирхам хүйтэн агаар үлээж, хэн нэгний нүд өөрийг нь ширтээд байх шиг эвгүйцмээр мэдрэхүй бүсгүйг эзэмдлээ.

“Ямар чөтгөр нь хүн сэрээчихэв ээ? Сайхан нам унтаж байхад...” хэмээн тэр ганц бие, хар амиа хичээсэн хүний ёсоор уцаарлан бодонгоо хана руу эргэн хэвтэл:

-Би чөтгөр биш ээ гэсэн шивнээн сонсогдон, өнөөх л хүйтэн агаар нуруу руу нь үлээх шиг санагдаж хамаг бие нь арзасхийлээ.

“Хий юм сонсогдоод байгаам уу? Аль хэзээний л нэг нохой авдаг байж...Эргэж л харахгүй юм шүү” хэмээн бүсгүй бодож биеэ хураан агийлаа.

-Одоо нохой авч амжихгүй ээ...

“Гарцаагүй хий юм сонсогдоод байна. Гэрлээ асаадаг хэрэг...”

Тэр айдас хүйдсээ дарж нөгөө тийш эргэлээ. Ядаж байхад буйдангийн пүршнүүд бие арзаганамаар зэвүүн чахран дуугарах аж. Гэтэл... Сунгаад ор болгочихдог буйдангийнх нь өмнөх сэтгүүлийн ширээний цаана... нэг юм... Юм ч гэж дээ хүн сууж байх шиг зэрвэс үзэгдлээ...

“Еэ бүү үзэгд...” Тэр шүтлэг багатай ч айсандаа нүдээ аниад бурханаас аврал эрэн “Ум ма ни бад ми хум...Пад суухаа...Өөр юу юу гэдэг билээ...” хэмээн уймарсан ухааныхаа мухар бүхнийг нэгжлээ.

-Маань уншаад ч хэрэггүй...

Энэ үг их л тодхон сонсогдсон тул тэр яагаад ч юм айхаа больчихоод нүдээ нээж зүрхлэв. Эхлээд гэрлийн бүрхүүл сүүдэртэх адар руу ширтэн хэвтсэнээ зориг орж сэтгүүлийн ширээний цаадхи "юм" руу харлаа. Хүн сууж байна гэж зэрвэс харсан нь худал байсангүй. Дөрөв, тав орчим насны жаал тэнд зогсч байх нь үдшийн бүдэг гэгээнд бүртийн харагдах нь тэр. Сөөсгөр халимаг, гайхсан мэт том дүрлийсэн нүдтэй, хацар нь цулцгардуу тийм нэг жаал хүү...

-Энэ чинь хэн бэ? айсандаа хоолой нь нэлээд чихрах шиг өөртөө санагдав. Уг нь тэрээр их энхрийхэн, дөнгөж л арван зургаатай охидод байдаг шиг хонгор, тэгсэн атал янагхан дуутай хүүхэн. Утсаар ярьсан эрчүүд бол ялдамхан дуу хоолойд нь татагдан дахин дахин залгах гээд л байдаг юм.

-Айх хэрэггүй ээ. Би таны үхэл байна...

-Үхэл ий? Тэр хирдхийн цочиж зүүд мөн эсэхийг шалгах санаатай хацраа чимхэлж үзлээ.

-Тийм ээ. Таны явах цаг болж байгаа болохоор би ирлээ.

Нээлттэй салхивчаар орж ирэх намрын сэржигнэсэн салхинд тэр жаалын халимагны ганц ч үс үл хөдлөх аж. Бас сүүдэргүй юм гээч. Харин харц нь амьд хүнийх мэт халирамхай ч юм шиг, тэгсэн атал өөдөөс нь зоримгоор ширтэх ч шиг хором бүрд өөрчлөгдөх ажээ.

-Би хий юм үзээд байх шиг байна. Эгч рүү утасддаг юм бил үү? хажууд нь хүн ч юм шиг биш ч юм шиг хэн нэгэн байгаа болохоор ч тэгсэн үү, бодсон юмаа л тэр хэлчихээд утсаа шүүрэн авлаа.

-Утсаар яриад хэрэггүй. Би хий юм биш. Худлаа гэвэл сая уншсан мааний үсгийг чинь энд биччихье гээд жаал хүү шалан дээр хэвтсэн үзгэн балыг нь авч унтахынхаа өмнө үзэж суусан зурагт сэтгүүлийнх нь захаар эрээчиж гарлаа.

-Тэгээд чи яах гэж ирсэн юм?

-Авч явах хүнээ гурав хоногийн өмнө харах ёстой юм. Гэтэл та сэрчихлээ.

-Би үхлийг хар даашинзтай хөгшин эмгэн байдаг байх гэж төсөөлж байсан...

-Эрэгтэй хүний үхэл нь эмэгтэй, харин эмэгтэй хүнийх эрэгтэй байдаг юм.

-Би тэгээд гурав хоногийн дараа үхэх юм уу?

-Тийм ээ. Энэ гарцаагүй зүйл.

Тэгээд л жаалхүү алга болж, өөрөө ч унтчихсан байлаа.

Өглөө нь бүсгүй их л зовуурьтай сэрлээ. Толгой нь хүндрэн сэтгэл нь юунд ч юм зовиноод байлаа.

Цаг харвал найм арав. Ажил нь есөд эхэлдэг. Тэр уг нь тогтмол долоо гучид нойр нь ханасан, сэтгэл өөдрөг сэрж, өглөөний цайгаа тухлан уугаад найм хагаст ажилдаа гардаг сан. Өглөөний цай ч гэж дээ, нэг ширхэг өндөг, аяга хар кофе... Илүүг идэх юм бол таргална гэж нэг аюул бий. Тэднийхэн хэзээний таргалдаг удамтай улс. Гэхдээ өтгөн хар кофегоо тухтайхан сууж уух ч сайхан шүү.

Гар утсаа асаахаар сэтгүүлийн ширээний зүг хэвтээгээрээ гар сунгаснаа гэнэт өчигдрийн барин тавин зүүдийг санан хамаг бие нь арзасхийлээ. Сөөсгөр халимагтай, гайхсан мэт том нүдтэй, цулцгар хацартай жаалхүү харанхуйд өөдөөс нь харан зогсч байсан... “Айх хэрэггүй ээ. Би таны үхэл байна” гэж байсныг бүсгүй гэнэтхэн саналаа.

“Би чинь ганцаардсандаа солиорч байгаа юм байна л даа. Үхэл хэзээ тийм бяцхан жаалхүүгийн дүрээр шөнө дунд ирж байлаа. Мэдрэлийн ядаргаанд орсон юм болов уу? Уг нь барагтай бол хар дарж зүүдэлдэггүй сэн.”

Тэр буйдан доогуур орчихсон гэрийн шаахайныхаа өрөөснийг олж аваад хэвтрээсээ хөнгөхөн гэгч нь өндийлөө.

Толгой нь дүйрэхээ больжээ. Зүүднээсээ айгаад л шал мангар юм...

Урьд шөнийн өнөөх явдал зүүд байгаасай л гэж тэр үнэнээсээ хүсч байлаа. Буйдангийн эсрэг талд намхан зөөлөвтэй сандал дээр хайхрамжгүй хаясан халадаа авах гэж очмогц тэр цочин зостуслаа.

Өчигдөр үзэж байсан эмэгтэйчүүдийн моодны сэтгүүлийн хуудсууд дэлгээстэй хэвтэнэ. Сэтгүүл ч яахав. Сэтгүүл л дээ. Харин тэр сэтгүүлийн дэлгээстэй хуудасны захад төвд үсэгнүүд бичээстэй байв. Нөгөө жаалхүү-Үхэлийн бичсэн маанийн үсэгнүүд... Бурхан минь! Урьд шөнийн явдал зүүд биш байх нь.

-Би гурав хоногийн дараа үхэх хэрэг үү?

-Тийм ээ. Энэ гарцаагүй гэж гэмгүй бяцхан жаалхүүгийн дүртэй тэр Үхэл хэлсэн.

Бүх л бие нь суларч гар нь салганасандаа тэр сэтгүүлээ унагачихав. Сэтгүүл өчигдөр шөнө тэр Үхэлийн зогсч байсан газар сархийн уналаа. Бүсгүй тэнд байгаа зөөлөн сандалд суухаасаа айж арагшаа ухрав.

Энэ гурав хоногт тэр юу хийж амжих бол?

Юу ч амжихгүй. Үгүй ээ, юуг ч амжуулж болох ч юм уу?

Хоолой ам нь хатан, цээж давчдахыг мэдрээд тэр гал тогооны өрөөндөө орж баахан ус залгилангаа ухаан бодлоо эмхлэхийг оролдлоо. Элдвийг бодсоор суутал нь цаг ес өнгөрчихөж. Нэгэнт л би гурав хоноод үхэх юм чинь ажилдаа яараад байх хэрэг байна уу? гэж

бодонгуут юунд ч яарахгүй байх чинь бас жаргал юм гэдгийг ухаарлаа. Кофегоо тухтайхан уугаад гардаг хэрэг. Хөргөгчөө ухан өндөг гаргах гэснээ ингэхэд дуртай юмаа ч идэж чадахгүй, цаг үргэлж хоолны дэг барин өөрийгөө тарчлаах хэрэг байхгүй болсноо саналаа. Цөцгий гаргаж талханд зузаан гэгч нь түрхэн, дээр нь халбага дүүрэн элсэн чихэр цацаад хазахад амьдралын баяр баясгаланг тэр өтгөн цөцгийнөөс л мэдрэх шиг сайхан. Байсан бол гахайн утсан мах, гүзээлзгэнэтэй бялуу том том зүсээд идмээр байлаа. Харамсалтай нь хөргөгчинд нь ийм аюултай хүнс байсангүй.

Ажил дээрээ нэлээд оройтож очоод өдөржин эд хогшлын тооллого хийсээр тарах цаг болчихжээ. Харин үдийн цайнаар хажуугийн зоогийн газар орж, өндөгний салат, гахайн шарсан нуруу, гүзээлзгэнэтэй бялуу авч таргална гэж айлгүй чихэж өгөв. Эсрэг талынх нь ширээнд суусан хос залуу ийм их иддэг бүсгүй үзээгүй болтой түүнийг хачирхан харж байгааг тоосон ч үгүй.

Орой нь хүнсний дэлгүүр орж бүх дуртай амттанаа хоёр тор дүүрэн цуглуулж аваад гэртээ ирж, найзууд руугаа залгах гэснээ больж, баахан мессэж бичээд хамаг юмаа эмхэлж цэгцэлж нэлээд суув. Гарч нэг газар суух юм уу, ядартлаа бүжиглэх гэснээ зүрх сэтгэлийнхээ гүнд нэг л туйлдан ядарч буйгаа мэдрэн больчихлоо.

Гэнэт хуучин нөхөртэйгээ яримаар санагдаж, залгавал гадаад явсан бололтой, мессэж роминг дээрээ тавьчихаж.

“Чи минь сайн явж байна уу? Биеэ бодоорой. Би чамдаа хайртай хэвээрээ шүү. Шинэ амьдралд чинь сайн сайхныг хүсье. Хэрвээ гомдоож байсан бол уучлаарай” Түүндээ урьд нь хэлмээр санагдсаар байсан ч гомдол, цөхрөл, хардалт, сэрдэлт гээд сэтгэл доторхи олон чөтгөртөө дийлдэн хэлж чадаагүй дотно үгсээ мессэжээр явуулаад сэтгэл амрав. Цаадхи нь салснаасаа хойш дуугарахаа болсон хуучин эхнэрээсээ ийм дотно үгтэй мессэж аваад мэл гайхна даа. Гэхдээ тэр хариу бичихгүй. Харин ирээд заавал залгах хүн. Харин түүнийг залгахад нь бүсгүй байхгүй, явчихсан байх болно. Тэгвэл нөхөр нь түүний хойноос харамсан гашуудаж, шарил дээр нь очин уучлал гуйх биз...

Маргааш ажилдаа очин юмаа эмхэлж цэгцэлнэ. Харин нөгөөдөр, хотоос гадагш тавин километр ахьнд нь суугаа аавтайгаа очиж уулзахаар шийдэв. Ээж нь хоёр жилийн өмнө өөд болсон билээ.

Харин шөнө нөгөө Үхэлтэй тааралдахаас айсандаа амьдралдаа анх удаа нойрны эм ууж унтлаа.

Үхэлтэй уулзсанаас хойшхи хоёр дахь өдөр. Тэр өглөө цагтаа сэрж, өчигдрийнх шиг баахан чихэж чихэж, хоёр аяга кофе уугаад гарлаа. Ажил дээрээ очих замдаа хайрцаг This авч өдөржин баагиулав. Оюутан байхдаа тамхинд орчихсон байснаа нөхрийнхөө шаардлагаар гарчихсан юм.

Хэлтсийн дарга нь орж ирээд тооллогын дүнг хэн шивэх вэ? гэхэд нь бүхнээс өрсөн”Би!” гэсээр байгаад баахан ажилтай болчихов. Харин ажлынхан нь түүнийг хачирхан харцгаагаад хоорондоо гайхсан харц солилцохыг тоосон ч үгүй. Өдөржин тооллогын дүн шивж, дараа нь

ширээн дээрх бичиг цаасаа янзалсаар орой болсон хойно шөнийн дэлгүүрээс үнэтэй чихрийн цуглуулга, сагстай жимс, хүргэн ахдаа виски аваад эгчтэйгээ уулзахаар очлоо. Хэд хоногийн өмнө эгчээсээ цөөхөн төгрөг зээлснээ өгмөөр, ганц төрсөн эгчтэйгээ сүүлчийн удаа уулзмаар байлаа.

-Чи чинь яасан хачин царай зүстэй яваа юм бэ? Манай нэг өрөөнд суу гээд байхад ганцаараа хөлсний байр сахиад л гэсээр эгч нь угтав. Эрхбиш хүний төрсөн нь гэсэндээ царай зүсийг нь нарийн аждаг байх нь. Эгчийнх нь дүрсгүй бага хүү өөрөө явдаг машинаараа давхин ирж хөлийг нь дайрчих алдана.

-Би танаас зээлсэн мөнгөө өгөх гэж ирсэн юм аа гэж тэр явахдаа хэлээд найзынхаа төрсөн өдрөөр авсан хорин мянган төгрөгөө өгснөө гэнэт эгчийгээ тэвэрч үнсээд гарав.

-Хэн чамаас нэхсийн? Дараа л болно биз. Харанхуй шөнөөр хорин мянган төгрөг барьж гүйгээд...

Гэвч түүнд дараа долоо хоног гэж байхгүй шүү дээ.

Гэртээ шөнө ирж, бүх гэрлээ асаан ганцаараа сууж зургийн цомгоо үзлээ.

Ээж, аав, ах эгч нартайгаа авахуулсан дөнгөж таван сартай байх үеийнх нь гартаа хуванцар тоглоом барьсан, өвдөг нь цоорхой өмдтэй мөлхөж яваа, дөрөв хүрээд цэцэрлэгт орохдоо авахуулсан үсэндээ том тууз зангидаж амаа өмийлгөсөн, сургуульд орж тэр үеийн цагаан захтай хүрэн даашинз, цагаан хормогч өмсөөд аавтайгаа хөтлөлцөн биеэ барьсан янзтай зогсох, сурагч үеийн найзуудтайгаа, оюутан цаг, хонхны баяр, хуучин нөхөртэйгээ танилцаж байх үеийн, ээжийгээ өнгөрөхийн өмнө амралтанд... тэр олон зураг амьдралынх нь түүх болон үлдэх байх даа.

Гат утсанд нь мессэж ирэв. Таны энэ сарын төлбөр... төгрөг, 10 дугаар сарын 25-ны дотор төлнө үү. Орой ирэхэд нь цахилгааны төлбөрийн нэхэмжлэл хаалган доогуур шургуулсан байсан. Дараагийн долоо хоногт машины зээлээ төлдөг өдөр... Уг нь тэр нөгөө хэлтсийн Зулаагаас нэлээд их авлагатай юм сан. Зээл, өр авлага, төлбөр, тайлан тооцоо, тооллого... тасралтгүй хөврөх энэ ертөнцийн хэрэг явдлаас залхаж байгаагаа сая л мэдэрлээ. Бас хааяа санаандгүй хэн нэгэнтэй хамгаалалтгүй энгэр зөрүүлчихээд жирэмслээгүй байгаа даа? гэх айдас. Жингээ яаж хасах вэ? Хамраа өндөрлүүлэх үү, яахав. Булган дээл зээлээр авах эсэх... ийм дэмий юманд цаг гарздах, тархиа зовоох хэрэг түүнд байхгүйг ухаармагц Үхэл гэдэг чинь харин ч амар амгалан юм гэдгийг ойлгож, эм уулгүйгээр урьдынх шигээ тайван сайхан унтлаа.

Өглөө. Энэ ертөнцөөс явахын өмнөх өглөө... Гадаа гудамжны хөдөлгөөн ихсэн, цонхоор нарны тунгалаг туяа хөгжилтэйгээ ээхийг үзээд тэр гэнэт явмааргүй санагдав. Хаашаа ч явахгүй, энэ ертөнцийг ч орхихгүй, хуучин нөхөр шигээ гэр бүл зохион, эгч шигээ ээж болж үзмээр санагдав. Үгүй ээ. Гэрээсээ гарахгүй суугаад байя. Тэгвэл үхэхгүй ч юм бил үү? Утсаа салгаад зурагтаа асаалаа. Тэр үхмээргүй байв. Гурав хоногийн өмнө үзсэн тэр Үхэлтэй дахин нүүр тулмааргүй байв. Их усны урсгалд хамагдан живж буй хүн гартаа тааралдсан мөчрөөс амь тэмцэн тас зуурдаг шиг Тэр амьдралаас чаргууцалдан энэ Ертөнцөд үлдмээр байв.

Монгол телевизүүдийн өглөөний хөтөлбөр, өдрийн кино, францын загварын долоо хоног, олон ангит солонгос кино, бас өөртөө байсан хуучин киноны бичлэгүүдийг үзэн, Үхлийн тухай бодлыг ор тас умартан, хөргөгчиндөө дүүргэсэн амтат зайрмаг, гахайн утсан мах, гүзээлзгэнэтэй бялууг хагартлаа идэн, хайрцаг тамхи баагиулан суусаар нэг мэдэхэд өдөр өнгөрч таван цаг болж байлаа.

Арай л их идчихлээ. Гэвч дахиад жимс ч болтугай гоочилмоор байлаа. Гадил... Хөргөгчнөөсөө баахан гадил гаргаж идэнгээ сэтгүүл үзэн суусаар цаг гаруй болж, хальсыг нь хаяхаар бослоо. Ашгүй ингээд өнөөдөр өнгөрөх нь. Өнөөдөр л өнгөрчихвөл тэр үхэхгүй гэсэн үг. Ажил руугаа утасддаг байж уу? Дэлгээстэй сонин дээр овоолсон гадилын хальсыг хаяхаар явж байхдаа нэг нарийхан хальс сэтгүүлийн ширээний хажууд унахыг тэр огт анзаарсангүй. Гурав хоногийн өмнө, нөгөө жаалхүүгийн дүртэй Үхэлийн зогсч асан зүймэл шалны үл ялиг халцархайтай хэсэгт тэр хальс унажээ.

Гадаа харуй бүрий болж эхэлжээ. Гар утсаа асаадаг хэрэг. Бүсгүй сэтгүүлийн ширээний дэргэдүүр өнгөрч яваад нөгөө гадилын хальсан дээр санаандгүй хальтирч, тас гэдрэгээ саван унахдаа шилэн ширээнийхээ хурц ирмэгт дагзаа хэгз татахыг л мэдэрч амжлаа. Тийнхүү унангуугаа нүдэнд нь хөх гал манасхийн дагзаар нь тэсэхийн аргагүй янгинаад явчихад ухаан алдахын өмнө мөнөөх сөөсгөр үстэй, цулцгархан хацартай, том дүрлэгэр нүдтэй жаалхүү ирчихсэн өөрийг нь дүрлийтэл харж зогсохыг л харж амжсан юм. Үхэл гэдэг зайлшгүй зүйл ажээ.

2009 он

Сүүлчийн өртөө

-Битгий уйл миний хүү. Хоёулаа хойд төрөлдөө заавал учирнаа.

-Таны үгүйд би энэ хорвоог яаж элээх юм бэ?

-Хүүхнийг нь бушуу салга! гэж ногоон малгайтнуудын дарга нь болтой нөгөө хоёроосоо илүү гял цал оргисон хувцастай, мөрөн дээрээ хоёр “шоргоолжтой” нуруулаг эр тушаагаад хөмсөг зангидахад, хоёр цэрэг хайрт нөхрийг нь бүсгүйн зуурсан гараас мулт татан салгалаа. Хайртай түүнийхээ дотнохон үнэрийг сүүлчийн удаа үнэрлэж, ханхар цээжинд нь эцсийн удаа наалдаж байгаагаа мэдэрсэн бүсгүй “Намайг бас аваад яв! Хамтад нь бариад яваач, та нар!” хэмээн хашгирсаар шороон дээр сөхрөн унахад хоёр ногоон малгайтан нөхрийг нь хашааны хаалгаар түлхэн гаргаж байв.

-Амьдралаа бодоорой миний хүү! Сайн ханьтай болж, үр хүүхэд төрүүлээрэй!

Хөх минчүү тэрлэгээ нөмгөн өмсч, Дотоодыг хамгаалахынханд баригдан одохдоо нөхрийнх нь хэлж амжсан сүүлчийн үг энэ байж билээ. Хоёр цэрэг нөхөрт нь буу тулган гарах тэр агшинд нөгөө дарга Наранханд руу хяламхийсэн ч ч үгүй. Зүү орох зайгүй амраг хоёр залуугийн хагацалд эрхбиш зүрх халирсан бололтой. Бүсгүй нөхрийнхөө хойноос хэд харайн хашааны хаалганд хүрээд:

-Даанч яав даа!Таныг би газрын газрын гаваас ч хамаагүй олоод очно! Очноо! хэмээн хэмээн байдгаараа хашгирах гээд хоолой нь чохарч, өвдөг дээрээ суун тусав.

Эрдэнэ бол дунд зэргийн нуруутай, уужим магнайтай, нүд хөмсөг ихгүй ч цайвар царай, өтгөн халимагтай, гуч хүрч яваа сайхан эр. Хүрээний хэдэн үе дамжсан түшмэлийн удам, манж,түвд, хятад хэл бичигт гаргуун, судар бичгийн хүрээлэнд эрдмийн ажилтай хүн. Наранхандын эцэг Сайн ноён хан аймгийн Илдэн гүнгийн хошуунаас Хүрээнд орж ирсэн түүхий эдий худалдаа эрхэлж асан чинээлэг хүн билээ.Өнгөрсөн цагаан сараар бүсгүй худгуйн талын айлдаа золгуут хийж яваад Эрдэнэтэй танилцан анхны харцаар л сэтгэл алдарсан юм.

-Манай Наранханд хоньтой билүү?Энэ жил хорь хүрэх нээ.Эрдэнэ маань нохойтой.Гуч хүрлээ одоо.Гэрлэж бараалдаг ч үгүй ном шагайсан хүн л байх юм.Энэ сайхан охиныг аваад суугаач ээ гээд л гэрийн эзэгтэйн аманцарлахад мань хоёр ичингүйрэн нүүр нь зэрэг зэрэг улс улсхийх атал хулгай нүдээр бие биенээ хүсэмжлэн сэм харчихаад, харц тулгармагц нүдэнд үл үзэгдэх долгионд цохиулах мэт зүрх нь догдлон булгилж байж билээ.

Тэр өдрөөс хойш дөрөвхөн сарын дараа Богд уулын Бага тэнгэрийн аман дахь цэнхэр цэцэг дэлгэрсэн сэрүүн сайхан дэнж дээр цоо шинэ таван ханат барьж, дуутай хууртай, ерөөл магтаалтай, агсан согтуутай нижгэр хурим дэглэн Эрдэнийх гэдэг айл галаа асаасан сан. Царай зүсээр хаана ч гологдохооргүй цэвэрхэн төрсөн Наранханд монгол бичиг гаргачихна.Бас үйлэнд уран тул гэртээ нөхрөө хүлээнгээ хавь ойрынхоо айлуудын захиалгаар шинэ цагийн нударгагүй цэмцгэр дээл, хуучны халхгар хүрэм, угалзтай хантааз, дэгшин

шаавай дан дээл оёж хөөрхөн мөнгө олчихдог. Завсар зайгаар нь хөшиг, дэрний уут, бүтээлэг дээрээ тогос, морь, эрвээхэй, цэцэг хатгамалдан оёж гэрээ чимж суухдаа сэтгэлдээ далай их жаргалтай байжээ.

Гэргийгээсээ арваад насаар ах Эрдэнэ түүнийг эрхлүүлж “миний хүү” л гэж дуудна.

Гучин долоон оны хавар. Хүрээ, хот, хөдөө гадаагүй баривчилгаа эхэлж, цаг төр түгшүүртэй болж байсан цаг. Нэг өдөр нөхөр нь ажлаасаа нэлээд эрт ирж, хийж өгсөн цай хоолыг амсаж тавин сууснаа:

-Миний хүү инжиндээ ирсэн үнэтэй цайтай эд, миний хөөрөг, өөрийнхөө минжин малгай, булган нударгатай дээл гэх мэтийн чансаатай юмсаа аавындаа аваачиж тавьдаг юм уу даа гэв.

-Яалаа гэж тэрэв? хэмээн Наранхандыг сэртхийн асуухад:

-Манай хүрээлэнгээс хүмүүс ганц нэгээрээ баригдаад л байна. Миний хүү орос хэл үзэж, сургууль соёл бараадна байгаа. Жаал жуул эдээ хураалгачихалгүй авч үлдвэл нэг хэсэгтээ л чи минь гэдсээ тэжээгээд байхад хүрэлцээтэй. Цаашид цаг төр улам хатуу болох нь. Би нэг өдөр баригдаад явж ч мэдэшгүй хэмээн ярихдаа харц нь бүүдийж, бие нь дэргэд атал сэтгэл оюун нь хаа хол газар одчих шиг хачин болсон байхыг сэргэлэн соргог бүсгүй анзаарчээ. Тиймдээ ч олныг асууж шалгаан түүнийхээ сэтгэлийг чилээхгүйг бодон дотроо шаналсаар сууж байв.

Маргааш нь бүсгүй хуримын инжинд эцгийнхээ өгсөн мөнгөн аяганууд, зааны ясан сийлбэртэй хар модон хайрцагтай сувдан сам, энгэрийн саран зүү, найман цэнгийн алтан бугуйвч, навчин хээтэй алтан бөгж, ээмэг тэргүүтэн зүүсгэл чимэг, сайн хувцаснуудаа аавынхаа амбаарт нууцаар аваачиж хийгээд цоожилж зогсоход зүүн нүднийх нь доод зовхи удтал татваганан ёрын муу совин татахад “Би нэг өдөр баригдаад явж ч мэднэ” гэсэн амраг нөхрийнх нь үг бодогдож зүрхний нь ховдол руу зүүгээр шивэх мэт болж билээ.

Энэ өдрөөс хойш ердөө л долоо хоногийн дараа нөхөр нь ногоон малгайтнуудад баригдан одсон нь тэр. Маргааш нь өөр хүмүүс ирж гэрийг нь лацдаж битүүмжлээд бүсгүйг гудманд гаргачихаад яваад өгөв.

-Хааяагүй л эсэргүүн дайсан илэрлээ гээд гэмгүй улсыг барьсан дуулах юм. Орох оронгүй хүн биш. Охин минь эндээ бай. Санаагаар бүү уна. Хүргэн маань хорхойд хоргүй хүн. Олон хэл мэддэгтээ л бурууддаггүй юм бол хэмээн эцэг нь тэр орой ярин, ээж нь охиноо өрөвдөн нулимс унагаж байж билээ.

Бүсгүй нөхрөө баригдан явахад нь “таныг газрын гаваас ч хамаагүй олно” хэмээн амласнаа мартсангүй. Золоор нууж авч үлдсэн үнэ цэнэтэй гэсэн болгоноо нэг нэгээр нь зарж, мөнгө болгон хадгалангаа, дотоодыг хамгаалахын тэрүүгээр эргэлдэн нөхрийнхөө сургийг гаргах санаатай амьтан хүнтэй уулзан гүйж байлаа.

Аз болоход Наранхандаар дээл хийлгэдэг хүүхнүүдийн нэг нь Дотоодыг хамгаалахад

хариуцлагатай алба хашдаг хар хүнтэй болж таарав. Нөхрөө Дотоодыг хамгаалахын доорхи газар шоронд байгааг тэр хүүхнээр дамжуулан сонсоод хоёр ч удаа эргэлт оруулж дөнгөхдөө гурван цэнгийн алтан бэлзгээр хахууль өгчээ. Тэгээд удалгүй түүнийгээ хойшоо Орос улсад ачигдсаныг баттай мэдэж авав. Ингээд л “Түүнийхээ барааг нь ганц харчих юм сан” гэсэн бодолд автаж, орос явахаар сэтгэл шулуудан рубль худалдан авч эхэлснийг эцэг, эх нь ч мэдсэнгүй. Хавар цас ханзрахад нөхөр нь баригдан одсон сон. Бага багаар цуглуулсаар мянгаад рубльтэй болж, хилээр гарах бичиг сачиг олж дөнгөөд бүсгүйг нэг л өдөр түүнийхээ хойноос Орос руу мал туух хүмүүс даган замд гарахад наймдугаар сарын хорьд гарчихсан байлаа. Зарсан юмнаас нь үлдсэн гурван алтан бэлзэг, өнөө орос мөнгөө навчин хээтэй хөх торгон дээлнийхээ хаваасан дундуур хүнд мэдэгдэхээргүй нуугаад, солих хувцас хунар, замын хүнсээ сэмхэн бэлдэж, олон жил Орос руу хонь туусан хижээл насны Дамдин хэмээх тохитой хүнтэй тохирон явах гэж буйг нь гуравхан насны зөрөөтэй охин дүүгээс нь өөр хэн ч мэдсэнгүй.

Бүсгүй намрын хяруу цавцайсан нэгэн өглөө гэрээс гарахдаа аав, ээждээ “Хэвлэх үйлдвэрт ажилд орсон. Ажлын газрынхантайгаа Заан Тэрэлжид самарт явлаа” гэж худал хэлээд л тууварчид даган хойд зүг гарч өгөв.

-Хүний газар хэл мэдэхгүй ийм бага залуу бүсгүй хүн хань нөхрөө яаж эрж хайх гэсэн юм бэ? Сүүлд нь хүний амины хэрэгт орно, яршиг зүгээр. Бусдаараа л бууз хуушуур шиг явъя хүүхээ хэмээн эхэндээ дургүй байсан “хэцүү” Дамдин хань нөхрөө гэсэн бүсгүйн цөхөршгүй сэтгэлийн өмнө эцэстээ бууж өгч, тогоо бариулахаар дагуулж явахаас аргагүй болж билээ. Тэгээд ч харваас үг хэл хурц, ухаан саруул, ажилд шаламгай байрын өнгөлөг бүсгүйг тууврынханд нэг их тээр дараа болохгүй гэдгийг ухаарсан ч биз.

“Баригдана гэдгээ мэдээд эд хөрөнгөө хураалгачихвал намайг л хоосон нойтон үлдэх вий гэж үнэтэй эдлэл, хувцас хунараа аавындаа аваачиж тавь гэж хэлж дээ. Үгүй, тэгээд буутай цэргүүдэд туугдан одохдоо хүртэл амьдралаа бодоорой миний хүү гэж байсныг бодоход үнэхээр сайхан сэтгэлтэй хүн шүү. Бид хоёр ганцхан жил хамт амьдрах гэж л ингэж хоёр биендээ соронзон адил татагдсан юм гэж үү? Намайг “Сормуус нь чинь яасан ч урт юм дээ. Орос хүүхэлдэй шиг. Тэгсэн мөртөө хятад шаазан дээр байдаг хүүхэн шиг гангар цагаан царайтай” гээд л дандаа магтаж сайлж байдаг сан. Нэг удаа “Үүлэн зардас” гэж хагацаж салсан хоёр амраг сэтгэлийн үгээ хурмастын үүлэнд дайж илгээж буй тухай хичнээн сайхан шүлэг хэлж өгч байлаа даа. “Байз тэр шүлгийн мөрүүд цээжи нд хадгалагдан үлдсэн байх чинь.”

“Агаар тэнгэрээр халин одох чамайг Алага зорин явахад

Аянчны эхнэр үсээ сөхөн харж, нөхрөө хүсэн хүлээнэм.

Аянга дуугий тань сонсоод, амрагаа таалахыг хэн үл хүсэх вэ?

Азгүй би л эзний хилэнд эрсдэж, энхрийлэн таалж үл чадам...” гэдэг сэн бил үү? Энэ шүлэг хайртай түүнээсээ хагацан салсан намайг ч хэлээд байгаа юм шиг “гэхчлэн бүсгүй тууврын урт замд тувт амраг ханийнхаа тухай бодолд автан явж байлаа.

Гэрээс гарснаас хойш арав гаруй хоног яваад Сэлэнгэ мөрний бэлчирт орж ирлээ. Дамдингаас гадна муруй Лувсан хэмээх дуугүй номой залуу хамт мал тууж явлаа. Доод уруулыг нь баруун тийш татаад оёчихсон мэт муруй, түүнээсээ болдог юм уу, юм асуувал “за,үгүй”- гээс өөр үг барагтай бол дуугарахгүй хорь гаруй насны тэр залуу Наранхандаас зовонгуйрдаг ч юм уу, эгцэлж харж ч үл чадна.

Намрын дунд сар гарч, тууварчдын сэмэрхий хөх майханд шөнөдөө хүйтэн гэж жигтэйхэн хононо. Дамдин эхэндээ хүн сайтай, яриа хөөрөөтэй хүн шиг байснаа аян замын уртад аажимдаа тар нь танигдаж эхлэв. Намрын азарган бороотой нэгэн шөнө нам унтаж байсан бүсгүйн өвөр рүү цэл хүйтэн гар ороод ирснийг нь очиртой бөгжөөр нь Дамдин гэдгийг шууд таньж,”Лувсаан!Босоод ир, гарч шээмээр байна” гэж залууг сэрээн, бие засах нэрээр лаа асаан гарч орж байж тэр шөнийг өнгөрөөв.

Маргааш нь мань эр юу ч болоогүй мэт Наранхандын чанасан цайг оочин “муруй” Лувсангаа зандчин сууж байв. Гэхдээ тэр шөнөөс хойш бүсгүйн журамтайг мэдэн зүрхшээсэн үү, яасан дахин татаж чангаасангүй.

Хатан Туул, Хараа, Ерөө, Харлин, Шарлин, Орхон, Сэлэнгийг гатлан олон зуун хонины тоосон дунд явсаар тэр гурав Монгол, Оросын хил дээр ирлээ. Тууварчид дундах ганц залуу бүсгүйг оросын хил, гаалийнхан сэжиглэнгүй харах боловч нэвтрэх бичиг баримт бүрэн тул саадгүй өнгөрүүлэв.

Банхар хөв хөв хуцалдан, аргалын хөх утаа, эсгий гэрүүд цайвалзах төрөлх монгол ахуй нь хил давмагц огцомхон өөрчлөгдөж, дүнзэн байшингууд шавсан орос тосгон, гахай, тахиа, тэргэнд хөллөсөн морь, хагалсан газар, халуун намраар толгойгоо алчуураар боосон урт банзалтай орос эмэгтэйчүүд үзэгдэх агаад Хүрээнээс гарч үзээгүй бүсгүй гайхан балмагдаж явлаа. Тууварчид хотоос гараад сар гаруй явж Хиагт хүрч хонио тушаагаад буцах болов.

Тууврын замд сайдахдаа сайдаж, муудахдаа муудаж явсаар нэгэнт ижил дасал болсон Дамдин, Лувсан хоёроос салах цаг ирэхэд Наранханд сая л хүний газар ганцаар хоцрох болсоноо мэдэн гэнэт сандарчээ.

-Хүний газар гүний хошуунд ч биш бүр хилийн цаана, харь газар, хар элгийн зүс буруу улсын дунд чам шиг бага залуу бүсгүй хүн ганцаараа үлдэнэ гэдэг амаргүй. Хүү минь буцна гэвэл аваад явъя.Эндээс чи нөхрийнхөө сургийг гаргаж чадна гэдэг юу л бол гэж Дамдинг өрөвдөн хэлэхэд хоромхон зуур сэтгэлээ чангалж амжсан бүсгүй:

-Үгүй ээ. Өчнөөн өртөө хол газрыг туулан энэ хүрчихээд би яаж буцах вэ? Би зүгээр.Заавал нөхрийнхөө сургийг гаргана. Та хоёр сайн явж хариарай. Энийг манайханд хүргээд өгчихээрэй гээд орос хоршооноос ээждээ ирис чихэр, аавдаа дүнсэн тамхи, дүүдээ цэнхэр пансан алчуур авч баадагнан боосноо өгч, хэлмэрч буриадтай хамт гар даллан хоцорч билээ.

-Айхтар шазруун бүсгүй юм аа, чи. Ахдаа гомдсон бол уучилна биз. Үйлс тань бүтэх болтугай гэж Дамдин Хиагтаас буцахдаа хэлжээ.

Аз болоход Дамдингийн танилцуулж өгсөн Хиагтын Сампил гэдэг буриад нь орос хэлэндээ ус цас, хүнээр ч гайгүй, танил талтай ч эр байв.

-Басган минь энд мангадуудын байсаагч түшмэлүүд бузар чанга улс. Шамайг өвчтэй, Улаан-Үд явж доокторт биеэ үзүүлнэ хэмээгээд зам явах бичиг шийтгүүлчихлээ. Гучин рубль гар дээр нь тавилаа гэнэ.

Бүсгүй Сампилтай хамт ачааны машины тэвшин дээр баахан орос,буриадуудтай зам нийлэн сууж Улаан-Үд хүрлээ. Захаараа дүнзэн байшингууд, төвдөө хэдэн тоосгон байшинтай. Хүн, машин, морин тэрэг хөлхөлдсөн, Улаанбаатарыг бодвол таримал улиас ихтэй хот байв.

Аравдугаар сар гарч, Сибирийн чийглэг хүйтэн намрын жавар хөвөнтэй дээлийг нь нэвт хайрна. Улаан-Үдэд бүсгүй хэлмэрчийнхээ хуучны танил орос айлд буулаа.

-Елена гэж өвгөн нь талийсан бэлбэсэн самган байгаам. Мухрын өрөөндөө чамайг хоногийн нэг рублиэр байлгая гэнэ. Хоол бас нэг рубль шүү. Хэрэгт дурлахгүй сайн самган. Чи түүнтэй оросоор ярьж бай. Хэл сурна. Би дүүгийн дээ буулаа гэж Сампил хэлэнгээ бүсгүйг түрийнээсээ хуучин хүрэн ширэн хэтэвч гаргахад хэр бэлтэйг нь сонирхсон байдалтай хяламхийгээд авав.

Наранханд яалаа гэж мөнгөө түүнд үзүүлэх билээ. Сар гаруй тууварт хамт явсан Дамдинд ч хэдэн рубльтэй, хэр зэрэг бэлтэйгээ мэдэгдээгүй хүн чинь. Хуучны сайн наймаачин эцгийн цус хаачих билээ. Мөнгө хөрөнгийн хэрэгт дүй сайтай, гар ч чангатай бүсгүй билээ.

Улаан -Үдийн бага сургуульд багшилдаг Елена Николаевна гэж жараад насны орос авгай зан сайтай, бичиг номтой сэхээтэн хүн байсан нь аз. Түүнийг Орос руу баригдан явсан нөхрийнхөө сургийг гаргах, болж өгвөл уулзах гэж ирснийг сонсоод толгой сэгсрэн шогширч:

-Хичнээн алт шиг сэтгэлтэй бүсгүй вэ? Хонгор минь, энд хүмүүсийг хэдэн мянгаар нь баривчилж байна. Тэдний дундаас хаа холын монгол хүний сургийг гаргах хэцүү, хонгор минь. Тийм холоос нөхрөө сурагласаар ганцаараа энэ хүртэл явсан гэдгийг төсөөлж ч чадахгүй нь. Гэрээ, ээжийгээ санаж байна уу? хэмээн дал мөрөөр нь тэврэн аргадсан нь орос хүний халуун сэтгэлийг түүнд анх мэдрүүлж билээ.

Сампил тэр хоёр Улаан-Үдийн Дотоодыг хамгаалах газар өргөдөл өгч, танил хүмүүсээр сураг ажиг тавьсаар монголоос баривчлагдан ирсэн хүмүүсийг Эрхүүгээр дайруулан Новосибирск рүү авч явсан тухай сураг гаргав.

Оросын хил давснаас хойш нэгэнт сар гаруй хугацаа өнгөрч зам явах, хил нэвтрэх бичгийн хугацаа ч дууссан байлаа. Бүсгүй энэ тэр хүнд сурталтны гар цайлган, байр хоолныхоо мөнгийг өгч, хэлмэрчдээ хөлс төлсөөр гарын бэл нь ч сүрхий нимгэрчээ. Энэ хооронд сэргэлэн бүсгүй гэрээс авч гарсан”Орос хэл өөрөө сурах ану” хэмээх номтой хамжин гэрийн эзэгтэйтэй ярьсаар өөрийгөө бусдад зэгсэн сайн ойлгуулахтай болсон байлаа. Гэтэл Эрхүүгээс ирсэн бичгээс үзэхэд Монголоос гадаадын тагнуулын хэргээр баригдсан Намсрайн Эрдэнэ Эрхүүд шоронгийн эмнэлэгт өвчтэй байгаа нь тодорхой болжээ. Хэлмэрч Бампил буриад нь:

-Эрхүү явах чиний замын байсаах бичгийг би энд байдаг Бадмаа гэдэг дүү басганы нэр дээр гаргуулж авлаа. Би маргааш Улаан-Үд буцна. Энэ галт тэрэгний пиу. Елена самганы дүү чамайг Эрхүүд угтаж авна. Цаашаа яахыгаа өөрөө мэд. Миний ар дахь ажил төрөл хэцүүдлээ. Гадаад Монголын хүн ийм удаан энд байж болохгүй дээ. Яаж буцахыг чинь мэдэхгүй байна. Замдаа сайн яваарай басган минь гээд орос ёсоор гар барьчихаад нэг л өглөө яваад өгөв.

Наранханд галт тэрэгний түжигнээн дунд, танихгүй орос хүмүүстэй хамт Эрхүү хот хэмээх мэдэхгүй газар руу аялах зуур цонхоор үзэгдэх өвлийн анхны цасанд дарагдсан нэвсгэр их тайга, харь газрын тосгон суурингуудыг ширтэн ”Ижий минь миний хойноос яаж сэтгэл нь зовж байгаа бол. Саранханд сэргэлэн охин юм чинь ижийг тайтгаруулж байгаа даа. Аав ч яахав. Намайг мэдэх юм чинь. Санаа нь хичнээн зовсон ч ижийд юм хэлэхгүй. Муу хань минь л энэ яс янгинам хүйтэнд, дан тэрлэгтэй аль газар зовж тарчилж явдаг юм бол? Орос орон гэж төсөөлшгүй том нутаг, тоолшгүй шороон түмэн хүнтэй, өлөн зэлмүүн, эд бараа ховор живэр хэцүү л газар юм даа. Зам явах, хилээр нэвтрэх бичиггүй би яаж нутгийн бараа харна” гэхчлэн түмэн бодолд дарагдан явж байлаа.

Галт тэргээр дүүрэн цэргийн хүмүүс, хүүхэд шуухад нь уйлалдаж майлалдсан эхнэр хүүхнүүд, суух суудал ч олдохгүй, бөөр бөөрөө дэрлэн унтацгааж, хэрүүл шуугиан үл тасарна. Үйлчлэгч нар нь ааш муутай гэж хачин.

“Сохрын газар сохор. Доголонгийн газар доголон” гэгчээр бүсгүй гэрээс өмсч гарсан монгол дээл хувцсаа эвхэн далд хийж, орос хувцас, гадуураа гайгүй зузаан пальто, өдөн алчуур олж авчээ. Оросууд түүнийг залуухан буриад бүсгүй л гэж бодож байгаа нь илт, хайхрамжгүй ширвэцгээнэ.

Хувь тавилангийн зам хаагуур зурайхыг хэн ч тааж мэдэх биш дээ. Наранханд Эрхүүд буухдаа нэгэн айхтар өвчин туссанаа анзаарч, толгой нь эргэж бие нь арзайгаад арай ядан хөлөө зөөж тавьж байлаа. Гай болоход Елена Николаевнагийн дүү нь ажлаар Ангарск явсан тул тосч авсангүй. Бичиж өгсөн хаягаар нь явсаар бас нэг ганц бие орос эмгэнийд очиж буулаа.

Ганц дан дүнзэн байшин дотор том ханан пийшинг галласан тул пүнхийм дулаахан байвч яагаад ч юм бүсгүй ясандаа тултал даарч, шүдээ хавчигнатал дагжсаар байлаа. Орос пийшин гэдэг халуу дүүгэсэн сайхан эд авч монгол гэрт задгай тулганд асах амьд галын илч, аргалын утааны сайхан үнэрээр цээж дүүрэн амьсгалах, хуурай гишүү шад падхийн шатах, тулганы амсраар хаа нэг оч үсэргэн, шатаж дуусч буй аргалын цог жаргах нарны цацраг мэт улайхыг харан сэтгэл бүлээцүүлэхийн сайхныг юутай зүйрлүүлэх билээ. Гэртээ л харих сан. Аргалын утаа үнэрлэх сэн... гэсэн бодол унтарч буй ухааных нь үзүүрт сүүмэлзэхийг, хөл нь мөс болтлоо даарах атал толгой нь халуу шатан, зуун тэнгийн ачаа зүүсэн мэт хүндэрч буйг мэдэрч байлаа...

Тэгсээр бүсгүй өглөө тахиа дуугарч байх үед хэдийн ухаан алдсан байсан тул эмгэн өвчтэй харь хүнийг арай ядан эмнэлэгт хүргүүлжээ.

-Эрдэнээ! Энэ Орос газар чинь яасан хүйтэн юм? Та минь даарч байна уу? Ижий! Охин нь тандаагалт тэргээр яваад очлоо. Орос чөтгөрүүд намайг чангаагаад байна хэмээн

төрөлх хэлээрээ солиорон хашгичих бүсгүй Эрхүү хотын нэгэн эмнэлэгт долоо хоногт үхэлтэй тэмцжээ.

-Девушка!Бадма, слышишь меня!Милая! гэх ялдамхан эрийн дуугаар тэр нэгэн өглөө Наранханд ухаан орлоо.

Зөөлөн харцтай том бор ногоон нүд, өтгөн хөмсөг. Өндөр хянга хамартай, шингэн цайвар хүрэн халимагтай орос эмч дээрээс нь тонгойн зогсч байв.

“Би үхээгүй юм байна. Бадмаа гэж хэн билээ?Аан,Сампил гуайн олж өгсөн бичиг дээр намайг Бадмаа гэж байгаа шүү дээ” хэмээн тэр бодож амжлаа.

Ингэж эрүүл чийрэг бие махбодь нь гэдэсний хижиг өвчнийг тэсч гарч чаджээ. Хэд хоногийн дараа үсээ хусуулж, турж эцээд яг бяцхан хөвгүүн шиг болсон Наранханд эмнэлгээс гарах болоход нөгөө орос эмчийнхээс өөр очих газар ч байсангүй. Павел Аркадьевич Муран гэдэг эмч залуу хувь заяаны шоглоомоор нөхөртэй нь нас чацуу, жилийн өмнө эхнэрээ уушигны сүрьегээр алдсан ганц бие хүн байлаа. Гэртээ ээжтэйгээ хоёул суудаг аж.

Харь холоос хань нөхрийнхөө сургийг гаргаж, уулзаж учрах гэж ганцаар яваа хорин хоёрхон настай залуухан монгол бүсгүйн түүх эх хүү хоёрыг уярааж гүйцэв.

Эрхүүгийн Их сургуульд багшилдаг дүү нь бас өнгөрсөн онд баригдсан болохоор Павелийн ээж улстөрийн хэрэгтнүүдийн сургийг хэрхэн гаргах, шоронгийн гадаа яаж шуу дугаарлах, эргэлтийн юмаа хэрхэн оруулж өгөх тухайд алтангэрэл судар мэт зузаан туршлагатай хүн байв.

Харамсалтай нь Монголоос баривчлагдан ирсэн хүмүүсээс 31 настай Намсрайн Эрдэнэ гэдэг хоригдол уушигны хатгалга тусан Эрхүүгийн шорон дундын эмнэлэгт эмчлүүлж байгаад долоо хоногийн өмнө Приморскийн нэгэн хорих газар руу ачигдсан сураг гаргаад л бүсгүйн эрэл мухардав. Хувь тавилан тэр хоёрыг учруулсангүй ээ. Монгол, халимаг хүмүүс Приморскийн хатуу өвлийг барагтай л бол давдаггүй юм даа гэж шоронгийн дамжин өнгөрүүлэхийн хүн хэлсэн гэнэ.

Шилжилт хөдөлгөөнийг чанд хатуу бүртгэдэг Орос оронд хууль, журам зөрчин гурван сарын турш холхисон монгол бүсгүй буцах замгүй гэдгээ тэр өдөр л ухаарав. Тэр өдөр бүсгүй сибирийн арваннэгдүгээр сарын хацар чимхсэн жаврыг ч хайхралгүй өвөлд үл хөлдөх Ангара мөрний харгиа ч үгүй, ёроол нь үл харагдах гүн хар урсгалыг ширтэн өдөржингөө эргүү юм шиг тэнэж яваад Павелийнд буцаж ирлээ. “Өдийд Туул гол захаараа хөлдчихсөн, хүүхдүүд шуугилдан гулгаж байгаа даа. Ижий, аавдаа сураг ажиг дуулгах уу, яахав? Хайртай түүнийгээ олж уулзах найдвар нэгэнт тасарлаа даа. Ядаж түүндээ удам залгах үр хүүхэд ч төрүүлж өгч чадсангүй. Надаас өмнө энд тэнд орхисон хүүхэд ч байдаггүй л байх даа...” гэхчлэн элдвийг бодсоор тархи толгой нь эргэж гүйцжээ.

Ингээд Наранхандын хайрт ханийхаа сургийг гаргаж, бүлээн зүсийг нь үзэх гэсэн уртын урт аяных нь сүүлчийн өртөө Эрхүү хот болж, аргагүйн эрхэнд үлдсэн ганц алтан бөгжөө заран Улаан-Үдэд төрсөн Надежда Сампиловна Доржиева гэсэн хуурамч бичиг баримт олж аваад

Павел эмчтэй гэрлэжээ. Хайрт нөхрийнхөө сургийг гаргах гэсэн цөхөршгүй итгэл найдварыг нь билгэдэн Павел түүнд Надежда буюу найдвар гэсэн орос нэр өгч билээ. Харин дараа жил нь төрсөн хүүдээ тэрээр Эрдэнэ нэр өгчээ.

Гэвч Надя буюу Наранханд бүсгүй “таныгаа газрын гаваас ч хамаагүй олно “ гэсэн амлалтаа умартсангүй ээ. Эрхүүд ирсэн 1937 оны аравдугаар сарын хорьдын тэр нэгэн өдрөөс хойш яг дөчин таван жилийн дараа “Таны асууж мэдэхийг хүссэн БНМАУ-ын иргэн, Н.Эрдэнэ Приморскийн “Кареченскийн” хорих лагерьт 1938 оны гуравдугаар сарын 23-нд онд сүрьеэ өвчнөөр нас барсныг мэдэгдэх ялдамд түүнийг хорих газрын дэргэдэх хоригдлуудын оршуулгын газар хөдөөлүүлсэн актыг хавсаргав. ЗСБНХУ-ын УАХХ” гэсэн албан бичиг хүлээн авч, түүнийхээ шарил дээр нь монгол ёсоор сүү өргөж, арц асаан өгөршиж хуучирсан загалмай модыг нь уйгарчин монгол үсэгтэй боржин хөшөөгөөр сольж билээ. Намар болж жавартай чийглэг салхи уйтайгаар үлээн, өмнө зүгт буцаж буй тогоруун цуваа зүрхэнд нэвтэртэл гашуунаар ганганаж байвай.

Дөнгөж Улаан-Үдэд буухад нь халуун сэтгэлээр угтан авч асан сайхан сэтгэл орос эмгэний дурсгалд нэрийг нь хайрласан ач охин Лена нь эмээгийнхээ царай өөд гайхан харж:

-Эмээ, энэ хэний шарил юм бэ? хэмээн оросоор шулганан асууна.

Дөчин дөрвөн настай, огт монгол төрх үгүй ч монгол эхийн үр, монгол нэртэй Эрдэнэ хүүгээ сугадсан Наранхандын сэтгэлд анхны хайрын эзэн монгол нөхрийнх нь уншиж өгч байсан “Үүлэн зардас” хэмээх гайхамшигт зохиолын

“Энэлгэтнийг тэтгэгч үүлэн чи,хайртанд минь мэдээ хүргээч,

Эзэн Гүвираагийн зарлигаар хагацсан намайг энд гэж хэлээч...” гэсэн уран яруу атал уй гуниг дүүрэн мөрүүд тэртээ дөчин зургаан жилийн өмнөх цаг хугацааны тоосон дундаас монгол хэлээр ой ухаанд нь сэргэн санагдаж байв. Мөнх бусын орчлонд хүний дүр төрх оворжин хөгширдөг ч зүрх сэтгэл л хавар шиг эгнэгт залуугаараа үлддэг ажээ.

2009 он

Бэр

Өвлийн эхэн сарын хайруу хүйтэн өглөө. Нар битүү. Уулын жавар үүрээр доошлон үүл хүртэл хүйтэнд тэнгэрт хөшин царцсан мэт хөдөлгөөнгүй бараантан байлаа.

Нүдэнд үзэгдэхтэй үгүйтэй жижигхэн жижигхэн ширхэгтэй цасан хялмаа хаялсан энэ өглөө Хонгорзул бүсгүй хөвөнтэй дээл нэвт сийгэх хүйтэн жаварт ороолгох хацраа зүүн гараараа нэг илбэн дулаацуулаад баруун гараараа хадмын гэрийн өрхний цантсан оосрыг тас атган нар зөв даялан татаж явна. Том улаан халтар хоточ нохой Жангар хүртэл пөөнийсөн их үс даахьтай сүүл, халуун цавиндаа хошуу шургуулан бүлээн хэвтэртээ хоргодох идэр есийн хүйтнээр шинэ өдрийг авчран өрх татдаг хүн арван өртөө алсаас буулгасан энэ бэр бүсгүй билээ.

Өндөр сүрлэг уулсын суган дахь нөмөр нөөлөг энгэрт барьсан чулуун хорооны баруун талд байх хоёр гэр үүрийн тэмдгэрэх төдий гэгээнд дөнгөж ялгагдах төдий цайвалзан бүртийнэ. Өвөлжөөний зүүнтээ хөглийх их уулсын цаадтай хоцорсон унаган нутаг, эцгийн халуун дулаан голомт, ээжийн элбэрэлт дүр төрх, хоёр балчир дүүгийнх нь хонгорхон даахины үнэр бүсгүйн сэтгэлээс үл гарна.

Хонгорзул бүсгүй өглөө бүр ийнхүү өөрийнхөө болон хадмынхаа гэрийн өрхийг татаад аргал хэрзэн хормойлон орж хоёр гэрт гал асаан дулаацуулна. Эрэгнэг дээрх тунхуутай цай зайрмагтан хөлдөөд хонодог тэсгим хүйтэн өвлийн өглөө халуун дулаахан нэхий хөнжлөөсөө сугарах юутай бэрх. Хэрэв хайрт ээжийнхээ дэргэд сэн бол “Ижий нь галаа түлээдэхье. Охин минь ганц удаа ч гэсэн дулаан гэрт бос доо” гэх байсан болов уу гэж бодохоос хамрын самсаа шархираад явчихдаг байснаа эрхбиш больжээ. Тийм хүйтэн өглөө суга ханцуйд нь жавар хургасан дээл, мөстэй цооног мэт цэл хүйтэн гутлаа угламагц саяхан дулаан хөнжилдээ тавтай амарч асан хамаг биеийнх арьс эгшин зуур даарсандаа бэржийн өөрийн эрхгүй хавжигнатал чичирнэ. Хонгорзул гурван сарын өмнө халхын Засагт хан аймгийн Ёст бэйсийн хошуунаас Ховдын хязгаарын Дайчин гүнгийн хошууны Балдан бичээчийн ганц хүү Дамбажавын эхнэр болж богтлогдон иржээ.

Бүсгүйн эцэг Сүхцоож мал гэх юмгүй шахуу, зүдэг ядуу гөрөөчин эр. Залуудаа хугацаагүй цэрэгт дайчлагдан Ховдод арваад жил алба хаахдаа Балдан хэмээх мянгад залуутай танилцан нөхөрлөжээ. Богд хаант төрийн үед цэргийн алба хугацаагүй байсан ч Балдангийн эцэг Жуурай таван зуун лан мөнгө Ховдын амбанд хахуульд өргөж байж хүүгээ чөлөөлүүлсэн бол Сүхцоож гэдэсний өвчин хүрч хэвтэрт ороход нь бусаддаа халдвар тараахаас түвэгшээсэн цэргийн хэрэг эрхэлсэн түшмэл түүнийг гэрт нь буцаахаар болж билээ.

Ийнхүү хориод насандаа цэрэгт дайчлагдан ирж, өлсөх цагтаа өлсөн, хааяа цадах цагтаа цадан хорвоогийн олон ч бор хоногийг цугтаа үдэж, арваад жил нөхөрлөсөн хоёр анд эртний заншлаар бүсээ сольж бүслээд хэрэв гал голомт бадраан ойролцоо насны хүү, охинтой болдог юм бол заавал худ ураг бололцох, хоёулаа хөвгүүдтэй болох юм бол анд нөхөд болгохын ерөөл талбиад хоёр тийш салан одсон ажгуу.

Нутагтаа очмогц хошуу тамгын газар бичээчийн алба залгуулах болсон Балдан амьжиргаа

сайтай айлын хүү тул андаасаа түрүүлэн гэрлээд жилийн дараа хөвгүүнтэй болж Дамбажав нэр өгчээ. Сар жил хөврөн одсоор Балдан бичээч хааяа нэг залуу цагаа дурсахдаа цэргийн анд Сүхцоожийн тухай бодол орж ирэхэд “Анд минь гэрлэж бараалсан болов уу? Хэрэв Сүхээ охинтой болсон бол хүүгээ томрохоор бэр буулгаж авна даа” хэмээн санаашрах агаад шилбүүр унан давхих нусгай хүү рүүгээ хараад “Энэ бид хоёрын эхнэр авах ч хаа байсан юм” хэмээн сахал дороо мушийдаг байлаа.

Чингэж цэргийн андынхаа тухай марталгүй санаж явсаар нэг удаа сураг тавивал Сүхцоож хошуу нутагтаа эсэн мэнд суугаа. Эхнэр авч, гурван нялх нойтон хүүхэдтэй болсон дуулджээ.

Тэгээд албанаас чөлөөлөгдсөн есөн жилийн ойн дээр Засагт хан аймагт Сүхцоожийн залгаа хошуу руу зарга заальхайн нэхэмжлэгчээр явах далимд нөхрөө сураглан хайсаар олж учирсан нь Хонгорзул бүсгүйн хувь заяаг шийдчихсэн хэрэг.

Залуугийн анд нөхөр нь нас дөч хэвийж шингэхэн шодон гээг нь духаараа халзран мах мариа нь шуугдаж, хадан дунд мориноос унахдаа үсэрсэн чулуунд цохигдон духан дундуураа хагас дугуй саран мэт сорвитой болж нэлээд өтөлсөн харагдана. Ярианаас нь үзэхэд малжиж хөрөнгөжсөн юмгүй, ан гөрөө хийж хоногийн хоолоо арай чамай залгуулдаг гэнэ.

Дөрвөн ханатай хуучин гэр нь хогшил тавьц ядруухан ч тоос шороогүй, цэмцгэр цэвэрхэн, дулаан тохитой. Авгай нь гав шув хийсэн ажилсаг янзын бондгор хүүхэн зээрийн мах татан мангиртай бууз хийн, авдрынхаа хөндийгөөс жижиг цагаан ваартай нэрмэл гарган халааж, цагаан тос хайлан гараа гарган дайлсан нь мань эрийн сэтгэлд их л нийцтэй байж.

Их охин нь гэж зургаа хүрч яваа гэх авч аюулын чацархаг, нүд нь гялалзсан хөнхөр бор охин эхдээ туслан аргал хормойлж, дүү нараа чирэн асрах нь Балдангийн нүдэнд шууд өртөж:

-За Сүхээ хоёулаа цэргийн албанаас харихдаа хэлэлцэж тохирсоноо мартаагүй бол хүү, охин хоёроо сүйлье. Манайх амьжиргаа муугүй, нутаг усандаа нэр сайтай айл учир улс охиноо өгөхдөө дуртай, бэр болох бүсгүй захаас аван мундахгүй бий ч шударга, шулуун зантай, хүн чанар сайтайг нь муугүй гадарлах андтайгаа худ ураг бололцох дуртай байна. Хүү минь луутай. Чиний охин хоньтой юу? хэмээн шалснаар дуу цөөтэй, за гэвэл ёогүй Сүхцоожийг ам алдуулж дөнгөж билээ.

Хар нялхаараа байгаа охиноо нутаг ус алс, ёс заншил ялгаатай хаа холын мянгад айлд сүйлнэ гэж эр нөхрөө амлахыг сонсоод галаа ухан цогшсон аргал цуглуулан үнс нурам бужигнуулж суусан гэргий нь цочихдоо шилээврээ алдсан ч сүх шиг хөндлөн зөрүүд зангаараа нутагтаа алдартай гэрийн эзний хөмсөг зангидахыг хараад навтасхийн чимээгүй болж билээ.

Чөдрийн ганц морь, таргийн хоёр үнээ, шөлний хэдхэн хоньтой, онгорхой хар цахиур буунаас өөр гавьтай мал хөрөнгө гэх юмгүй харанхуй цээжтэй, нүгэлт хар гөрөөчин эцэг нь яс угсаа өөр, нутаг алс холын ч атугай бичиг номтой, дунд чинээний хөрөнгөтэй айлд охиноо өгвөл идэх өмсөхөөр дутахгүй, алс хэтдээ төрүүлэх үрс нь удам угсаа сайтай байх юм хэмээн хэтийг харсных бүлгээ.

“Ижий, аав, дүү нартайгаа ганц ч гэсэн уулзах сан. Ижийн минь чанасан цай, хурган мөөгтэй

хар шөл хичнээн сайхан амттай вэ.

Аав намайг явахад гэрийнхээ гаднаас саахалтын зайтай даган гаргаж өгөөд:

-Миний охин хадамдаа ачлалтай, ханьдаа халамжтай, айлын сайн бэр, хүний сайн гэргий болоорой. Төрхмөө санагалзан гиеүрдэггүй юм шүү. Угжтай байхдаа манайх, уужаа өмсөөд хүнийх болдог гэж бүсгүй хүнийг хэлдэг юм. Ажилч хичээнгүй, зөөлөн даруу, эртэч байвал хадмынхан нь чамайг ээнэгшин хайрлана хэмээн захиад хоолой нь зангирахад цаашаа эргэмэгц тэр чигтээ явчихсан. Нүүрээ надаас нуусныг бодоход эр хүний харам нулимсаа үзүүлэхгүй гэснийх биз хэмээн бүсгүй бодох зуур гэртээ орж галаа асаах гэж хэт цахиж нойтон аргалын утаанд нүд хорсгон, хахаж цацан сууж байлаа.

Балдан бичээчийнх гурван зуугаад хоньтой, хориод амбан шар, сүү татуухан ч тарга хүч сайтай арваад үнээ, хориод сарлагтай, хоёр азарга аргамаг сайн адуу, ачлагын хэдэн сайхан аттай, их зургаан ханат гэртэй айл.

Эхнэр нь Мижидцоо гэж гэрт гадаагүй дуу хадаасан хангинуур сүх шиг сүрхий хөнгөн шингэн биетэй, аманцар авгай. Хадам эхийн тэр хангинуур хэлэмгий долонгойг үзээд Хонгорзул галаа ухаж, гэрийн ажлаа дуугүй оролдон сууж, цагийн мөнхөд эцгийнх нь өөдөөс эгцлэн харж чаддаггүй ноомой буурай эхтэйгээ харьцуулан бодож сүрдэн гайхширна..

Энэ айл эрхбиш өнгөн дээрээ эр нөхрийн нэрээр Балдан бичээчийнх гэж дуудуулдгаас биш, хоймрын сийлбэртэй гурван авдрын түлхүүрүүдээс өгсүүлээд, гэр доторхи бүх эрх мэдлийг гартаа бүрнээ атгасан хадам эх нь дуугүй дүмбэгэр хүү, холоос буулгаж авчирсан бэрийнхээ хаашаа хөдлөх, юу ярихыг хүртэл зааж заавардана.

...Хонгорзулыг зургаатайд анх гэрт нь айлчлан ирэхдээ аман сүй тавиад буцсан Балдан бичээч арван жилийн хойно гэнэт л зуны эхээр Сүхцоожийнд хөтөлгөө морьтой, эрээн майхан, идээ, ууц, бэлэг сэлт ганзгалан эр эм хоёр хүн дагуулан мянгад ёсоор хадаг тавихаар буужээ.

-За анд минь сайн сууж байна уу? Би багш ламтандаа баранзад хадаг барьж танай охиныг бэр буулгах эсэхийг асууж, “Оюу чулууг нь тавиуллаа”. Бүсгүй хүн хонь жилтэй байх нь номхон дөлгөөн, үржин өсөх буянтайн шинж. Манай ёсоор хүүхний тань жил, мэнгэ, оюу чулуу тохируулж үзэхэд болж бүтнэ, ивээл өлзийтэй хэмээн айлдлаа. Энэ хоёр маань миний эцгийн талын үеэл ахан дүүс маань. Бэр гуйхад надад хань хамжаар болж яваа юм хэмээн палхийтэл хэлдэг байгаа.

Гэрийн сүүдэрт ижийнхээ хуучин даалимбан тэрлэгийн хуулгаар хамгийн отгон бүстэй дүүдээ дээл эсгэж суусан Хонгорзулыг аав нь сүртэй гэгч нь дуудахад зүрх нь нэг л хачин ёгхийгээд явчихсан нь тийм учиртай байж.

Бүсгүйг танихгүй, сүртэй олон улсаас цэрвэж, дөлсөөр гэрт ороход ижий нь ногоон даалимбан дээлийн хиртэй нударгаар нулимсаа арчин суух агаад, нэрмэлд халж царай улайсан аав нь:

-Охин минь чамайг хүүдээ авч өгөх гэж аавынх нь багын анд хадаг тавьж байна. Энэ

ахтайгаа золгож, ирсэн гийчдийн амрыг мэдээрэй гэжээ.

Хүний урманд нөхөр болох хүнийхээ барааг зүсийг ганц ч удаа үзээгүй ч “үгүй ээ, би хаашаа ч явахгүй, гэртээ үлдмээр байна” гээд хэлчих толгойгүй, дөнгөж арван зургаатай бүрэг жаахан бүсгүй чичирхийлсэн хоолойгоор ирсэн хүмүүстэй мэндэлж, хадам эцэг болох гэж буй харь хийцийн хилэн малгай, хөх чисчүү дээлтэй хүнд духаа өгөн золголоо.

-Нүдэндээ галтай охин байна. Дүүд минь сайн хань болох байх. Хүү, хүүхэн хоёрын билгэ дэмбэрэл хувь заяа бүрэлдэж, сайхан айл болохын төлөө худ ураг холбож хадаг тавин бэлэг хүргэж явна гэж хадмыг даган ирсэн дөчөөд насны махлаг бор авгай хэлээд зэс цартай идээ, борвитой архи гарган дээжийг нь галд нь өргөчихөв. Чингээд охины эцэг, эх, гадаа тоглож яваад орж ирсэн хоёр дүүгээс нь эхлээд сахалт айлын Дамба өвгөнд хүртэл хадаг, цай, мөсөн чихэр, дээлийн торго гэхчлэн бэлэг сэлт өгчээ.

Нэгэнт аав нь арван жилийн өмнө анддаа худ ураг бололцохын ам өгч, өнөөдөр бурхандаа тавьсан хадаг, барьж ирсэн идээ, бэлэг сэлтийг нь ийнхүү гар дэлгэн авсан тул Хонгорзул охин тэднийхээс есөн өртөө алсад байх мянгад айлын бэр болох зам нь шулуудсан билээ.

Хол нутгаас хадаг тавихаар ирээд хонон өнжин найрласан худууд сарын дараа сүй бэлэг хүргэж ирэхдээ хүргэнийг авчирна гэцгээгээд явахад “Таньж мэдэхгүй газар одож, ганц удаа нүүр учраагүй хүний эхнэр яаж болно доо. Нөхөр болох хүн минь хэр царайлаг эр бол? Ядаж л сайн хүн байгаасай даа...?” хэмээн бодоод тэр бодлоосоо ичин нүүр улайх Хонгорзул өдөр хоногийг бүү хурдан өнгөрөөсэй хэмээн зүрх алдан бэмбэгнэсээр дараа сартай нь золгожээ.

Хадмын талаас сураг чимээгүй л байлаа. Бүсгүй “Ингээд л намайг бэр буулгахаа больчихдог бол мөн сайхан аа” гэсэн шиг гэнэхэн юм бодож байтал нэг л өдөр гэнэт хөтөлгөө морьтой хоёр мянгад хар хүн “Бэрийн сүй хүргэхээр явна” гэсээр хүрээд иржээ.

Тэдний нэг, их дуутай шалхгар бор нь түрүүн хадаг тавихад ирсэн хүн гэдгийг бүсгүй хараад л танив. Нөгөөх нь жавхайсан биетэй, алаг нүдтэй, нуруулаг сайхан залуу байлаа.

Энэ хүн арай миний нөхөр биш байгаа даа хэмээн бүсгүйн сэтгэлд горьдлогын оч маналзсан ч:

-Хүргэн маань бэрийг мордуулах өдөр хадмындаа ирнэ. Энэ хархүү манай нутгийн нэртэй сайн бөхийн хүү, танай худгуйнхны талын хүүхэд байгаа юм гэж нөгөө их дуут хөлсөө урсган халуун цай ууж, ээжийнх нь тавьсан өрмийг хаман идэнгээ хэлсэн нь урмыг нь хугалчихаж билээ.

Хожим хадмындаа очсон хойноо мэдэхнээ мянгадууд өрөм загсаадаггүй учраас тэр сүй хүргэсэн хар хүн ээжийнх нь тавагласан өрмийг тийнхүү хомхойрон идэж байжээ.

Хадмын талаас ирсэн хоёр хүн цайлж, зуншлага, малын тарга тэвээрэг мэтийн тухай хэв ерийн хэдэн үг солиод, хөгшин хар хүн нь хуучин хилэн нударгаа буулган, мянгад тоорцгоо тэргүүндээ асааж хоолой засаад:

-Ээ, бид танай охины сүйд мянгад уламжлалын дагуу найман дээлийн торго, эмжээрийн арван ам хоргой, гутлын эсгий, тавин лангийн мөнгөн ембүү нэг, ижийд нь “экийн сүүний мал” нэг байдас өргөж байнаа гээд бэлгээ давхарлан өрж, сайр хадаг хэмээх хоёр үзүүрийнх нь цацагт бяцхан шүр сувд тэргүүтнийг уясан цэнхэр хадгийн хамт өргөснөөр Хонгорзул эгнэгт тэр айлын бэр болох нь зайлшгүй болж билээ.

Охиныхоо сүй бэлэгт ирсэн тэр жаахан эдийг үзээд аав нь нэг их идээд баршгүй эрдэнэс хүртэж буй мэт сандчин, хуучин сармай дээлийнхээ ханцуйг буулган, толгой дээрээ хиртэй цууямбуу алчуураа тавьж хоёр гардан авсан бол хөөрхий ижий нь аанай л галаа ухангаа нулимсаа арчиж суусан сан.

Сүй хүргэж ирсэн улс тэднийд өдөржин найрлаад унтсан хойно зочдын авчирсан ганзай архинд нам согтсон эцэг нь баруунтайх намхан модон орон дээгүүрээ унаад өгч билээ. Харин хөөрхий ижий нь охиныхоо өтгөн гэзгийг самнан суухдаа “Муу охиноо харь хол газар хадамд мордуулчихаад юугаа бодож суух хүн юм бол доо? Ганц мөнгөн ембүү, дээлийн хэдэн торгоноос охиноо өгчих гэж...Бүсгүй богино жолоотон бидний аль насандаа хийсэн үйлийн үр энэ юм бол...?” хэмээн шугшран уйлж сууж билээ.

Гал дээрх цай даргилан буцалж, гэрийн жавар хөөгдөн бүлээцэхэд бүсгүй хадмынхаа мөнгөн бүслүүрт том хар домбонд цайгий нь юүлж дуусахдаа санаандгүй хөлийнхөө шагай руугаа асгачихаад өвдсөндөө цочин хашгирлаа.

-Чимх нойр авахуулахгүй яах гээд хар өглөөгүүр хашгичаад байгаа заяагүй эм бэ! хэмээн нэхий хөнжил дотроос нөхрийнхөө зандчих дуунаар бүсгүй бондгосхийтэл цочиж, халуун цайнд шалзартал түлэгдсэн хөлийнхөө өвчинг тэвчин шүд зуун босч, хадмындаа цайг нь оруулж өгөхөөр гарлаа.

Буцлам халуун цайнд түлэгдсэн баруун хөлийнх нь шагай тэсэхийн эрхгүй хорсовч хадмындаа орж домботой цайгаа тавиад галыг нь сэргээж, хэдэн хөрзөн хийж дөнгөлөө. Тэгээд доголсоор гэр рүүгээ явж оронгуут эрэгнэгийнхээ өмнө өөрийн эрхгүй өвдөг нь нугаран суун туслаа.

...Мянгад заншлаар сүй хүргэсний дараахан, ”Бяруут хурим” гэж бага хурим хийж, сүинд өгөх малыг зургаан хүн, нэг бярууны хамт тууж очоод найрладаг ёстой ч нутаг хол, халх айлтай заншил ондоон тул тэр ёсыг алгасан шууд, хагас сарын дараа хүүхнээ мордуулахаар ирнэ гэж нөгөө их дуут хар хүн яриад сайхан залуугаа дагуулан одсон билээ.

Сүй тавьсан тэр өдрөөс хойшхи хэдхэн хоногт бүсгүй ижийнхээ дэргэд мартагдахын аргагүй нуруу тэнийн жаргаж дээ. Хөөрхий ижий нь холын газар хадамд мордох охиныхоо “ясыг амраана” гээд үхэр тугалд барагтай бол явуулахгүй, өрөмтэй шүүсэн тараг, ээзгий хольсон тос, борцтой мөөгтэй шөл гэхчлэн дуртай хоолыг нь хийж өгөн, өглөөд “миний охин дахин хэзээ ч бүтэн нойртой хонох юм билээ, хэвт хэвт” гээд дүү нарыг нь шуугиулахгүй гэж хөөн гаргаад л, унтаж байхад нь ирж магнайг нь сүү саалинд зөөлөрсөн гараараа илбээд л хичнээн сайхан байгаа вэ. Ижийнхээ тэр зөөлхөн гарыг санангуут ийнхүү хадмын гэрт, хар элгийн хүмүүсийн дунд хөлийн шагайгаа шалзалчихсан байхад нь “яав?” гэх хүнгүй суугаагаа санасан бэр бүсгүй нулимсаа барьж дийлсэнгүй. Хоёр хацры нь даган бөмбөрөх нулимсаа ч

арчилгүй гутлаа тайлан түлэгдсэн хөлөө үзэв. Буцлам халуун цайнд шал түлэгдсэн шагайны нь арьс зумарч, хуучин монгол гутлын эсгий оймсонд наалдсан нь салгахын аргагүй болсон байлаа. Тулганд аргалын гал асч, дулаахан гэрт нөхөр нь дугжирсаар л байлаа.

Хонгорзул арьс нь хуурч улаан нялга болсон хөлийнхөө шархыг эврээх санаатай ил гарган, аяга цай оочлон сууж байтал “Хөөе, Хонгорзул! Айлын бэр ухаантай юм бол аавынхаа морийг эмээллээдэх. Өглөө өрх татсан болоод, халуун хэвтгэртээ үд болтол буцаад хэвтэх нүү, энэ чинь?” гэх хадам ээжийн хахир дуугаар бүсгүй арьс нь хуурч нүд халтирам болсон хөлдөө ширүүн эсгий оймстой гутлаа өмсөнгүүт ухасхийн гарлаа.

...Элбэрэлт ижийнхээ дэргэд өнгөрөөх охин хонгор насны сүүлчийн өдрүүд хоромхоноо дуусч, тэртээгээс бөөн тэмээн ачаа, олон морьтнууд намрын эхэн сарын халуун өдрийн тэнгэрт тоос манаруулсаар нүүгэлтэн айсууг отгон дүү нь эхлэн харснаар бүсгүйн сэтгэлд түгшүүр дэлдэж билээ. Хадмын талынхан түүнийг мордуулахаар ирсэн нь тэр.

Арваад тэмээ хөтлөн, баахан архи, цагаан идээ, хятад пүүсний маатан чихэр, танзуур боов, ваартай архи, таван ханат гэр ачаалан ирсэн арав гаруй хүний түрүүнд хурдан буу үүрсэн, налчгар хамар, өтгөн хөмсөг, жижигхэн нүдтэй, хавчиг цээжтэй нүдэнд хүйтэн залуу ирсэн нь бүсгүйн нөхөр эцэнхий Дамбажав байсан юм. Хуримынхаа өдөр л тийнхүү анх нүүр тулан уулзсан эр нөхөр нь бүсгүйн сэтгэлд огтхон ч нийцсэнгүй.

Мянгад заншлаар бэрийн эцгийн гадаа нүүж очин, шинэ гэрээ барьж ”Хавчигийн найр”-наас эхлээд хэдэн өдөр найрласны эцэст, хүргэн хүү хадам эцгийн галд мөргөснөөр олон хоногийн тээртэй ёслол дуусч, хөөрхий бүсгүйн нүүрийг цагаан эдээр бүтээгээд сүй хүргэж ирсэн сайхан залуугийн эцэг “суйлдаг” Сугар хэмээх тэнхээтэй эрд дүүрүүлэн хөдлөхөд Хонгорзул “Ижий,аав аа!Намайг битгий явуулаач дээ” хэмээн зүрх зүсэм дуугаар чарлан уйлсаар мордож билээ...Харин тэдний муу уяан дээр нэгэн зээрд байдас нутгийн хүмүүстээ хоргодох шиг тогтож ядан үүрссээр хоцорсон нь хагас сарын өмнө бэрийн сүй бэлгэнд амлаж байсан “Экийн сүүний мал” нь байсан юм.

Хонгорзул шагайгаа түлснээ хэнд ч хэлсэнгүй. Түлэнхийн шархандаа шаналан, доголсоор буй бүсгүйн зовлонг доожоо муутай атал дээрэлхүү зантай нөхөр нь ч, хийсэн бүхнийг нь голж өдөржин хангинах хадам эх нь ч хүний урманд анзаарсангүй. Нэгэнт хүний хүмүүс хөөрхий бэр бүсгүйг гадаа гэртгүй л зарахаа мэдэх тул Хонгорзулд шалз түлэгдсэн хөлөө арчилж тойглон эмчлэх завдал ч үл гарна. Тийнхүү өглөө бүхэн босч гал түлэн, цай чанаж, хонины ээлжинд өдөр алгасалгүй явсаар хөөрхий бэр бүсгүйн шархтай шагай эдгэх нь бүү хэл улам ч идээлэн хүндэрсээр, нэг л өдөр шархны халуун болж халууран дэмийрч эхлэхэд л хадмынхан нь сандран үймэлдлээ.

“Хөлөө түлснээ хэлэхгүй яагаав?” хэмээн хадам эцэг нь бэрээ зандраад хойлгийн мах идүүлэн, хошуундаа зартай маарамбыг залан түлэнхийд сайн хятад эм тан өгч, хэд хоног хэвтүүлснээр бүсгүйг хазганаад ч болов явдаг болох үед нь цагаан сар дөхсөн байв.

Хонгорзул нэгэн өдөр багш ламдаа бараалхан ирэх жилийн өнгө, зүг чиг гаргах тухай асуухаар мордох гэж байсан хадам ааваасаа биеэ гайгүй болонгуут төрхөмөө эргээд ирж болох эсэхийг асуув.

Бүсгүйн хөлийн түлэнхийгээс болж бэрдээ санаа тавьсангүй хүйтэн хандлаа хэмээн яншаа авгайгаа зэмлэн, ёсолж авсан эхнэрээ халамжил гэж хүүгээ зандрах зэргээр өөрт нь хамгаас илүү халуун дулаан сэтгэл гаргаснаар нь хадам эцэгтээ л зүрхлэн ам нээж чадсан нь тэр.

Чонын арьсан зузаан хүрэм өмсөн дулаалаад мордох гэж байсан Балдан бичээч минжин малгай дороос хөөрхий бэрээ өрөвдсөн харцаар харсан боловч хоромхон зуур хөмсөг зангидсанаа ”Болохгүй ээ. Охин минь ёс ёмбогор, төр төмбөгөр. Хадамд гарсан бэр ирснээсээ хойш гурван өвлийн цас хайлж, төрхмөөсөө наашилсан мөр нь угаагдан арилтал эцгийн дээ очдоггүй номтой” гэхчээ яваад өгчээ.

Хонгорзулын хөлийн шарх хаврыг хүртэл бүрэн эдгэрсэнгүй. Бүсгүй хүний үйлийн үр дуусах биш. Цагаан сарын дараахнаас махан хоолны үнэр авахаараа огин, хонинд явахдаа үргэлжид нозоорон үүрэглэх болсон нь бие шалтгаантай болсных байжээ.

Бэрээ хөл хүндтэй болсныг хахир хатуу хадам эх нь анх ажиглан мэдмэгц, “Бие тулгар болсноо эртхэн хэлэхгүй яасан юм!” хэмээн Хонгорзулыг ханцуйгаараа нэг ороолгож авснаа, духан дээр үнсэж, орой нь нөхөр, хадам эцэг хоёрт нь дуулгаснаар гэр дүүрэн баяр хөөр болж билээ. Энэ нь хөөрхий бэр бүсгүйн хувьд хадам ээжээсээ халуун дулаан үг сонсч, хүн шиг үзэгдсэн анхны тохиолдол, хадамд гараад үзсэн хамгийн баярт өдөр нь байсан юм.

Цаст Алтайд хавар оройтдогийг хэлэх үү. Хаврын дунд сар гарсан ч үе үе цасаар шууран тэнгэр муухайрч, тасхийм жавартай салхиар ороолгодог нь хэвээр. Энэ өдрөөс хойш хэдхэн хоногийн дараа Хонгорзулын хонины ээлжтэй өдөр гэнэт цасан шамрага тавьж гарах нь тэр. Бүсгүй шуурга уруудан уулын уруу зүтгэх хонио хадны нөмөр бараадуулах санаатай морио давиран энд тэнд нь гарч хашгирч, гуугачин явтал нойтон цасанд норсон мөлгөр хаданд морь нь халтирч эзнээ хоромхон зуур эмээл дээрээс хийсгэн унагачихав. Дагзаараа хадны ирмэг мөргөсөн бүсгүйн ухаан балартжээ. Намрын ууланд татсан манан мэт ээдий бүүдий болсон ухаан санаа нь цэлмэх шиг болоход бүсгүй алсад хоцорсон төрсөн гэрээ олж харав. Ижий нь гэрийнхээ гадаа охиноо хараад инээмсэглэн зогсч, отгон дүү “Хонгороо эгч ээ!” гэсээр өөдөөс нь сөөсгөр үсээ хийсгэн гүйж явна. “Ижий! Миний дүү!” Гэрийнх нь тооноор аргалын шингэн цэнхэр утаа гарах нь тодхон үзэгдэнэ. Бэр бүсгүй ийнхүү амьсгал хураахын өмнө төрсөн гал голомт, хайрт ижий дүү нараа үзэн баясч, нүүрэндээ жаргалтай инээмсэглэл тодруулсаар алсын аяндаа оджээ.

Тээр орой болсон хойно нөхөр нь хадны ёроолд осгосон хөөрхий бүсгүйг олж авчрахад Хонгорзул хэдийнээ ертөнцөөс хальсан байлаа.

Гэтэл маргааш нь үүрээр уян дээр нь адуу үүрсэх шиг болоход нь давсагаа суллах гэж гарч явсан Балдан бичээч гайхан дуу алдав.

-Хөөе самгаан нөгөө “Экийн сүүний мал” нутгаадаа гүйгээд ирж гэм!” гэхэд бэрийн амьсгал хураасны дараахь уйт энэ өглөөний жаварт гал хөсөө асаах гэж тунтганаж байсан Мижидцоо тулганыхаа өмнө суугаа чигээрээ нулимс бөмбөрүүлэн мэгшиж “Хөөрхий бэр охин. Төрөл төрхөмдөө айлчилж, ижийдээ ганц үнэрлүүлж ч амжилгүй талийчихсан байтал нүүрэндээ үстэй энэ адгуус нутагтаа гүйгээд ирдэг. Ээ хөөрхий, ээ хөөрхий” хэмээн халаглаж байлаа.

Цэцгэн титэмт бүсгүй

Өгүүллэг

Дөрөвдүгээр сарын яруухан орой. Урьхан атал шогч салхин хавар авхайн олон аашийг илбэдэх мэт үе үес сэржигнэн үлээж, байгаль ертөнц баясгалант зуныг зүүдлэн зүүрмэглэх мэт.

Номин үсчин орохоор алхаж явлаа. Түүн шиг хорин гуравтай залуухан бүсгүйд ийнхүү ажлаа тараад хаврын сайхан орой зугаалж явах шиг сайхан юм юу байхав. Өөрийг нь таалан ширтэх эрчүүдийн харцыг мэдрэн дотроо сэтгэл баясна. Энэ хавар дэндүү эрт дулаарч, хотынхон яагаа ч үгүй хөнгөн нимгэн хувцсандаа оржээ. Номин энэ хаврын моод, богинохон ханцуйтай оготор цувныхаа хормойг хийсгэн тэв тэгшхэн шилбээ гялалзуулан алхсаар замын гарцан дээр ирлээ. Амжсангүй. Улаан гэрэл асчихлаа. Өдрийн ажлын ачаалал одоо л толгойд гарч байх шиг. Дагзандаа шууж хавчсан өтгөн үс нь тээртэйгээр арагш чангаагаад байх шиг. Бүсэлхий давсан урт гээг нь түүний бахархал. Гэхдээ төрөлхийн шулуун биш болохоор задгай тавья гэхээр баахан арчилгаа шаарддаг тул ажилдаа явахдаа ийнхүү дагзандаа хумиад тогтоочихдог юм. Цалингаасаа илүүчлэн хадгалсан мөнгөөрөө Номин энэ дуулгаваргүй, өтгөн үсэндаа шулуун хими хийлгэн бороо шиг намирсан гоё болгохоор үсчин рүү алхаж яваа нь энэ. Хаврын салхинд үсээ задгайлан цувны хормой дэрвүүлэн алхах сайхан шүү.

-Эгч ээ гоё уран зураг үзэх үү? гэх жаалхүүгийн дуу бодлыг нь тас дайрах нь тэр.

Номин эргэж ч харсангүй.

-Үгүй ээ хэмээн эрсхэн хэлэх мөчид ногоон гэрэл аслаа. Урдуур нь голын урсгал мэт хөвөрч асан олон өнгө загварын машинуудын цуваа шидэт дохиураар дохих шиг гэнэтхэн зогслоо.

Номинг урагшаа алхах гэтэл өнөөх жаал тохой дээрээс нь барин:

-Та ядаж энэ зургийг харчих л даа. Ямар гоё зураг гээч. Тан шиг соёлтой хүнд яг тохирно доо хэмээн салах янзгүй шаллаа.

“Яадаг нойтон хамуу гэгч вэ?” гэсэн ууртай бодол орж ирсэн ч хүн л юм хойно магтаалаас яаж буцахав, “Тан шиг соёлтой хүнд яг тохирно” гэсэн сүүлчийнх нь үгэнд уярсан уу яасан, уцаарласан мөртөө сонирхон эргэж харлаа. Хүмүүс зам гараад л байдаг. Удахгүй ахиад л улаан гэрэл асах гээд байдаг. Харваас цэвэрхэн хувцастай арван гурав, дөрөв орчим насны хүү томоохон, 35 инчийн зурагтын дэлгэцийн хэртэй боодолтой юм барин зогсох аж.

-Арай чиний бүтээл юм биш биз дээ? Эгч нь зураг авахгүй ээ гэнгүүт тэр ногоон гэрэл рүү хялсхийв. Хүүгийн нүд рүү ганц хараад л түүнд айдас төрчихжээ. Учир нь тэр хүү тийм жаахан мөртөө хүмүүсийн толгойг эргэтэл ятгаж, түрийвчийг нь сэгсэрч дөнгөдөг амьтан гэдэг нь ганц харцнаасаа илт мэдэгдэж байлаа.

-Алив, та юу ч гэсэн үзчих л дээ гээд хүү гарцны дэргэдээс ялимгүй холдон зогсоод

ях ийхийн зуургүй зургийн боодлыг задалж, зураг руу нэг, Номингийн нүд рүү нэг харж, шаргуу гэгч нь ээлжлэн ширтэнэ.

Ердийн л нэг сааралдуу жаазтай тэр зураг үнэхээр гайхамшиг байлаа. Яг л түүний хүсдэг шиг, бороо мэт намирсан гоё шулуун үсээ зүүн мөр рүүгээ унжуулаад, толгойдоо нил ягаан цэцгэн эрхи зүүж, хагас нүцгэн цээжин дээрээ хоёр гараараа нэг л эрхэмсгээр зөрүүлсэн залуу бүсгүйн хөрөг. Ийм танхил бүсгүйд арай ширүүдсэн гэмээр харцтай хурц нүд нь хаашаа ч харсан дагуулах мэт өөдөөс цоо ширтэнэ. Ард нь салхивч нь нээлттэй, борооны дусал ганц нэгээрээ урсах том цонх. Борооны дуслууд юу юугүй цонхны шилийг даган доош урсаж буй мэт...

Бүсгүй гэнэт сэхээ оров. Тэр зургийг ширтэн зогсох хэдхэн хоромд үсчин орох гэж яваагаа, хариугүй асах гэж байгаа улаан гэрлээс урьтан зам гарах хэмээн яарч явснаа тас умартан нил ягаан цэцгэн титэмт гоо бүсгүйн ертөнцөд түрхэн зуур очоод саатчих мэт болсноо сэхээрэв.

-Энэ чинь тэгээд ямар үнэтэй юм? хэмээн асуухдаа “Авчих ч юм шиг. Эмэгтэй хүний саваагүй зантайг ээ” хэмээн өөрийгөө дооглож амжлаа.

-Аймаар хямдхан. Зуун мянга.

-Надад бол аймаар үнэтэй л юм байна. Арай зуун мянган доллар юм биш биз дээ? Эгч нь зуун жилийн дараа ч тийм их мөнгөтэй болохгүй байх даа гээд тэр замын гэрэл рүү хяламхийлээ. Аль хэдийн улаан гэрэл асчээ.

-Эгч ээ. Авчихаач. Одоо хивсний оронд хүмүүс гэртээ зураг өлгөдөг болсон ш дээ. Ийм гоё зураг зуухан мянгаар танд дахиад хэзээ ч олдохгүй дээ гэж хэлэхдээ хүү нэг их ятгаагүй юм шиг янз гаргаж чадаж байгааг Номин гайхаж байв.

“Нээрээ энэ зургийг аваад өрөөндөө өлгөчихвөл өнгө ороод л явчина даа. За байз, ноднин ангийн багшдаа энэнээс онцгүй зургийг таван зуун мянгаар авч өгч байл уу? Нээрээ хямдхан юм гээч. Өрөөндөө энэ зургийг өлгөчихвөл Нараагийн нүд орой дээрээ гарч, Мягаа намайг баян ивээн тэтгэгчтэй болоо юу? гэнэ биз”. Номин нэг л мэдэхэд түрийвчээ гарган байгаа зуун мянган төгрөгөө хүүд өгч байлаа. Хэдэн мөчийн дараа цаасанд ороолттой том зураг сугавчилсаар байрныхаа гадаа таксинаас буухдаа тэр өөрийгөө солиороогүй гэхэд эргэлзэж л байлаа. Үсэндээ хими хийлгэх нь ингээд өнгөрчээ. Гэхдээ зүгээр нэг хими хийлгэхийн оронд хожим нь зарвал авсан үнээ хэд ч нугалж болох ийм гоё уран зургийн эзэн боллоо шүү дээ гэсэн бодол сэтгэлийг нь өег тэнэгэр болгох аж. Цаг дөнгөж долоо болох гэж байлаа. Хоёр найз нь ирээгүй биз. Түлхүүрээ гаргая байз. Номин найз охидтойгоо хамт хоёр өрөө байр хөлсөлж суугаад жил гаруй болж байгаа юм. Мягаа тэр хоёр Эрдэнэтийн охид учраас их хотод толгой хоргодох орон зайлшгүй хэрэгтэй байсан бол Нараа хотод гэртэй боломжийн айлын хүүхэд. Түүний хувьд эцэг эхээсээ тусдаа амьдрах хүсэлдээ хөтлөгдөн хоёр найзтайгаа хамт байр хөлсөлсөн хэрэг. Түрийвчний хэмжээ бүхнийг тодорхойлдог ертөнцийн жамаар гэх үү дээ Мягаа арай зайтай гал тогооны өрөөг мөнгө гарган унтлагынх болгон янзлаад өөрийн болгож, уужуу саруулхан том өрөөнд нь Нараа төвхнөж, хамгийн жижигхэн мухрын өрөө сонголтгүйгээр Номинд оногдсон юм. Дөнгөж л сургуулиа төгсч цалингийн бараа харах гэж байгаа түүнд өрөөгөө тохижуулах бэл бэнчин ч байсангүйг хэлэх үү, өрөөнийх нь ханын цаас

хариугүй өнгө муутай цайвар бор өнгөтэйг ч хэлэх үү. Ахынхаа илүүчилсэн ханын хуучин цагийг орныхоо эсрэг талд хадаж, цонхондоо тод шар хөшиг өлгөж гэгээ оруулахыг оролдсон ч шинэ диван, зөөлөн тоглоомууд, ганган хөшигтэй хоёр найзынх нь өрөөний хажууд тэднийх өрөвдмөөр даржин харагддаг юм. Уг нь бүсгүй хадгаламжиндаа бага сага нөөцтэй ч гэсэн хэзээ нэгэн цагт орхиод нүүн одох хөлсний өрөөг тохижуулахын төлөө ганц ч төгрөг гаргахыг хүсээгүй. Түүний мэргэжил нь санхүүч учраас ч тийм тооцоотой юм биш, ердөө л Номин эрт бие дааж, мөнгөний үнэ цэнийг ухаарсан болохоор үргүй зардал гаргаж чаддаггүйнх билээ.

Тааварласан ёсоор нь тэднийд хэн ч байсангүй.Нараа, Билгүүн хоёр хүнс цуглуулж, Мягаа гадаадад сурдаг найз залуутайгаа интернетээр чааталж байгаа биз. Номин цуваа өлгөсөн ч үгүй өрөөндөө өнөө зургаа барин орж, ханын цагнахаа оронд өлгөөд сайн харахын тулд нэг алхам ухрав. Үнэхээр гайхалтай! Орных нь залгаа хананд байх цонхноос тусах гэрэл нил ягаан цэцгэн титэмт бүсгүйн хөрөгт ташуу тусч, шар хөшгөөр дамжин орж ирэх дулаахан шаргал гэгээ догшин нүднийх нь харцыг арай ээвэргүү зөөлөн болгох шиг.Энэ зураг түүний бүүдгэр даржин өрөөнд тэс өөр ертөнцийн гэмээр шинэ өнгө нэмж , илүү уужуухан тохилог ч юм шиг харагдуулах нь урлагийн ид шид юм болов уу даа.

Удалгүй Нараа найз залуугаа дагуулан баахан уут савтай хүнс авчран хөргөгчөө дүүргэж байгаа болтой гялгар уут сав шажигнан, тас няс хийж байснаа шал арчингаа Номингийн өрөөний хажуугаар өнгөрөхдөө:

-Чи чинь үсээ янзлуулна гээд байсан юун эрт хүрээд ирсийн? гэж хаалганы цаанаас бувгнав.

-Тэр мөнгөөрөө өөр юм авчихгүй юу.

-Үгүй байлгүй.Мягаа байсан бол өөр хэрэг.Чи хэзээ тэгж төлөвлөөгүй юманд мөнгөө үрдэг болчоов гэснээ шагайж:

-Юу вэ?Чи чинь саятан болчихсон юм уу? Хөөе хайр аа, чи Номиогийн өрөөнд юу байгааг хар даа хэмээн сүр бадруулснаа орж ирэн, зургийн өмнө очиж гараараа амаа даран шогширч гарав. Түүний найз залуу Билгүүн ч орж ирэн нөгөө зургийг баахан шагширч хэдээр авсныг нь шалгаалаа. Номин тэр зургийг зуун мянгаар авсан гэдгээ хичнээн баталсан ч тэр хоёрыг итгүүлж дөнгөсөнгүй.

-Зо боль доо.Манай ангийнхан хонхны баяраар багшид зүгээр нэг байгалийн зураг авч өгөхөд дөрвөн зуун мянгаас буухгүй байсан. Ийм зураг яаж ганцхан зуун мянга байдгийн хэмээн Билгүүн мэтгэж, Нараа “Өөрөөгөө тохижуулах мөнгө алга энэ тэр гээд байсан. Ийм үнэтэй юм авах бэлтэй л байсан байгаам даа” гэнэ.

Оройхон Мягаа ирээд зургий нь дув дуугүй бохь зажлан харж байснаа гарахдаа” Найз аа чи баян “нууц”-тай болоо юу?” гэлээ.

Долоо хоног өнгөрөв. Хачирхалтай нь шөнө нойрон дунд нь өрөөн дотуур нь хүн яваад ч байх шиг хувцас сүрчигнэх, орны нь дэргэдэх түмбүүшигний татуургаар оролдоод ч байх шиг барин тавин юм сонсогдон Номин нэг л тавгүй унтах болов. ...Тэр нэгэн өглөө яагаад ч юм

бүсгүй ажилтай гэдгээ мартсан юм шиг таг унтсаар гэнэт сэрвэл найм дөч болж байлаа. Толгой нь ер бусын хөнгөхөн болчихсон мэт санагдан орноосоо хурдан гэгч нь өндийлөө. Нөгөө хоёр нь ажилдаа гарцгааж байгаа бололтой цоож дуугарах завсар Нараа:

-Энэ Номин ажилдаа явахгүй юм байх даа. Хоцорчлоо ш дээ гэхэд

Мягаа:

-Өвчтэй гээд пялж байгаа юм биш үү? Ер нь цаадхи чинь сүүлийн үед бид хоёроос нуух юм ихтэй болоод байх шигээ гэх дуулдав.

“Яагаад ингэж таг унтчихав аа, би.Ойрдоо нойр муутай байснаас л боллоо гэж бүсгүй бодоод сурсан зангаараа үсээ илэх гэтэл өм өм хяргасан мулзан толгой баригдав. Энэ чинь юу болж байнаа! Бүсгүй угаалгын өрөөнд гүйн орж толинд харангуут цочсондоо “Ээж ээ!” хэмээн бархираад толинд туссан нүд халтирам дүрээсээ айж нүдээ анив. Айж хийрдхийсэн нүд, өнөө сайхан гэзгийг нь өм цөм хяргаад хаячихсан хавчиг толгой...Бахархал болсон сайхан гэзгийг нь хэн нэгэн нойрон дунд нь тарлан хуйх болтол нь хяргаад хаячихсан байх нь тэр..

Энэ чинь юу болж байнаа?Үсий минь хэн ингэчихдэг байна? Өрөөндөө гүйн орвол орных нь өмнө цаасны ногоон иштэй жижигхэн хайч нь гэмт хэргийн ул мөр болон хэвтэж байх юм. Бүслэхий давсан урт сайхан гэзэг нь хаачив?

Ороо нааш нь татаж хармаар санагдаад явчихлаа. Татлаа. Орных нь араар шал, шалны хөвөөн дээгүүр хайчилж хаясан үс нь эзэндээ гомдоллох мэт асгаран байж байлаа. Бүсгүй шалаар нэг харлан хөглөрөх үсээ харж нэг хэсэгтээ ухаангүй мэт мэнэрэн суулаа. Хоолой нь хатах шиг болоход ус уух санаатай дахин угаалгын өрөө рүү гарахдаа өнөө зураг руу халти харсан чинь зураг дээрх гоё хүүхний догшин нүд зөөлрөн доогтой ч юм шиг мишээж байх шиг санагдахад нуруугаар нь хүйт оргиж шурдхийн гарч хаалгаа тас хийтэл хаалаа. Айсан зүрх нь дэлссээр л. Тэгээд шилэн аягаар ус дүүргэн залгилах гээд чадсангүй. Шилэн аяганы амсрыг шүдээрээ тажигнуулан чичирсээр л байв.

Тэр өдөр Номин ажилдаа явж чадсангүй. Хоёр найз нь орой ирээд болсон явдлын учрыг олъё гэхээсээ өмнө Номинг сэтгэл зүйч эмчид очихыг зөвлөхөөс өөр яаж ч чадсангүй ээ.Мэдээж ямар эрүүл саруул хүн шөнө босч үсээ хяргасан мөртөө өглөө нь түүнийгээ санахгүй байхав дээ.

Маргааш нь бүсгүй урт гэгчийн хиймэл үс олж зүүгээд ажилдаа явлаа. Хиймэл үс зүүх гэдэг хүсээд байхаар эд биш юм гээч. Урин дулаан цаг ирж байгааг хэлэх үү, хиймэл үс нь зузаан ноосон малгай өмчихсөн юм шиг халууцуулан толгой халуу оргиж, хүзүү хөшнө. Орой бушуухан гэртээ харьж гайтай хиймэл үсээ толгой дээрээсээ авч хаяхын түүс. Гэртээ ирээд гайтай тэр үсийг ширэлдүүлэхгүй арчлах гэж бөөн ажил болно. Шөнө хааяа санамсаргүй сэрэхэд ширээний чийдэнд тохсон хиймэл үс нь хэн нэгэн хүүхний тасарсан толгой шиг аймаар харагдана. Номин нөгөө цаасны хайчийг хог руу хаяж сэтгэл амарчээ.Түүнийг өөрийн мэдэлгүй үсээ хяргаж хаяснаас хойш долоо хоногийн дараа. Нэгэн өглөө хамгийн орой босдог Мягаагийн өрөөнөөс “Ээж ээ! Миний үс...” гэсэн дуу хадаад явчихлаа.

-Яасан бэ? гэсээр Номинг өрөө рүү нь очиход Мягаа яг өөрийнх шиг нь өм цөм хяргаж хаясан мулзан толгойгоо тэврэн :

-Чи зайлаач ээ. Нараа наад галзуугаа аваач ээ.Түргэн дууд, түргэн дууд.Билгүүн ээ, наад галзуугаа надаас холдуулаач хэмээн хашгирч байлаа. Орных нь өмнөх хивсэн дээр түүний богинохон шаргал үс бөөн бөөнөөрөө хөглөрөн хэвтэнэ.

Хэн ч Номингийн тайлбар үгийг сонсохыг хүссэнгүй. Ердөө хагас цагийн дараа Сэтгэцийн эмнэлгийн машин давхин ирж түүнийг бядтай хоёр эрэгтэй сувилагч хоёр талаас нь сугадан машин руугаа чихээд давхин одох нь тэр.

Эмнэлэгт Номинг нэгэн залуухан эмэгтэй эмч үзэн, хэсэг ярилцсанаа урт ханцуйтай номхотгогч цамц өмсгөн ганцааранг нь нэг өрөөнд оруулчихав. Үе үе түүнд мансуурдаг тариа хийнэ. Цонхондоо тортой, ор, сандал, ширээний хөлийг шаланд суулгаж бэхэлсэн тэг дөрвөлжин жижигхэн гэгчийн энэ өрөөнд удах юм бол хүн жинхэнээсээ галзуурах биз. Гар утас, компьютер, зурагт байхгүй гав ганцаараа өнгөрүүлсэн энэ хэдэн хоног түүнд дэндүү аймшигтай байлаа. Болж буй явдлын учрыг олох гэж Номин ганцаараа толгойгоо гашилтал бодсоор тав хонолоо. Нэгэн өдөр Номинг эмч нарын комиссоор оруулаад онош тогтоож чадсангүй, дахин долоо хоног хэвтүүлэхээр болов. “Үс хяргадаг хүүхэн. Шизофрений нэг төрөл байж болох юм...” эмч нарын нэг нь ингэж хэлдэг байгаа.”Нээрээ би шизофрени тэй юм болов уу?” Аав, ээж хоёрт битгий дуулгаарай гэж уржигдар Нараад хэлүүлсэн юм сан. Үдээс хойш түүнийг арай уужуухан дөрвөн ортой өрөөнд оруулав. Хачирхалтай нь тэр өрөөний нэг орон дээр Мягаа хэвтэж байв. Харин нөгөө хоёр ор нь эзэнгүй ажээ. Өөр шиг нь мансуурдаг тариа хийлгэнээс нүд нь хялалзан хэвтэх урт ханцуйтай саарал галзуугийн цамц өмссөн мулзан толгойтой хүүхнийг харангуут анхандаа тэр багын найзыгаа таньсангүй. Мягаа бол богинохон тайрсан шаргал үс, том цагирган ээмэг, заавал ямар нэгэн гялалзаж гялтгасан саатай ч юм уу, чимэглэлтэй бусдаас онцгой чамин хувцас өмсдөг ганган бүсгүй. Гэтэл сэтгэцийн эмнэлэгт ийнхүү мансуурдаг тариа хийлгээд нүд нь цэхэлзэн хэвтэх, номхотгогч саарал цамц өмссөн мулзан толгойтой нүд халтирам амьтан болчих гэж. “За нөгөөх чинь Нараагийн үсийг хяргачихсан байх нь” гэсэн бодол толгойд нь орж ирэв.

-За, үс хяргадаг хүүхнүүд.Чи уйдаад байсан хүн, найзтайгаа ханьтай байж бай даа гэж нэг асрагч хэлээд хаалгы нь цоожиллоо. Оройдоо Мягаа тариа нь гарч, овоо ухаан орчихсон босч ирэв.

-Би халзан болчихсон чинь ой гутмаар муухай харагдаж байгаа биз?

-Гайгүй л байна ш д.

-Чи миний үсийг хяргаагүй юм байна, тээ?Найз нь одоо л ойлголоо.

-Цаадхи чинь яаж байна?

-Нараа юу?Яах вэ дээ.Үсээ хяргуулсан хүн яадаг билээ, хашгирч цамнаж гарахгүй юу.

-Мулзан толгой зохиж байна уу?

-Нээх том нүүр л болчихсон ш дээ. Нараа үсрээд гурав хоногийн дараа л энд хүрээд ирнэ, харж л байгаарай. Билгүүний гельтэй таван хялгасыг хайчлаад...гээд тэр яриагаа дуусгалгүй хорсолтойгоор тас тас хөхрөнө.

-Инээх яах вэ. Бид гуравтай ер нь юу тохиолдоод байна? Чи юу гэж бодож байна? гэхэд Мягаа дуугарсангүй. Болоод байгаа явдлын учрыг олох өчүүхэн ч хүсэл түүнд байхгүй нь илт. Харин Номин энэ учир битүүлэг явдлуудыг эргэцүүлэн бодсоор байлаа.

Гэвч Нарааг гурав хоног хүлээх хэрэг байсангүй. Нөгөөдөр нь Нарааг оруулж ирэв.

Мөн л тайвшруулах хүчтэй тариандаа мансууран, орон дээрээ ухаангүй хэвтэх найз руугаа харан “Мань хүн Билгүүнийээ үсийг хяргачихжээ” гэж Номин, Мягаа хоёр ярилцаж суулаа. Махлаг биерхүү Нараа үсгүй болж, будаг шунхаа арилгачихсан чинь бүсгүй хүн гэхээсээ цэвэрхэн царайтай хал цэргэрхүү л харагдах аж. Тортой цонхны цаанаас оройн нарны сүүлчийн туяа мэдэгдэх төдий тусч байх үеэр Нараа ухаан орлоо.

-Чи хайртынхаа гельдсэн ганган толгойг мулзалчихсан уу? гэж Мягааг асуухад орон дээрээ өвдгөө тэврэн гөлрөх Нараа дуугарсангүй. Мягаа Номин руу нүд ирмэлээ.

-Чиний тэр балай зурагнаас л хамаг юм болж байна гэж Нараа гэнэт хэлэв.

Түүнийг одоо хүртэл цочролоосоо гараагүй юм байх гэж таамаглаж байтал гэнэт ийм үг хэлсэн нь Номинг мэл гайхахад хүргэв.

-Зураг яасан гэж?

-Яахав дээ. Чи үсээ нээх гоё болгоно гэж яриад л байсан. Тэгээд хими хийлгэнэ гэж яваад тийм хачин зураг аваад ирсэн биз дээ? Тэр хүүхний зургийг ханандаа өлгөөд хэдхэн хоногийн дараа л хамгийн анх чи үсээ юу ч үгүй хяргаад хаячихсан. Дараа нь Мягаа үсгүй болсон. Өөрийнхөө үсийг хайчилсан юм чинь чамайг л галзуураад Мягаагийн үсийг хусчихлаа гэж бид анх бодоцгоосон. Тэгтэл чамайг галзуугийн эмнэлэг рүү явуулсан хойно миний үс ийм болчихсон. Мягааг л чиний хойноос солиорчлоо гэж бодсон чинь би Билгүүний үсийг хайчлах гээд ээжийн хуучин үйлийн хайчийг бариад явж байсан гэж байгаа юм. Би тэрний үсийг хайчлаад яахав дээ. Би зүүдэндээ тэр...чиний зурагны хүүхэн хайч барьчихсан Билгүүний ор руу гэтэж явахыг харсан байхгүй юу. Тэгээд хүүеэ чи болиоч гэх гэсэн чинь Билгүүн “Нараа чи яаж байнаа!” гээд миний гарыг барьчихсан хашгирч байсан.

-Чи тэр зургийн хүүхнийг зүүдлээд босч явсан хэрэг үү? Хачин юм байна даа. Хайчлахын хувьд бол чи хайчлах гээд л явж байгаад үйлдэл дээрээ баригдсан юм биш үү? гэж Мягааг мөчөөрхөхөд Нараа түүний үгийг тоосон ч үгүй. Инженер хүн гэсэндээ ямарваа юмыг учир шалтгааны талаас нь бодон тунгаахдаа Нараа гаргуун билээ.

-Нээрээ, энэ бүхэн тэр зургийг авснаас хойш л болоод байгаа юм байна шүү. Бодоод байхнаа, миний өрөөнд хүн яваад ч байх шиг хачин чимээ гараад байдаг болсон. Та хоёрт энэ тухай хэлэх гэснээ үнэмшихгүй байх гээд больчихсон юм. Тэгээд, тэгээд л би үсээ хайчилчихсан байсан...Хамгийн хачирхалтай нь яагаад тэр зурагнаас болж хүн үс гэзгээрээ

оролдоод байдаг байнаа? хэмээн Номин өөртэйгээ ярих шиг өгүүлэв.

-Ер нь ямар ёр нь хатгахаараа чи хамаг мөнгөөрөө тийм зураг авдаг байнаа?Надад анхнаасаа л тэр хүүхний чинь харц нь нэг л аймаар амьд юм шиг санагдаад байсан юм аа гэж Мягаа хэлэв.

-Намайг үсгүй болсноос хойш нүд нь бүүр баярлаад байгаа юм шиг болчихсон байсан шүү гэж Номинг хэлэхэд:

-Нүд нь ч нээрээ эвгүй шүү хэмээн Нарая дуугарч билээ. Ямар ч гэсэн энэ бүх хачирхалтай явдал тэр уран зурагтай холбоотой гэдэгт гурван найз санал нэгджээ.

Эмнэлгээс хамгийн түрүүнд Номин гарлаа. Тэр гэртээ ирэнгүүт нөгөө зураг руу харсан ч үгүй шууд, хананаасаа авч, цаасанд боон аваад гарах гэснээ зүүн өнцгийг нь эвтэйхэн гаргаж зураачийн гарын үсгийг харах санаа төрөв.

“О.Чулуунсүх 1999 он” гэж гаргагдах төдий таталгажээ. Зургийг таньдаг хүнийхээ гараашид хадгалуулаад бүсгүй ажлаасаа чөлөө авч, зураачдын урлангаар эргэлдэн “Цэцгэн титэмт” бүсгүйг зурсан зураачийн эрэлд гарав. Эхлээд зураач нь өвчтэй гэсэн сураг дуулдаж байснаа Германд үзэсгэлэнгээ гаргах гээд явчихсан байлаа. Энэ хооронд хоёр найз нь ч эмнэлгээс гарч ирэв. Номингийн өнөөх зургийг хананаасаа авч хаяснаар өрөө нь хуучин шигээ тохь муутай атал нэг л сэтгэлд дулаан санагдах болжээ. Гурвуулангийнх нь мулзан толгойд үс нь өрвийн ургаж эхлэх үеэр бүсгүй Чулуунсүх зураачийг урлангийнхаа умгар өрөөндөө байхад нь олж уулзлаа. Тэр нь торгон хантааз өмссөн, өндөр янхигар биетэй, зөөлөн харцтай туранхай хүн байв.

Бүсгүйг өнөөх зургийн тухай цухуйлгамагц царай нь хүрлийн харц нь төвөгшөөнгүй болж:

-За, бас л тэр зургийн тухайд явна уу? Уг нь овоо хэл ам татлахгүй удсан юм сан гэлээ.

Зураг дээрх бүсгүй хэн юм бэ? гэдэг л Номинд хамгийн чухал байлаа.

Зураачийн яриа

-Би сайн мэдэхгүй ээ. Санамсаргүй тохиолдлоор тэр бүсгүйтэй танилцаж хөргийг нь зурсан юм. Миний дүү охинд хуримын даашинз урлаж өгсийн гэсэн. Дүүгийн хурим болох гээд би тэр оёдлын газар нь очиж дүүгээ авахдаа тэр бүсгүйг анх харсан юм. Нүд, үс хоёр нь онцгой харагдсан болохоор нь натурт сууж хөргөө зуруулаач гэж би гуйсан ухаантай юм. Миний урланд хоёрхон удаа л ирж зуруулсан. Чийгтэй мойл шиг, нэг хурц болоод л нэг зөөлрөөд л байдаг тас хар нүдтэй. Үс нь нэг л гоё усны урсгал шиг...Ер нь хараад л баймаар гоё мөртөө, цаанаа хачин гуниг зовлонтой ч юм шиг хачин охин байсан л даа. Би зовж байж наадхийг чинь зурсан. Дуусангуут нь нэг баян нөхөр авсийн. Хэзээ хойно дүүгээсээ нөгөө охиныг нас барсан гэж дуулсан. Гэтэл энэ зургийг авсан нөхөр гэнэт гарч ирээд, хэл ам татлаад л яваад байхаар нь буцааж аваад мөнгий нь эргүүлээд өгчихсөн. Эхнэр хүүхэд нь үс мүсээ хяргаад байна гэхээр нь би эхэндээ үнэмшээгүй юм. Сүүлд нь энүүнийг гэртээ авчирч охиндоо өгсөн чинь миний охин бас үсээ хяргачихсан...Тэхээр нь би зусландаа аваачаад

орхичихлоо. Гэтэл зуслангийн байшинд маань хулгай орж, гайтай зураг ашгүй нэг нүднээс далдарсан юм. Ёртой зураг л даа. Сүүлд сонсохнээ тэр толгой дээрх титэмнийх нь цэцгийг хараалч цэцэг гэдгийн гэнэ лээ. Би бэрцэцэг л гэж бодож зурсан ухаантай. Тэрнээс болсон ч юм уу, мэдэхгүй ээ.

Би Чулуунсүх зураачийн охин дүүтэй уулзаж зураг дээрх бүсгүйн тухай лавлалаа. Хоёр нялх хүүхэдтэй, харваас жаргалтай гэрийн эзэгтэй гэдэг нь илт цайлган нүдтэй тэр бүсгүй миний асуух гэсэн зүйлийг дуулаад гуниглачихав. Зураг дээрх бүсгүйн нэр нь Танан, ослоор нас бараад удаж байгаа гэнэ. Би сурагласаар яваад талийгч бүсгүйн ээжтэй уулзав. Охиных нь хөргийг судалж буй урлагийн сургуулийн оюутан хэмээн тэр эхэд би худал хэлэхээс аргагүй байлаа.

Цэцгэн титэмт бүсгүйн ээжийн яриа

-Миний охин уу? Нас бараад долоон жил болж байна, хөөрхий. Богино настай амьтан болоод тийм сайхан, бас уран гартай төрсөн юм болов уу даа. Тийм, тийм. Нэг зураачаар хөргөө зуруулж байна гээд хэд хэдэн удаа гэртээ оройтож ирсэн юм даг. Би ч дургүй л байсан. Өөрөө зовлонгоо мартахад нь хэрэгтэй байсан юм болов уу даа. Охин маань багадаа галд өртсөнөөс болж, огт үсгүй болчихсон юм шүү дээ. Тананг дөнгөж ой өнгөрч байхад нь манай гэрт гал авалцаад толгойтой үс нь юу ч үгүй шатчихсан юм. Үсий нь ургуулах гэж би үзүүлээгүй эмч, яваагүй газар байхгүй. Хуйх нь атиралдаж үрчийгээд голын хатсан сайр, суваг шуудуу шиг л аймаар харагддаг сан, хөөрхий. Дандаа толгойдоо хиймэл үс зүүж, түүнээсээ халууцаж, хөөрч, тархи толгой нь өвддөг, хүн мэдэхгүй л болохоос их зовсон амьтан байсан даа. Үерхэж байсан хархүү нь хиймэл үсээ авахад нь мулзан толгойг нь хараад л голчихсон гэдгийн... Тэгээд л тэсээгүй. Машин доогуур өөрөө гүйгээд орчихсон...

Ингэж хамаг учир тайлагдав. “цэцгэн титэмт бүсгүй”... галд өртсөнөөс хожгор болж, хожим нь амиа хорлосон бүсгүйн хөрөг байжээ. Номин тэр хөрөгнөөс үүрд салахаар шийдэв.

Номингийн яриа

-Ингээд Нараа, Мягаа бид гурав такси хөлслөн Гоодойн зуслан руу гарч ойн захад нөгөө зургийг шатаалаа. Ажил тараад гурвуулаа нийлж, хотын зах руу явах гэсээр байтал долоо өнгөрчихсөн байлаа. Наран үүлний цаагуур орж, тэнгэр бүүдийгээд салхи үе үе зөөлөн үлээсэн тавдугаар сарын дулаахан орой. Бид гурав зураг дээрх золгүй гоо бүсгүйн нүд рүү харж чадсангүй. Зөөлөн сэвшээ салхинд хөгжих галын дөл дунд бүсгүйн хиймэл үс нь хийсэх ч шиг... аймаар харагдана. Бид гурав гурвуулаа богинохон пинтүү үстэй болохоор салхинд хийсээд байх үс гэзэг үгүй амар ч юм шиг. Сэвэлзэх салхинд гал дорхиноо дүрэлзэн асч, эхлээд зургийн зузаан саарал жааз, бүсгүйн гоо цагаан цээжний хэсэг хамгийн түрүүнд шатаж алга болов. Яагаад ч юм галын догшин дөл хүртэл хүүхний өнөөх хиймэл намирсан үс, хурц хар нүдийг шатааж дийлэхгүй байх шиг хамгийн сүүлд нүд, үс нь шатсан шүү. Зургийг бүрэн шатаж дууссан хойно шингэн цэнхэр утаа нь агаарт замхран алга болохын өмнө урт сайхан гэзэг намируулсан бүсгүйн дүрсийг үзүүлээд аажмаар замхран арилж билээ. Хачин юм шүү. Бид “Цэцгэн титэмт бүсгүй”-н зургийг шатаасан тэр газар руу эргэн харсан ч үгүй хот руу давхин одлоо.



Цэцэгсийн ертөнц дэх би...

Дэндүү гоё сайхан юмыг дүрслэх гэхэд үгийн ертөнц шавхагдах үе олон бий. Түүнтэй адил цэцэгсийн тухай бичих гэтэл үгийн хүч хүрэлцэхгүй байх шиг санагдах юм.

Энэ хорвоог өөртөө нээх гэсэн уртын урт аяны эхэнд зогсч асан балчирхан надад байгалийн бүтээсэн түмэн гайхамшгийн нэг болсон уулын цэцэгс хосгүй гоо сайхны анхны мэдрэмж таашаалыг өгч билээ. Хоёр гурван настай л байсан байх даа, би аавтайгаа ууланд гарч балжингарма цэцгийн гоёыг гайхан багсайтал түүж харьснаас эхлээд гартаа балын харандаа барихтай болонгуут л дөрөв таван дэлбээтэй ур муутайхан цэцэг зурах болсноос хойш өнөөг хүртэл цэцэгсийн тансаг ертөнцтэй би танилцсаар л явна.

“Аав нь Болгарт сарнайн үзэсгэлэн үзсэн. Урьд өмнө төсөөлж ч байгаагүй олон төрлийн гоё гоё сарнайн төрлүүд байдаг юм. Гэхдээ таримал цэцэг хичнээн үзэсгэлэнтэй ч гэсэн ууланд ургаж байгаа зэрлэг цэцэг бүхэн өөр, өөрийнхөөрөө өвөрмац гоё байдаг юм. Та нарын эмийн ургамал гээд түүгээд байдаг тарваган шийрийн цэцэг, энэ шар будаан чинээ бяцхан дэлбээтэй цэнхэр цэцэг хүртэл сайн харвал бүгдээрээ л гоё байдаг. ..” гээд бэр цэцгийн домгийг аав надад ярьж өгч байсан нь огт мартагддаггүй. Түүнээс хойш зэрлэг цэцгийн нэр, домгийг энд тэндээс сонирхон асуух дуртай болсон нь энэ эрхэмсэг ертөнцийн нууцад татагдахад хүргэсэн юм.

Миний багад цэцэг худалдан авья гэхэд хэцүү, дал,наяад оны Улаанбаатарт ганц нэгхэн цэцгийн дэлгүүр байсан гэж ярихаар охид минь гайхаад байдаг юм. Ямар сайндаа л 19 жилийн өмнө ууган охиноо төрөхөд нөхөр минь надад өгөх цэцэг хайсаар, эцэст нь

дөрөвдүгээр цахилгаан станцын тэндэх хүлэмж рүү очин байж арслангийн нүд,башир цэцгийн холимог баглаа арай гэж олж байхав дээ.

Эдүгээ манай хотод цэцгийн дэлгүүр олширч, харьцангуй олон өнгийн сарнай, цахирмаа, хонгорзул, алтанзул, сараана гээд нэр төрөл нь ч баялаг болсноор сонголт илүү сайжирч, хүмүүс нэг нэгэндээ цэцэг бэлэглэх соёл ч улам дэлгэрч байгаа нь үнэхээр сайн хэрэг.

Миний хамгийн дуртай цэцэг сараана. Ганцхан ширхэг сараана усанд хийгээд өрөөндөө хонуулахад л өглөө нь анхилам зөөлөн үнэрээр тасалгааг дүүргэсэн байдагт нь ч биш. Энэ цэцгийн үгээр өгүүлшгүй ялдам, эрхэмсэг гоо сайханд нь л би татагддаг. Цэцэг хүнд ямар их гоо сайхны таашаал, бусад эд зүйлтэй харьцуулшгүй эрхэм дээд мэдрэмж төрүүлж аз жаргал бэлэглэдгийг би нэгэн удаа номын баярынхаа дараа л урьд урьдынхаас илүү ойлгосон юм. Хэд хэдэн ном хэвлүүлсэн ч номын нээлтээ хийж амжаагүй явсан би “Хулан” туужийнхаа 5 дах удаагийн хэвлэлтийн үеэр “Интерном” дэлгүүрийнхний санаачилгаар анх удаа баяр хийж, орой нь машины тээшний хэсэгт багтахаргүй хэдэн тэвэр цэцэгтэй харьсан юм. Хэдийгээр надад сэтгэл харамгүй тусалсан дэлгүүрийн эрхлэгч Цэрэннадмид эгч, өөрийнхөө жолооч, туслах, болон охин дүүдээ хүртэл цэцгийн баглаанаасаа бэлэглэсэн ч надад зөндөө их цэцэг үлдсэн байлаа.

Тэр үдэш би цэцгийн баглаануудаа задлан өнгө, нэр төрлөөр нь ялган гэртээ байдаг бүх л ваар сав, шилэнд хийсээр бараг үүр цайх гэж байхад унтахдаа чимх ч ядраагүй юм шиг санагдаж билээ. Гэтэл тийм оройтож унтсан гэхэд өглөө нь хачин сэргэг, нэг л баяр хөөртэй сэргж, цонхон дээр тавиастай цагаан, ягаан, шар сараана цэцэгсийг харангуут зүрх сэтгэл нэг л хөнгөхөн аз жаргалаар дүүрэх шиг болж ялдамхан анхилам үнэрт нь тархи улам сэргээд ирэв. Тэгээд зочдын өрөөнийхөө үүдэнд ирэнгүүт өөрийн эрхгүй баярлан дуу алдсан юм. Библийн сударт гардаг диваажингийн цэцэрлэг л ийм байсан болов уу гэмээр сэтгүүлийн ширээ, төгөлдөр хуур, тавиур, цонхны тавцангаар дүүрэн цэцэгс...

Гэтэл саяхан хоёр бага охиндоо зориулан 9-р сарын нэгэнд багш, захирлуудад нь өгөх хэдэн баглаа цэцэг аваад усанд хийж хонолоо. Маргааш өглөө нь эртлэн босоцгоож цэцэгнүүдээ аваад хоёр охиныхоо хоёр өөр сургуулийн хичээлийн шинэ жилийн баярт очихоор яаран гарцгаахдаа миний хайртай ваарнууд цэцэггүй болж хоосрон хоцрохыг үзэхдээ л өөртөө үлдээх ганц цэцэг авдаг байж гэж түрийвчээ гээчихсэн хүн шиг л харамсан бодож билээ. Тэгээд сургууль дээр нь очин охиноо багшдаа цэцэг өгөхийг харан зогсох зуур багш нар 9-р сарын 1-ний орой тэвэрт багтахгүй их цэцэгтэй гэртээ харихдаа яг л миний номын нээлт хийсэн тэр үдшийнх шиг ер бусын аз жаргалыг мэдэрдэг байх даа гэж үл ялиг атаархан бодсон.

Цэцэг гэдэг үнэхээр гайхамшиг. Саяхнаас зүгээр нэг цэцгийн сайхныг бахдахаас илүү домгуудыг нь бас эрж хайн цуглуулах болсноо уншигчидтайгаа хуваалцахаар шийдсэн юм. Цэцэгсийн домгийг цуглуулах тусам янз бүрийн үндэстэн,ард түмний соёл, зан заншил, билэгдэл, шашин шүтлэгтэй хүртэл холбогдон улам сонирхол татах юм билээ.

Ингээд цэцэгсийн ертөнцийн гайхамшгаас тантай хуваалцъя.



Мөнхийн хайрын билгэдэл

Цагаан уул

Цагаан уул цэцгийг францчууд Альпийн од хэмээдэг. Италид хадан дундах мөнгөн цэцэг гэж нэрлэдэг. *Leontopodium* гэсэн латин нэр нь арслангийн савар гэсэн утгатай. Харин Грекчүүд цагаан уулыг Прометейн цэцэг гэлцдэг. Хүнд гал хулгайлан аваачиж өгснийхөө төлөө хаданд цовдлуулсан Прометейг цээрлүүлсэн элгэн хадны хормойгоор цагаан уул ургасан байсан гэж грек домогт өгүүлдэг. Европчууд энэ цэцгийг үнэнч хайр дурлал, эрэлхэг баатарлаг үйлсийн билгэдэл гэж үздэг юм.

Харин эргэх дөрвөн цагийн эргэлтэнд өнгө нь огт ганддаггүй энэ цэцгийг монголчууд “Үхэшгүй мөнхийн” цагаан уул цэцэг гэдэг. Цусны даралт бууруулдаг тул энэ цэцгийг түүж хатаан дэр хийвэл сайн гэж дуулаад би багадаа бүтэн зунжин цагаан уул түүж хатаасаар эмээдээ дэр хийж өгч байж билээ. Тэвэр тэврээр нь түүн нарны илч буурах үеэр сонин дээр дэлгэн хатаасны дараа өнөө их цэцэгнээс ганц сайн атгын чинээ л юм үлддэг сэн. Ингэсээр Ар согоотын зуслангийн нэг энгэрийн бараг бүх цагаан уул цэцгийг хатааж байж жижигхэн дэр хийж эмээдээ өгөхөд нүдэнд нь нулимс цийлэгнэн магнай хагартал баярлаж байсан ч өнөөх дэрээ дэрлэж байгаа нь харагдахгүй л байлаа. Хожим мэдвэл эмээ маань тархины даралттай төрсөн үеэл дүүд маань тэр дэрээ өгчихсөн байсан юм.

Одоо хот орчимд энэ цэцэг урьдынх шиг тийм элбэг байхаа больсон байна лээ.

Цагаан уул Альпийн, Сибирийн гэж хэд хэдэн төрөл байдаг. Манайд байгаа нь сибирийнх нь төрөл бөгөөд Алтайн уулсаар ургахдаа тогоон чинээ баг болон буталж, бөөн бөөнөөрөө өвдөгцөө өндөр ургадгийг ноднин аавынхаа нутаг Говь-Алтайд явж байхдаа өөртөө нээсэн юм. Тийм болохоор Алтайд ургадаг цагаан уул хангайнхаас илүү үзэсгэлэнтэй санагдсан.

Европын соёлд бол, хүн хүрэхэд хэцүү өндөр ууланд ургадаг Альпийн төрөлтэй нь холбож, дурлалт залуус болзоот бүсгүйдээ хэцүү бэрхийг үл хайхран энэ цэцгийг авчран бэлэглэвэл үнэнч хайртайн илэрхийлэл гэж үздэг.

Уулын нэгэн ард түмний хэлэлцдэг домгоор бол хоёр биедээ оломгүй сэтгэлтэй хос залууст ханилан суух хувь дутжээ. Бие биенээ л үгүй бол амьдрах хүсэлгүй амрагууд гар гараа атгалцан халил өндөр хаднаас үсэрсэн гэдэг. Хаднаас үсэрсэн хос залуус газарт унахдаа үзэсгэлэнт цагаан уул цэцэг болон ургажээ.

Цагаан уул цэцгийн тухай бас нэгэн сайхан домгийг өгүүлье. Эрт урьд цагт энэ хорвоо дээр дөнгөж л өвөл зуны хоёр улирал ээлжлэн ирдэг болоод байсан цагт холын холд орших нэгэн хаант улсад хаан хатан хоёр үзэсгэлэнт гүнжийн хамт амьдардаг байсан юм санж. Урьд хожид дуулдаагүй гоо үзэсгэлэнтэй төрсөн гүнжид сүй тавихаар олон хаан хөвгүүд, хөлөг баатрууд ирсэн ч бүсгүйд хэн ч таалагдсангүй татгалзсаар байлаа.

-Надад үзэсгэлэнт цагаан уул цэцэг авчирсан хунтайжтай л би гэрлэнэ хэмээн гүнж хэлдэг байжээ.

Гүнжийн хэлсэн энэ болзол холын холд, мянган уулын цаадтайх улс гүрнүүдээр тарсаар, тэр ховор гайхамшигт цэцгийн эрэлд эрэлхэг баатрууд, хунтайж нар мордоцгоосоор байлаа.

Сарьдаг өндөр уулын оройд ургадаг тэр цэцгийн байгаа газарт хүн очих зам ердөө байсангүй. Хунтайж нарын замд элгэн халил хад дүнхийнэ. Цагаан уул цэцгийн хойноос уул өөд явсан зарим эр хараа цуцам өндөр элгэн хаданд авирахаас зүрхшин буцаж, зарим хунтайж үзэсгэлэнт гүнжийн хайр дурлалын төлөө сарьдаг өндөр хад руу мацаж байгаад хөл алдан үхэж, зарим нь ч буцаж ирээд өөр бүсгүйтэй гэрлэцгээж байв.

Элгэн хадаар хүрээлэгдсэн ноён оргилд цагаан уул цэцэг жилээс жилд улам хараа булаам гоёмсог болон ургасаар л байлаа.

Гэтэл нэгэн цөс ихтэй омог бардам залуу эр зориг зүрхээ сорьж үзэхээр шийдэн ховор үзэсгэлэнт цагаануул цэцгийг авчрахаар замд гарав.

Тэр залуу олон олон сар явсаар цагаан уул цэцгийг хүрээлсэн өндөр байц хаданд хүрчээ. Залуу хүү тэр халил хаданд авирахаас өчүүхэн ч зүрхшээсэнгүй. Зүрх сэтгэл нь ариухан, эрэлхэг зоригтой тэр залууг азын тэнгэр ивээж гэнэ. Хувцас хунараа урж, гар хөлөө шалбарахыг эс тоон авирсаар элгэн хадыг даван сарьдаг өндөр оргилд гарч үзэмж төгөлдөр цагаан уул цэцгэнд хүрч чаджээ.

Сүрлэг хадан уулын оройд ургасан тэр цэцэг эмзэг турьхан хайр хүрмээр харагдаж байлаа. Залуу хүслэн болсон цэцгээ аваад буцан замд гарчээ. Буух зам нь авирахаас хэд дахин бэрх байв. Элгэн халил хаднууд эмзэг турьхан цэцгээ хэнд ч алдахыг эс хүснэ. Эгц өндөр хад гишгэх бүрд нурж, бутран хөл гар нь халтирч, өтгөн бутнууд хайр найргүй шилбүүрдэн, ширүүн салхи нүүр нүдгүй шуурч, шатам халуун нар зулай дээрээс нь цоононо. Бүхий л бие нь шарх сорви, шалбархайгаар дүүрч, гар хуруунд нь цус шүүрсэн ч залуу эр гагцхүү үзэсгэлэн төгс гүнжийн тухай бодлоор сэтгэлээ тэжээн түмэн бэрхшээлийг даван туулж чаджээ. Эцэст нь эр зориг, сайхан сэтгэлийг бурхан ямагт ивээдэг тул эрэлхэг залуу ховор үзэсгэлэнт цэцгээ аваад элгэн хаднаас эсэн мэнд бууж чадав. Ингээд цагаан уул цэцгээ барьсаар хааны ордонд очжээ.

-Үзэсгэлэнт гүнж минь! Чиний хүслэн болсон тэр цэцгийг тань авчирлаа хэмээн залуу хэлэв гэнэ.

-Чи миний чин хүслийг гүйцээж чадсан цорын ганц эр. Зориг баатарлаг эр минь би чиний гэргий больё гэж гүнж өчив.

Гэвч залуу хүү таггалзсан гэдэг. Учир нь үзэсгэлэнт гүнж цагаан уул цэцэг авчирч өгөх зоригт эрээ хүлээсээр хэдийнээ өтөл эмгэн болсон байлаа. Зоригт залуу хааны ордныг орхиж адал явдал хайн дахин холын замд гарчээ. Дараа дараагийн хүнд бэрх аянд нь ч түүнийг азын тэнгэр ивээсэн гэдэг. Хосгүй ховор цагаан уул цэцгэнд хүрч чадсан хүнийг хэзээ ч азын тэнгэр орхидоггүй гэлцдэг. Хэрэв хэн нэгэн эр зүрхний хайртай бүсгүйдээ цагаан уул цэцэг бэлэглэх юм бол түүний зүрх өнө мөнхөд тэр залууг хайрладаг ажээ. Энэ бол европ соёлд түгээмэл байдаг домог.

Баян худалдаачны алтан зоос

Жамьянмядаг цэцэг болон таржээ

Зуны эхэн сард ойд хэдхэн хоног цэцэглээд хагдран унадаг гал мэт улаан шаргал өнгөтэй Жамьянмядаг хэмээх үзэсгэлэнт цэцэг бий. Тавдугаар сарын эцсээр цэцэглэн хорвоод ердөө л хориодхон хоног амьдарч, хөхөөн дуутай уралдан хагдардаг энэ цэцэг сарнайтай төстэй, одон бөмбөгний чинээ том болон дэлбээлж, өвдөгцөө өндөр ургадаг нь үнэхээр нүд булаам. Ойн цоорхойн нов ногоон өвсөн дунд бөөн бөөн Жамьянмядаг дэлгэрсэн нь галын дөл асах мэт цог жавхлан төгөлдөр харагддаг юм.

Миний хувьд хээрийн зэрлэг цэцэгсээс хамгийн дуртай нь Жамьянмядаг. Жилийн жилд зуны эхэн сард энэ цэцгийг хагдрахаас нь өмнө ойд очиж амжвал би тэр зундаа л сэтгэл өөдрөг явдаг. Энэ зун Нүхтийн амралтанд очиж ойн чөлөөнд алтан хивс дэлгэсэн мэт үзэсгэлэнтэйгээр дэлгэрсэн Жамьянмядаг цэцэгс дундуур алхаж, гар утсандаа зургийг нь авч хадгалсан. Хориодхон хоногт хагдран оддог энэ цэцэг надад залуу нас мөнх бус, гоо үзэсгэлэн ахархан хугацаанд гунддагийг сануулах мэт санагддаг юм.

Европын хойд талаас Оросын Сибирь, Якут, Алс дорнод, Монголд тархан ургадаг Trollius хэмээх энэ цэцэг нь латинаар аяга, дугуй сав гэсэн утгатай. Хойд Америк, Канадад бас энэ цэцгийн бусад төрөл нь ургадаг.

Сибирийн сарнай ч гэж нэрлэдэг энэг гоёмсог цэцгийн тухай нэгэн орос домгийг хуучилъя.

Эрт урьд цагт нэгэн асар баян худалдаачин гоо үзэмж төгс ганц охинтой байж гэнэ. Охин нь оюун ухаан төгс, ариун сэтгэлт, нэгэн сайхан залууд дурлажээ. Гэвч охиных нь дурлалт залуу баян худалдаачны сэтгэлд огтоос нийцсэнгүй. Учир нь мань баян охиноо өөр шигээ чинээлэг худалдаачны хүүд их сүй бэлгээр өгөхийг хүсдэг юм санж. Гэтэл охин нь хөрөнгө мөнгөгүй, даржин ядуу залууд дурласныг мэдээд гэрлүүлэхээс татгалзаж, төлөөсөнд нь асар их эд баялгаа охиндоо өгч гэнэ.

Сэтгэл зүрхний хайрттайгаа хуримлан жаргаж чадахгүйдээ гунигласан бүсгүй эцгийнхээ авдар дүүрэн алтан зоосыг хээр талд аваачин тарааж цацсан нь галын дөл мэт улбар шаргал Жамьянмядаг цэцэг болон дэлгэрсэн юм гэдэг.



Итгэл найдварын билгэдэл

Яргуй

Монголчууд цэнхэр яргуйг хаврын билгэдэл гэж үздэг. Латинаар Galanthus англиар snowdrop гэдэг энэ цэцэг хөх цэнхэр, цагаан хоёр янз өнгөтэй, нийт 12-18 төрөл байдаг.

Европын орнуудад ургадаг яргуй цэцгийн төрлүүд 12 дугаар сараас гурав, дөрөвдүгээр сард цэцэглэдэг байна.

Европын соёлд яргуй цэцэг итгэл найдварын билгэдэл юм. Загалмайн шашны эртний домогт өгүүлснээр хүн төрөлхтний дээд өвөг Адам, Ева хоёр диваажингийн цэцэрлэгээс хөөгдөхөд яргуй цэцэг итгэл найдварын биелэл болон дэлгэрсэн гэдэг.

Өвөлгүй зунаараа, өлсөх даарах аюулгүй диваажингийн цэцэрлэгээс хөөгдөн өвлийн тэсгим хүйтэнд даарч дагжсан Евагийн өмнө тэнгэрийн элч үзэгдэн цасыг хайлуулж яргуй болгоод урин хаврыг билгэдэн түүнд бэлэглэсэн домогтой.



Хосгүй гоо үзэсгэлэнг билгэддэг

Нарцисс

Нарцисс цэцэг хосгүй гоо үзэсгэлэнг билгэддэг. Зургаан дэлбээтэй, голдоо давхар гоёмсог титэмтэй энэ цэцэгний латин нэр нь яруу найргийн нарцисс. Гурав, дөрөвдүгээр сард бүхнээс эртлэн цэцэглэдэг нарцисс хурц хүчтэй үнэртэй.

Эртний грекчүүдийн дунд Нарциссын домог элбэг байдаг.

Нэгэн халуун өдөр Нарцисс хэмээх залуу эр ойн цоорхой дахь тунгалаг горхиноос ус уухаар очив гэнэ. Тэр горхины усанд туссан өөрийнхөө дүрийг хараад мэл гайхан ус уухаа ч мартав. Учир нь өөрийнх нь царай түүнд хосгүй сайхан харагдсан юм санж. Үүнээс хойш Нарцисс өглөө бүр өнөөх горхины хөвөөнд ирж, усанд туссан дүрээ ширтэн суух болов. Ингэсээр хөөрхий Нарцисс өөрийнхөө дүрд дурлан нойр хоолноосоо ч гарчээ. Нэг л мэдэхэд сайхан залуу Нарцисс хаашаа ч юм сураггүй алга болж, нөгөө горхиных нь хөвөөгөөр цасан цагаан өнгөтэй үзэмжит цэцэгс ургасан гэдэг. Энэ цэцгийг тэр цагаас хойш Нарцисс хэмээн нэрлэсэн домог буй.

Үүнээс хойш хэтэрхий биеэ тоосон хүмүүнийг “Нарцисс шиг” гэж зүйрлэдэг өвөрмөц хэлц үүссэн нь европын уран зохиолд элбэг тохиолдоно.

Өөр нэгэн домгоор бол Нарцисс тэнгэрт хальсан хайрт эгчийнхээ дүрийг олж харах гэж байнга горхи руу очдог байж. Нэгэн удаа хөөрхий залуу эгчээ санан дурссан уй гунигаа дийлэлгүй горхины усанд унаж үхжээ. Тиймээс грекчүүд Нарциссыг уй гашуу, үхлийн цэцэг ч гэдэг.

Гэхдээ мэдээж, ард түмэн бүхэнд энэ цэцэг өөр өөр билгэдэл илэрхийлдэг.

Хятадууд шинэ он гарахад гэрээ шар нарциссаар чимэглэдэг. Нэн ялангуяа Гуанжоу мужид шилэн саванд суулгасан шар нарцисс цэцгийг хуучин оноо үдэхэд хэрэглэдэг байна.

Харин эртний Ромчууд дайн тулаанд ялсан баатруудаа шар нарцисс цэцэгтэй угтаж, толгойд нь энэ цэцгээр хэлхсэн титэм зүүж алдаршуулдаг заншилтай.

Прусст нарцисс хайр дурлал, азтай гэрлэлтийн билгэ тэмдэг байжээ. Шинэ бэр эцгийн гэрээс нарцисс авчран тарина. Хэрэв түүний шинэ гэртээ тарьсан цэцэг нь сайхан ургавал залуу хос аз жаргалтай гэр бүл болж чадна гэж үздэг байв.

Харин Швейцарид тавдугаар сарын эхний ням гаригт нарцисс цэцгийн баяр болдог. Энэ баяраар байшингуудыг өнгийн туг, дарцгаар чимэглэн, айлууд гэрийнхээ хаалганд энэ цэцгээр хийсэн хэлхээ зүүдэг.

Зэрлэг нарцисс газрын дундад тэнгис, Хойд Карпатын хэсэг, Альпийн нам дор газар ургана. Ер нь энэ үзэсгэлэнт цэцэг далайн түвшнээс 200 м-ээс нам дор газар ургадаг.

Гэрийн нөхцөлд хүйтэн цаг ууртай бүсэд ч сайн ургадаг тул нарцисс цэцэрлэгчид, цэцэг сонирхогчдын шохоорхдог ургамал юм.

Туркт хэрэв хоёр талхтай бол нэгийг нь худалдаад нарцисс цэцэг ав.Талх ходоод баясгадаг бол нарцисс сэтгэл баясгадаг хэмээн ярьдаг.

Агуу Шекспир нарцисс цэцэгт дуртай байж. Тиймээс “Буря” хэмээх эмгэнэлт жүжгэндээ энэ цэцгийн тухай өгүүлсэн байдаг.

И.С.Тургеневын хамгийн хайртай цэцэг нь нарцисс байв. Тэрээр 1867 онд нэгэн блиц асуултанд хариулахдаа “Таны хамгийн хайртай цэцэг?” гэсэн асуултанд “нарцисс” хэмээн хариулсан нь тэмдэглэлийн дэвтэрт нь үлджээ.



Цэцэгсийн хаан

Сарнай

Ялдам гоо үзэсгэлэн, ер бусын анхилам үнэрт сарнайг цэцэгсийн хаан гэдэг. Дэлхийн ихэнх үндэстэн сарнайн тухай үлгэр, домог зохиож, гоо үзэсгэлэнг нь биширсээр иржээ.

Эртний Энэтхэгт хаанд бараалхахдаа сарнайн баглаа аваачиж өргөсөн хүний хүслийг заавал биелүүлдэг байж. Энэтхэгийн дээд угсаат бярмангууд сүм дуганаа энэ эрхэмсэг гоо цэцгээр чимж, бие барсан хааны цогцсыг сарнайгаар хучин, шашны ёслол үйлдэхдээ бурхадын замд сарнайн дэлбээ асгадаг байв.

Энэтхэгийн нэгэн домогт өгүүлснээр энэ ертөнцийн бүсгүйчүүд дундаас хамгийн гоо үзэсгэлэнтэй төрсөн Лакшми хүүхэн сарнайн цоморлиг дундаас мэндэлсэн гэнэ. Тэгтэл энэ ертөнцийн дээд эзэн Вишну тэнгэр сарнайн өлгийндоо нойрсон буй нүд гялбам гоо Лакшмиг үзээд үнсэлтээрээ сэрээж улмаар гэргийгээ болгон авчээ. Түүнээс хойш Лакшми гоо үзсгэлэнгийн тэнгэр болон өргөмжлөгдөж, сарнай цэцэг түүний газрын бус тэнгэрлэг гоо сайхны билгэдэл болсон гэдэг.

Харин эртний Персийн яруу найрагчид сарнай цэцгийн гоо үзэсгэлэнг магтан дуулахдаа цуцдаггүй байсан гэнэ. Эртний иранчуудын үздэгээр сарнай нь Аллах тэнгэрээс газарт заяасан бэлэг ажээ. Нэгэн удаа ертөнцийн бүх цэцэгс Аллах тэнгэрээс цэцэгсийн хаан Бадамлянхуагийн оронд шинэ тэргүүн сонгож өгөхийг хүсчээ. Учир нь цэцэг цэцэгсийн дунд Бадмлянхуа гоо үзэмжээрээ хосгүй ч хааны үүргээ умартаад байдаг гэнэ.

Аллах тэнгэр цэцэгсийн хүслэнг сонсч соёрхоод шинэ хатан хаанаар нь хурц өргөстэй ч нүд булаам гоёмсог цагаан сарнайг сонгожээ. Алтан гургалдай шувуу цэцэгсийн шинэ хатан хааныг үзээд гоо үзэсгэлэнд нь соронзон мэт татагдан догдолсондоо түүнийг цээжиндээ наан тэвэрч гэнэ. Гэтэл сарнайн хурц өргөс нь хөөрхий гургалдайн зүрхийг нэвт хатгаж час улаан цус нь дэлбээ рүү гоожжээ. Ингэж гургалдайн цусанд будагдсанаар сарнайн дэлбээ цасан цагаан биш ягаан, улаан улаан хүрэн туяатай болсон юм гэнэ.

Грекчүүд сарнайг бурханы хишигт тооцдог. Грек домгоор бол сарнай нь гоо үзэсгэлэнгийн охин тэнгэр Афродитаг тэнгисээс гарч ирэхэд биеийг нь бүрхсэн цасан цагаан хөөснөөс мэндэлсэн ажгуу. Энэ үзэмж төгөлдөр шинэ цэцгийг харсан бурхад сайхныг нь бахадсандаа анхилам шүүсээр шүршсэн нь сарнайг тансаг үнэртэй болгосон гэнэ.

Афродита охин тэнгэрийн тайлгач нар цагаан сарнайгаар шүтээний ширээ, тахилын өргөө, ариун нандин цэцэрлэгээ чимжээ. Гэвч Афродитагийн дурлалт эр Адонисыг зэрлэг бодон хүндээр шархдуулах хүртэл сарнай гагцхүү цагаан өнгөтэй байсан гэдэг. Хайрт Адонисыгаа шархадсаныг дуулаад түүнийхээ хэвтэж байсан Пифоны шугуй руу Афродита хөлийн хурдаар гүйхдээ битүү ургасан сарнай мандлыг туучиж яваагаа ч анзаарсангүй. Сарнай ишний хурц өргөсүүд үзэсгэлэнт Афродитагийн булбарай хөлийг шалбалан дэлбээ нь цусанд будагдсаар байжээ. Ийнхүү цагаан сарнай тэр цагаас хойш улбар, ягаан, улаан өнгөтэй болсон гэдэг.

Грекчүүд сарнайг баяр цэнгэл, уй гашуудлын ёслолдоо аль алинд нь хэрэглэдэг. Сарнай титмийг залуухан сүйт бүсгүйн тэргүүнд зүүж, хуримлагч хосын явах замд дэлбээг нь зулдаг заншилтай.

Мөн энэ цэцгээр талийгаачийн цогцос, авсны доторхийг ариулах ёс ч бий.

Дайн тулаанд ялсан баатрын эргэн ирэх замд бас сарнай дэвсдэг.

Грекчүүд шашны ёслолын үеэр бурхадын тэргүүнд сарнай титэм асааж, хөл дор нь энэ цэцгийг тавьдаг.

Сарнайтай холбоотой билгэдэл, зан үйл Грекээс эртний Ромын соёлд нэвтэрчээ. Грект сарнай нь бурхадын хайр дурлал, гоо үзэсгэлэнгийн билгэдэл байхад хүмүүст баяр цэнгэл, уй гашуудлын аль алиных нь илэрхийлэл болж байлаа.

Харин ромчуудын хувьд цэцэгсийн хаан сарнай цэвэр ариун ёс суртахууны билэг тэмдэг, гавьяат үйлсийн билгэдэл байв.

Эртний Мисирийн домогт Клеопатра хатан хаан Марк Антонийг хүлээн авахдаа танхимын шалаар битүү сарнай дэвсэхийг тушааж байжээ. Тэгээд эрэлхэг жанжинд өгсөн хайр сэтгэлийнхээ үнэнчийг үзүүлэхийн тулд тэргүүндээ зүүсэн сарнай титэм рүүгээ үхлийн аюулт хор шүршив гэнэ. Үзэсгэлэнт хатан хааныг үзэн сэтгэл догдолсон Антоний Клеопатрад ойртон хайрын үгээ хэлэх гэтэл хүүхний титэмний сарнай дэлбээнээс хор дуслан цомтой дарсыг нь хордуулчихжээ. Энэхэн агшинд Клеопатра дарстай цомыг нь булаан авч:

-Харж байна уу, Антоний?, чамайг энэ ертөнцийн данснаас хасах нь миний хувьд гарын алга урвуулахаас амархан байсныг. Гэвч би чамгүйгээр амьдрах хүсэл алга даа гээд хортой дарсыг өрөвдөлт нэгэн боолд уулгахад золгүй тэр амьтан газар дээрээ үхэдхийн унасан гэсэн домог бий.

Ромчууд тулаанд мордохдоо дуулгаа түр зуур тайлж, сарнай титэм зүүдэг байж. Энэ нь ромчууд сарнайг эр зоригийн билэг тэмдэгт тооцдог байсных юм.

Ер нь европын соёлд энэ гайхамшигт цэцэгтэй холбоотой домог, билэгдэл, зан үйл, баяр ёслол, хэлц үгс тоймгүй их бий.

Германы зураачид бурханы эх гэгээн Мариаг гартаа нялх хүүхэд тэврэн, сарнай гурван өнгөт

титэм агссанаар дүрсэлдэг. Цагаан сарнай нь түүний баяр баясгалан, улаан нь эдэлсэн зовлон, шар нь яруу алдрыг нь билгэддэг учиртай.

Католик шашны домогт сарнайг сайн үйлийн ивээгч гэж дүрсэлдэг. Дундад зууны үеэс эхлэн Ромын пап дээд буян үйлдсэн, сайн үйлс бүтээсэн хүнийг үнэт эрдэнэс шигтгэсэн алтан сарнайгаар шагнадаг уламжлал тогтжээ.

Францчууд сарнай цэцгэнд нэн хүндэтгэлтэй ханддаг.Тиймээс дээр цагт хүссэн бүхэнд сарнай түгээхийг зөвшөөрдөггүй байжээ.

Дундад зууны Англид хаан ширээний төлөөх тэмцэлд сарнай онцгой билгэдэл илэрхийлж байсан удаатай.

Английн хаан ширээ булаалдагч хоёр өрсөлдөгчийн нэг Ланкастерийн 6-р Генрих сүлдэндээ цагаан, Йоркширийн Эдуард улаан сарнай дүрсэлжээ. Ингээд энэ хоёр удмын дунд хаан ширээний төлөө гучин жил үргэлжилсэн цуст тэмцэл “улаан, цагаан сарнайн дайн” хэмээн түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн юм.Түүгээр ч зогсохгүй английн цэцэрлэгчид нэгэн онцгой төрлийн “Ланкастер-Йоркшир” хэмээх сарнай гарган авсан нь нэг бутанд улаан ба цагаан сарнай нэгэн зэрэг цэцэглэдэг ажгуу.

Германы 3-р Фридрих Вилгельм сарнайд онцгой дурладаг байв.Тэр Потсдам дахь ордондоо тэр үед гаргаж аваад байсан сарнайн бүх л төрлийг цуглуулсан “Тогосын арал” хэмээх гайхамшигт цэцгийн хүрээлэн байгуулж байжээ.

1829 онд энэ сарнайн цэцэрлэгт Пруссын Шарлотта гүнж Оросын хаан Николай Павловичтай сүй тавих ёслол үйлдсэн гэдэг. Гүнжийг Орос руу хадамд гарсан өдөр нь Германд сүр жавхлан төгс сарнайн баяр хийжээ.

Орост 1-р Петр хааны үед сарнай дэлгэрч хатан хаан 2-р Екатринагийн үед оросууд энэ цэцэгт онцгой дурлах болжээ.



Сараана

\лилия\

Цэцэгсийн ертөнцийг шатар гэвэл сарнай ноён, үзэсгэлэнт сараана цэцэг лавтай бэрс баймаар санагддаг юм. Сараана цэцгийн тоймгүй олон төрлийг байгаль эх болон цэцэрлэгчид бүтээсэн ч цагаан сараана хамгийн онцгой нь юм. Лилия гэдэг нь ч эртний грекээр цав цагаан гэсэн утгатай үг ажгуу.

Гайхамшигт цагаан сараана цэцэг нь цэвэр ариун байдлын билгэдэл юм. Европын соёлд хуримын бэр цагаан даашинзаар гоёдогчлон сарааныг бэрийн цэцэг ч гэж нэрийддэг.

Энэ цэцэг бурхадын эх Юнонагийн сүүнээс ургасан гэж эртний грекийн нэгэн домогт өгүүлдэг. Фива хотын хатан хаан эх нь нялх Херкулес хүүгээ Юнонагийн хилэнт харцнаас нуужээ. Гэтэл Юнона тэр нялзрай хүүг олж хараад тэнгэр бурхадаас сурвалжтайг нь мэдэж сүү өгчээ. Гэвч нярай Херкулес түүний хорон санааг зөнгөөрөө мэдээд өгсөн сүүг нь түлхэж асгаснаар тэнгэрт Сүүн зам буюу тэнгэрийн заадас үүссэн юм гэдэг. Харин асгарсан сүүний хэдхэн дусал газарт унаж цагаан лилия болон ургасан ажээ.

Эртний грекчүүд энэ домгийг зохиохоос ч өмнө эртний персийн нийслэлийг Суза хот гэдэг байсан нь сараана цэцгийн хот гэсэн үг.

Ариун журамт байдлыг цагаан сараана цэцгээр билгэддэг заншил эртний иудейн шашинд бий. Библийн домогт өгүүлснээр диваажингийн цэцэрлэгт сараана ургаж байх үед Ева чөтгөрт уруу татагдан хөөгдөхөд сараана цэцэг цэвэр ариун хэвээр үлдсэн гэдэг.

Эртний мисирчүүд энэ цэцгийг мөнх бус, итгэл найдвар, эрх чөлөөний билгэдэл болгон дүрсэлдэг байжээ. Мөн тэдний сайхан үнэрт тос хийх гол түүхий эд нь сараана байсан юм.

Ромчууд Флорагийн баярт сарааныг хэрэглэдэг

Эртний герман домогт аянга цахилгааны бурхан Тор баруун гартаа цахилгаан, зүүн гартаа сараана цэцгээр чимэглэсэн очирт таяг барьснаар дүрсэлсэн байдаг.

Харин Францад сараана хаан ширээний билгэдэл байдаг.12-р зуунд 7-р Людвиг хаан энэ

цэцгийг өөрийнхөө сүлд болгон сонгож, цагаан туган дээр гурван алтан сараана дүрсэлж байжээ.

Сараана цэцэг нь зөвхөн хаан төрийн сүлд болоод зогссонгүй. Папын сүр хүчний билгэдэл болжээ.

Итали, испаничууд ч энэ цэцгэнд дуртай.Тэд сарааныг гэгээн Эх дагины цэцэг гэж үздэг. Тиймээс Христийн эх гэгээн Мариаг сараана цэцгээр хүрээлүүлэн дүрсэлсэн байдаг.

Кавказ хүүхнүүд сарааныг мэргэ төлгөнд ашигладаг. Тэд борооны өмнө сараана тасдан авч нуугаад, хэрэв цэцэгний өнгө шар болон хувирвал сэтгэлт залуу нь өөр бүсгүйд урвасан, харин гал улаан болох юм бол үнэнч хэвээр байгаа юм байна гэж таадаг заншилтай.

Сарааны хамгийн ховор төрөл нь өмнөд Хятадын уулсаар ургадаг Хааны лилия юм.

Бас нэг ховордсон төрөл нь Барын лилиягийн Азийн төрөл буюу бидний сайн мэдэх төмсний улаан ажээ. Улаанбаатарын орчмын зусланд элбэг байсан энэ гоёмсог цэцгийн үндсийг хүмүүс ухаж идсээр улаан номонд орохоор ховордсон байна лээ.



Бадамлянхуа

\Лотос\

Усны толигор мандал дээр цэцэглэдэг Бадамлянхуа цэцэг нь газар дэлхийг тэжээн тэтгэж, хүн амьтныг умдаалагч ус-чандмань эрдэнийн хүчин чадлын билгэдэл болдог.

Тиймээс дорнын соёлд бурханы шашинтнууд болон энэтхэгчүүд энэ цэцгийг онцгой шүтэж, ариун гэгээний билгэ тэмдэгт тооцдог. Ер нь дорнын соёлд бадамлянхуа цэцэг сарнай шиг онцгой байр суурь эзэлдэг.

Халхын Өндөр гэгээн, анхдугаар богд Занабазарын бүтээл цагаан ногоон дарь эх тэргүүтэн бурхад дэлгэрч буй бадамлянхуа цэцгэн суудал дээр заларч байдаг.

Өглөө наран мандахад цоморлигоо дэлгэн орой жаргахад нь дэлбээгээ хумьдаг энэ гайхамшигт цэцэг төгсөшгүй дахин сэргэх, үржин өсөх, үхэшгүй мөнхийг билгэддэг гэж дорныхон үздэг.

Эртний шумер, финикийн соёлд энэ цэцэг үхэх, төрөх, амилах, дахин сэргэх байгаль эхийн төгсөшгүй хөдөлгөөний билгэдэл юм. Хэрэв бадамлянхуа цэцгийг бурханы хамт дүрсэлсэн байвал нарны бурхан, үнээний хамт зурсан бол сарны эх дагины шинж ажээ.

Бурханы шашинд бадамлянхуа ариун гэгээн 8 зүйл билгэдлийн нэг юм. Бурхан Будда эхээс мэндлэнгүүт босоод долоо алхсан гэдэг. Ариун гэгээн Буддагийн алхсан газраас нь үзэсгэлэнт бадамлянхуа дэлгэрсэн домогтой.

Грек, Ромын соёлд энэ цэцэг Афродита, Венера охин тэнгэрийн билгэ тэмдэг, Перст нар, гэрлийн билгэдэл, Даогийн сургуульд сансар хорвоогийн хүрд, оюун сэтгэхүйн цараа, зүрх сэтгэлийн билгэдэл, мөн бүсгүй хүний цэвэр ариун, үзэсгэлэн гоогийн илэрхийлэл юм.



Гэсэр цэцэг

\Астра\

Астра гэдэг нь грек хэлээр од гэсэн утгатай. Гэсэр цэцгийн тухай эртний грекийн домогт өгүүлснээр энэ цэцэг оддын тоосноос үүссэн гэдэг.

Хятадын нэгэн домогт өгүүлснээр Даогийн хоёр санваартан од руу аялахаар шийджээ. Ингээд мань хоёр лам өтгөн шигүү ойгоор яваад л байж гэнэ, яваад л байж гэнэ. Явсаар арц модон шугуй руу орж ирлээ. Тэд арцны шугуйгаас уулын бүдэгхэн зөрөг дээр гарч ирэв. Зөрөг замаар явсаар мөсөн голд тулгарав. Мөсөн голоор явах гэтэл халтирч гулгаад байсан тул мөлхөж мацан байж туулаад ч өндөр уулын оргилд хүрсэнгүй. Ийнхүү түмэн бэрхшээлийг давсаар уулын оргилд гарсан ч одод хүршгүй алсад хэвээр л байхыг үзлээ. Хичнээн өндөр оргилд мацаад ч тэнгэрийн одод хүрэхгүйг ухаарсан хоёр лам аяны жолоогоо эргүүлэхээс аргагүй болж дээ. Гэтэл оргил руу мацахаас уруудах нь хэд дахин бэрх байлаа. Хоёр аянчны аяганы хийц дуусч, богцонд нь амандаа хийх үмх будаа, дусал ус ч үлдсэнгүй. Өмссөн хувцсаа урж, алд биеэ шархалж шалбартал өлөн хоосон явсаар хөдлөх ч тэнхэлгүй болж байж уулнаас бууж гайхам сайхан нугад орж ирлээ. Тэнд хивс мэт зөөлөн ногоо ургаж, цэнгэг уст горхи чихнээ чимэгтэйеэ хоржигнон урсч, хөвөөгөөр нь од шиг гоё урт нарийхан дэлбээтэй цэцэгс ургасан байв гэнэ.

-Хараач! Хоёулаа тэнгэрийн одонд очих гэж хичнээн бэрх зам тууллаа. Гэтэл одод гэдэг чин энд газар дээр цэцэг болон буусан байна биш үү? хэмээн нэг нь дуу алджээ.

Хоёр санваартан горхины тунгалаг уснаас ууж цангаагаа тайлаад тэр гоё цэцэгнээс хэдийг үндсээр нь малтан авчирч хийдийнхээ хашаанд тарьсан гэдэг. Энэ цагаас хойш өнөөх цэцэг латинаар од буюу астра нэртэй болсон ажгуу.

Унгарчууд гэсэр цэцгийг “намрын сарнай” гэгцгээнэ. Эртний мажарууд гэсэр цэцгийн дэлбээг түүдэг галд шатаахад могой үргээдэг хэмээн итгэдэг байжээ. Гэсэр цэцэг нь охины ордны бүсгүйчүүдийн сүлд цэцэг нь байдаг гэнэ.

Бэрцэцэг

\дельфиниум\

Эртний Элладад оюун төгс нэгэн залуу амьдарч байсан юм гэнэ. Тэрбээр нас нөгчсөн дурлалт бүсгүйнхээ дүрийг марталгүй санан санасаар баримал дүрийг нь хийж амь оруулжээ.

Нэгэнт наснаас нөгчсөн хүний дүрийг амилуулан ертөнцийн жамыг зөрчсөн залуугийн тэрслэлд тэнгэр бурхад цээрлэл үзүүлж далайн гахай \дельфин\ болгон хувиргажээ.

Тэнгэрийн цээрлэлээр далайн гахай болсон хөөрхий залуу үдэш бүр эргийн зүг сэлэн ирээд дахин амилсан дурлалт хонгор бүсгүй рүүгээ тэмүүлэвч ганц ч удаа уулзаж чаддаггүй байв гэнэ.

Эрэг дээр амрагаа харуулдан зогсох бүсгүй ч тэнгисийн мандлыг хайр, гуниг хурсан нүдээр ширтэн оройжин эрэг дээр зогсоход үнсэлт мэт урьхан салхи гялалзсан сайхан үсээр нь тоглон хийсгэж, царай нь уйтгар гуниг дүүрэн байдаг байж. Гэтэл нэгэн удаа бүсгүйн харц баяр хөөрөөр гийж сэртэсхийгээд явчихжээ. Учир нь далайн гахай болон хувирсан хайрт нь номин хөх өнгийн цэцэг зуусаар эрэг рүү хөвж ирээд өлмий дор нь мөнөөх энхрийхэн атал гуниглангуй цэцгээ тавьж гэнэ.

Тэр цагаас хойш тэр хөх цэнхэр цэцгийг дельфиниум гэж нэрлэсэн гэдэг.

Монголчууд энэ цэцгийг бэрцэцэг гэдэг.

Амрагаасаа хагацсан бэрийн нулимс

Бэрцэцгийн тухай хуучны нэгэн монгол домог буй. Эрт дээр цагт, эзэн Чингисийн үед гэнэ. Сартуул аймгийг дайлаар мордох их цэрэг хөдөлжээ. Арын их хэнгэргээ дэлдэн ай түмэн цэргээ хурааж, өврийн их хэнгэргээ дэлдэн үй түмэн цэргээ хурааж баатар эрс дайнд одоход саяхан хуримласан амраг хосууд хагацан салах болж гэнэ. Эр нөхрөө хүлээж үүрд бат журмыг сахина хэмээн амраг залуу бүсгүй ам тангаргаа өргөн үдсэн юм санж.

Амраг бүсгүй хань нөхрөө хүсэмжлэн сарын сайныг саатан хүлээж, өдрийн сайныг өнжин хүлээж сураг чимээ чагнан байтал их цэрэг сартуул аймгийг байлдан дагуулж эрхшээгээд эх нутгийн зүг хүлгийн жолоо залсан тухай таатай сайхан мэдээ дуулав.

Амраг хань, хайртай хүү, дүүгээ угтахаар ялсан цэргийг тосох олны дунд өнөөх шинэхэн бэр бас байлаа. Өглөөний мандах улаан нарнаас үдшийн саран гарах хүртэл хар нүдээ хөхөртөл харсан ч аян дайнаас эсэн мэнд ирэгсдийн дунд бүсгүйн амраг хайрт байсангүй гэнэ.

Бүсгүй уйлан хайлж “Ай алтан наран чи амраг түүний минь харах нь яав.Хараацай болон нисдэг ч болоосой. Харийн хүйтэн хөрсөнд хөсөр хаягдсан хайрт ханийнхаа хатан ясан дээр очиж хүний нутгийн шороог нь үлээгээд ч болов арилгах сан.Сэрүүн сэвшээ салхи чи сэтгэлт түүнийг минь харах нь яав. Хүүрзгэнэ болоод нисдэг ч болоосой. Хүний газар хаягдсан хөөрхий түүндээ очиж халуун нулимсаараа шархыг нь угаан уйлах сан. Уяраад босоод ирэх ч юм бил үү? хэмээн гаслан тэнгэр газар, алтан наранд гашуудлаа өчөөд халуун амраг сэтгэлтэнг хагацаан салгасан дайн дажин дахин бүү гараасай хэмээн ерөөхөд нулимс нь газар унаж хөх өнгөтэй хөөрхөн цэцэгс болон ургасныг хөөрхий тэр бэрийн дурсгалд бэрцэцэг хэмээн нэрийдсэн ажгуу.

Цахирмаа

\орхидея\

Гайхмаар нууцлаг, өвөрмөц үзэсгэлэнтэй энэ цэцгийн тухай олон сонин домог бий. Байгаль эхийн үзэмж төгөлдөр бүтээл болсон энэ цэцгийн 20 мянга гаруй төрөл одоогоор мэдэгдээд байгаагаас л харахад цахирмаагийн нууц нээгдэх хүртэл өдий байгаа бололтой. Харьцангуй сүүлд 250 жилийн өмнөөс л энэ цэцэг хүлэмжийн ургамал болжээ. Анх цахирмааг европчууд огт мэддэггүй байжээ. Америк руу “алтны халуурлаар” очсон цагаан арьстан аянчид тэндээс урьд үзэгдээгүй гайхамшигтай гоё цэцэг олж европод аваачсанаар цахирмааг дэлгэрүүлсэн гэнэ. Тарихад нөр их хөдөлмөр, уйгагүй арчилгаа, багагүй хөрөнгө мөнгө шаарддаг цахирмааг цэцэрлэг сонирхогчид “язгууртан цэцэг” гэдэг. Цахирмаагийн зарим ховор төрөл нь олон улсын цэцгийн үзэсгэлэн яармаг дээр хамгийн дээд үнэ хүрдэг 10 цэцгийн нэгд ордог.

Хятадын соёлд цахирмаа нь хүний төгс төгөлдөр шинжийн билгэдэл болдог.

Харин Шинэ Гвинейн эрчүүд цахирмаа их дэлгэрсэн газар үдэлж амрахыг их цээрлэдэг. Уугуул нутгийнхны үздэгээр цахирмаа цэцэг үзэсгэлэнт хүүхэн болж хувирахад түүнийг үзсэн эр хүн гоо сайханд нь татагдаад салж чадахаа больдог юм гэнэ.

Цахирмаа цэцгийн үүслийн тухай Шинэ Зеландын мамори овгийнхны зохиосон сонирхолтой домгийг хуучилью.

Эрт галавын үед хүн үүсэхээс ч өмнө юм гэнэ. Хүн бүү хэл газар шороо ч бүрэлдэн бий болж амжаагүй байсан эрт цагт дэлхийг эзэлсэн их тэнгис далайгаас өндөр их уулсын цасан оргилууд дөнгөж цухуйж байжээ. Наран хурцаар ээж уулсын цасан оройг хайлуулсаар өндрөөс буух урсгал нь аяндаа асар том том хүрхрэнүүдийг үүсгэжээ. Хүрхрээний ус далайд цутгахдаа асар их үүл болон хөөрч гэнэ. Үүлс аажмаар газрын хөрс болон царцсанаар хуурай газар үүсчээ. Тэгтэл наран авхай үүлнээс үүссэн газрыг цоо хатгамаар санагдаж хүчтэй аадар бороо оруулав. Энэ их борооны дараа тэнгэрийг бүрхсэн асар том солонго татаж гэнэ.

Гэтэл эрт галавын цагт газар дэлхийж эзэгнэж асан үхэшгүй мөнхийн сүнснүүд тэр өдрийг хүртэл солонго гэдгийг огт үзээгүй байсан юм санжээ. Сүнснүүд тэнгэрийн гайхамшигт гүүр мэт долоон өнгийн гоёмсог солонго руу бөөн бөөнөөрөө нисэлдэн очиж цөмөөрөө л түүн дээр багтан суухыг тэмүүлцгээв. Эцэст нь тэр сүнснүүд солонгон дээр арай гэж багтан сууцгаагаад баярласандаа дуулалдаж гарчээ. Харин солонго бие дээр нь зай завсаргүй шавсан тэр олон сүнснийг зайлуулахын тулд өнгө өнгийн хэлтэрхий болон задрал. Үхэшгүй сүнснүүд тэнгэрээс бороо болон асгарах өнгийн солонгын хэлтэрхийг гайхан харна. Гэтэл солонгын хэлтэрхийнүүд газарт буухдаа үзэмж гоё цахирмаа цэцгүүд болон хувирчээ.

Малчин хүү цахирмаа цэцэг олсон нь

\Япон домог\

Эрт урьдын цагт. Наран ургах зүгт хязгааргүй их далайн дунд орших нэгэн арал дээрх бяцхан нугад ядуу малчин хүү хэдэн ямаа хариулж явж гэнэ. Хүү хариулж буй ямаагаа ч, нугын гоо үзэмжийг ч үл хайхран гүн уйтгарт авган сууж байлаа. Тийн уйтгарт авгсаны учир гэвэл хүү хичнээн их хүсэвч хэзээ ч самуурай болж чадахгүйд байсан юм. Бяцхан ямаачин хүү, ертөнцийн амьдрал юуны учир ийм шударга бус байна вэ? хэмээн бодолд авган элдвийг эргэцүүлсээр суув. Зарим хүн яахаараа баян, өндөр угсаа язгууртай төрсөн атал самурай байхыг ойшоодоггүй байхад харин самурай болохыг хүсэн мөрөөддөг тэр хүү юуны учир ядуу малчныд мэндэлсэн юм бол? Тэгээд түүн шиг малчин айлын хөвгүүд бүхий л насаараа хүнд хүчир ажилд нухлагдсаар гэгээн сайхан мөрөөдөл нь хөсөр хаягддаг. Ер нь энэ гарал угсаа гэж хэнд хэрэгтэй юм бэ? Хэргэм зэрэг ч бас юунд хэрэгтэй юм? Хүмүүс нэгэн тэнгэр дор төрж, яг л адилхан ус ууж, ижилхэн л шувуудын жиргээнийг сонсох атал хувь тавилан нь яагаад ингэж тэнгэр, газар шиг ялгаатай байдаг байна? хэмээн бодож эргэцүүлж суутал гэнэт тэнгэрт хос цагаан шувуу нисэхийг харав. Хүү тэр шувуудын барааг тасартал тэнгэр рүү ширтэж байснаа санаандгүй хөл дорхи газар руугаа харвал цав цагаан шувууны хоёр далавч шиг дэлбээтэй чамин янзын цэцэг олж үзэв гэнэ. Тэрхүү цэцгийн дэлбээ нь цагаан дэглийтэй яг адилхан, хараа булаам өвөрмөц ургамал байлаа.

Ямаачин хүү саваа модоороо тэр цэцгийг үндсээр нь малтан гаргаад гэртээ авчран вааранд суулгаж тарьжээ. Өнөө гоё цэцэг вааранд ургаж, үзэх бүрд сэтгэлийн баяр баясгалан бэлэглэх боллоо. Гайхамшигт цагаан цахирмааг харахдаа л тэр малчин хүү Бурхан багшийн сургасан амьдралын эгэл үнэнийг гэнэт ухаарсан гэдэг. "Энэ ертөнц дээр буй бүхэн, шувуу нисэх нь хүртэл мөнхийн гоо сайхан юм. Цэцэгс рүү, шувууд руу хар. Тэгээд л үнэнийг ухаарна" хэмээн Бурхан Будда сургасан билээ.

Тэр цагаас хойш япончууд цахирмаагийн овгийн цагаан дэглийн далавч мэт дэлбээтэй нэгэн зүйл цэцгийг гэрийнхээ цэцэрлэгт тарьж ургуулах болсон юм гэнэ.

Зургадугаар сарын цас

(тууж)

Зургаан сар... Мөнх залуугийн билэгдэл, зугаа, цэнгэл, хөгжил баясгалангийн улирал зуны эхэн сар. Тэр нэгэн зун мянга мянган залуу ногоон навчис ширчигнүүлсэн зургадугаар сарын моддын мөчрийг цагаа олоогүй цас нэвсийтэл дараад гүн цэнхэр тэнгэр, нов ногоон зүлэг, навчсын өнгөтэй сүлэлдэн байгаль эхийг гайхаш алдруулсан атал ганцхан хоногийн дотор ор мөргүй хайлан алга болж билээ... Зургадугаар сарын цас... Хоромхоноо хайлан алга болохдоо бодол, ухаарал, хөнгөхөн, бас хүйтэн гуниг л ой дурсамжид үлдээн оджээ...

Тэр өдөр намрын эгэл нэг өдөр байсан. Намар. Халгиж цалгисан, алтан навчис хийсгэсэн элбэг баян намар цаг. Зүйрлэх юм бол нэгэн баян өвгөн алт эрдэнэсийн авдраа нээж, үр хүүхэд, хамаатан садан, барлаг зарц нартаа хүртэл өв хөрөнгөнөөсөө хувь хүртээн гар тэнийлгэж буй мэт элбэг дэлбэг намрын өдөр. Гэхдээ үзэсгэлэнт ногоон навчис хорчийн хатаж эх модноосоо тасран газарт хөсөр унах нь гоо бүсгүйн цасан цагаан гар мойнийж судаснууд нь гүрийн үрчийж, насжилтын тэмдэг бор бор толбоор дүүрч салганасан эмгэний сарвуу болон хувирах мэт. Айсуй хүйтэн, хөлдүү, хахир өвлөөс байгаль дэлхий айн дагжих мэт түгшүүртэй, зэвэргэн бүүдгэр өдрүүд ч намарт бас олон байдаг даа. Тийм л нэгэн онцгүй өдөр байсан юм, тэр өдөр.

Тэр хөвгүүн зүрх сэтгэлийг нь үүрд эзэгнэх үзэсгэлэн гоо бүсгүйг олж харсан өдөр тийм л өдөр байсан. Тэр хөвгүүнийг Бямбадаш гэдэг. Нэгэн ламын хайрласан гэх энэ нэрэндээ тэр дургүй. Найзууд нь түүнийг нэрийнх нь англи үсгийн товчлолоор BD буюу Биди гэж дуудах нь харин жинхэнэ нэрээс нь хавьгүй дээр санагдана. Тэр бол аав, ээж нь гадаадад ажиллахаар яваад дараа нь салчихсан тул өвөөтэйгээ аж төрдөг, арван зургаан настай, хип хоп маягийн нэвсгэр хувцсанд дурладаг жирийн л нэгэн хөвгүүн. Үсэрсэн 11-р ангид сурдаг.

-BD бөмбөг өө!

Тэд дөрвүүлээ намрын тэр бүүдгэр өдөр уйдагдаа дэмий л сагсны шийт рүү бөмбөг шидэж байжээ. Гэтэл Хатнаагийн цагираг руу оруулж чадаагүй бөмбөг баруун тийш өнхрөн одож ойр байснаараа BD хойноос нь залхуутай боловчиг гүйлээ. Уг нь гүймээргүй, хурдан түргэн хөдөлмөөргүй, гэртээ л халуун шоколад ч юм уу, аль эсвэл эмээгийнхээ будаатай цайг ууж хэвтмээр мангар өдөр байсан юм.

Бохир, шавартай хөвөн мэт хэсэг хэсэг саарал үүлс толгой дээр унаад ирэх нүү гэмээр тээр доогуур нэвсийн, байрных нь эргэн тойрны гудамжны шороо уржигдрын ус ихтэй бороонд нялцгай зуурмаг болон шалчигнаж байснаа хатах аядан царцсан нь хүмүүсийн гуталд наалдсан өтгөн шавар болоод байв.

Навчис нь шарлаж бөөн бөөнөөр хийсэхэд модод харамсан уйлах мэт бөхийж, хэдий нэмэх арваад хэм дулаан байвч хүмүүс бээрсэн мэт бөгтийн хурдан хурдан алхална. Эмээ нь амьд мэнд сэн бол шил шилээр ногоо дарах буюу зах дэлгүүр хэсэн хүн бүхэнд дулаан дотуур өмд ноосон оймс базаагаад л “Дороосоо дулаал, миний хүү дороосоо дулаал” гээд зузаан оймс

гаргаж тавиад л ”...за больё.”

Аяа яа намар аа гэж...

-Ээж ээ бөөбөө!

гэх өхөөрдөм нялх хүүхдийн дуу намрын бүгтхэн агаарыг зүсэв. BD тэр хүүхдийг хатуу том бөмбөгт цохиулчихна гэж айхдаа өөрийн мэдэлгүй хариугүй гүйцэн барьж авах байсан бөмбөгнийхөө дээрээс даран ойчив. Ээ п... гэх гэснээ амаа барин өндийлөө. Энэ ч дэмий хараал л даа. Хамаг хувцас нь цул шавар.

-Босоорой! Хувцас чинь муухай болчихлоо доо гэсэн уяхан дуу...тэгээд эмэгтэй хүний дулаахан зөөлхөн алга гараас нь чанга татан босгов.

Хоёр настай болов уу гэмээр хөөрхөн хүүхэд хөтөлсөн залуухан гоё бүсгүй түүний дээрээс санаа зовонгуй ширтэнэ.

-Баабаа! хэмээн нөгөө бяцхан амьтан шулганав. BD-д бол хэдийгээр эгдүүтэй ч гэсэн тэр шулгануур жаахан хүүхэд огтхон ч сонин биш байлаа. Нялх жаахан иймэрхүү амьтан хаа ч байж л байдаг юм чинь. “Эрчүүд хүүхдийг өхөөрдөн харж зогсохдоо асрагчийг нь шохоорхон ширтэж байдаг “ ч гэл үү нэг тийм үгийг ямар нэгэн америк киноны баатар хэлдэг нь яагаад ч юм энэ мөчид санаанд нь буужээ. Учир нь хүүгийн ээжийг хараад тэр таг гөлөрчихөв.

Цонхигордуу цагаан царай, ардаа шууж хайш яйш тогтоосон шаргал хүрэн үс.Тас жимийсэн зузаавтар уруул. “Хувцас чинь муухай болчихлоо доо” гэж хэлэхэд нь тодорсон зүүн хацар дээрх хонхорхой, нүд хөмсөг, хамрынх нь чухам аль нь илүү гоё юм бэ гэдгийг ялган хэлэхийн эцэсгүй царайных нь бүх юм нь хоорондоо яв цав таарч зохицон уран барималчийн гараар бүтсэн мэт тийм гоо цэвэрхэн бүсгүй зогсч байх нь тэр.

Өндөр ч биш, намхан ч биш дунд зэргийн нуруу, урт цав цагаан ноосон цамцаа өргөн бүсээр бүсэлсэн нарийхан голшиг бэлхүүс. Саяхан BD-ийн гараас татан босгосон савхан нарийхан хуруутай, гялалзсан ягаан хумстай цасан цагаахан гар. Ер нь нүд салгамгүй ширтээд л баймаар үзэмж төгөлдөр, нэг үгээр хэлэхэд жинхэнэ саак бүсгүй байлаа.

-Зүгээр ээ хэмээн арай ядан хэлээд хүү хурдхан шиг босон найзууд руугаа дуртай дургүй гэлдрэв. ”Энэ хүүхэн хэдтэй бол?”. Оюутан, арван найм, естэй эсвэл бүүр арван зургаатай болов уу ...Тэгвэл тэр жижигхэн амьтан юу нь байж таарах вэ? Ах, эгчийнхээ хүүхдийг саатуулж байж болно ш дээ. Бүсгүйг аль болохоор өөртэйгээ ойролцоо насных байгаасай гэж тэр өөрийн эрхгүй горьдоод байжээ. Хөвгүүн аль ухаан орсон цагаасаа л энэ байранд байсан юм чинь ийм гоё бүсгүй гэнэт хаанаас гараад ирэв гэдэг ч бас сонин байлаа..

- BD худлаач ээ! Бөмбөгөө паасалчих. Мань ганц шидчээд орлоо. Ээж дуудаад байна. Хүнсний зах явна гэнээ хэмээн Хатнааг хэлэхэд л тэр сая тэр газар дэлхийд бууж ирэх шиг болов.

-Ээж ээ, ээж , навчаа түүе л дээ гэх шингэн дуунаар далимдуулан эргэж харав. Тав

зургаа орчим насны охин баахан навч барьчихсан нөгөө хүүхэн рүү гүйж ирнэ. Өөртэйгээ үе насных байгаасай, ах эгчийнхээ хүүхдийг асарч яваа өөрийнхөө үеийн охин, ядаж оюутан бүсгүй байгаасай хэмээн горьдсон өнөөх гоо хүүхэн нь хөтөлж яваа дүрсгүй жаахнаасаа ч том хүүхэдтэйгий нь хараад хүү санаа алдав. Аягүй бол одоо нөхөр нь гээд нэг бүдүүн гүзээтэй эр гараад ирэх биз.

-Хоёр хүүхэдтэй хүүхэн юм байна гэсэн хөндийхэн бодлыг нь:

-Хүүе миний дүү бугуйвчаа хаячихаж гэсэн уяхан дуу тасалж BD баяртай нь аргагүй эргэн харахдаа “Миний дүү гэчихжээ.Өөрөө тийм хөгшин юм байх даа” гэж бас бодоодхов.

-Миний хүү тэр агаадаа аваачаад өгчих.Унав аа гэсэн үгс чихэнд нь хөгжим мэт уянгалж, хүүхэн нөгөө жижигхэн жаалдаа цагны оосор шиг арьсан бугуйвчийг нь өгч байна.

-Өө за гээд тэр дуртай нь аргагүй хоёрхон үсрээд л бяцхан жаалын дэргэд очиж бугуйвчаа авснаа ээж рүү нь талархан хяламхийнгээ :

-За агаадаа өгчих гэхэд хүү өгөх дургүй байсан болтой “бай бай” хэмээн өөдөс шиг гараараа түүнийг цохиод хүчиндээ бөгсөөрөө унаад “ална шүү” гэж гар зангав.

-Миний дүү яажаагаан? гээд эгч охин нь гүйж ирэн дүүгээ босгоход , ээж нь хэн нэгэнтэй гар утсаар ярьж эхлэв. Одоо хүүхэн түүнийг нэгэнт анхаарахаа больжээ.

Хүү бөмбөгөө аваад найзууд руугаа дуртай дургүйхэн гэлдрэв.

-Өө,чи бариад авахгүй яасын?Дажгүй хүүхэн байгаа биз?Түрүү долоо хоногт Цэнгүүний орцонд нүүж ирсийн...

Хатнаагийн ийнхүү хайхрамжгүй ярих, бүсгүйн хойноос \хүүхний гэхээр түүнд нэг л доромж утгатай мэт санагдаад байв\ нэн ялангуяа аятайхан өгзөг рүү нь илт шохоорхсон харц шидэх нь хүртэл BD-ийн дургүйг нь хүргэж өөрийн эрхгүй эмээ хайрлан харамнах эр амьтны зөнг нь сэрээж байлаа.

Одоо түүнд сагс тоглох сонирхол өчүүхэн ч үлдсэнгүй. Бөмбөгөө хоёр найз руугаа шидчихээд хүүхэн рүү нэг хяламхийснээ орц руугаа залхуугайяа гэлдрэв.

- BD!

-Өө чи бөмбөг жоохон шидчээд орохгүй юм уу?Би ч гэсэн орлоо ш дээ гэж Хатнаа хашгирах сонсогдсон ч одоо түүнд юм бүхэн улам ч сонирхолгүй уйтай санагдаад байв.

-Мань гэртээ орлоо. Өвөө гэртээ ганцаараа...

-Өвөө чинь дандаа л ганцаараа байдаг биз дээ?

-Ээ чи...гэцгээн хоёр найз нь хойноос нь үглэж дуулсаар хоцров.

Гэртээ орж хөгжим сонсдог хэрэг. Шинэ I-podoo жаахан “ухах” хэрэгтэй байлаа. Тэгээд... тэгээд тоогоо жаахан нухдаг юм уу...

Орц хүртэлх ердөө л гучаад алхам газар. Дахиад л нөгөө хөөрхөн бүсгүйг эргэж хармаар санагдаад байлаа. Гэртээ орохын өмнө түүнийг л ганц харчихвал өөр юу ч хэрэггүй мэт санагдана.

Ашгүй Хатнаа дуудаж байна. Далимд нь хүүхнийг харах санаатай эргэн харав. Нөгөө хоёр найз дээр нь Байка нэмэгдээд гараад ирж. Бүсгүй гар утсаараа ярьсаар хүү охин хоёр нь бүүр хол гулсуурын тэнд хөтлөлцөн яваа харагдана.

-Чи л илжигдые гээ биз дээ. Жоохон байж байгаад ор л доо гэж байна.

-Мань орж хувцсаа сольё оо. Дараа нь тоогоо хийе.

-Аая, өнөөдөр чинь хагас сайн тэх үү? гээд Хатнаа Тэнгис рүү мөрөө хавчихад цаадхи нь

-Энэ чинь чи мөн үү? гэхийг ч тоосонгүй. Ганцхан дуугүй томоотой Байка л юу ч хэлсэнгүй. Магадгүй харцаар нь найзынхаа дотоод сэтгэлийн амар амгалан эгнэгт алдагдсаныг мэдэрсэн ч байж магад. Хөвгүүд бол эрийн хугархайнууд. Эрчүүд гэдэг бие биенээ элдэвлэн үгээр идэж, явуулж, тоглоом наадам хийж, хаггаж, уруу татах зэргээр цаг үргэлж хэлхээтэй юм шиг хамтдаа байж, хэрэг нь болбол бие биедээ санаа тавьсан шиг тавьж, бас хаацалж хамгаалж, хайрлаж ч чаддаг улс.

-Би ч гэсэн орлоо. Ээж түрүүнээс хойш дуудаад байсан гэх Тэнгисийн дуу ард нь гарлаа.

-За за орцгооёо гэлцэн найзууд нь гэр гэр рүүгээ зүглэцгээв бололтой.

Найзууд нь түүнийг бодвол ээжтэй улс. Ээж дуудлаа энэ тэр гээд гэртээ орох сайхан л байдаг байх. Уг нь BD ч ээжтэй л дээ. Солонгос явчихсан л болохоос. Гэхдээ хүүгээ дөнгөж долоотой, сургуулийн босго алхаж байхад л “Мөнгөтэй болоод хурдан ирнэ” гэж амлаад явсан хүн одоо хүүгээ ийнхүү арван зургаа хүрч, арваннэгдүгээр ангид орчихсон шилжилтийн нас, гар хангалга, анхны үерхэл, эмээгээ алдсан аймшигт хагацал гэх мэтийн баяр гунигтай олон олон явдал үзэн өнгөрүүлэхэд дэргэд нь байхгүй арван жилийг үдсэн байдаг. Байраа томруулаад, ахыг нь гадаадад явуулаад, машины мөнгө олоод... тэгээд л ээж нь ирнэ гэсээр энэ арван жилийг үдчихсэн ээжийгээ одоо тэр бүүр түүрхэн л санадаг. Солонгосоос дандаа утсаар ярьж, мессэнжерээр зургаа явуулсаар байгаа ч ээж нь түүний хувьд хэдийнээ хар элгийн хүн шиг хол хөндий болчихсон хэрэг.

Хүү одоо 16-тай. А-ээс F хүртэл өөрөөр хэлбэл онцсайнаас муу хүртэлх бүх дүнг авч үзсэн. “Бямбаа минь чи хичээвэл мөн ч толгойтой хүүхэд юм сан” хэмээн багш нар нь хэлдэг ч хүү онц сурах гэж, сайн хүүхэд байх гэж нэг их хичээдэггүй. За тэгээд дүрсгүйтэх цагтаа дүрсгүй, ойлгоод хийхээрээ тооны төрлийн бүх хичээлдээ шаггүй, харин уран зохиол, түүхийн хичээлд ясны дургүй. Тэр ганцхан ахтай. Өөрөөс нь таван насны зөрүүтэй ах нь гурван

жилийн өмнө Америкт сурахаар Номхон далай гатлан оджээ. Аав...Түүний тухай бодох бүрд хүүгийн цээжинд нэг юм хөндүүрлэх шиг болдог. Түүнийг бүр цэцэрлэгт явж байхад анх аав нь Солонгос явсан юм. Онгоцны буудал дээр хүүг дээр өргөж үнсээд “Аав нь зөндөө гоё тоглоом явуулна. Бас их мөнгөтэй болоод хурдан ирнээ. Миний хүү томоо болоод байгаарай” гээд үнсэж байсныг нь бүүр түүрхэн санадаг юм. Дараа жил нь тэр сургуульд орохдоо ээжтэйгээ хөтлөлцөн, өвөөтэйгээ гурвуулаа явж байж билээ.Тэгэхэд бусад хүүхдийн ээж, аав хамт нь ирчихсэн зарим аав аппараттай ирчихсэн сургуулийн босго алхаж буй хүүхдийнхээ зургийг аваад л хичнээн атаархмаар санагдаж байсныг томчууд ойлгох биш дээ. Ээж нь тэгэхэд хүүгийн тэр гомдлыг анзаараа ч үгүй бөгөөд ямар ч билээ гоё үнэртэй ус сэнгэнүүлэн хүүгээ үнссэнээ, олон бужигнасан хүүхэд дунд зогсоо үсээ буржийлгасан настай эмэгтэй рүү зааж:

-За миний хүү багшдаа цэцгээ өг. Багш нь тэр байна. Ингээд л миний жижигхэн Памбууш сургуульд орлоо доо гэж билээ.Тэгэхэд хүү ээжийгээ тэр олон хүүхдийн дунд багынх нь муухай нэрээр дуудлаа хэмээн дургүйцэн хүрлийгээд багш руугаа алхсан. Багш руугаа тийнхүү хүрлийж дургүйцсэн царайтай алхаж явахдаа ээжийнхээ гоё үнэр, сайхан ааштай байгаад, бас сурагч болж байгаадаа баярлаж байсан нь бүгд хийсэн одож, олон танихгүй хүний дунд өөрийг нь Памбууш гэж нэрлэсэнд нь нь бас аавтайгаа биш өвөөтэйгээ ирсэндээ улам улам сэтгэл гонсойсоор байж билээ. Энэ бол ямар ч байсан ээжтэйгээ хамт байсан гэгээн сайхан дурсамжуудын нэг.

За тэгээд ээж нь түүнийг сургуульд ороод хэдхэн хонож байхад аавынх нь хойноос Солонгос явж, хүү эмээ, өвөө, ахтайгаа үлдсэн. Гэтэл Сологост хамт гурван жил болсон хойноо аав, ээж хоёр нь салчихдаг байгаа. Ээжийнх нь хэлдгээр “толгой нь эргэж гүйцээд хамт ажиллаж байсан хүүхэнтэйгээ нөхцөн салахаа больж одоо Солонгосын хаа нэгтээ санаа амар яваа” аавынхаа тухай бодохоос ч дургүй хүрнэ.

Ээжийн хайрыг орлож байсан эмээгээ тэр уржнан жил харсаар байгаад алдсан юм. Тэр өдөр эмээ нь хүнсний зах руу яваад ирснээ “Жаахан ядарсан юм уу, эмээ нь бие эвгүй байна. Миний хүү цонхоо онгойлго доо” гэж билээ. Хүү салхивч онгойлгоод өрөөндөө орж найзуудтайгаа чааталж байтал эмээ нь түүнийг сулхан дуугаар дуудах шиг болсон. Тэрхэн агшинд урьд нь хэзээ ч амсч байгаагүй аймаар ч юм шиг түгшүүрийг тэр мэдэрч эмээ, өвөөгийнхөө өрөө рүү үсрэн орвол намхан хүрэн орон дээрээ агийн хэвтсэн эмээ нь ядрангуй нүдээр түүн рүү харснаа:

-Зүүн талаар хатгаад ч байх шиг зүрх юм уу...Муу хүүгээ айлгачих вий дээ. Өвөөгөө дууд даа... хэмээн арай ядан хэлэн ор руу нь оройтон ирсэн BD-ийн духыг үнэрлэж:

-Эцэг эхтэй элэг бүтэн мөрт өнчин хүн шиг өсөж байна даа миний өрвийсөн хүү...гээд гүн хайр шингэсэн нүдээр ширтсэнээ нүдээ аниж билээ.

-Эмээ та хэвтэж бай...Би одоохон өвөөг, бас эмч дуудаадахья. Одоохон, одоохон.

Хүү тэр дороо хонгилд байх утсанд хүрч байрны мөнгө тушаахаар явсан өвөөгөө дуудангуут хотын түргэн рүү дахин дахин залгасаар арай гэж нэг юм дуудлага өгөөд өрөөнд нь эргэн ороход эмээ нь нэг л хачин гилжисхийн хэвтэж байсан нь эргэж ирэхгүй аяндаа хэдийн

мордсон байж билээ.

-Эмээ!

Ингэж л хүү эмээгийнх нь онож хэлснээр элэг бүтэн атал өнчин мэт өсч, хайртай эмээгийнхээ үхэлтэй хүртэл орь ганцаараа нүүр тулсан юм. Оршуулгын ажил явдал дуусч бужигнасан олон хүн явцгаасны дараа гэр нь нэг л хачин хоосон оргин ханхайж, зул өмнө нь асаасан эмээгийн зураг гунигтай, өрөвдсөн харцаар өөрийг нь ширтээд ч байх шиг санагдаж байсан...Харин эмээгийн оршуулганд ээж нь Солонгосоос ирээгүй.

Ээжийнхээ гэнэт өнгөрснийг дуулаад утасны цаана хэсэг уйлан шугширснаа “Би очоод ч яах билээ дээ, нэгэнт амьдад нь уулзаагүйгээс хойш. Дараа нь аягүй бол виз гарахгүй биз...” гэж өвөөд нь хэлсэн гэдэг. Уг нь эмээг өнгөрлөө гээд ажил явдалд нь оролцох гэж ээжийгээ лавтай ирнэ гэж тэр дотроо горьдож байсан юм. Эмээгээ шарил хадгалах газраас гаргаж авсан тэр өдөр ивээл жилтэй гээд цогцост нь гар хүрснээ тэр мартаж чадахгүй удаж билээ. Үхэлтэй анх нүүр тулсан хүнд цохилтноос гарч амжаагүй байтал улаан гараараа цэл хүйтэн цогцост нь хүрэхэд тэр гэхийн аргагүй үл танигдах нэгэн айдас хамаг биеэр нь тарах шиг болсон ч “Энэ чинь миний эмээ шүү дээ” хэмээн хүчээр өөрийгөө тайвшруулж байж билээ. Хүү эмнэлгийн шарил хадгалах газрыг гадаадын кинонд гардаг шиг хана дагуу олон хаалгатай шүүгээнд цогцоснуудыг тус тусад нь хийчихдэг цэмцгэр газар байдаг юм бодож байсан нь тэс өөр өрөвдмөөр газар угтаж билээ. Хотын нэгэн том эмнэлгийн шарил хадгалах газар гэж хүйт даасан ханхай өрөөнд модон вандангууд дээр цагаан даавуугаар хайш яйш бүтээн, хөл тавих зайгүй чихсэн хөөрхий талийгаачдын дунд хайрт эмээ нь хэвтэж байсан. Халуун намар байсан ч үхэл үнэртсэн тэр өрөөнд амнаас уур гараад л ...Эмээ нь янхигар биерхүү хүн байсан болохоор алд хүрэхгүй цагаан даавуу биеийг нь бүрэн халхалж хүрэхгүй нүүр нь бүхэлдээ ил гарчихсан, дандаа зүүдэг сувдан ээмэг нь санжганан, гар нь хуучин модон вандангийн хажуу руу сул унжиж байж билээ. Бас яг эмээгийнх нь хажуугийн вандан дээр цэл залуухан яг үеэл Заяатай нь ойролцоо насны охин алтлаг бор үс намируулан гантиг мэт цонхийж цайчихсан хэвтэж байсныг тэр одоо ч мартаж чаддаггүй юм. Хэдхэн хоногийн өмнө л амьдарч баясч цэнгэж явсан нь илт тэр охины задгай үс эзэнгүй мэт унжин, хажуугаар нь өнгөрөх амьд хүмүүсийн алхаанд цахилгаанжин үлмэдэг хийсч байж билээ. Үүнээс хэдхэн хоногийн өмнө японы аймшгийн кино үзчихсэн байсныг ч хэлэх үү, тэр олон талийгчдын сүнс хажуугаар нь сүлжилдээд, тэмтрэх биегүй хоосон орон зайгаараа өөрийн нь бие дундуур нэвт шувт яваад байгаа ч юм шиг санагдаад л...

Хүү нь ингэж арван дөрөвхөн насандаа үхэлтэй нүүр тулан учирч, хайрт эмээгийнхээ хөшсөн цогцсыг халуун гараараа тэмтэрч явахад аав, ээж хоёрынх нь хэн нь ч дэргэд нь байгаагүй. Ээж нь амьдралынхаа төлөө л Солонгос явсан нь үнэн л дээ. Гэхдээ эргэж олдошгүй ижийгээ алдчихаад ядаж оршуулганд нь ирэхийг ч шамдаагүйг нь юугаар ч зөвтгөхийн эцэсгүй..

Ийнхүү гэнэтийн үхлээр эмээгээ алдсан Бямбаа өвөөтэйгээ хоёулхнаа ханхай гэртээ хоцорчээ.

Түүний хувьд гэртээ орох үнэндээ уйтай байдаг юм. Гэрт нь гэрэл гэгээ, халамж хайр ундраасан эмэгтэй хүн эрхгүй үгүйлэгдэнэ.

“Хөгшин залуу хоёр эр хүн айл болж явах ч гэж буруу хойшоо, оронгоо л тараачихгүйм даа...” гэж өвөө хэлдэг. Гэрээс нь өвөөгийнх нь тамхины үнэр, бас угаагаагүй удсан хувцасных шиг эсвэл тоос шорооны ч юм уу нэг тийм таагүй үнэр ханхийн , бас олон жил тамхи татсан хүний бөгшүүлэн ханиалгах, голдуу найз хөгшидтэйгээ даалуу тас нясхийлгэн шуугилдах нь сонсогдоно.

Хүү уйдагдаа зурагт асаана. Дандаа л мэдээ гарч байх бөгөөд чихэнд чимэггүй, өдий насны залуу хүний сонирхлыг огтхон татахааргүй эдийн засгийн хямрал, төсвийн тодотгол энэ тэр ч гэх шиг, за тэгээд ерөнхийлөгч, ерөнхий сайд энд тэнд ажиллав, улигт долдугаар сарын нэгэн... тэгээд л гүйцээ. Хааяа ч гэсэн бас Бямбаа шиг хүүхэд залууст сонирхолтой тэдэнд хэрэгтэй мэдээлэл байж болдоггүй юм байх даа гэж бодоод хөгжмийн суваг дээр л тавина.

Байрных нь орц бахь байдгаараа л бохир, айлууд үүдэндээ гялгар ууттай хогоо бөндийтөл нь тавьж, шатны ирмэгээр шавхай наалджээ.

Түүнийг ороход өвөө нь хоол хийж байв. Нөгөө өрөөнд өвөөгийнх нь найз хэдэн хөгшний даалуу тачигнуулах сонсогдоно.

Дахиад л мах чанаж, шөлөн дээр нь бэлэн гоймон хийсэн хоол.

-Миний хүү овоо эрт ороод ирээ юу?

-...

-Миний хөө, мах идэх үү?

-Үгүй ээ.

Хүү үүдэндээ гутлаа тайлж орхиод өрөөндөө орж шавартай хувцсаа тайчин угаалгын машинд хийгээд усанд орох гэснээ мөнөөх бүсгүйн тухай бодол гэнэт орж ирэхэд түүнийг гадаа байж магадгүй гэсэндээ цонх руу очив.

Гадаа бүүдгэр хэвээрээ. Үгүй тэгээд хэдхэн мөчийн дотор юу гэж тэнгэр цэлмэх билээ дээ. Цав цагаан ноосон цамцтай бүсгүй хоёр хүүхэдтэйгээ хамт тоглоомын талбайн дундуур зугаалан навч түүж яваа харагдана. Нөгөө жижигхэн хүү ээжтэйгээ хөтлөлцөн гартаа баахан улаан, шар хатсан навч барьж явснаа бүдрээд гар дахиа газраар нэг тараан унагахад ээж нь татан босгоод элгэндээ тэврэв. Ээжийнхээ элгэнд наалдсан хүү газар унагасан навчнуудаа авна гэж байгаа болтой гараа сарвалзуулна. Ээж...ээжтэйгээ байх хичнээн сайхан бэ гэж түүнд гэнэт бодогдоход цээж нь харанхуйлах шиг, ээжийнхээ энгэрт наалдмаар бодогдоно. Энэ хараад л баймаар цэмцгэрхэн хөөрхөн бүсгүйн хүү болчих юм сан. Нэг америк кино байдаг даа. Ээж охин хоёрын сүнс нь солигдчихдог. Охинд нь Линдсей Лоан гээд сэвхтэй нүүртэй жүжигчин бүсгүй тоглодог. Тэрэн шиг энэ бүсгүйн бяцхан жаалтай сүнсээ солиод хүү нь болчих юм сан гэсэн тэнэг бодол толгойд нь оров. Яг энэ жаал шиг түүний энгэрт наалдах сан. Хөх нь хичнээн зөөлхөн, хүзүү нь ямар тансаг гоё үнэртэй бол? Ийнхүү бодмогц хамаг бие нь жирвэгнэх шиг болоод явчихав.

Гэтэл утас нь гонгинож мессеж ирснээр бодол нь тасарчихав. Тэр цонхноос холдох дургүй байлаа. Бүсгүй хүүхдүүдээ дагуулан байрны нөгөө булан тийш яваад өгөв. Хичээлийн дэвтэр, тооны номнуудаа хайш яйш хаялсан ширээнийх нь хаа нэгтээ утас нь гомдолтойёо ёнгиноно.

-Аа п...Утас хаачив аа?

Ашгүй ширээний өнцөгт сонины навгархай доор утас нь хэвтэнэ. Энэ навсарсан сонин энд юу хийж байгаа билээ? гэтэл “Утасны амраг” гэсэн том гарчиг нүдэнд нь тусав. Нээрээ энэ эротик өгүүллэгийг унших гэж Хатнаагийнхаас хуучин шар сонин авчирснаа санав.Өвөө харчих вий дээ гээд тэр сонингийн тасархайг шалавхан номын шүүгээ рүүгээ хам хум чихсэнээ утсаа авлаа. Мессеж нь шал дэмий зар сурталчилгаа байв. “Сэрчмаагийн шинэ дууг татаж авахыг хүсвэл ... кодыг хийгээд...” За за больё. Баахан нэгж зулгаана л биз.

Дахин цонх руу очвол гадаа нөгөө бүсгүй харагдсангүй тул сэтгэл нь улам уйтгартай болчихов.

Түүнийг хэн гэдэг бол? Нөхөртэй болов уу? Гар нь хичнээн зөөлхөн, бүлээхэн тэгээд өөрийнх нь гарыг ямархан чанга атгаж байлаа... Тэр тухай эргэн санамагц түүний татаж босгосон зүүн гарын алга халуу оргих шиг нэгэн таатай мэдрэмж төрөх аж. Ийнхүү өнөөх л үл таних бүсгүйн тухай бодол тархи толгойд нь хадагдчихаад зовоож эхлэхэд хүү хүчээр тэр бодлоо хөөн зайлуулаад өдий хүртэл ганц шуудагтайгаа нүцгэн зогсоогоо санаж орныхоо хөлд тайлж орхисон гэртээ өмсдөг богино өмдөө авч углалаа.

Гэтэл утас нь мессеж ирлээ хэмээн гонгиноход дотроо “Бас л дуу тат гэж байгаа биз” хэмээн төвөгшөөсөн мөртөө үзвэл үеэл эгч нь Түүгээр бодлого бодуулахаар айлчлан ирэх гэнэ.

Дээд сургуулийн оюутан байж дандаа түүгээр тоогоо бодуулна. Математикгүй анги сонгочихлоо гэсэн чинь тооны хичээл салдаггүй гэнэ.

Гэдэс нь өлсч байгаа гэж жигтэйхэн. Ходоод нь хоол нэхэн муухай хоржигнон дуугарч эвгүй базлан эсэргүүцлээ илэхийлнэ.Гал тогооны өрөө рүүгээ орвол өвөө нь аяга таваг, сав суулгаа овоо цэмбийтэл угаачихжээ. Чанаж тавьсан махнаас хонины шаант авч кимчитэй хольж хэд зулгааснаа, хөргөгчнөөс хиама гарган талхтай баахан идэж, араас нь нэг зайрмаг, хоёр зүсэм талх идэж ус залгилаад сая цадаж сайхан болоод ширээгээ цэвэрлэв. Өвөөгийнх нь өрөөнөөс “Балдаан хөгшөөн чи надад гурван цайны өртэй боллоо. Өртэй хүн өөдөлдөггүй ээ гэж...”, “Гайгүй байлгүй, гуравхан цай ч гайгүй хэвтэнээ...” “Арван тэрбум идчихсэн хүн аравхан жил авч байхад уу” гэлцэн өвгөдийн хөгжилдөх дуулдана.

Түүнийг хэн гэдэг бол? Чөтгөр гэж, дахиад л нөгөө бүсгүйн тухай бодол ороод ирэхийн. Нөхөртэй бол түүний туяхан бэлхүүсээр тэврэн цав цагаан ноосон цамцыг нь тайлан... за за больё.

Өрөө рүүгээ орж компьютерийнхээ ард суун нетэд холбогдон face book-ээ нээж ахынхаа мессежийг уншив.

Ах нь шинэ найз охинтой болсон бололтой солонгос маягийн этгээд үстэй туранхай

бүсгүйтэй тэврэлдсэн зургаа тавьчихжээ.

За тэгээд нийгмийн ухааны хичээлийн даалгавар эссегээ овоо бичиж эхэлтэл хонх.

-Миний хөө! Түнжин толгойт оо. Хөөе Бямбаа. Хаалгаа тайл аа.

-....Чч гэх шиг. Өвөө нь дандаа Түнжин мүнжин гэсэн тэнэг хочоор дууддагийгаа бас өхөөрдөж байгаа ёошоор нь тэр хэмээн биеээ өмөөрөхий нь яана.

Үеэл эгч нь иржээ.

Тэр уг нь Бямбаагаас гуравхан эгч атал түүнд их эгчирхэнээ.

-За сайн уу?

-Сайн.

Танайхаас кимчи үнэртээд л өвөө та хоёр хангүг хоолонд орж гүйцжээ? гэсээр тэр үүдэнд гутлаа тайлахад нь Биди “Хангүг ч гэх шиг” гээд цааш эргэв. Заяа гутлаа тайлснаа:

-Өө энэ шалных нь шавхайг ээ. Танай шалыг завааруулчихна гээд гутлаа тайлсан биш миний оймс л хохирох нь шив дээ. Заваан юм гээд ээжийнх нь хуучин шаахайг олж углан Бямбаа руу харснаа:

-За чамаар сонин юу байна? гэхэд нь яагаад ч юм хэлэх үг олдсонгүй мөрөө хавчин өрөө рүүгээ эргэхэд нойлын өрөөнөөс ус татах сонсогдон өвөө нь гарч ирснээ:

-Хэн бэ? Аан Заяа миний охин уу? гэсээр ирж духыг нь үнэрлээд:

-Танайхан сайн уу?Охиноо ирнэ гэж мэдсэн бол өвөө нь хоол хийнэ гэж ухнадаггүй л байж гэхэд Бямбаа дотроо”Намайг Түнжин гээд л байсан. Заяаг болохоор миний охин энэ тэр гэж нялуураад л бөөн ялгавар “ гэсхийсэн юм бодон өрөө рүүгээ алхав.

-Би танд банштай цай хийж өгөх үү? гэж Заяагийн тал засах сонсогдсоноо өрөө рүү нь шууд ороод ирэв.

Уг нь цонхоор нөгөө бүсгүйг хүүхдүүдтэйгээ явааг ганцаараа хармаар байсан юм. Ганцаараа баймаар байхад өрөөнд хүн орж ирэх шиг лайтай юм байдаг болов уу.

Хүү цонхноос холдон ширээ рүүгээ очив.

Заяа өөдөөс нь харсан сандалд ирж сууснаа:

-Яагаад урвайчаав. Охидууд тоохгүй байна уу? гээд тас тас хөхрөхөд Бямбаагийн уур хүрч царай нь минчийгээд ирэв.

-Тэнэг юм. Юун охин.Тэр тоогоо гаргаад ир. Би бас завгүй байна гэж дуугарав. Ашгүй

компьютер нүүрийг нь халхлах тул царай минчийснийг нь үеэл эгч гуай анзаарсангүй.

-За за тоглоом байлаа. Хэдхэн бодлого л байгаа даа. Хүүш ээ, Ууганаа найз охинтой болчихсон юм шиг байна лээ тээ? гэсээр боссоноо:

-Хүүеэ манай сургуулийн Од ажаа танай байранд нүүгээд ирээ юу? Монгол нээрээ жижигхэн юм аа гээд цонхоор цээжээ цухуйлгачих шахан хэрэгт дурлахад Бямбаа эхлээд ажиггүй сууснаа сэртэсхийгээд ирэв. Ууганаа гэдэг нь Бямбаагийн ах нь. Бодвол ахынх нь нөгөө face book-тээ тавьсан зургийг Заяа үзсэн бололтой.

-Уг нь дажгүй хүүхэн шүү. Захиралтай учиртайм шиг байгаан. Нөхөр нь шал сонин залуу байсийм аа. Энэ Одыг хаяад өөр хүүхэнтэй болчихчихсон гэсэн. Тэгээд нөхрөөсөө салчихаад л энд нүүж ирсэн юм байх даа. Хараач. Үнэн донжтой оо гэхэд хүү цонх руу очиж харвал өнөөх бүсгүй хар шил нүдэндээ зүүчихсэн хүүхдүүдээ хөтлөн орц руугаа орж явлаа.

Бямбаа түүний тухай асуумаар байвч хорон хэл амтай үеэл эгчээсээ нэрэлхэж :

-Тийм үү? гэхээс өөр үг амнаасаа унагасангүй.

-Нэрийг нь Од гэдгийн. Ийм том охинтой гэж мэдээгүй ш дээ. Аргагүй дээ. Бараг гуч хүрч байгаа хүүхэн ийм том хүүхэдтэй байж л таараа ш дэ. Харахад оворгүй харагдаад байгаа болохоос энэ чинь шал хөгшин хүүхэн байхгүй юу. Тэгсэн чинь манай ангийн нэг гайгүй банди ноднингоос хойш энэнд хайр зарлаад. Энэ чинь манай сургуулийн номын сангийн эрхлэгч байхгүй юу. За тэр ч яахав. Чамд түй ч сонин биш байгаа биз? Сониноос Отгоо эгч мөд ирэхгүй нь үү? хэмээн ярианы сэдвээ өөрчлөв. Отгоо гэдэг нь Бямбаагийн ээж.

-Ээж хэзээ л ирж байлаа даа гэж тэр хайхрамжгүй дуугараад “ Тэр бүсгүйн тухай л яриулмаар байхад түй ч сонин биш гэнэ шүү. Од,Од. Нэрийг нь Од гэдгийн байна. Бас нөхөргүй...” гэж бодохоос цээжинд нь ёстой л од гэрэлтээд байв.

Үеэл эгч нь удалгүй далан хэл дэлгэхээ больж, өвөөгийнх нь хувцаснуудыг индүүдэн, жижигхэн жижигхэн амттай банш чимхэн хоол хийв. Ашгүй өвөөгийнх нь даалууны найз нар ч гэр гэр рүүгээ таран одоцгоож гэр нь нам гүмхэн боллоо. Өвөө нь өөрийнхөө хийсэн бэлэн гоймонтой шөлөнд хоолшоогүй нь илт:

-Охины гарын хоолонд хөлс гарч байна. Маргааш өвөө нь намын хорооны хуралтай. Ашгүй цамцнууд цэмбийгээд бэлэн. Нөхөн сонгуульд энэ Ху намынхан луйвар хийх гээд байна. Өвөө нь маргааш хэсгийн хорооны ажиглагчдын сургалтанд сууна гэхчлэн ярихыг ч анзаарсангүй.

-За... а, өвөө танай ардчилсан намынхан ч адилхан луйвар хийдэг л гэсэн ш дээ. Аав тэгж байна лээ хэмээн Заяа ширэв татна.

Бямбаа нэг л мэдэхэд нөгөө хэдэн бодлогы нь бодож өгөөд, нэг л мэдэхэд үеэл нь явчихсан байв.

Дахин дахин цонхоор хармаар. Тэгэхдээ мэдээж Од хэмээх тэр бүсгүй сэтгэлээс нь гарахгүй байлаа. Ялангуяа түүнийг нөхөргүйг сонсонгуут сэтгэл нь онгойгоод явчихсаныг одоо л мэдэрч өөрийн эрхгүй инээмсэглэчихэв. Гадаа хэдийн бүрэнхий болжээ.

Уг нь ээж, эмээгээ санаж, ах, аавыгаа үгүйлэн, хоёр айлын сууц нийлүүлсэн ханхай том байранд өвөөтэйгээ хоёулхан суудаг хүүд үеэл эгч нь хааяа ирж, гэр цэвэрлэн, элдвийг ярьж, жингэнэтэл инээх нь таатай байдаг сан. Гэтэл өнөөдөр Од бүсгүйн тухай бодолд нь саад хийгээд байснаас ч тэр үү үеэл эгчийгээ тээршаасаар байгаад явуулчихжээ.

Нөгөө өрөөнд өвөөгийнх нь бүгшүүлэн ханиалгах сонсдон, эмээгийн зургийн өмнөх зулын гол шаржигнах, шатаж буй шар тосны таатайхан хурц үнэр хамар цоргино. Гадаа тэнгэр бүүдийн харлаад салхи хүүгэн балбана. Намрын уйтай шөнө. Цонхоор харахад байрных нь гадаах сагсны шийтний шон харанхуйд ганцаардах мэт ёрдойно.

Тэдний байр “Г” хэлбэртэй агаад өнөөх сэтгэл эзэмдсэн Од бүсгүйнх эхний, Бямбаагийнх сүүлээсээ хоёр дахь орц байсан нь юутай аз жаргал вэ гэмээр. Тэдний гал тогооны өрөө нь усан цэнхэр хөшигтэй юм. Нимгэн сиймгэр тэр хөшигний цаана тодрох хар сүүдэр. Бодвол тэр бүсгүй л байж таарна. Нөхөргүй...нөхөргүй бүсгүй. Тэгээд харц булаам сайхан...

-Миний хөө! Унтахгүй юу энэ чинь. Маргааш хичээлтэй биз дээ. Түнжин толгойт минь...

Ээж нь бол түүнийг дуудахдаа өвөө шиг нь “миний хөө!” гэж бус “миний хүү” гэхдээ тэр “үү” үсгэн дээр хайр энхрийллээ шингээх мэт ээвэргүү зөөлөн дууддаг сан.

-За за, унтах гэж байна.

Өвөө нь сонин барьсаар орж ирээд толгойг нь тамхи ханхалсан эрүүгээрээ шөргөөчөөд яваад өгөх нь үнсэн эрхлүүлж буй ёошоор нь тэр.

Хүү маргааш өмсөх цагаан цамц сэлтээ гарган өлгөөд буйдангаа дэлгэн орондоо оров. Бүрэнхийд сиймгэр хөшигний цаана сагсайсан том сонгинон цэцэг том гэгчийн байцаа мэт эсвэл сэгсгэр том толгой ч юм шиг харагдана. Ээжийнх нь тарьж асан тасалгааны олон цэцэг эмээгээс хойш үхэж дуусахад ганц энэ сонгинон цэцэг л өвөө тэр хоёрын хатуу гарыг даан үлдсэнийг Бямбаа өөрийнхөө өрөөнд оруулж цонхон дээрээ тавьсан юм байж. Тэгэхгүй бол услахаа мартчихна шүү дээ. Сонгинон цэцэг...Ээж нь гараараа арчлан ургуулсан юм гэж бодохоор түүнд нэг л дотнохон. Үгүй ойрд цэцгээ услаагүй санагдаад явчихав.

Хүү ширээний чийдэнгээ асаангуут ганц үсрээд л цонх руу очив. Далимд нь бүсгүйн цонх руу харвал гал тогооных нь гэрэл унтарчихжээ. Том өрөөнд нь шөнийн гэрэл боллолтой ногоовтор бүүдийсэн гэрэл асаажээ.

Цэцгээ хэн ч услаагүй лав л гурав дөрөв хоносон болтой шороо нь хатаж гүйцэж. Хүү ус авчран цэцгийг усалж байтал сонгинон цэцэгний зангидсан гарын чинээ их биеийн хажуугаас хар хар толботой улбар шар цох хорхой гараад ирэв.

Хүүхдүүд алтан тэмээ гэлцдэг тийм нэг хөөрхөн тод өнгөтэй цох. Одоо чинь есөн сарын 20.Энэ цох хорхой энд юугаа хийж яваа билээ? Хүү цохыг авч алган дээрээ тавихад нэг атиран дургүйцэх мэт болсноо эелдгээр мэхэлзэх шиг зогтусаад насны зураасыг нь даган аяархан явж эхлэв. Хөөрхий цох гав ганцаархнаа юм байх даа гэж бодоод хүү цэцгийн шороонд болгоомжтой гэгч нь буцаан тавилаа.

Ингэхэд би чинь яагаад ийм уяхан хонгор сэтгэлтэй болчихоов ээ, өчүүхэн цох хорхойг ч өрөвдөөд л ...Хүн уян зөөлөн болж, нүцгэн гараараа улайдсан цог ч барьж, саран дээр ч буучихмаар болдог бадрангуй ганц л юм байдаг нь дурлал. Тэр дурлачихжээ.

Нойр нь хулжиж зөндөө эргэж хөрвөөлөө. Тэгээд тэр дурлалын охин тэнгэр нь ангийнх нь ч юм уу, хөршийнх нь охидын нэг биш, хоёр хүүхэдтэй, өөрөөс нь олон насаар эгчмэд, нэгдүгээр орцонд саяхан нүүж ирсэн үл таних нэгэн бүсгүй байлаа. Элдвийг бодон хөрвөөсөөр арай гэж нэг юм нойрны бурхан нь харж үзэв бололтой, дөнгөж зүүрмэглэж эхлэхдээ тэр гагцхүү Од бүсгүйг л зүүдэнд ороосой хэмээн бодож амжсан юм.

Маргааш өглөө нь Бямбаа өвөөгөөрөө дуудуулсан ч үгүй. Үл мэдэгдэх нэгэн гар сүвээ рүү нь нудраад авах мэт болж, гэнэт сэрчихэв. Цаг харвал долоон цаг. Долоогоос ганц ч хором өнгөрөөгүй байхад өөрөө сэрчихжээ. Хичээл нь найм хорьд эхэлдэг юм.Сургууль нь тэдний байрнаас ганцхан буудлын зайтай. Ердөө л арван хором аажуухан алхаад хүрэх газар. Өвөө нь говийн нэгэн аймгаас залуудаа нийслэлд ирж суурьшин, он удаан жилд нэлээд хотожсон ч үе үе гууль нь цухуйн хөдөөний яриагаар их яринаа. Жишээ нь лаг ойрхон гэхийг “шээсний газар” гэнэ. Нэг үгээр хэлэхэд тэдний сургууль гэрээс нь “шээсний газар” тул Бямбаа үүгээр далимдуулан орноосоо босохгүй лазагнаж хэвтсээр найман цаг болгоод цайгаа ч уухгүй, гэдэс өлөн чигтээ үсрэн алга болно.

Тийнхүү хичээлээсээ хоцроход нь өвөө нь уулгалан сандарч, өмд цамц, цүнхийг нь тэврэн ирээд манжингийн үлгэрт гардаг өвгөн шиг хөнжлөөс нь хүчлэн зулгааж гарна даа.

Өнөө өглөө тийм юм болсонгүй.Үүрийн гэгээ, үлээх урьхан салхи илбэх шиг л сэргэг гэгч нь босч орноосоо сэргэлэн гэгч нь сугаран босов. Урьд нь бүр жаахандаа өглөө эрт цэцэрлэгт явахдаа ээжээрээ үнсүүлж, аавдаа аргадуулан босдог сон. За тэр ч яахав. Аль тэртээд өнгөрөн одсон цаг. Тэр одоо ямар нялх жаахан амьтан биш.

Халуун хөнжил нь урьдынх шиг тийм салж ядам сайхан санагдсангүй. Гадаа шинэ өглөө эхэлж байлаа. Хүү орноосоо босмогц л хөшгөө ярж өнөөх сэтгэлд дотно болж амжсан цэнхэр хөшигтэй цонх руу харлаа.Толгойдоо цагаан тасам зүүсэн бүсгүй хөшгөө нээж цонхоороо ийш тийш харснаа цааш одохтой яг таараад сэтгэл нь баяр хөөр гэмээр хөг эгшгээр дүүрчихэв. Зүрх нь булгилан хөөр догдлолоор хөвсөлзсөөр.

Тэр угаалгын өрөө, хувцасны шүүгээ, ширээ рүүгээ нисэх мэт харайсаар аравхан мөчийн дараа гал тогоо руугаа үсрэн орлоо.

Нөгөө “найз” эмгэнийхээ хийж өгсөн дээлийг нөмрөөд цааш харан цахилгаан зуухан дээрээ цай тавихаар мунгинан зогсч байсан өвөө нь түүний сүр сархийн орж ирэх чимээнээр цочин данхныхаа тагийг унагачихаад:

-Харламар,түнжийсэн хог чинь! Хар эрт босч цочоогоод хаях чинь юув хэмээн уулга алдах зуур данхныхаа тагийг авч тавиад сая сэхээ орж буурал хөмсгөө өргөн:

-Гүй чи чинь.Одоо дөнгөж долоо хорь болж байгаа юм биш үү? Яасан эрт босоов, миний хөө! Цай арай буцлаагүй байна. Амсаад яв гээд духыг нь үнэрлэв.

Өвөө нь хөгшнөө сэрүүн тунгалаг ахуйд өглөөний унд бэлэн болсон хойно аажуухан босч цайны дээж хийж тавьсан дунд гарын мөнгөн аягаа авч нэлээд зөөгшсөн сайхан цай хэд балган их л таатайяа тамшаалж суудаг сан. Тун сэтгэл хангалуун байгаа нь тэр. Өмнө нь эмээгийн гарын боорцог, урьд оройн чанасан хонины хавирга сэлт заавал байдгаас гадна халуун хайлмаг юм уу, цайны ёроолд нь хуурсан будаа хийчихсэн байдаг асан. Тэгэхэд Бямбаа эмээгийнхээ шарж өгсөн өндгийг идэх зуур өвөөгөө ажиглан ”Намайг хөгшрөхөөр бас нэг эмгэн ингээд өглөө бүхэн мөнгөн аяганд нь будаатай цайны дээж аягалж өгөх болов уу?” гэж бодохоор инээд нь хүрдэг байжээ.

Хүү өвгөний хажуугаар шуртхийн цэвэр ус хийж авснаа хөргөгч рүүгээ “шунган” орж өглөөний цайнд хоолой давуулчмаар аяганы хийц гаргав. Мэдээж зайдас, бас өндөг, зүссэн талх. Хүүхдүүд өглөө юм идэж чаддаггүй гээд сургууль дээр өлөн ирчихээд дөнгөж хоёрдугаар цагийн завсарлагаар гуанз руу гүйлддэг бол Бямбаа тэгэхгүй ээ.Өглөө сайн идэж авах хэрэгтэй гэсэн номлолтой. Гэхдээ харин заримдаа таг унтаад хичээлээ хоцрох дөхдөгөөс тэр номлолоо зөрчихдөг юм.

Талхандаа масло зузаан түрхэн, өндөг зайдсаа шараад цайлахаар суусан ч хоол хоолой давдаггүй ээ.

Хүү аяга тавгаа хураагаад өөрийн мэдэлгүй цонх руу очин нөгөө бүсгүйг харуулдлаа. Үзэгдсэнгүй.

Тэгээд цүнхээ шүүрэн гарахаас өөр яах билээ.

-Түлхүүрээ авсан уу миний хөө?

Өвөөгөө тийн хашгирахад нь ч хариу дуугарсангүй.”Чихгүй түнжин толгой” гэж байгаа биз.

Орцноосоо гарвал дан дүрэмт хувцас нь жиндүүлж байнаа. Дөнгөж есдүгээр сарын хорьд гэхэд монголын намрын жавар гэсэндээ даавуун хүрэм жиндүүлэхээр болжээ. Өчигдрийн нэвсийсэн саарал үүлс тэнгэрээс зуурах мэт тогтчихоод хаа нэг сиймхийгээр нь нар туниа муутайхан цухалзсан намрын жиндүүхэн өглөө.

Цаг яагаа ч үгүй эрт байлаа.Одоо сургууль дээрээ очих юм бол хар эрт ганцаараа хичээлдээ ирдэг гээд ёстой бөөн онигоо болно доо. Яагаад ч юм нэг л урамгүй болчихжээ.Өнөөдөр ээж нь утсаар ярих байсан ч баярлаад байх юм алга. Эх үрс хааяа нэг утсаар ярих биш хамтдаа байвал л аз жаргал байх байсан юм.Одоо ч тэр ямар ээжийгээ санаж уйлдаг асан нэг, хоёрдугаар ангийн нусгай биш дээ. Ээж нь түүнийг дөнгөж Д үсэг үзэж арай ядан мурий сарий үг холбож эхэлж байхад Солонгос руу яваад өгч билээ. Тэгэхдээ “Ээж нь ажил хийж их мөнгөтэй болоод хүүдээ дугуй, компьютер, бас чихэвчний хөгжим авчирч өгнө” гэж амлаж

байж билээ.

Хаа холоос ээж нь түүнд мөнгө явуулж дугуй, хөгжим, компьютер авч өгсөн л дөө. Гэхдээ тэр бүхэн эхийн хайрыг орлох юм уу? Ээжийгээ MP3, дугуй, компьютерээр солих уу? гэж захын нэг бацаанаас асуугаад үз л дээ. Тэгвэл мэдээж ээжийнхээ зөөлөн хүзүүнээс тас зуураад ”үгүй, үгүй, үгүй” л гэх байсан. BD ээжийгээ санаж, ирэхгүй болохоор нь гомдож, уурсахдаа тамхинд орсон. Арван хоёр хүрмэгц шилжилтийн нас нь эхэлж, ээж, аав хоёр нь түүнийг голоод явчихсан юм шиг гомдолтой санагдахад тэгэхээс тэгэх гэж болохгүй бүхнийг хиймээр санагддаг болж билээ. Тавдугаар ангид ороод нэг хэсэг гадуур тэнэмээр санагдан нэг хэсэг болдоггүй хүүхдүүдтэй нийлээд авсан ч удаа бий.

Өглөө сэрэхэд нь ээж нь ирчихсэн гал тогоондоо түүний дуртай үзэмтэй шарвин хайрч сайхан үнэр нь гэрээр нэг түгж байгааг мэдрэхэд баярласандаа орноосоо год үсрэн босч хөл нүцгэн гүйсээр очоод ээжийнхээ бэлхүүсээр тэврэн авч...”Ээж ээ, та одоо хаашаа ч явахгүй, тийм ээ? ” гэж асууж байна...Ээж ирчихсэн. Ямар гоё вэ? Одоо ээжийгээ хаашаа ч явуулахгүй юм шүү. Гэтэл энэ харамсалтай нь дандаа л зүүд байдаг байсан.

Харин одоо...тэр аль хавар 16 хүрчихсэн. Иргэний үнэмлэхээ ч авчихсан. Өнгөрсөн энэ есөн жилд хайрт ээжийнх нь дүр сэтгэлд нь бүдгэрэн бүдгэрсээр бага насны бүүр түүрхэн дотнохон дурсамж алсад хоцорч, одоо ердөө л хаа нэгтэйгээс утсаар ярьж мэнд мэдэлцдэг, мөнгө төгрөг явуулдаг л нэг хүн болон хувирсан мэт.

Үсээ босгон гелдээд хамгийн дэгжин цүнхээ үүрэн намрын энэ жихүүн өглөө эрт алхаж яваа түүний сэтгэлийг одоо ээж нь биш, хахь хар элгийн өөр нэгэн эмэгтэй эзэмдчихээд байлаа. Зүрхийг нь ганцаараа эзлэнхэн байсан ээжийнх нь байр бүр алсын булан руу шахагдаад оронд нь сайхан инээмсэглэл цацалсан, жижигхэн бүлээхэн гартай, голшиг хөөрхөн бүсгүй эзэгнэчихлээ гэж үү?

Тэр одоо л нэг гараад ирэх болов уу хэмээн горьдон бүсгүйн орцны зүг өөрийн эрхгүй харсаар зогслоо. Орцны хуучин хаалга чахран нээгдэх бүрд тэр бүсгүй огтоос биш, дандаа өөр хүмүүс гарч зүг зүг рүү яаран одоцгоох нь урамгүй.

Од, Од, Од. Тэр бүсгүйг л ганц харах гэж хүү энэ өглөө тийм эрт сэрснээ одоо л ухаарах мэт. Тэгээд хамгийн гайхалтай нь Бямбаа яг долоод сэрэх юм шүү гэж огт төлөвлөөгүй, утсандаа сэрүүлэг ч тавиагүй билээ. Ердөө хар аяндаа л хажуугаас нь нэг юм ёврох мэт болоод сэрчихсэн.

Мартсанаас цаг хэд болж байгаа юм бол оо? Дөнгөж долоо дөч. Бүүр холын сургуульд явдаг ганц нэг хүүхэд л нойрмог нүдлэн гарч яваа үзэгдэхээс биш найзууд нь бараа ч алга. Өчигдрийн түүний унасан шавхай нэлээд өтгөрөн хатаж, дээгүүр нь намрын хяруу мөнгөрөн цайрна.

Hi bosson u? Vi gadaa bn. Yavah u? Хатнаа руу нэг ийм мессеж явуулаад цонх руу нь харав. Найз нь цамцаа ч өмсөөгүй цээж нүцгэн нүдээ нухалсаар цонхоороо шагайсанаа “тэнэг” гэж байгаа болтой долоовроороо чамархайгаа эргэдээд цааш орчихов.

Бямбаа инээд алдав. Толгой сэргэлэн, агаар цэнгэг. Өглөө эрт босох ч тийм муугүй юм гэдгийг тэр ухаарав. Хаашаа ч яарахгүй, уужуу тайван, ёстой эр хүн шиг маадайтал алхангаа элдвийг эргэцүүлэн бодох зав зайтай.

Хатнаа ч гарч ирдэггүй. Од бүсгүй ч байдаггүй. Гар утасныхаа бүх л тоглоомыг ухаж дуусах гэж байтал найз нь ам дүүрэн хиам чихээстэй гарч ирэхэд хэдийнээ наймаас 11 хором өнгөрч хичээл эхлэхэд есхөн хором дутуу байлаа. Сургууль хүртэл хар гүйхээрээ л очиж амжих нь. Тэгтэл нэгдүгээр орцны хаалга тасхийн:

-Цэцэллэгтээ явахгүй ээ! Чиний ажил луу явна гэж уйлан дуугарах хүүгийн дуу хадаад явчихлаа.

Бямбаа тийш сэртэсхийн харвал зүрх нь догдлон булгилаад явчихав. Тэр гараад иржээ.

-Хүүхэд ажилд явж болдоггүй юм гэж тэр орилоо хүүдээ хэлээд газар тавив. Охин нь ээжийнхээ нөгөө талд үүргэвчээ үүрчихсэн зогсоно. Бүсгүй өчигдрийнхөөсөө ч илүү гоё, нүд булаам хөөрхөн харагдана. Тас хар цув, гоё шилбийг нь тас барьсан, урт түрийтэй, өндөр өсгийтэй хар гутал, задгай үс...

Түүнд хажууд нь зогсоод хиам зажлах Хатнаа найз нь, хичээл ном, өвөө, хаяад явсан аав, Америкт байгаа ах, өнөөдөр Солонгосоос утсаар ярих ээж, намрын энэ бүрхэг зэврүүн өглөө ер нь хорвоо ертөнц бүхэлдээ огтхон ч сонин биш, гагцхүү богиновтор хар цув, задгай үстэй энэ гоё бүсгүйг л нүд салгалгүй ширтэн зогсоод баймаар байлаа.

-Алив, ээж нь ажлаасаа хоцорлоо. Ану, дүүгээ харж бай. Ээж нь такси бариадхая.

Түүний дуу хоолой хичнээн уянгалаг сонсогдсон гэх вэ. Удалгүй шар такси давхин ирж тэр гурав явж, Бямбаа ч найзтайгаа сургууль руугаа амьсгаадсаар гүйлээ.

-Би ди! Чи чинь өнөө өглөө яачаав? Зүүлэг юм шиг болчоод? Гоё пүүз ээж чинь явуулаа юу?

Хүү өнгөрсөн долоо хоногт ээжийнхээ хүнээр явуулсан шинэ загварын "Nike"-ийг өмссөнөө сая санах.

-Аль эрт явуулсийм аа.

-” Nike”-ийн шинэ загвар байна. Лайтай гоё юм аа.

-Монголд лав орж ирээгүй байх аа гэж хэлэхдээ Бямбаа пүүзний тухай огтхон ч бодохгүй байлаа. Хатнаа ч яахав дандаа хувцас, гангараа л сонирхдог хүн. Одоо ч өөрөө бас л “лайтай” “Adidas” жийчихсэн л байлаа.

Тэр өдрийн хичээл яасныг мэдэхгүй нэг л мэдэхэд дуусч багш нь маргааш ангийн цонх дулаалах тухай зарлаж байлаа. Ангийн багшийг дөнгөж гарч хаалга хаагдаж дуусаагүй байхад:

-Хөвгүүд ээ ангиараа “Тэнгис” оръё оо. “Ертөнцийн сүүлчийн өдөр”-ийг үзье! гэж хүүхдүүдийг дандаа шоу цэнгээнд уриалж байдаг Гүнжээ гэдэг өндөр охин хашгирна.

-Тэгье л дээ.

-Манайхаан, маргааш цонх угааж, дулаалах хар ажилтайм чинь өнөөдөр кинонд явъя аа.

-Мөнгөгүй ирсэн ш дээ.Билет нь үнэд орчихсон байна лээ.

-Киану Рийвз тоглосон биз дээ?

-Ёстой гоё залуу шүү гэлцэн шуугилдахыг Бямбаа л ганцаараа сонсоогүй мэт бодол санаа нь алсад одсон байлаа.

-Чи кино үзнэ биз дээ? гэж Хатнааг нудрахад л тэр сая ухаан орж орчиндоо бууж ирэв.

-Үгүй мань харимаар байна гэснээ:

-Тэр кино чинь саяхан 25-р сувгаар ч бил үү гарчихсан биз дээ, манайхаан? Би л лав харилаа гэхэд Гүнжээ:

-Өөрөө явахгүй юм бол билетний мөнгөгүй ганц охинд ч гэсэн хандиваа өгөөд яв л даа BD! гэхэд ангиас гарахын түүс болсон хүү “За за, май” гээд халаасаа ухаад гарч ирсэн гурван мянган төгрөгийг ширээн дээр тавьчихаад хаалга руу зүглэхэд Гүнжээгийн дуу гарч:

-Номько чи мөнгөгүй гээд байсан биз дээ?Энийг авчих. Манай BD ингээд л охидын хайрыг татдаг байхгүй юу даа хөвгүүд ээ гэсээр үлдэж ангийхан нь шуугилдах чимээ хаалганы цаана хоцров.

Номин-Эрдэнэ гэж даруухан жижигхэн охиныг түүнд сайн гэж найзууд нь хэлдэг, охид ч тийн шивэр авир гэлцэхийг Бямбаа сонссон ч гэсэн төдий л анзаарч хайхралгүй өдий хүрчээ.

Харин Гүнжээгийн тухайд бол жинхэнэ хутган үймүүлэгч.Түүний өгсөн мөнгийг заавал Номинд өгөх гэж байгаа нь, өөрийг нь хөөргөнгөө бусад хөвгүүдийг хатгаж байгаа нь, бас багш нарын нүдэн дээр таг дуугүй ноомой дүр эсгэдэг атал далдуур ангийнхнаа болохгүй бүтэхгүй юманд байнга уриалан дуудах атал хэрэг бишдэхэд гэмгүй царайлан сугарч үлддэгт нь дургүй хүрмээр. Хэрэв Гүнжээ санаачлаагүй бол Бямбаа зурагтаар үзчихсэн ч гэсэн тэр кинонд хүүхдүүдтэй хамт явах л байсан юм.

Гэхдээ үгүй ч байж магад. Өнөөдөр түүний хувьд энгийн биш онцгой өдөр юм шиг санагдах атал юу хийх, яах учраа олохгүй нэг л сонин байв. Ямар ч гэсэн үдээс хойш тооны сонгондоо явдаг хэрэг. Харин тэр хүртэл юу хийхэв? Сургуулийнх нь гадаа бага ангийнхан үймэлдэн, түүний бараг бүсэлхийнээс доогуур татахаар бяцхан жаалууд хөөцөлдөн гүйлдэж, толгой эргэм их шуугиантай байв. Цүнхээ даахгүй шахам бяцхан мөртөө хөөцөлдөн гүйлдэж өөрийг нь дайрчих алдан хөгжилдөх тэр бяцхан жаалуудыг хараад Бямбаа өөрийнхөө нэгдүгээр ангид анх орж байсан тэр мартагдашгүй намрыг дурсан түүнээс улбаалан ээжийгээ санаж хөмсөг

зангидав.

Өөр сургуульд сурдаг Байка хичээл тараад яах гэж байна? гэсэн мессеж явуулж байна. Юу гэж хариу бичих вэ? “I don t know” гэж хариу явуулаад гэрийн зүг залхуутай гэлдрэв. Ашгүй Хатнаа ангийнхантай кино үзэх гээд хоцорсон нь яамай. Түүнд өнөөдөр, яг одоо ганцаараа баймаар, өөрөө өөртэйгээ ярмаар, элдвийг эргэцүүлэн бодмоор байлаа.

Тэнгэр овоо цэлмэж, нэвсгэр саарал үүлс намрын хонгор салхинд бутран тэнгэрээр нэг тарж сарниад үд нэлээд өнгөрсөн ч дээр хөөрсөн нар илчтэйгээ ээж байлаа.Өглөө дан дүрэмт хувцастай жиндээд байсан бол одоо харин ч халууцах аядмаар бараг л зургадугаар сарын сэрүүвтэр өдрийнх шиг дулаахан, бүүр халуун ч гэмээр болчихсон байв. Намрын ааль гэж өглөө жиндүү, өдөртөө дулаахан, яг л жаахан юманд уцаарлаж гомдоллох буюу эсвэл дорхноо уяран хайлж суудаг хөгшин хүн шиг ч юм уу даа.

Түүний тухай бодохгүй сэн гэж хичнээн хичээх тусам нэгдүгээр орцонд нүүж ирсэн мөнөөх гоё бүсгүйн тухай бодчихсон явж байв. “Шал хөгшин 27-той бил үү 28-тай хүүхэн ш дээ. Манай ангийн нэг дажгүй банди энэнд хайр зарлаад...” гэж Заяагийн ярьсан санагдангуут “Юу нь хөгшин байгаан?Өөрөөс нь дутахгүй л залуу охин шиг харагдаж байсан даг. Од бол юун Заяа...үнэхээр хараад баймаар хөөрхөн хүүхэн...” хэмээн тэр бодлоороо үеэл эгчтэйгээ хэрэлдэх шахуу болчихсон явж байлаа.

Сургуулиас гэр хүртэл урьд нь ийм хурдан ирж байсан болов уу, бүү мэд. Эсвэл удаан ч явсан юм уу. Нэг л мэдэхэд байрныхаа гадаа ирчихсэн өнөөх цэнхэр хөшигтэй цонх руу ширтэн зогсч байлаа. Тэдний тагт нь яг орцны хаалганы саравчны дээхэнд байдгийг сая анзаарав. Тэр саравчин дээр гараад л цонхоор нь шагайчихаж болохоор. Хөшиг нь нээлттэй, цонхных нь тавцан дээр нэг хоосон ногоон ваар харагдана. Энэ вааранд нь цэцэг хийж өгөх сөн гэж бодчихоод өөрөө их л ичих аядан эвгүйрхсэн тул гэр рүүгээ алхав.

Өвөө нь намын ажилдаа гарч одсон болтой гэр нь эзгүй байсанд ямар их баярлав аа.

Усанд ороод хөгжим сонсдог хэрэг. Уснаас гарч ирээд үдийн цайгаа уух гэж баахан өндөг шарсан ч хоол идэх дуршил нь хаашаа ч юм алга болчихжээ.Өндөгнийхөө талыг нь ч барсангүй. Ээж нь утсаар ярив.

“Өвөө нь сайн уу?Ах нь ярьж байна уу?Ээж нь хүүдээ юу явуулах вэ?Өвөөгөө сайн асраарай.Тооны сонгондоо явж байна уу?...” ямар ч сонирхолгүй яриа болов. Нэг л их утасны цаанаас зааж зааварладаг, мөнгө төгрөг явуулдаг ивээнгүй хүн. Хүү нь юу бодож санаж, юунд шаналж, юунд баярлаж хөөрч яваа юм, дөнгөж долоотой цүнхээ даахгүй жаахан амьтан байхад нь орхиж явснаас хойш ямархуу хүн болж өсч байгааг мэдэхгүй, хааяа л нэг утсаар ярьдаг хүн.

Хэлдэг үг нь “Юу захих вэ?Юу захих вэ?” Хэдэн жилийн өмнө бол ээжийгээ өөрийг нь захих байсан.Тэр үед ээж, аавыгаа санаад хааяа орондоо шээчихдэг, ялангуяа ээжийгээ тэсэхийн эрхгүй их санан бараг л бэтгэрч байсан үе бий. Ямар сайндаа нэг удаа есөн насны төрсөн өдрөөрөө дэлгүүрт аав, ээжтэйгээ хамт яваа хүүхдийг хармагц цохиод авмаар санагдаж, уурандаа зүв зүгээр байж байгаад уйлчихаж байхав дээ.

Түүнийг өрөөндөө ийнхүү бодлогоширч хэвтгэл хаалганых нь хонх огцом часхийхэд тоглоомгүй бондосхийтэл цочсондоо уцаарлан “Хэн байдаг байнаа?” гэсээр үүдний хонгил руугаа алхав. Өвөө нь мэдээж биш. Өөртөө түлхүүртэй, тэгээд ч хонхоо тун намбатайхан дуугаргадаг хүн.

-Хэн бэ?

-Сонгуулийн материал өгөх гэсийн...

Дурангаар хараад хаалгаа тайлбал хижээл насны хоёр эмэгтэй баахан сонин, бас танилцуулга барьчихсан зогсч байв.

-Миний дүү, танайд хувьсгалт намаас мөнгө тараагаагүй биз?

-Үгүй ээ гэж тэр уцаартай хэлээд өгсөн сониныг нь авангуут хаалгаа тасхийгэл хаалаа. Орон нутгийн нөхөн сонгууль гэж ядаргаа. Ногоон нам гэнэ үү? Тийм байлгүй дээ. Уг нь өвөөгийн нь Ардчилсан намын идэвхтэн гэж мэдээд Ху намынхан тараах материалаа өгдөггүй юм. Хүүгийн хувьд хамгийн утгагүй сэдэв бол улстөр. Гэтэл томчууд тэр тэнэг зүйлээ нээх утга учиртай гээд бодчихсон, зурагт асаахаар л улстөр, хааяа нэг өвөөгийнхөө сонинг аваад үзэхэд л тэр гишүүн тэгэв, энэ гишүүн ингэв, тэр нь авилгачин, энэ нь ард түмний төлөө гэхчлэн дэндүү сонирхолгүй юмаар дүүрэн байдаг билээ. Тэгээд бүүр сонины эхний нүүрээс авахуулаад л хамаг зай талбайг тэр гишүүд, дарга, сайд нар нь эзлэхийг яана. Тэд ямар Холливудын одод биш дээ. Чааваас гэж. Өвөө нь хүртэл тэтгэвэртээ гарсан атал ардчилсан нам, ардчилсан нам гэж гүйнэ. Гэтэл ВД шиг хүүхдүүдийн хүсэл мөрөөдөл, тэдний амьдрал, зовлон бэрхшээлийг сонирхдог хүн гэж байдаг юм уу? Хүн бүхэн нас насандаа өөртөө таарсан зовлонтой, хүсэл мөрөөдөл, өөрийн гэсэн ертөнцтэй байдаг шүү дээ. Гэтэл заримдаа сонирхоод тэр сонгуульд нэр дэвшиж буй хүмүүсийн мөрийн хөтөлбөр ч гэнэ үү худлаа үнэн юмыг нь аваад уншихаар тэтгэврийг тэгж нэмэгдүүлнэ, эмзэг ядуу өрхөд тэгж тусална, өрх толгойлсон эхчүүдийг тэгнэ ингэнэ ч гэх шиг мэдээжийн баахан юм байх атал түүн шиг хүүхдүүдэд хэрэгтэй тийм ийм юм хийнэ гэж огт байхгүй шүү. Гэтэл тэдний ээж нь ч ааваас нь салсан юм чинь “өрх толгойлсон” эмэгтэй шүү дээ. Тэгээд ээж нь найм, есөн жилийн турш үр хүүхэд, хөгшин эцэг эхээ орхин Солонгост оймсны үйлдвэр, жимсний талбайд ажилласаар л байгаа нь хэн гэгч улстөрчид хамаатай байгаа юм бэ? Шаал худлаа гэж хүү бодно.

Байка хичээлээ тарж ирээд хамт маханд явья гэхээр нь зөвшөөрлөө. Байкагийн хувьд дандаа гэрийнхээ ажилд тусалдаг, бас түүнээс мөнгө шаналгаад байдаггүй, тэгээд ч юм юманд үнэн сэтгэлээсээ ханддаг, бас их нямбай хүү билээ. Бямбаа далимд нь нь хүнсний захаас гэртээ жаахан юм аваад өвөөгөө ирэхээс өмнө өөрийнхөө чаддаг ганц хоол будаатай хуурга хийж тавилаа. Дараа нь гэрийн даалгаврын хэдэн бодлогоо гаргаж баахан суулаа. Цаг явж өгдөггүй дээ.

Өвөө нь дөрвөн цагийн үед нэг залгав. Нам дээрээ ажилтай, дараа нь нэг айлд очоод харих гэнэ. Тэр айл гэдэг нь нөгөө найз эмгэн нь биз. ”За тэгвэл энэ гар чинь хоол идэхгүйм байна даа” гэж Бямбаа бодсоноо нет рүү орж баахан сайтаар хэслээ. Харин порно сайт руу л орсонгүй. Түүн шиг хөвгүүдийн хамгийн сонирхдог юм чинь уг нь порно сайт л даа.

Байсхийгээд л Одын цонх руу харна. Сонгинон цэцгээ хажуу тийш жаахан зайчлахгүй бол хамаг цонх халхлаад байв. Нүдэнд нь нэг юм бүртэлзэх шиг болоход нь анзаарвал нөгөө нэг алтан тэмээ цох цэцэгний хажуу бөөр хавиар явж л харагдана. Зургаан цаг болох нь, хүү гэртээ байгаад байж тэсэхээ болиод гарлаа. Гадаа налгархан сайхан намрын орой болж байв. Өчигдрийн бүүдийсэн тэнгэр нүүрээ угаасан мэт цэмцийгээд хүүхдүүд шуугилдан тоглож, хөгшид гадаах модон сандал дээр салхилан сууцгаана.

Тэгтэл нэгэн цагаан Accent ирж зогсоход Од хоёр хүүхэдтэйгээ гартаа том ууттай хүнс бололтой юм барьчихсан гарч ирэв. Бямбаагийн зүрх түг түг цохилон ам нь хатах шиг болж, хүүхнийг нүд салгалгүй ширтэв. Тэр улам ч хөөрхөн харагдах аж. Хар цувныхаа энгэрийг задгайлан шилээ толгой дээрээ тохсон байна. Өглөө цэцэрлэгтээ явахгүй зөрүүдлээд байсан жижигхэн жаал нь зайрмаг долоож хацар ам нь халтайсан юм ээжээсээ зуурчихсан машинаас буухад эгч нь арай том юм гэсэндээ дүүгийнхээ нөгөө талаас нь хөтлөв. Хүүхэн эргэн тойрныхоо юуг ч анхаарахгүй нэлээд ядарсан бололтой бушуухан орц руугаа зүглэв. Мэдээж тээр тэнд урт модон сандал дээр суугаад өөрийг нь хулгай нүдээр ширтэж байгаа BD-г бүүр ч авч хэлэлцсэнгүй ээ.

-За гурвуулаа гэртээ ороод ээж нь гоё хоол хийнэ.

-Ээж та хуушуур хийнэ шүү.

-Амралтын өдөр хуушуур хийе, тэгэх үү? гэлцсээр орц руугаа орцгоов.

-Хөөрхий нөхрөөсөө салж байраа хоёр хуваагаад нүүж ирсийн гэсэн энэ “охин”.

-Тийм гэнэ лээ. Сайхан охин юм. Нөхөр нь айхтар зоддог золиг байсан гэнэ лээ. Эднийх нөгөө хадгаламж зээлийн хоршоонд мөнгөө алддаг Должингийн хүргэний байрыг авсан байхгүй юу. Должин одоо хүүгийнхээ байгаа. Охин хүргэн хоёр нь гадагшаа гарсан гэсэн.

-Должин зайлуул, орон байраа алдчихдаг. Мөн хэцүү еэ.

Хажууд нь суугаа хоёр эмээгийн ярианаас хүү Одын тухай иймэрхүү юм олж чих дэлсэв.

Од бүсгүйг олж харсан тэр өдрөөс хойш хүүгийн амьдрал орвонгоороо эргэж билээ. Ээжийнхээ явуулсан мөнгийг утга учиргүй үрэхээ зогсоож найз нартайгаа тэнэхийн оронд гэртээ тоогоо бодон, англи хэл үзэн суух нь ихсэв. Бүсгүйг өөрөөс нь олон насаар эгчмэд гэдгийг санан санан ухаан бодлоосоо дүрийг нь зайлуулах гэсэн тэмцэл хэдэн сар үргэлжлээд эцэст нь тэр бууж өгчээ.

Одоо өглөө орондоо урьдынх шиг лазагнан хэвтэж, хичээлээсээ хоцрох гэгчийг ор тас мартжээ. Өглөө бүр яг л Одыг анх харсан тэр өдрийн маргаашийнх шиг эртлэн босч заншив. Тэгээд хүүхнийг хоёр хүүхдээ дагуулан ажилдаа гарахыг харах л гэж заавал эртлэн гарч хүүхдийн тоглоомын талбай дахь хуучин сүүдрэвчинд суун ажиглана.

Өдөр юу ч хийж байсан түүний л тухай бодно. Орой хүүхдүүдээ аваад гэртээ ирэх цагийг нь

анаж хүлээн сууна.

Бас Бямбаа хорооны нийгмийн ажилтан залууд туслах нэрээр айл өрхүүдийн бүртгэлээс түүний тухай ихийг мэдэж авчээ. Ам бүл гурав, боловсрол дээд, нас 28...Өөрөөс нь даруй 12 насаар эгчмэд бүсгүй байх нь. За тэр нас мас ч дурласан зүрхэнд ямар ч хамаа байхав дээ. Зүрхэнд үрчлээс суудаггүй гэдэггүй бил үү? Нас бол зүгээр л тоо гэдэг биз дээ? Харин тавдугаар сарын нэгэнд Түүний төрсөн өдөр нь болдгийг утсандаа тэмдэглэж авчээ. BD-г хорвоо дээр сураг ч үгүй байхад хоёрдугаар амаржих газар төрсөн Одыг хэдийнээ 12 хүрчихсэн үеийнхээ хөвгүүдтэй хөтлөлцөн гүйж, магадгүй анх удаа үнсэлцэж үзэж байхад Бямбаа гэж улаан нялзрай юм хорвоод мэндэлж, ээж нь уяран, ах нь дэвхцэж, аав нь урам хугарч байж дээ. Ингэхэд тэр хичнээн хүнтэй үнсэлцэж үзсэн бол? гэхээс хардлагын хар манан тархийг нь бүрхээд авах нь тэр. Нөхөр нь ч юм шиг хардаад байхдаа ч яахав дээ. Түүнд Одыг хардах эрх байгаа юм уу? Тэнэг амьтан. Харуулдан харуулдан байж бараагий нь харах төдийд хөөрөн баярлаж, хулгайгаар цонхыг нь гөлөрч яваа нь зол. Хамгийн гол нь тэр нөхрөөсөө салсан ганц бие бүсгүй. Ганц хараад л зүрхэнд нь од шиг гэрэлтэн, сэтгэлийг нь эзэмдэж гүйцсэн гайхам гоё хүүхэн шүү дээ. Ийм бүсгүйгээс салж байдаг нөхөр нь гэж ямар тэнэг амьтан байдаг бол? За даа энэ тухай бодож тархиа чилээгээд ч яахав дээ.

Харин Бямбаа хичээл дээрээ ирэхээрээ ангийнхаа Номин-Эрдэнэтэй хааяа харц тулгармагц гуниг дүүрэн нүднээс нь өөрийнхтэйгээ яг адилхан шаналлыг олж хараад хурдхан нүд буруулдаг байлаа. Урьд нь хичнээн ч Номио “BD-д сайн” гэж халти сонсч байсан ч юман чинээнд боддоггүй байж. Ер нь урьд тэр охиныг огт анзаарч хардаггүй байсан бол одоо зовлон нэгтэн болсноо ухааран өөрөө түүндээ улам ч шаналдаг байлаа. Номин-Эрдэнэ өөрт нь зүгээр ч нэг “сайн” биш бололтой. Тэглээ гээд яая гэхэв дээ. Одтой түүнийг зүйрлэхийн аргагүй байлаа.

Нас бие гүйцсэн хүүхэнд л бүрддэг өөртөө итгэлтэй гэрэлтсэн харц, намбалаг хөдөлгөөн, болж гүйцсэн жимс шиг гоолигхон бие галбир, тэгээд гагцхүү түүнд л байдаг эвлэгхэн төрх, сэтгэл татам дуу хоолой, дэгжин хувцаслалт, ер нь тэр бүсгүйн төгс гоо үзэсгэлэнгийн өчүүхэн ч хэлтэрхийг үеийнхээ охидоос, нэн ялангуяа туниа муутай жижигхэн, даруухан Номиогоос тэр олж харж чадахгүй байлаа.

Сар өдөр ээлжлэн өнгөрсөөр байлаа. Шинэ жилийн дараахан нэг орой Бямбаа , Хатнаатай хамт явж байгаад хоёр оюутан охинтой танилцан дискодоод дараа нь буудалд хоночихоод үүрээр гэртээ ирэв. Жаахан пиво л уусан боловч толгой нь ангалзан, хямдхан буудлын жижигхэн өрөөнд болж өнгөрсөн тэр нэгэн явдалд нэг л дур гутан байлаа.

-Чи чинь хаачдаг хүүхэд вэ?Тархигүй гэдэг нь! Муу эхийнхээ махаа зулгааж олсон хэдэн төгрөгийг хайрлахгүй ээ чи! Бяруу болоогүй байж бухын баалтаар баана гэнээ, муу түнжин толгойлсон хог гэхчлэн өвөө нь нэлээд эрүүний “шөл” чанаж байснаа, тэгсхийгээд чимээгүй болсон нь ч сонин биш.

Цаг хэдийнээ гурав өнгөрчээ. Тэр аль 13-тайдаа зандан биш болсон байлаа. Өөрөөс нь сайндаа л хоёр гурван насаар эгч оюутан охин түүнд ямар ч таашаал өгсөнгүй. Өвдөгний ором гарсан хямдхан жийнсний цаанаас харандаа шиг чөргөр гуя нь ёрдойх, усанд ороогүй лавтай тав зургаа хонож буй нь илт тослогтож гүйцсэн шингэхэн үснээс нь нүүрс үнэртэж

байсныг бодоход гэр хорооллынх биз. Цагийн арван мянгын хүүхэн. Тэр хүүхний муухай хурц нялуун үнэртэй ус нь одоо хүртэл санаанаас нь гарахгүй улам ч ой гутаасаар байлаа. Зочид буудлын хоёр ортой хямдхан өрөө, хээ нь бүдгэрсэн хуучин хивсэн дээр тараан хаясан тэр хүүхний хуучин, өнгө алдсан хувцас. Хөхөвчөө өөрөө тайлан ор руу тонгойход тэр үнэртэй ус нь үснийх нь үнэртэй холилдон дотор муухай оргимоор нилхийсэн нь, шингэн гэзгээ өрөөсөн мөр рүүгээ шидэлснээ сурмагаар хэвтээд өгсөн нь, хажуугийн орон дээр Хатнаагийн уухилж байсан нь сэрэл хүслийг нь улам ч унтраачихсан. Өнцөг нь элэгдчихсэн цүнхэндээ дэвтэр ном чихчихсэн байсныг бодоход хичээлээ тараад хариагүй яваа тэр охиныг гэрийнхэн нь дээд сургуульд нэг их эрдэм ном сурч яваа л гэж боддог байх даа. Аягүй бол гэрээс нь хэн нэг нь BD-ийн аав, ээж шиг Солонгост ажиллаж байж түүний сургалтын төлбөрийг төлдөг биз.

Одыг хүсэмжлэх сэтгэл нь бие махбодын хэрэгцээг нь хангаж чадахгүйгээс хойш хаашдаа өөр охид, хүүхнүүд амьдралд нь орж ирсээр байх нь тодорхой ч сэтгэл зүрх нь үүнийг хууран мэхлэлт хэмээн үзэж цээж хөндүүрлэн гэмших сэтгэл тэсэхийн эрхгүй шаналгах аж. “Уучлаарай Од минь”. Тэр цонхон дээрээ ирж сонгинон цэцгээ зайлуулаад Одын цонх руу харлаа. Мэдээж тэдний хоёр цонх харанхуй. Тэр цонхнуудын цаана түүний мэдэхгүй амьдрал нууцаа таг харанхуйд тас нууцлах мэт. Хэзээ нэгэн цагт энэ цонхны цаадахь амьдралд нэвтрэн тэр тэнгэрлэг бүсгүйн зүрх сэтгэлд хүрч чадах болов уу?

Удтал нойр хулжин хөрвөөсөөр бараг унтаж чадаагүй ч маргааш нь яг л долоон цагт тэр сэрчихсэн байлаа. Тэгээд сэрэнгүүтээ мөнөөх цэнхэр хөшигтэй цонхыг харлаа. Цэнхэр хөшиг нь нээгдчихжээ. Сэтгэл нь нэг л аятайхан баяр хөөртэй болж, сонгинон цэцгийн хар шороон дээгүүр залхуутайяа явах цоохор цохны нуруу руу хөнгөхөн няслаад хувцаслаж эхлэв. Энэ цох ингэхэд ганцаараа уйддаггүй юм байх даа гэж бодсон ч тэр дороо өмсөх хувцсаа бодон хөөрхий шавьжны тухай мартаж орхив.

Өмд, цамцнуудаа анх удаа л шүүмжлэлт нүдээр харлаа. Дандаа л элбэг халхгар загвартай цамцнууд нь гэж орны даавуу шиг өргөн, зарлалын самбар шиг эрээн мяраан. Дүр төрхөө эрс өөрчлөхөөр шийдлээ. Ийм хувцас хунартай амьтныг Од шиг дэгжин гоё хүүхэн хэрхэн тоох вэ дээ. Салбаганасан хүүхэд л харагддаг байх даа би гэж бодонгуут толгойгоо сэжин өөртөө эгдүүцэв. Арван зургаан нас гэдэг хүүхэд наснаас хагацах болсон цаг аа. Өвөө нь мэдээж босчихсон ханиалгах нь дуулдана.

Хүү өөртөө хамгийн намбалаг санагдсан бариудуу хар ноосон цамцаа шүүгээнээсээ сугалан авч углах зуур өнөөдөр дэлгүүр хэсдэг хэрэг гэсэн бодолтой гал тогооны өрөө рүүгээ орлоо.

Өвөө нь цай чанаагүй байв. Хурдхан шиг цэвэр ус залгилан, ганц өндөг шарж идчихээд гардаг хэрэг гэж бодсоноо өдийд гал тогооны өрөөнд цай чаначихсан данх саваа дүй муутай хангинуулж байдаг өвөөгөө яагаад орондоо хэвтээд байгаа билээ? гэж гайхсандаа амандаа өндөг үмхэлсэн чигтээ өрөө рүү нь зүглэв.

“Би ч өөдгүй амиа бодсон амьтан юм аа” гэж тэрхэн зуур өөрийгөө зэмлэж амжаад өвөөгийнхөө өрөө рүү шагайлаа. Аав, ээж, ах, эмээ, өвөөтэйгээ байсан өнөр гэр бүлээс түүнтэй үлдсэн цорын ганц дотнын хүн өвөө нь биш үү?

Хуучны хүн гэдгийг нь илтгэх цагаан майк хөнжлөөс нь цухуйн цаашаа хараад хэвгэж байсан өвөө нь эргэн харж:

-Миний хүү явахгүй яагаав?... гэхэд нүд нь сэлхэрчихсэн харагдав.

-Таны бие зүгээр үү?Өвөө...

-Толгой маналзаад л байхын...Гүй миний хүү овоо доо. Өвөөгөө яав, ийв? гэж санаа тавьж байдаг хэмээгээд өвөө нь ядруухан мушийв. Өвөөгийнх нь өрөө бүгчим, ойрд олигтой цэвэрлээгүйгээс тоостой байлаа. Тэр орных нь хажуугаар явж салхивч нээгээд даралтны хэрэгслийг нь авчран бугалганых нь булчинг ороон сурамгай гэгч нь үзлээ.

-Даралт л ихэсчив ээ дээ. Хөгшрөх гэдэг хүсмээр юм биш.Танагтай дээрээ хөгшнийхөө хойноос явчихмаар л байна, зүгээр хэмээн тааз руу харан ярих өвөөгийнх нь дуу нэг л сулхан, дорой сонсогдоход зүрх нь агших шиг болж, эмээгээ яг л энэ өрөөнд амьсгаа хураасныг санангуут өр рүү нь нэг юм огшоод явчихав. Гэхдээ өвөө нь энэ бүхнийг түүнд биш өөртөө л яриад байх шиг. Дөнгөж 16 хүрч, үхлийн тухай биш амьдрал, хайрын тухай ирээдүйн тухай л бодож яваа BD-д үхэл яг дэргэд нь зэрэгцэн зогсоод мөс шиг хүйтэн амьсгалаар хүзүү рүү нь үлээх мэт аймаар мэдрэмж төрсөн ч хүчээр тэр айдсыг үргээн:

-Өвөө боль л доо. Юун үхэх мүүхэн вэ? Намайг ганцааранг нь орхих гээд байгаам уу? Одоо би Туяа эгч, Заяа энэ тэрийг дуудаадхая гэхдээ даралтын хэмжүүрийг хараад хирдхийлээ.

90,190. Хүү гэрлийн хурдаар шүүгээнээс даралтын эмийг нь авч уулгамагц, нагац эгчдээ хэл өгч бас түргэн дуудлаа. Мэдээж түргэн тусламж мөд ирэхгүй л дээ.

-Хэдэн настай хүн бэ? Согтуу юм биш биз. Яг яасан юм бэ? гэхчлэн уцаартай эмэгтэй утасны цаанаас хүүг загнаж загнаж, дуудлага их байгаа, 30 минутын дараа очно гэв.

Цаг дөнгөж долоо арав.

Тэгтэл ашгүй, хонх жингэнэж бага нагац эгч Энхтуяа, цаанаас нь хүргэн ах нь орж ирцгээлээ.

-Хичээлдээ явж үз миний хөө! Өвөө нь зүгээр. Хар өглөө амьтан сандаргаад энэ хүүхдийг хичээл номыг нь таслуулаад яана...

-Аав зүгээр намаржин нам нам гээд гүйгээд байсын.Тэгээд л биеэ муутгаж байгаа юм хэмээн нагац эгчийнх нь зэмлэх дуулав. Тэгснээ Урнаа хэмээх том эгч рүүгээ утасдаж байгаа бололтой “Аавын даралт нь хөдөлчихөж. Тийм ээ. Бямбаа утасдсан юм. Та хүрээд ир...”гэх нь дуулдана.

“Яахав дээ, хөгшин хүн тэгж намын ажил хийхдээ дуртай л юм байгаа биз.Тэгээд гэртээ ганцаараа юугаа хийдгийн. Өөрсдөө ямар өндөр настай эцэг эхээ тоох биш. Хааяа ирж номчирхохоос цаашгүй. Ер нь өвөө нь хөгшнөөсөө хойш хичнээн ганцаардаж байгааг Бидигээс өөр хэн анзаарч байлаа даа. Монголд ер нь улстөр сонирхдоггүй хөгшин гэж байдаг

юм уу? Тэдний байрны хөгшчүүд бүгд л улстөр яриад сууж байдаг шүү дээ. Ядахад тэр нөхөн сонгуульд өвөөгийнх нь намынх нь нэр дэвшигч ялагдчихдаг...Тэгээд л даралт нь ихсээ биз” хэмээн тэр гарч явахдаа дотроо өвөөгөө өмөөрөн бодож байлаа. Хүн бүхэн л хөгширнө. Дараа нь үхнэ энэ бол зайлшгүй гэдгийг орцноос гарах хүртлээ өвөөгийнхөө тухай бодож явахдаа гэнэтхэн ухаарч энэ “нээлтэндээ” бүүр сэтгэлээр уначихав.

Гадаа хүйтэн гэж жигтэйхэн. Цас шуурсан өвлийн өглөө, бүрхэг тэнгэр, хамар хорсгосон утаа үхлийн тухай бодлыг нь мартуулж сэхээ оров.

Хүү Одын орц руу нэг харж санаа алдаад байшингийн булан руу хурдлан алхав. Найзууд нь ч байсангүй. Ер нь ч тэгээд хичээлээсээ хожигдох нээ. Утсанд нь мессэж ирлээ.Гаргаж харах ч зав байсангүй. Харин Одын утсыг мэддэг, тэгээд мессэж бичилцдэг сэн бол хичнээн жаргалтай байх бол хэмээн бодсоор ангидаа ирлээ.

Хатнаа эхний цаг тасалчихжээ. Бямбаа завсарлагаанаар Номинтой хамт анги цэвэрлэхдээ түүний сормуус дэрвэлзээд хөөрхөн ч юм шиг болчихсоныг анзаарав. Ширээн доогуурх цаас түүж байгаад тэр хоёр золтой л мөргөлдчихсөнгүй.

-Чи явж гараа угаа, угаа. Би цонх онгойлгоод жоохон агаар оруулаадхая.За баахан утаа ороод ирдэг юм болов уу гэж эцэст нь BD-г хэлэхэд Номин царай нь улсхийснээ:

-За за гэж дуулдах төдий хэлээд гараад явчихав.

Цагаан цамцны цаанаас хөх нь мэдэгдэх төдий товойсон турьхан бие, ичимхий гэнэн харцтай энэ охины даруухан зан түүнд таалагдавч сэтгэлийг нь огтхон ч татахгүй юм даа.

Химийн багш өвчтэй тул сүүлийн цагууд цонхолж, хөвгүүд PC-дэхээр сургуулийн хажуугийн интернет кафе руу шуугилдан гарцгаалаа.

Харин BD өвөөдөө санаа зовинон нэгжээ хайрласангүй утасдав.Туяа эгч нь яваагүй байлаа. Түргэн ирж даралт бууруулах тариа хийгээд явсан. Удахгүй Заяа ирэх гэнэ. Өвөө нь унтаж байлаа.

“Ашгүй дээ. За өвөө гайгүй байгаа бол явж дэлгүүр хэсдэг хэрэг” гэж тэр бодоод Хатнаад мессэж бичив.

Ээжийнх нь түрүү түрүүчийн сард явуулсан мөнгө бараг үрэгдээгүй, бас өвлийн хувцас авна гэж нэхэж авсан хэдэн төгрөгтэй нийлээд түрийвч нь овоо түнтийж байлаа.

Орой түүнийг баахан уут тортой хувцас барьчихсан гэртээ ороход өвөө нь овоо тэнхэрчихсэн дээлээ нөмрөн зурагтаар мэдээ үзэж, үеэл эгч нь шөл, салат хийгээд гэр нь өглөөнийхийг бодоход хавьгүй тохилог, таатай байлаа.

- Хөөх, “ах” бүүр гангарчжээ. Охинд дурлачихаа юу? Өвөөгөө бие нь муу байхад дэлгүүр хэсээд гэсээр Заяа өрөө рүү нь шагайна.

-Ээж өвлийн хувцас ав гэж мөнгө явуулсийм аа. Ядаргаатай юм. Дандаа дурлал мурлал

гэж шоолж байхын... гэж хүү үглээд авсан хувцаснуудаа хаман шүүгээндээ хийв.

Ингэж хэлэхдээ тэр Заяа руу эгцэлж ч харсангүй, бушуухан нүүр буруулахдаа үеэл эгч нь түүний ингэж хувцас хунартаа гойд их анхаарах болсны шалтгааныг онож хэлчихээд доог тохуу хийж байгаад бүр ч эвгүйрхэн ичиж байлаа.

-За за маяглаад л.Чам шиг банди нарыг мэдэхгүй биш. Хоолоо ид. Гоё салат хийсэн шүү гээд Заяа яваад өгөв.

Урьд нь түүнийг ирэхэд их л хань татан эмээгээс нь хойш бүсгүй хүний орон зай эзгүйрсэн гэрт нь гэрэл гэгээ, илч дулаан ороод ирэх шиг санагддаг байсан бол одоо ийнхүү илүү үгэнд дурлах, Одын тухай бодолд нь саад хийх зэрэгт нь тээршаадаг болжээ.

Түүнийг том өрөө рүүгээ ороход өвөө нь өндийсөн ч үгүй.

-Бямбаа миний хөө. Даралт үзээдэх дээ гэлээ.

Хөгшний даралт овоо буусан ч харц нь тамирдангуй хэвээрээ.

Энэ үеэр Заяа түүнийг гал тогоо руу дуудав.Ороход нь нийслэл салат таваглаж өгснөө:

-Өвөө найз эмгэнтэй болоо юу? Сонин юм аа, нэг эмгэн байсхийгээд л залгаад байхын хэмээн шивнэн асуув.

-Мэдэхгүй ээ.Юун эмгэн?

-Нэг эмээ утасдаад байна лээ. Харин өвөө та хоёр ингэж будилж байхаар хойд эмээтэй болчихвол дээр юм уу гэж би бодлоо.

-Хойд эмээ? Балай юм. Намынх нь хүн л байлгүй дээ. Ардчилсан намын баахан эгч нар байдаг юм аа. Хичээл чинь гайгүй юу?

-Гайгүй ээ. Ууганаа бүр мессенжэрт ч орж ирэхээ больжээ гэж Заяа ахынх нь тухай хайхрамжгүйхэн хэлснээ нэг юм санасан бололтой нүд нь томорч:

-Хүүеэ, би Дансран ахтай яаг адилхан хүнийг Их дэлгүүрт нэг хүүхэнтэй сугадалцаад явж байхыг харсаан. Ёстой нээрэн, дэндүү адилхан хүн байсан. Хүн андуурчихав уу гээд сайн харах гэсэн чинь Чимгээ гэж нэг юм энэ бөгжийг хараа гээд анхаарал сарниулчихсан. Тэгээд л тэр хооронд нөгөө хоёр алга болчихсон байсан. Гоёл чимэглэлийн тасагт явж байсан байхгүй юу.

-Биш байлгүй дээ... гэхээс өөр үг түүний амнаас гарсангүй. Аавынх нь тухай эл мэдээ хүйтэн дүнсгэр, өглөөнөөс эхлээд таагүйхэн өнгөрсөн энэ өдрийн хамгийн муу төгсгөл байлаа.

Дансран гэж Бямбаагийн аав. Хааяа нэг хаанахынх нь үл мэдэгдэх хачин дугаараас залгаж товчхон хэдэн үг солихоос өөр сураггүй таг чиг байх болсон аав нь эхнэр, хүүхэддээ хэл

дуулгалгүй Солонгосоос гэнэт хүрээд ирчихсэн байснаас ... за больё.

-Яасан? Би чамд дэмий л энэ тухай хэлчихэв үү дээ. За за, тэр хүн аав чинь биш байлгүй дээ.

Заяа бодлогогүй дуугардаг ч цаанаа өр зөөлөн. Өөрөө дүүгүй, тэгээд ч тэднийх хүүгүй айл болохоор Бямбаа, Ууганаа хоёрт хамгаас элгэмсүү байдаг билээ. Дээрээс нь ядарвал нагацаа түш гэдэгчлэн хэн хэн нь эхийн талын элэг татаад хоорондоо нэг л дотно.

-Чи ойрдоо нэг л хачин болчжээ. Сургууль дээр чинь элдэв хоёр юм болоогүй биз дээ? Царай чинь зэвхийрээд л. Алив наашаа хар даа гээд Заяа эрүүг нь өргөн нүд рүү нь анхааралтай харлаа.

-За боль л доо. Яагаа ч үгүй гээд байхад сүртэй юм гэнгүүтээ Бямбаа жаахан бүдүүлгээр гарыг нь тавиулаад I-rodoo гарган оролдмор аядав.

-Би чамд ерөөсөө Дансран ахын тухай шал дэмий юм хэлчлээ. Мөн ч юм уу, биш ч юм уу. Зүгээр адилхан хүнийг ч андуурсан юм бил үү? Би ер нь шал тэнэг юм аа. Одоо чинь хүүхдүүд өвс энэ тэр үнэртээд л мансуурах донтой болчихоод байгаа юм зөндөө. Түүнээсээ болж л ааш зан нь элдвээр хувирдаг гэсэн. Хөвгүүд ер нь хэцүү ш дээ. Чи ямар нэг юм болбол надад шууд л хэлээрэй дээ. За юу? Хүн дотроо юм нууж явах шал дэмий байдаг юм хэмээн эгчирхлээ.

Аавын тухай саяын яриа ч яахав. Сонссон дороо хэсэгхэн хором цохилтонд ороод л сэтгэл нь тайвшран мөс шиг гөлийчихсэн. Аянга хэдий хүчтэй ч ганцхан хоромд л ниргээд өнгөрдөг бус уу? Харин сэтгэл зүрхэнд урилгагүй орж ирэн өчүүхэн ч орон зай үлдээлгүй эзэгнэчихээд гарч өгөхгүй, мэсээр тастаад хаячихаж болохгүй, тэгсэн атал мөч хором бүрт хөндүүрлүүлэн шархлуулж байдаг нэгэн өвчин бол дурлал юм даа. Тэгээд тэр тухайгаа ярьж гэхэд хэнд ч сөхөж болдоггүй. Мартъя гэхээр улам санагдаад л байдаг. Бямбаа санаа алдчихаад түүндээ бантсандаа угаалгын өрөө рүү бараг л зугтчихав.

“Энэ Бямбаа нэг л биш болжээ. Отгоо эгчид хэлдэг юм бил үү? Энэ харваас аавынх нь тухай миний хэлсэн юмнаас болоогүй ээ. Нэг л юм нуугаад байна даа. Арай ч ийм хүүхэд байгаагүй дээ” гэж Заяа бодон өрөөнөөс нь гарчээ.

Заяагийн эгч Саруул Бямбаагийн ах Ууганаатай нас чацуу. Эмээгээ амьдад тэд хамтдаа Жигжидийн зусланд гарч, хүүхдийн зусланд ч хамтдаа явцгаадаг байж билээ. Тэр дөрөв бүхэл зунжин хөзрөөр хамраа дарах, илжигдэх зэрэг тоглоом тоглон шуугилдаж, ойд мөөг, самарт хамтдаа явцгаан, хожим том болцгоосон хойноо орой үдэш UB палас руу шоудах гэж эмээ, өвөөгөө молигодон алга болохдоо Бямбааг ганцааранг нь бацаан хэмээн голж орхин уйлуулах зэргээр хичнээн дотно, яг нэг айлын хүүхдүүд шиг цугтаа эв, найртай өсөцгөөлөө дөө. Одоо Саруул эгч нь хүнтэй суугаад Эрдэнэтэд суурьшиж, Ууганаа ах нь Канад яваад, эмээ нь бурханы оронд одож, тэр үеийн бүх сайхан дурсамж мартагдах нь гэхээр дэндүү гунигтай. Уг нь Бямбаа цэцэрлэг, бага ангид байхдаа хүүхдийн гэнэхэн шохоорхол, дурлалынхаа тухай өөртэй нь арай нас ойролцоо юм болохоор Заяад л ам алдчихдаг байж билээ.

Бас Бямбааг төрөхөд охин гэж хүлээцгээж байсан гэрийнхэн нь, нэн ялангуяа аав нь “Өө дахиад нэг бакаал гарлаа” гэхчээд найзуудтайгаа загасанд явчихсан тухай Заяа анх түүнд ярьчихаад эмээдээд загнуулж байж билээ. Үнэндээ аав нь том хүү Ууганаадаа л илүү хайртайгаа нуудаггүй, төрснөөс нь эхлэн Бямбаад тоомсоргүй хандсаар ирсэн нь ухаан орсон хойно нь ч мэдэгдээд байдаг байсан юм. Аав нь одоо ч Ууганаатай илүү дотно харилцаатай байдаг болтой. Үүнд нь ч тэр аавдаа гомдохоо хэдийнээ больжээ.

Гэхдээ уржнан Бямбаа цэргийн баяраар ангийнхантайгаа нийлэхдээ цагаан архи, пиво хольж уусаар анх удаа согтож аавдаа гомдож явдгаа найз Тэнгистээ ярьж уйлан “Одоо хүрээд ирвэл би Дансранг нам цохино” гэх мэтээр жаахан агсамнах аядсан удаатай. Түүгээр ч зогсохгүй гэртээ ирээд өвөөгөө орондоо орсныг нь далимдуулан эмээгээ зөөлчилж “Эмээ, би гологдсон хүүхэд тийм биз дээ? Намайг тоодоггүй байсных нь, бас ээжийг хүний газар орхиод явсных нь хариуг би тэр Дансрангаас заавал авна даа” гэж бас гоншигножээ. Одоо энэ тухайгаа бодохоос ч ичмээр санагдана. Сүүлд нь Заяа тэр явдлыг сонсоод “Шал сүртэй юм. Би ч бас гологдмол хүүхэд дэг. Тэгэхдээ аав биш ээж л намайг төрөхөд хүү биш охин гарчихлаа гэж голоод уйлж байсан юм гэх чинь билээ. Тэгсэн чинь эх баригч “Эрүүл саруул хөөрхөн охиноо голлоо...” гэж аашилж, дараа нь аав “ Хүүхдийн заяа гомдоолоо...” гэж загнаж байж гайгүй болсийм биш үү? Заяа гэдэг нэрийг чинь тэгж надад өгсийн гэсэн.” гээд л түүнийг тайвшруулж байсан юм. Заяа тэр хоёр ийм л зовлон нэгтэй, эхийн талаас элэг татан дотносч өссөн бүл эгч дүүс атал яагаад ч юм улам л холдож хөндийрөөд л байдаг.

Эмээ нь тэдэнд эгч дүүсийн хүүхдийг бүл, ах дүү нарын хүүхдүүдийг үеэл гэдэг хэмээн хэлж өгсөн ч хүмүүс тэгж нарийн мэдэхгүй болохоор нь бие биенээ үеэл л гэж нэрлэх болдог юм.

Бямбаа угаалгын өрөөнд орж шал дэмий ус гоожуулан удтал зогсов. Хэрэв хэн нэгэн үеийнхээ охинд татагдсан бол дурлалынхаа тухай Заяад яриад сэтгэлээ онгойлгох ч юм уу, ер нь түүнийхээ хойноос хөөцөлдөн гүйсээр байгаад үерхэж болох байсан. Гэтэл ямар тэнгэр нь хаяхаар өөрөөсөө өчнөөн олон насаар эгч, хүрч болшгүй өндөр хадан дунд ургасан цэцэг мэт тэр бүсгүйд татагддаг байнаа? Анх Одыг олж харсан намрын тэр нэгэн өдрөөс хойш түүнийг мартвал ч мартахаар олон сар өнгөрч, хуанлийн хуудас нэг оноор эргэж, хорвоод амьдарсан нас нь нэгээр нэмэгдчихсэн байтал тэр бүсгүйд улам улам татагдсаар л байх юм. Хамгийн харамсалтай нь тэр бүсгүй Заяагийн сургуулийн номын сангийн эрхлэгч байж таарахдаа яахав дээ. Тэгээд ч сэтгэл доторхио уудлан ярьчихдаг ганц хүн нь болох үеэл эгч нь Одоод тал муутай, ер нь дургүй юм гэдгийг мэдсэн хойно зүрхэнд хамгийн эрхэм түүнийхээ тухай хэрхэн ам нээж нууцаа дэлгэх билээ. Гадаа явж асан Одыг хараад “ Энэ чинь шал хөгшин бараг гуч хүрч байгаа хүүхэн...” гэж тэр өдөр Заяа хэлснээс болоод л үеэл эгчдээ хандах халуун сэтгэл нь яг л анчнаас үргэсэн гөрөөс мэт хулжин оджээ.

Түүнийг угаалгын өрөөнд удаж удаж гарч ирэхэд нь Заяа ашгүй өвөөд нь эм уулгах гээд гал тогоо руу орчихсон байлаа. Бурханы аврал. Хаалгаа хааж түгжиж байгаад өнөөдөр авсан хувцаснуудаа үзлээ. Дандаа биед нь яв цав таарсан, өөрийг нь арван найм, хорьтой ч юм шиг арай л оворжуу харагдуулахаар буурьтай, бас моодны хувцаснууд. Одоо хип хопын навсар юм хэдэрдэг цаг өнгөрсөөн. Гэтэл ийм дэгжин хувцас өмслөө гээд ч Од түүнийг тоож харах юм уу даа? гэж бодохоос сэтгэл нь гэнэт гунигlauchав. Өөрт нь бараг мөнгө ч үлдсэнгүй. Дандаа муу ээжийнхээ харь газар үйлээ үзэж байж олсон мөнгийг үрээд байна гэдэг утгагүй.

Тэгэхгүй гээд хаанаасаа мөнгө олох билээ?

Ер нь хүний амьдралд мөнгө яагаад дандаа ийм чухал байдаг юм бол? Урьд нь энэ тухай нэг их бодож байгаагүй ч юм шиг. Нөгөд орж баахан тоглоом тоглож, хажуугаар нь ахтайгаа чааталж аваад нэг харахад бүүр орой болчихжээ. Өвөө рүүгээ нэг очоод унтдаг хэрэг.

Тэгээд өвөөдөө сайхан нойрсохыг ерөөх далимаар Заяатай хэсэг дэмий яриад унтахаар өрөөндөө орж ирээд савтай цэцгээ харангаа нэг л мэдэхэд нөгөө цэнхэр хөшигтэй цонх руу хяламхийлээ. Бүсгүй харагдсангүй. Хөшиг нь таг хаалттай байлаа. Түүнийг бүтэн хоёр хоног олж харсангүй. Сэтгэлээ сэмэртэл санаа алдаад орондоо оров.

Маргааш нь ашгүй Заяа явж, орой нь үнэхээр өвөөгийнх нь танил гээд нэг хөгшин ирчихсэн хоол хийж өгөөд гараад явчихав. Заяагийн хэлсэн найз эмгэн гэдэг нь тэр бололтой.

Яриа хөөрөөтэй, сайхан хоол хийдэг тэр эмээд дургүйцэх ч юу байхав дээ. Харин өвөө нь зээ хүүгээсээ илт санаа зовсон шинжтэй байгааг анзаарч аль болохоор гайхсан царай гаргахгүйг хичээж байлаа. Өвөө нь эмээг өнгөрснөөс хойш их ганцаардаж байгаа. Тэгээд ч бас тэр хөгшин эмэгтэй л хүн юм чинь өвөөд таалагддаг байж болно шүү дээ. Түүнийг явсны дараа өвөө нь зээгээсээ жаахан зовсон бололтой нэг ханиалгаснаа:

-Өвөөгийнх нь таньдаг хүн. Гэр нь урд байранд байдаг. Намайг бие муу гэж дуулаад эргэж тойрч яваа юм хэмээн тайлбарлав.

Бямбаа харин өнөөдөр дотроо их аз жаргалтай байлаа. Учир нь бүтэн хоёр өдрийн турш тааралдаагүй Түүнийхээ царайг харжээ. Орой гадаа Одын хоёр жаалтай тааралдаж зайрмаг авч өгөөд бага хүүтэй нь бүр ходий болж гулсуур дээр баахан гулгуулжээ. Охин нь нэрээ Ану гэж хэлээд ичингүйрэн духайхад сормуус нь хацар руугаа буун ээжтэйгээ хичнээн адилхан харагдсан гээч. Хүү нь намар анх харснаас хойш их өсч, эр юм гэсэндээ гулсуурны зүг түрэмгий гэгч нь заан гараас нь чангаасан нь хоёулаа гулгаж тоглоё гэж байгаа бололтой.

-Ахын дүүг хэн гэдгийн? гэж BD-г түүнээс асуухад нэрээ ч хэлэхгүй гагцхүү гараас нь зулгаан:

-Хөб хөб хэмээн гулсуур руу зүтгэх нь дэндүү өхөөрдөм.

-Миний дүүг Анар гэдэг. Таныг BD гэдэг юм уу? гэж эгч нь дүүгийнхээ өмнөөс хариулахад Түүний хүүхэд өөрийнх нь нэрийг мэдэж байгаад баярласандаа зүрх нь түг түг цохилж:

-Тийн. Миний дүү яаж мэдсийн? гэж асууснаа өөрийн эрхгүй хүүхний гэрийн цонх руу хяламхийж билээ.

-Найзууд чинь л тэгж дуудаад байсан ш дээ.

-Яагаад таныг Биди гэдгийн?

-Бямбадаш гэхийг товчлоод л...

-Өө таны жинхэнэ нэрийг Бямбадаш гэдэг юм уу? Яг хөгшин хүний нэр шиг юм аа.

Айхтар золигийн бацаан. Нэрийг нь хөгшин хүнийх шиг гэж үнэхээр оноод хэлчихжээ. Ааваас л болж байгаа юм.Өвөө нь хүртэл тийм гоё биш ч Батсайхан гэж өөрийнх нь хажууд хавьгүй залуу хүнийх шиг нэртэй байхад.

-Танай ээжийг Од гэдэг тээ?

-Тийн.Та яаж мэдсийн?

-...Зүгээр хүмүүс тэгж байна лээ хэмээхдээ Бямбаа тэр жаахан охиноос их л ичиж билээ.

-Манай ээж ёстой хөөрхөн тээ?Энэ байранд бас, манай ангийн хүүхдүүдийн ээжүүдээс хамгийн хөөрхөн нь манай ээж...

Хүн бүхэнд ээж нь хөөрхөн харагддаг нь мэдээж боловч тэр бяцхан охин үнэхээр оноод хэлчихжээ.

Тэгтэл өнөөх цэнхэр хөшигтэй сэтгэлд дотнохон цонхны салхивч онгойж өнөөх бүсгүй ялдамхан дуугаар :

-Ану! миний охин дүүгээ аваад орж хоолоо ид гэнгүүтээ тэр дорхноо хаагдахад цан татсан цонхны цаанаас юу ч харагдсангүй, мэдээж бүсгүй мань эрийг анзаараа ч үгүй бололтой.

-Ах аа, бид хоёр орлоо. Ээж дуудаад байна гээд охин дүүгээ хөтлөн орц руугаа чирлээ.

-Үгү үү, гэртээ орохгүй ээ хэмээн бяцхан жаал зөрүүдлэн адраад газар суучихлаа.

-Алив агаа нь оруулаад өгөх үү? Биди бүсгүйн гэрт орох бөөн далим болсон тэр зөрүүд бяцхан амьтныг газраас сэвхийтэл өргөлөө. Одоо түүний гэрт орно гэхээс л мань хүний өвдөг чичрэн, зүрх нь догдлон хөөрч амьсгал давхцах шиг болж байлаа.

-Үгүү буу буу хэмээн хүү зөрүүдэлсээр байсан ч ,

-Манай дүү аймаар зөрүүд зантай. Уг нь тэврүүлж явах дуртай байгаа мөртөө л тэгж байгаан. Та манайд орж хоол идээрэй. Ээж хуушуур хийсэн гэж охин ярьж явахыг тэр бүүр түүрхэн сонсох авч, дотроо бол гагцхүү тэр бүсгүйг л харж, түүний амьдардаг гэрийнх нь босгоор алхана, сэтгэл татсан нууцлаг ертөнц болсон цэнхэр хөшигний цаана ямархан амьдрал өрнөж байдгийг мэдэх болно гэхээс сэтгэл нь тогтож өгөхгүй байлаа. Хоёр ойтой, мариалаг, түнтийтэл дулаалчихсан жаалхүүг өргөж үзвэл санаснаас зэгсэн жинтэй амьтан байлаа. Тэдний орц яаж орж, хэрхэн гуравдугаар давхарт гарснаа ч ВД мэдсэнгүй. Нэг л ухаарахад цав цагаан төмөр хаалганы өмнө тэр гурав зогсч байлаа.

-Би хонхонд хүрдэггүй юм. Хаалгаа ингээд цохичихоор бид хоёрыг ирж байна гэж ээж мэддэг юм гэнгүүтээ охин зузаан нэхий бээлийтэй бяцхан нударгаа зангидан хаалгаа түг түг

нүдэхэд сандарсан Биди хүүг нь буулгаж тавимагц бүсгүйн хөлийн чимээнээр шаг руу дайжин зугтлаа.

-Хөөе, та манайд орж хоол ид л дээ. Биди ах аа! гэж Ану охин хойноос нь дуудахыг тэр доод давхраар пижигнэтэл гүйж явахдаа л халти сонслоо.

Зүрхгүй амьтан. Улаан нүүр рүүгээ халуун усаар цацуулсан биш дээ, ямар. Өнөө цэнхэр хөшигний цаана тэр бүсгүй хэрхэн амьдардгийг харна, танилцана энэ тэр ч юу байхав. Би гэж шал тэнэг п... юм аа хэмээн нэгдүгээр давхарт бууж тайтгарсан хойноо тэр өөрийгөө зүхэв. Байлдаантай кинонд гардаг гал харвагчаар улаан нүүр рүүгээ шүршүүлбэл л тэгдэг байх даа. Зүгээр л хоёр хүүхдийг нь оруулж өгөх далимаар тэр бүсгүйтэй танилцчихад болох л байсан шүү дээ. Том хүнтэй мэндлэх үедээ , таньдаг айлын үеийн хүүхдүүдтэй уулзаад таг дуугүй зогсоход нь эсвэл багад нь айлаас давс гуйгаад ир гэхээр нь үгүй ичээд байна хэмээн гэжүүдлэхэд нь эмээ нь түүнийг ”Нүүрэндээ үстэй юм шиг...” гэж загнадаг байсныг нь гэнэт санах. Уг нь ч тийм нүүрэндээ үстэй юм шиг бүрэг зантай ядарсан амьтан биш л дээ, тэр. Өөрт нь таагүй газар, таашаал төрүүлэхгүй үйлдлээс л тэр дургүйцдэг юм. Харин Од түүний хувьд таагүй хүн огтоос биш. Ердөө л ичих сэтгэлээ тэр дийлсэнгүй. Тэгээд орцноос нь гарч ухаан зулаггүй гүйсээр гэртээ оров.

Гэхдээ л тэр оройжингоо аз жаргалтай байлаа. Унтахын өмнө цонхон дээрээ очиж цэцгээ услангаа тэдний цонхыг ширтэн хэсэг зогсов. Мэдээж юу ч харагдсангүй ч тэр цэнхэр хөшигний цаана Од байгаа. Бас Ану, Анар хоёр байгаа. Охин нь лав ээждээ өөрийнх нь тухай ярьсан даа хэмээн бодохоос зүрх сэтгэл нь нэг л үл ойлгогдом зөөлхөн ая эгшгээр дүүрч байх шиг таатай сайхан байлаа. Харин цонхноос холдохдоо сонгинон цэцгээ анзаарвал чийгтэй шороо нь үлмэдэг оволзох шиг болсноо өнөө цоохор цох гарч ирснээ арай ядан хөдлөх нь харагджээ.

Сонин юм. Нөгөө цох л өдий болтол амьдарсаар байгаа юм байх даа. Хүү цохны нуруунд зөөлхөн хүрэхэд тэр хорхой дургүйцэх мэт биеэ хураах нь мэдрэгдэв.

“Цоххон минь шороон дундуураа явж л бай даа.” гэж тэр бодоод орондоо орж нам унтлаа. Тэр шөнө янз бүрийн, утга учиргүй зүүд холилдон зүүдлэгдээд байсан ч өглөө нь харин юу ч санаанд нь үлдсэнгүй.

Тэр өглөө бүхэн эртлэн боссоор бүүр заншсан ч өнөөг хүртэл Одын анхаарлыг өөртөө татаж чадаагүй хэвээрээ л байлаа. Ер нь ч тэгээд дөнгөж арван долоо хүрэх гэж буй түүн шиг ердийн нэг хөвгүүнийг тийм сайхан бүсгүй юу гэж ч тоох юм билээ.

Ямар ч гэсэн хэлхгэр хувцас өмсөхөө больж, үсээ шинээр засуулснаас хойш охид өөрийг нь урьдахаас илүү их хардаг болсон нь мэдрэгдэнэ.

Нэг удаа тэр их завсарлагаанаар ангидаа хамгийн арын ширээний цаагуур унтаж байтал хэдэн охин орж ирэн элдвийг хаман чалчиж гарлаа. Эхэндээ ч мань эр охидын яриаг анзаарсан ч үгүй. Гэтэл өөртөө Энжи гэж чамин нэр өгсөн Энхчимэг гэдэг охины яриа чихий нь сортойлгочихов.

-Хүүеэ, манай ангийн Биди нэг охинд сайн гэнээ. Гэхдээ тэр нь хэн гэдэг нь нууц байдаг. Та нар ер нь анзаарсан уу?

-Яажийн?

-Яахав дээ. Хичээл дээр дандаа л бодолд орчихсон сууж байхын. Тэгээд бас сүүлийн үед бүүр гангараад байгаам аа. Та нар ажиглаагүй гэж үү?

-Нээрээ ...Биди аягүй сонин зантай болчоод байгаа ш дээ.

-Шал их зантай. Шалихгүй юм байж. Тэр юундаа Номиог голдгийн. Ээж нь Солонгосоос их мөнгө явуулдаг нь тэндээ л юм байгаа биз. Тэр одоо ямар Их хурлын гишүүний хүүхэд юм уу хайшаа юм.

-Уг нь дажгүй банди ш дээ. Даанч хэтэрхий чөргөр л болохоос гэж Энхчимэгийг хэлэхэд охид хөхрөлдлөө.

-Өө чи өөрөө санаатайм байна.

-За юу гэж дээ. Тэрүүгээр яадгийн. Эзгүй арал дээр тэрэнтэй хоёулхнаа л үлдчихдэггүйм бол...

“Даанч хэтэрхий чөргөр...” Энэ үгэнд эхлээд уур омог нь дэлбэрэх нь үү гэлтэй нэг хөөрч ирснээ эцэст нь түүнийг харин ч ноцтой бодолд оруулсан юм.

Бямбаа орой гэртээ цээжээ нүцгэлж байгаад толинд харж бугалга, шууны булчингаа барилан хэсэг зогслоо. Энхчимэг үнэн хэлжээ. Ангийнх нь охид л өөрийг нь тэгж голж байгаа юм чинь Од шиг насанд хүрсэн гоо бүсгүйд тэр гэж өрөвдмөөр чөрийсөн амьтан харагддаг байх нь. Тэр өдрөөс хойш хүү бялдаржуулах төв рүү гүйдэг боллоо. Уг нь арван найм хүрч, өсөлт зогссон хойно биеэ хөгжүүлнэ гэж боддог байсан юм. Ах нь тэгж захижээ.

Охид бүсгүйчүүд л царай зүсээ байнга тольдож зогсдог гэж хүмүүс боддог. Харин Бямбаа сүүлийн үед өглөө оройд шүдээ угаах, усанд ороод гарахдаа үргэлжид угаалгын өрөөнийхөө толинд харан нүүрний арьсаа арчилж, царай зүсээ өөлөн зогсох болов. Ашгүй сайн арчилсны хүчинд шилжилтийн насны онцлог гэгддэг бага сага батга байсан нь оргүй алга болжээ. Шингэндүү хөмсөг, овоо аятайхан том нүд, шүд нь ямар азаар аюулын тэгшхэн юм бэ. Үсний засалтаа сар бүр өөрчлөн өглөө хүйтэн усаар цээжээ норгох болов.

Өвөөгийнх нь бие ч сайжран, зээ хүүгээ өдөр өдрөөр ийнхүү өөртөө арчаатай болж, өглөө дуудуулахгүй үсрэн босч хичээлдээ явах болсонд нь үнэхээр сэтгэл хангалуун байсан ч цаад учрыг нь үл гадарлана.

Хоёрдугаар сард цагаан сар болж, тэднийх хэд хоног золгуутын хүмүүсийн хөлд дарагдаад өнгөрөв. Цагаан сар аа гэж. Эхлээд өвөөгийнх нь цагаан сард бэлтгэн гэр цэвэрлэн, бууз салад хийж байгаа нь энэ хэмээн нагац эгч нар, өнөөх үеэл Заяа, хүргэн ах нар нь ирцгээн хоёрхон хүнтэй энэ айлын амар амгаланг баахан алдуулав. Өвөө нь ч хөл хөнгөрөн, бууз, боов,

мах, ууц, бэлэг сэлт ярин орж гарч, хөргөгч нь элдэв хоол хүнсээр дүүрэн, хивс, ширдэг нь тоосгүй болж, гэр нь цэмцийн, зурагт асаасан ч цагаан сар, гараад найзуудтайгаа уулзсан ч бууз чимхэх, хүнсний зах явж цагаан сарын юм авчралцах тухай яриа залхтал сонсогдох аж. Арай гэж битүүний залхуутай үдшийг бартал шинийн нэгэн. Золгох хүмүүс...Бурхан минь. Аав, ээжээс нь бусад нагац, авга нар, зүсийг нь огт мэдэхгүй шахуу улс ч өвөөтэй нь золгохоор ирцгээнэ. Тэр бүрт нь Биди очиж золгож байгаа нь энэ хэмээн хацраа шүлсдүүлнэ. Цагаан сар гэж ийм ядаргаатай баяр гэдгийг урьд нь яагаад анзаардаггүй байсийн бол оо? Гай болоход энэ өдрүүдэд Од хоёр хүүхдээ аваад аавынх руугаа явсан бололтой гадуур ганц ч үзэгдсэнгүй нь түүнийг бүүр ч гунигт автуулчихжээ. Ашгүй ирсэн гийчид буцдаг ёсоор цагаан сарын хөл үймээнт өдрүүд хэдэн хатсан ул боов, ууцны царцуу өөх үлдээгээд улиран одож санаа амрав.

Цагаан сар дуусч ажлын өдрүүд эхэлсэн анхны өглөө Бямбаа яг орцных нь гадаа хүлээж зогссоор Од бүсгүйтэй тааралджээ. Хүүгээ тэвэрч, охиноо хөтлөн гарч ирсэн цайвар саарал булган дээлтэй бүсгүйг харангуут өнөө муу зүрх нь цээжин дотроо багтахгүй болтлоо давчдан цохилж гарах нь тэр.

Хүү нь ээжийнхээ гараас мултрах санаатай бяцхан хөлөөрөө тийчигнэн “Би өөлөө явна. Намайг буулгаач. Өөлөө явна...” хэмээн зөрүүдлэх аж.

-Битгий маяглаад бай. Цэцэрлэгээсээ хоцрох нь. Чиний өөрөө явах гэж юу байдгийн хэмээн ээж нь загнавч хоолойд нь хүүгээ өхөөрдсөн өнгө илт сонсогдоно.

Хоёрдугаар сарын өглөөний жавар бас л тасхийж байлаа. Гэвч хавар авхай хаяанд ирснийг илтгэн өвлийн өглөөг бодвол нэлээд гэгээ орчихсон байлаа. Тэгээд ч жавар хичнээн ч тачигнаад цаанаа л нэг хүч алдсан шинжтэй, хаврын урь мэдрэгдэх аж.

Биди тэр гурав руу очиж хүүгий нь тэврэн автобусны буудал руу хүргэж өгдөг юм уу гэснээ ичиж, халшран зогссоор байтал нь албаны дугаартай хар “Sonata” давхин ирж хүүхний хажууд зогсмогц дотроос нь тийм ч залуу бус эрийн дуу гарч:

-Сайн уу? Од оо! Алив суу. Хүргээд өгье гэх нь тэр.

Бас л бүтсэнгүй. Биди гэж зүрхгүй амьтан зүгээр л ойртож очоод энгийн яриа өдөх далимд хүүг нь тэврэн автобусны буудалд хүргэж өгөх буюу заримдаа такси барих үед нь ядаж машинд суулгаад өгчих юм сан гэж бодсоор л таван сар өнгөрүүлчихсэн байгаам даа.

Нэг мэдэхэд хөл нь даарсандаа янгинаж байв.

-Чи одоо яасан эрт босдог юм бэ? Хөгшин хүнтэй хамт байсаар байгаад нойргүй болчихсон юм уу? Өвгөн шиг хар үүрээр босч гадаа дэрчийж зогсчихоод хүн унтуулахгүй юм гэсээр Хатнаа хавтсаа сугавчлан гарч ирэв.

-Мэнд ус байдаггүй ээ? хэмээн Биди хөндийхөн хэлээд цамцныхаа юүдэнгийн бүчийг чангаллаа.

Тэр бусад хөвгүүдийн адил өвөл малгай өмсөх дургүй. Гэхдээ малгай өмсдөггүй ч хүйтнийг аргалж чихээ хамгаалах санаатай зузаан гэгч юүдэнтэй цамц өмсөх агаад чих нь даарсан үед ийнхүү цамцныхаа юүдэнг угладаг зантай.

-Өнөө орой эртүүдийнх шиг шоудах уу? Байкагийн сургуулийн 11-ийн хоёр дажгүй охин байгаа.

-Тэгье!

Хатнаагийн хэлээд байгаа ”эртээдийнх шиг шоу” гэдэг нь ойлгомжтой. Орондоо орж элдэв хүүхэн бодож, төсөөлөн гар хангалга хийж хэвтэхийн оронд жинхэнэ секс. Гэхдээ Хатнаа өөрөө бараг мөнгө гаргахгүй, Бидиг л монжино гэсэн үг. Тийнхүү охидтой хоноглох бүрд Одыг хуураад байгаа юм шиг зовуурьтай санагдах л хэцүү. Гэвч байз. Од... гэдэг тэр бүсгүй өөрт нь Бидигийн дурласныг бүү хэл, ийм нэгэн хүн энэ ертөнцийн тоос хөдөлгөн явааг мэдэх бил үү? Биди түүнийг харсан тэр л үйлтэй өдрөөс хойш өнөөдрийг хүртэл дурлалдаа шаналан зовж явааг огтын таамаглаа ч үгүй хүн шүү дээ. Ер нь тэгээд таамаглалаа гээд ч яах юм. Дөнгөж арван зургаатай түүн шиг бандиар тийм сайхан бүсгүй яах ч юм билээ...

Одоос “өшөөгөө авч” өөр сургуулийн 11-р ангийнх гэж Хатнаагийн хэлсэн хоёр охинтой цэнгэснээс хойш гурав хоноод гэгээн Валентиний өдөр тохиолоо. Хичээл дээр ангийнхан нь бие биенийхээ нэрийг сугалан бэлэг солилцсон ч Биди эс мэдээчин мэт өнгөрүүлэв. Осолтгүй л нөгөө Энжи гэдэг охин бэлэгний мөнгөө хураалга гэсээр хүрч ирэхэд нь гурав, дөрвөн мянган төгрөг өгч л байх шиг байсан. Ангийнхан нь хичээлийн дараа юу юу зохионо, хаана хаана очиж доргино ч гээд байсан бүү мэд. Тэрэнд нь оролцсон ч үгүй хичээл тарангуут л гараад гүйсэн. Тэгээд интернет кафед очин ганцаараа нетээр хэсэг хэсэв. Ахдаа off-line мессеж үлдээж, ээждээ мэйл бичив. Бас facebook-тээ баахан юм бичлээ.

Тэгээд л нэг л мэдэхэд цэцгийн дэлгүүр рүү алхаж явлаа. Өөрөөсөө ч нуугаад байгаа мөртөө л хийхгүй байж чадахгүй нэг зүйл байсан нь “Түүнд” валентиний өдрийн бэлэг авах явдал байв.Түүнд гэдэг нь мэдээж Одод. Бүр интернетэд сууж байхдаа л яагаад ч юм Түүндээ цагаан лили цэцэг авч өгнө хэмээн шийдчихсэн байв. Тэр бүсгүйг анх харсан намрын тэр нэгэн өдрийг тэр тодхон санаж байв.Тэгэхэд тэр цасан цагаахан ноосон цамцтай байж билээ.

“Лили. Ариун журамт байдлын билэгдэл. Монголоор сараана цэцэг. Юнона бурханы эхийн сүүнээс ургасан хэмээн эртний Грекийн домогт өгүүлдэг ажээ.Түүнээс ч өмнө эртний Персчүүд нийслэлээ Суза гэж нэрлэдэг байсан нь “лилийн хот” гэсэн утгатай байж. Иудейн шашинтнууд ч мөн энэ цэцгийг цэвэр ариуны билгэдэл хэмээн шүтэж иржээ.

Домогт өгүүлснээр диваажингийн цэцэрлэгт цагаан лили ургадаг байв. Гэтэл тэнд байсан Ева чөтгөрт уруу татагдахад лили цэвэр ариун хэвээр үлдсэн гэнэм. Эртний мисирчүүд ч лилиг мөнх бус, итгэл найдвар, эрх чөлөөний билгэдэл болгон дүрсэлж, түүгээр анхилуун үнэрт тос хийдэг байжээ. Ромчууд энэ цэцгийг бас л итгэл найдварын билгэдэл гэж үздэг байж. Эртний герман домогт Аянга цахилгааны тэнгэр Тор баруун гартаа цахилгаан, зүүн гартаа лилигээр чимэглэсэн очирт таяг барьснаар дүрсэлдэг байв.

Францад лили хаан ширээний билэгдэл байдаг. Анх 12-р зуунд долдугаар Людвиг хаан

өөрийнхөө эрхэт төрийн билгэдэл болгож цагаан туган дээрээ гурван алтан лили дүрсэлсэн нь гагцхүү хаан төрийн сүлд болоод зогссонгүй папын сүр хүчний билгэ тэмдэг болсон домогтой. Францаар “Estre assis surdes lys“ буюу “Лилин дээр суух” гэдэг нь өндөр сэнтийд залрах гэсээ утга илэрхийлдэг аж.

Кавказ хүүхнүүд энэ цэцгийг мэргэ төлөгт ашигладаг.Тэд борооны өмнөхөн лили тасдан авч нуугаад өнгөнийх нь хувирлаар амраг сэтгэлт залуугийнхаа үнэнч эсэхийг сорьдог гэнэ. Хэрэв цэцэгний өнгө шар болон хувирвал итгэлт залуу нь өөр бүсгүйд урвасан гэсэн үг. Харин цэцэг гал улаан өнгөнд хувирвал амраг нь үнэнч хэвээр байгаа юм байна хэмээн таадаг...” Интернетээс энэ цэцэгний тухай олж уншсан эдгээр домог үнэхээр гайхалтай санагдав. Болдог сон бол тэр өөрөө ч Одыг өөртөө хайртай болох эсэхийг нь, олон насны зөрүүтэй ч гал халуун хос болж чадах эсэхээ энэ цэцгээр мэргэлэх сэн.

“Цэцэг” төв рүү очлоо. Гурван ширхэг цав цагаан лили цэцэг авч ягаан туузаар боолголоо. Лилийн эмзэг нимгэхэн дэлбээнээс анхилам тансаг үнэр үл мэдэгхэн ханхийнэ. Гоё бэлэг. Гэвч чин хайрын энэ бэлгээ хэрхэн түүнд өгөх вэ? Мэдээж өөрөө өгч болохгүй, чадах ч үгүй. Цаг харвал дөнгөж таван цаг. Гэтэл Од хүүхдүүдээ сургууль, цэцэрлэгээс нь аваад зургаа өнгөрөөж байж гэртээ ирдэг шүү дээ. “Цэцэг” төвөөс “Сансар” хүртэл таксигаар арваад минут л явна.Өдийд өвөө нь гэртээ байж л байгаа. Яахав? Байка түүнийг аль түрүүнээс хойш “хаа явна?” хэмээн мессежээр шалгаагаад байсан.Тэднийд орж болох л юм.Тэгээд цэцгээ яах билээ? Цэцгийн лангууны хажууд бодол болон зогссон түүнийг хүмүүс “Хөөе, тэр хүү юмаа авсан бол холдооч” гэцгээн адалж буйг ч анзааралгүй зөндөө удаан зогссондоо ичиж хурдхан шиг үүд рүү зүглэв. Хаалганы хажууд зогсоо сонин худалдагчийг харангуут энэ гайхалтай цэцэг нь хоёрдугаар сарын жаварт тас хөлдөж болзошгүйг гэнэт саналаа. Тэгээд хоёр сонин авч цэцгээ давхарлан боов. Хэдэн давхар сонингоор нямбайлан боосон цэцэг нь өлгийтэй нялх хүүхдэрхүү оворжуу юм болж хувирлаа.

Гэгээн хайрын өдрийн бэлэг, цэцэг, бялуу барьсан хүмүүс гудамжаар яаран яаран зөрцгөөнө. Хэдий сонингоор зузаан гэгч нь боосон ч цэцэг нь даарч байгаа даа. Такси барилаа. Гэрийнхээ гадаа буугаад тэр шууд л Одын орц руу орлоо.Тэгээд цаг яагаа ч үгүй тул тавдугаар давхарт гарч цэцгээ барин суусаар л байв. Ядахад цаг явж өгдөггүй ээ. Цаг нөхцөөхийн тулд ээжийнхээ тухай, нэлээд дээр Заяагийн ярьснаар энд ирчихсэн танихгүй хүүхэн сугадаад явж байсан гэх аавынхаа тухай, өөрийг нь эрхлүүлж, өвөртөлж унтдаг асан хайрт эмээгийнхээ тухай элдвийг бодсоор суулаа. Ер нь ч Одын тухай бодлыг тархиндаа байлгахгүйн тулд л тэр. Тэгсэн мөртөө гэгээн хайрын энэ өдрөөр зөвхөн түүнд л цагаан сараана бэлэглэх гээд орцонд нь хамаг биеэ хөштөл маанаг царайлан сууж байдаг. Найзууд нь энэ тухай мэдвэл яах бол? Хатнаа ч яахав. Анзааргагүй амьтан. Байка л түүнийг сүүлийн үед нэг л өөр болоод байгааг ажиж мэдчихсэн атал юу ч асуухгүй гайхаад л яваа бололтой. Үнэндээ зүрх сэтгэлийнхээ нууцыг хэн нэгэнтэй хуваалцмаар л байлаа. Гэхдээ хэнд? Хүнд хэдий найз нөхөд, гэр бүл байлаа ч яс юман дээрээ ер нь зүрх сэтгэлийн нарийн нандин бүхнээ нээж болохоор тийм ойр дотнын хэн нэгэн байдаг юм гэж үү? Үгүй л бололтой.

Цэцгээ тавчихаад дээврийн хонгил руу авирлаа. Дээвэр дээр гарангуут хүйтэн агаар, хотын утаатай холилдон хүзүү хоолой руу нэвг салхилах аж. Гэхдээ халуун орцонд үүрэглэж сууснаас дээр байв. Гэрийнхээ цонх руу харлаа. Зургаа хагас.Орцонд цаг гаруй суучихжээ.

Наран аль хэдийн шингэж бүрэнхий нөмрөөгүй ч зарим нэг айл гэрлээ асаажээ.Өвөө нь гал тогооны өрөөнийхөө цонхны ойролцоо бөгтгөнөж байгаа харагдана. Ашгүй. Тэгэгл Од орцныхоо гадаа таксинаас бууж байгаа харагдав. Хөөрхий муу зүрх нь Түүний барааг ганц харангуут л түг түг цохилоод явчихлаа. Хүү ганцхан үсрэн доош буудаг шат руу очиж гишгүүр алгасан харайсаар орц руу орж дээврийн нээлхийг хаагаад, цэцгээ авч доош пижигнэтэл гүйв.

Гүйх замдаа цэцгээ ороосон олон давхар сонинг задлан Одын хаалганы бариулд ягаан туузаар нь дөнгөж бэхлэв үү, үгүй юү дээшээ буцан зугтлаа. Түүнийг тавдугаар давхарт гарч амьсгаа даран зогсоход доод давхрын шатаар Од хоёр хүүхэдтэйгээ чанга чанга ярилцан өгсч яваа нь дуулдав.

-Ээж ээ,би гадаа гална. За юу!

-Чи дуугай байж бай л даа. Ээж ээ, би цагаан толгойн баярт О үсэг болсон.

-Өө тийм үү? ...

-Би гадаа гална...

-Ээж жж, хар даа, манай хаалганд гоё цэцэг өлгөчихөж!

-Тийм байна ш дээ. Ямар гоё юм бэ? Айл андуурсийм болов уу?

-Үгүй юу гэж андуурдаг юм бэ?Өнөөдөр чинь баяр юм уу?

-Хүүеэ,"Гэгээн ва-валентиний өдөрт! Чамдаа ариун гэгээний билгэдэл лили барья" гээд биччихсэн байна.Ээж ээ.

-Тийм байна уу?

-Өө, нээрээ Гэгээн Валентиний өдөр гэдэг чинь дурлалт хосуудын өдөр гэж багш хэлсэн ш дээ. Багшид нөхөр нь дандаа шоколад, цэцэг өгдөг гэсэн. Аав танд бас шоколад цэцэг өгч байсан уу?

-Аавынхаа тухай надаас битгий асуугаад бай! гэсэн шүү. Анараа алив буу.

-Би гадаа галмаал байна...

Хаалганд түлхүүр торжигнох сонсогдон тэр гурав гэртээ орчихов бололтой.

-Ээж цэцгээ аваач!

-Авчих уу?

-Ав,ав.Танд л өгсөн байж таараа.

-За авлаа.

Хаалга нь тасхийн хаагдав. Энэ яриаг дуулаад ВD-ийн сэтгэл хэмжээлшгүй их баяр хөөрөөр дүүрч доошоо гишгүүр алгасан харайлгалаа. Ямар ч гэсэн Од түүний бэлгий нь авчихлаа. Хэнээс ирснийг нь мэдэхгүй ч сэтгэл гаргаж гагцхүү Түүнд л зориулж авсан ганган цагаан лилийн баглааг нь авчихлаа.

Гэгээн хайрын өдрөөр түүндээ өгсөн анхны нь бэлэг. Бас хуучин нөхрийнхөө тухай ярих дургүй юм гэдгийг нь мэдэж авлаа. Тэхээр түүний тухай дурсах ч дургүй гэсэн үг. Тэгвэл зүрх сэтгэл нь эзгүй гэсэн үг. Эзэнгүй тэр зүрх сэтгэл нь нэг л өдөр түүнийг хүлээн авах ч юм бил үү?

Хүүгийн сэтгэл баяр хөөрөөр дүүрнэ.

Удахгүй тавдугаар сард Түүнийхээ төрсөн өдрөөр нь дахиад үзэсгэлэнт цагаан лилийн баглаа бэлэглэх болно. Ер нь жил бүрийн баяр болгоноор Түүнд ийм цэцэг бэлэглэж байх болно гэж тэр өөртөө амлалаа.

Хүүг гэртээ ороход өвөө нь ашгүй байсангүй. Гал тогооны өрөөнөөс өвөөгийнх нь бараг дандаа хийдэг гоймонтой шөл үнэртэнэ. Түүнд гоймонтой шөл оочих дур байсангүй. Ганц өндөг шарж идчихээд хичээлээ давтахаар суулаа.

Нэг босохдоо цонхоороо өөрийн мэдэлгүй Одынх руу харвал нөгөө хоосон байж байдаг ногоон ваарандаа өөрийнх нь өгсөн цагаан лилиг хийчихсэн байхыг үзмэгц сэтгэлд нь гэгээ татаад явчихлаа. Дуу аялмаар, хөгжим сонсмоор бас шүлэг уншмаар санагдана. Урьд нь Биди уран зохиолын хичээл гэхээр толгой нь өвддөг сөн. Гэтэл өнөөдөр энэ хичээл харин ч гоё юм шиг санагдаад явчихжээ. Тэгэхээр нь интернетэд орж уран зохиолын сайтнаас өөрийн мэдэлгүй баахан хайрын шүлэг түүж уншаад сэтгэл нь бүр ч хөнгөрчих шиг. Найм өнгөрч байхад хаалганы цоож торжигнон өвөө нь амьсгаадсаар орж ирж байгаа дуулдав.

-Миний хөө!Түнжгэр банди аа!

“Кк хх...Хүнийг дандаа энэ тэнэг үгээр дуудаж байхын” хэмээн ундууцсан ч “юу гэв ээ,өвөө?” хэмээн аядуухан дуугарлаа. Ер энэ өдөр хэнд ч юунд ч уурлаж уцаарламааргүй байлаа.

-Аа, ирчээ юу миний хүү? гэх өвөөгийнх нь хоолойд өөрийг нь өхөөрдсөн зөөлөн өнгө илрэхэд нь тэр ч бас дотроо уяраад ирэв.

-Хоолоо идээ юу?

-Идсэн.Гоё шөл байна лээ.

-Аль, өвөөгийнхөө гэрийн шаахайг олоод өгөөч.

-За аа.

Өвгөний майжгий хоёр шаахай нь угаалгын өрөөний үүдэнд эзэндээ гомдсон мэт хайш жайшхан хэвтэж байхыг нь олж аваачиж өгөөд өрөөндөө орлоо. Өвөө нь сурсан зангаараа зурагт асаан мэдээ үзэж эхлэв бололтой.

Компьютерийнхээ ард суусаар байгаад нэг сэхээрч цаг харвал хэднийнээ унтах цаг болчихжээ. Цонх руугаа очиж өнөөх цэнхэр хөшигтэй танил дотнохон цонх руу харж нэг санаа алдсанаа орондоо оров.

Өдөр хоног урсан өнгөрсөөр. Гурав, дөрөвдүгээр сар нэг л мэдэхэд дуусч байлаа. Мартын наймнаар BD бас л гурван ширхэг лили авч гоёмсгоор боолгон, бүсгүйн гэрийн хаалганд хавчуулж билээ. Тэгээд орой нь Од нөгөө л ногоон ваарандаа цэцгүүдийг нь хийж цонхон дээрээ тавьсан байхыг харж бас л хэмжээлшгүй аз жаргалд автсан сан.

Дөрөвдүгээр сарын сүүлчээр ханш нээх өдөр хүү өвөө болон том нагац эгчтэйгээ хамт хөөрхий эмээгийнхээ шарил дээр очиж булшных нь орчмыг цэвэрлэн арц уугиулж, дуртай амттаныг нь тавьсан. Жижигхэн боржин чулуун хөшөөн дээрээс эмээгийнх нь зураг түүнийг гунигтайяа ширтэнэ. Сар бүр эмээгийнхээ таалал болсон өдрөөр зургийнх нь өмнө зул өргөхөөс бусад цагт хайрт эмээгээ бараг дурсахаа больсноо санаж хүү хачин их гэмшлээ. Хүн гэдэг хичнээн мартамхай өөдгүй, амиа хичээсэн амьтан байдаг юм бэ? Эмээгээ хөдөөлүүлснээс хойш хэдийнээ гурван жил өнгөрчихөж.

Эмээгийнх нь булшийг янзлан, эргэн тойрных нь хогийг түүж, зул асаан будаа цацаад буцахын өмнө нагац эгч нь чимээгүйхэн мэгшиж, Бямбаа өвөөтэйгээ хоёул нулимс унагаагагүй ч, сэтгэл дотроо шугшран уйлж буйгаа хоёулаа мэдэрч байлаа. Эргэн тойрон тэдэн шиг хайртай, дотно хүнийхээ шарилыг эргэж, булшных нь орчны хогийг түүж, хайсыг нь засан будаж байгаа хүмүүс. Бас хэн ч эргэж ирдэггүй, өнчирч хаягдсан мэт өчнөөн олон булшнууд. Хүн юуны төлөө энэ хорвоод ирж, яах гэж зовж зүдрэн амьдраад, эцэст нь хайшаа оддог юм бол? гэмээр. Тэр өдрөөс хойш дөрөвдүгээр сар хоромхноо урсан өнгөрөв. Тэр сэтгэл дотроо бүсгүйг бодож мөрөөдөвч төгсөх ангийн хичээлдээ шамдан хоног сар санаснаас хурдан өнгөрсөөр тавдугаар сарын босгонд тулж ирсэн байлаа.

Тавдугаар сарын нэгэн.Түүний төрсөн өдөр. Нарлаг, навчис гөлөглөн тэнгэр цэнхэртсэн сайхан өдөр байлаа.

29 насных нь төрсөн өдрийн өглөө хайртай түүнийгээ хэрхэн баярлуулдаг билээ? Хэд хоногийн өмнө үеэл эгч Заяагаа ирж хоноод явахад нь Бямбаа үгийн далимаар эмэгтэй хүнд төрсөн өдрөөр нь юу авч өгвөл зүгээр болохыг болгоомжтой гэгч нь асуусан юм.

-Яах нь вэ?

-Ангийнхаа охинд баяр хүргэх гээд л...

-Ямаршуу охин юм бэ гэдгээсээ болно ш дээ.

-Юу гэсэн үг юм?

-Тэр чинь юу сонирхдог охин юм бэ? Үгүй ядаж л ямархуу хэв маягаар хувцасладаг, ямар хоббитой, хөнгөмсөг юм уу, ухаалаг юм уу гээд л. Охин бүр яг адилхан юм сонирхохгүй ш дээ.

-Нэг тийм ...Ухаалаг талдаа...охин гэх үү дээ...

-Чи тэр охинтойгоо үерхэж байгаам уу тэгээд?

-За үгүй дээ. Надад таалагддаг охин байхгүй юу гэж хэлэхдээ Бямбаа дотроо яагаад ч юм Номин-Эрдэнийг төсөөлж байлаа. Хэрэв чи заавал ангийнхаа нэг охинтой үерх гэвэл Номин-Эрдэнийг л сонгох байсан байх гэж тэрхэн мөчид боджээ.

-За тэгвэл эхлээд мэдээж гоё цэцэг, тэгээд аятайхан тэмдэглэлийн дэвтэр, эсвэл ном зүгээр байх аа. Битгий тэнэг ээмэг мээмэг авчаарай. Таалагдахгүй бол зүүхгүй ш дээ.

-Заа... за. Зөвлөгөө өгсөнд баярлалаа. Харин том...эмэгтэй хүнд бол ямар бэлэг гоё бол? Нэг багшдаа бас бид нар... юу... бэлэг авч өгөх ёстой юм л даа?

-Хэдэн настай хүн юм?

-Юу..у хорин хэдтэй л байх даа.

-За тэр чинь бүүр ч хэцүү юм байна. Ер нь бүх эмэгтэй хүн үнэртэй усанд дуртай байдаг. Үнэртэй ус бэлгэнд авах дургүй эмэгтэй хүн би л лав мэдэхгүй юм байна.Томхон ядаж 50, бүүр 100 граммтай ус бэлгэнд авбал ч гоё шүү. Мөн үү? гээд тас тас хөхөрснөө:

-Гоё гоё брэндийн ус зөндөө л байгаа ш дээ.

-Жишээ нь?

-Чи чинь яасан нойтон хамуу шиг салдаггүй амьтан бэ?

-Та одоо надаар тоогоо бодуулдаг байж юундаа үнэд ороод байгаан?

-За за. Цаагуур чинь DIOR, Boss, Anna sui энэ тэр гээд зөндөө л уснууд байгаа ш дээ. Жишээ нь би Anna sui-д дуртай. За за, би найзтайгаа чааталж байна.

Ийм яриа Заяа тэр хоёрын хооронд болсон юм.

Бүсгүйн төрсөн өдрийн урьд өдөр нь тэр хичээлээ тараад өдөржин Их дэлгүүрээр явж, Заяагийн хэлсэн нөгөө уснуудын 100 граммаар савласан нь айхтар үнэтэйг хараад цочив. Тэгээд ч тэр гоё юмыг хаалганых нь бариулд зүүж орхилтой нь биш дээ. Цалин мөнгөгүй, ганц ээжийнхээ харь газар хар ажил хийж олдог мөнгөөр тийм үнэтэй юм авч өөрийг нь танихгүй шахуу бүсгүйд өгнө гэдэг утгагүй хэрэг гэдгийг ч дотроо хүлээн зөвшөөрч байлаа.Тэгээд таван ширхэг цасан цагаан сараана цэцэг боолгон “Төрсөн өдрийн мэнд хүргэе чамдаа! Х-ээс “ гэсэн зурвастай хаалганых нь бариулд бэхэлчихээд хичээлдээ гүйчихлээ. Х гэдэг нь өөрийгөө икс залуу гэж байгаа ухаантай юм уу даа.

Хичээлдээ ирэн биолог, химийн шүүлгээ өгч байх зуураа тэр бас л Одын тухай л тасралтгүй бодсоор байлаа.

Удахгүй хориод хоногийн дараа өөрийнх нь төрсөн өдөр болно. Тэр өдөр Од бас түүнд баяр хүргээд ядаж ганц үнсвэл, үгүй ээ, өөрөө түүний хагас жимийсэн зузаандуу атлаа жижигхэн уруул дээр нь үнсвэл, бүүр озон үнсвэл тэрнээс илүү тансаг сайхан бэлэг гэж үгүй мэт

санагдана. Одыг харах тусам гонзгойдуу нүүр, памбагар жижигхэн уруул, өндөр ч биш, намхан ч биш дунд зэргийн гоолигхон бие сэлт нь дуу алдам сайхан санагдана. Гэтэл ангийнх нь Гүнжээ, Энжи мэтийн охидыг Одтой харьцуулахад бие хаа, галбир төрх нь хөгжиж гүйцээгүй дутуу болсон жимс шиг атлаа, яагаа ч үгүй зан ааш нь эвдэрч гүйцсэн байхыг яана. Харин Од бол амьдралыг таньж ухаан суусны гэрэл гэгээ харцанд нь тодорч, зүс царай, бие галбирт нь жинхэнэ эмэгтэй хүний гоо үзэмж тэгш бүрдсэн, үзтэл эгэл даруухан зан аальтай, хайр халамжтай, ёстой л жинхэнэ төгс бүсгүй хүн. Хүсэл татсан хүүхэн гэдгийг нь ухаарах тусам улам л сэтгэл татагдана.

Биологийн шүүлэг ч гэж амархаан тест байлаа. Гэтэл хими. Ердөө ч бэлтгээгүй бодлого ирчихсэн шилээ маажлан хулмалзаж суутал багшийг утсаар ярих чөлөөгөөр баруун хойноос жижигхэн эвхсэн цаас яг өвдөг дээр нь унадаг байгаа. Тэр зүг гайхан харвал Номин-Эрдэнийн царай улсхийгээд дохиж байв. Задалж үзтэл нөгөө бодлогыг жирийсэн гаргацтай бичгээр бодоод явуулчихсан байлаа.

Номио өөрт нь сайн гэдэг шивэр авир яриа үнэн л юм байна даа. Царай нь улсхийж байгаагийг нь харахгүй юу. Хүн гэдэг яасан муухай амьтан байдаг юм. Химийн шүүлэг дуусангуут л тэр Номин-Эрдэнийн тухай бараг мартчихсан ангиасаа гарч явлаа.

Оюун бодолд нь байрных эгчмэд бүсгүйн дүр төрх хадаастай. Сэтгэл эзэмдсэн түүндээ хэрхэн төрсөн өдрийн баяр хүргэх вэ? Бодож бодож тэр ажил руу нь очихоор шийдэв. Гэхдээ нэг аюултай нь тэр Заяагийн сурдаг хувийн сургуульд хүний нөөцийн ажилтан, номын сангийн эрхлэгчийн ажилтайд байлаа. Тиймээс хамаагүй тэрүүгээр явах юм бол үеэл эгчтэйгээ тааралдан бөөн асуулт, байцаалтанд унана гэсэн үг.

За, яадаг юм, Заяатай тааралдвал ч тааралдаг. Ер нь алийн болгон хайртай бүсгүйгээ цонхоороо харуулдаж суухын. Түүнийгээ төрсөн өдрөөрөө ямархуу байгааг нь харах тэсгэлгүй хүслэнд автаад байлаа.

Одоо тэр өөрөө 17 хүрэх гэж байгаа билээ. Биди бодоод байхнаа бүүр цэцэрлэгт байхдаа ангийнхаа Хүслэн гэдэг хөөрхөн эрлийз охинтой хөтлөлцөн гүйдэг байсныг эс тооцвол яагаад ч юм өнөөг хүртэл ганц ч охинтой үерхэж үзээгүй явсаар анхны хайр амслаа гэсэн нь ийм хяслантай дурлал байдаг.

Ээждээ ч, ахдаа ч хайрынхаа тухай цухуйлгаж болдоггүй. Найз нартаа ярьж бүр ч болохгүй. Гэртээ авчран өвөөтэйгээ танилцуулна гэж ч байхгүй. За юун гэртээ авчрах вэ? Ер нь ч мөн мөрөөдөв өө, бас. Хамгийн харамсалтай нь хайрын эзэн түүнтэйгээ танилцаж, сэтгэлээ илчилж бүүр ч болохгүй ийм л утгагүй дурлал байх гэж. 12 насны зөрөө гэж тийм аймаар юм гэж үү?

Деми Мур гэх мэтийн Холливудын одод, ээжийнх нь шүтээн Оросын дуучин Алла Пугачёва гээд хүүхэд нь баймаар залуутай суучихсан эмэгтэйчүүд зөндөө л байдаг ш дээ.

-Хүүе, BD! Хаачих нь вэ? Хичээл тарангуут л ганцаараа чимээгүйхэн яваад өгөх юм. Чи нэг нууцтай болжээ дээ. Мөн үү? гэсээр Хатнаа хүрээд ирэв.

-Маньд нь ганцаараа явах нэг ажил байнаа. Орой уулзъя.

-Кк.

Түүнийг Одын ажил дээр ирэхэд ашгүй оюутнууд нь бараг тарчихсан байлаа.

Номын санг нь сурагласаар яваад олж шагайвал Тэр гарахаар юм хумаа цуглуулж байв. Төрсөн өдрөөрөө Од үнэхээр гайхалтай үзэсгэлэнтэй харагдаж байлаа. Усан цэнхэр өнгийн торгон цамц, шулуухан хөлөө гаргасан богино хар банзал өмсч, цамцтайгаа ижил өнгийн цэнхэр шигтгээтэй жижигхэн унждаг ээмэг зүүсэн нь цонхоор туссан тавдугаар сарын хөгжөөнт нарны гэрэлд туяаран, дандаа ардаа даруухнаар шуусан байдаг гялгар хүрэн үсээ задгай тавьсан нь үнэхээр харц салгамааргүй үзэсгэлэн төгс.

-Өнөөдөр эгчийнх нь төрсөн өдөр. Та нар номоо Батцэцэг багшид хураалгаарай. Хавтсыг нь гэмтээсэн, хуудас тастсан хүн байвал надаас ном авах нүүргүй болно шүү. За баяртай хэмээн тэр оюутнуудад хэлэх аж. Цаана нь нөгөө Батцэцэг нь бололтой тарган эмэгтэй сууж байснаа:

-За төрсөн өдрөө сайхан өнгөрүүлээрэй! Санаа зоволтгүй. Би номыг нь сайн шалгаж авна гайгүй гэлээ.

-Төрсөн өдрөө сайхан өнгөрүүлээрэй Од эгч ээ! хэмээн оюутнууд ам амандаа шуугицгаав.

Түүнийг тэгшхэн шилбээ гялалзуулан товор товор алхалсаар ойртоход Бямбаагийн нүүр рүү бас л гал харвагчаар харвах мэт мэлсхийн халуу оргиод явчихав. Тэгээд амьсгаа нь дээрдсэндээ бушуухан буруу харав. Түүнийг цааш харан зогсох зуурт Одын хөнгөхөн алхаа тог тогхийж, толгой эргэм анхилам үнэр түгээн өнгөрлөө. Өчигдөржин дэлгүүрт үнэртэж, барилан үзэж явсан нөгөө гоё уснуудын нэг нь түүний өөрийнх нь биеийн тансаг үнэртэй холилдон толгойг нь мансууруулчих дөхөв.

Тэр хэнтэй, хаана төрсөн өдрөө тэмдэглэх бол? Хойноос нь дагадаг юм уу гэж нэг бодсоноо гэнэт хичнээн утгагүй бүдүүлэг алхам хийх гэж буйгаа ухаарлаа. Түүний ертөнц рүү нэвтрэх эрхийг хэн чамд өгсөн юм бэ? Чам шиг нэг тэнэг банди өөрт нь дурлачихаад толгой нь эргэж явааг энэ бүсгүй мэдээ ч үгүй, зүүдлээ ч үгүй байгаа шүү дээ хэмээн мэхээрмэгц тэр толгой ганзгалан гарч одлоо.

Бямбаа тэндээсээ гарч ганцаараа нэг жижигхэн бүүдгэр кафед орж, хичнээн лааз “Сэнгүр” хоосолсныг бүү мэд. Хаврын наран хурцаар ээж, модод дөнгөж гөлөглөн буй энэ сайхан өдөр сая гаруй хүнтэй энэ хотод түүн шиг ганцаардсан хүн үгүй мэт бодогдоно. Эргэн тойрон яарсан, инээсэн, бухимдсан янз бүрийн хүмүүс хөлхөлдөн, замаар машинууд багталцахгүй түгжрэн, уур омогтой жолооч нар дохиогоо чарлуулан, хаа нэгтээ өөрт нь сэтгэл алдсан Номин-Эрдэнэ хэмээх аятайхан охин зөвхөн түүний тухай бодолд автан, найзууд нь чи хаачив аа? хэмээн мессеж нисгэн шалгааж, хайртай өвөө нь гэрээсээ гар утас руу нь залган, ээж нь хаа байсан Солонгост түүний л төлөө, идэх өмсөхийг нь залгуулах гэж хар ажилд зүтгэн, аав, ах нь хаа нэгтээ байгаа ч сэтгэл зүрх нь тэсвэрлэшгүй ихээр гуниглан, сэтгэлийн тэр

ганихрал, ганцаардлыг юугаар ч эдгээшгүй, гагцхүү ганц хүн л дэргэд нь байвал зүрх нь аз жаргалаар дүүрнэ гэдгийг мэдрэх хичнээн хэцүү вэ! Магадгүй, тэр хэдэн жилийн дараа энэ тухайгаа санаж өөрийгөө шоолон инээж ч болох юм. Гэхдээ л 17 нас нь эргэн ирэхгүй шүү дээ. Ер нь ч арван долоотой зүрхний дурлал л чин үнэн байдаг ч юм бил үү? Зүрхэнд үрчлээс суудаггүй гэдэг ч хорь гараад, гуч дөхөөд, дөч шүүрээд ирэхээрээ хүний зүрх сэтгэл нь хүртэл цэвэр ариун чин үнэнч чанараа алддаг ч юм бил үү?

Түүнийг кафенаас гарахад хөл нь бадайрч, уусан пивондоо толгой эргэж байвч сэтгэл нь арай хөнгөрсөн байлаа. Хайрынхаа төлөө тэмцэх хэрэгтэй юм гэдгийг л тэр өнөөдөр тов тодхон ухаарсан юм.

Бусдад юу гэж бодогдох нь хамаагүй. Зүрх сэтгэл гэдэг зөвхөн түүний ертөнц, хэн ч нэвтрэх эрхгүй цайз нь юм. Нэгэнт тэр бүсгүйг сэтгэлээсээ цэцэг тасдах мэт гарган хаяж чадахгүйгээс хойш, насны зөрөө хамаагүй, гагцхүү түүний л төлөө эр хүн болдог хэрэг, хайрыг нь булаахын төлөө чадлаараа тэмцдэг хэрэг хэмээн эрс шийджээ.

Түүнийг гэртээ ирэхэд том нагац эгч нь ирчихсэн бууз жигнэн, сайхан цай чаначихсан өвөө нь додигор амьтан сууж байлаа.

-Миний хөө! Урнаа эгч нь бууз хийгээд. Хоолоо ид. Давтлаганд сууж байгаад ирэв үү? гээд духыг нь үнэрлэсэнээ:

-Бямбаа маань надаар дуудуулж барилгүй өглөө хар эрт босоод л хичээлдээ гүйчихдэг болсон. Ууганаагаас ч хамаагүй дээр. Өөрөө цай ундаа уучихаад л явчихна. Санаа амар хэмээн магтав.

-Миний дүү хичээл нь сайн уу? Шалгалт эхлээгүй юу? Ээж нь чамайг захиад л байна лээ. Нүднийх нь доогуур хөхрөөд бүүр ядаргаанд орчихож. Эрэгтэй хүүхэд гэхэд элдэв хэрэгт түвэгт орооцолдохгүй, эцэг эхийнхээ байхгүйд өдий зэрэгтэй байгаа нь овоо ш дээ хэмээн нагац нь бас ичиж үхтэл нь магтаж гарлаа.

Бууз үмхлэн хийцтэй цай хэд оочоод л хөлс нь чийхран эмээ нь бодогдоод ирэв.

-Эмэгтэй хүнгүй айл гэж хөндий оргиод чаавас гэж. Хөгшин залуу хоёр энэ зэрэгтэй байгаа нь хэр. Цаад Отгончимэгт чинь мөнгөнөөс өөр юм бодогдохоо байсым байх даа. Хүүгээ төгсөхөөр ирнэ л гээд байдаг. Мэдэхгүй дээ. Энэ хүүхдийн хаврын шалгалт хаяанд тулаад ирлээ. Хүүгээ дөнгөж нэгдүгээр ангид орж цагаан толгойн баяраа хийгээгүй байхад нь л хаяад явсан. Амны хишигтэйдээ энэ хүүхэд гудамжинд гарчхаагүй байх гэхчлэн өвөө нь гомдоллож гарахад Бямбаа өрөө рүүгээ орлоо.

Түүний хувьд ээжийгээ ирнэ гэж хөөрч догдлон хүлээхээ бараг больчихсон. Харин өвөө нь настай хүн болохоор хөгшнөө алдсанаас хойш ээжийг нь ирэхийг л хараад байдаг бололтой.

-Хөгшин хүний үг ч үг биш болсон хойно доо хэмээн өвөөгийнх нь үглэх бүүр түүр сонсогдсоор тэр нам унтчихсан байлаа.

-Миний түнжгэр хүү яасан эвгүй унтчаав?Хүзүү нь гоёодно доо гэх өвөөгийнхөө дуугаар тэр сэрлээ. Цаг оройн ес өнгөрч байлаа.

Цэв цэнхэр цамцтай Од инээмсэглэн хацрыг нь илж байна хэмээн зүүдэлж байтал сэрсэн нь өвөө нь л дэрийг нь засангаа хацрыг нь үнэрлэсэн бололтой.

-Урнаа эгч явчихсан уу өвөө?

-Түрүүн гарлаа. Цонхоо онгойлгохгүй, энэ өрөө чинь бүгчим гэж...халуун зун болчоод байхад энэ паараа тасалдаг болоосой. Миний хүү хичээлээ хийсэн үү? Босч толгойгоо сэргээ. Өлсчөө биз.Чи бид хоёрт мөд ийм сайхан цай чанаж өгөх хүн олдохгүй хэмээгээд өвөө нь хүнд хүнд гишгэлэн өрөөнөөс нь гарав.

Тэр босоод өөрийн мэдэлгүй л Одын цонх руу харлаа. Нөгөө ногоон вааранд өөрийнх нь өглөө хаалганд нь зүүж орхисон цагаан сараана цэцгүүд байж байлаа. Энэ цэцгийг өөрт нь хэн өгөөд байдаг гэж тэр боддог бол?

Тэднийд нэг амралтын өдрөөр ирж хонохдоо Заяагийн мартаад явчихсан байсан номонд “Эмэгтэй хүн оноо өгч үнэлэхдээ хайрын бэлэгний хэр зэрэг том жижиг нь хамаагүй бэлэг тус бүрт ижил тэнцүү нэг нэг оноо өгдөг.

Эрэгтэй хүнд маш өчүүхэн бэлэг мэт санагдаж байгаа боловч эмэгтэй хүний хувьд агуу том бэлэгтэй харьцуулам үнэ цэнэтэй байдгийг ойлгодоггүй. Эмэгтэй хүний хувьд ганц ширхэг сарнай цэцэг авсан ч өндөр үнэтэй эрдэнийн зүйл авсан ч сэтгэл шингэсэн зүйл гэж адилхан үнэлдэг...” гэсэн байсныг гэнэт саналаа. Энэ тавхан ширхэг цагаан сараана цэцэгт хичнээн их сэтгэл шингэснийг тэр ойлгодог болов уу?Өнөөдөр төрсөн өдрөө тэмдэглэнэ гээд ажил дээрээсээ гоёж гангалаад хэн рүү гарч явсан юм бол? Өдий зэргийн сайхан хүүхэнд уулзаж учирдаг, ядаж ор хөнжлийн хамтрагч байдаг нь ойлгомжтой шүү дээ гэж бодоход сэтгэл нь урагдах мэт болж цонхноос холдлоо.

Харин маргааш өглөө нь нөгөө албаны дугаартай “Sonata” тэдний байрны гадаах ил зогсоолд хоносон бололтой байж байгааг харангуут хүүгийн дотор нь харанхуйлаад явчихлаа. Түүнийг эргүүлдэг гүзээтэй эр төрсөн өдрөөр нь далимдуулан гэрт нь хоножээ. Цонхон дээрээ ногоон вааранд хийж тавьсан цагаан сараана цэцгүүд нь урьдынх шигээ түүнийг баярлуулсангүй. “Эмэгтэй хүний хувьд ганц ширхэг сарнай авсан ч өндөр үнэтэй эрдэнийн зүйл авсан ч ...адилхан үнэлдэг” гэл үү? Худлаа.Түүн шиг хоосон худал үг байхгүй. Хоёр хүүхэдтэй ийм гоё бүсгүй бүү хэл, арван зургаатай охид л том жийптэй, зузаан хэтэвчтэй баян хөгшин эр рүү гүйлддэг...

Бямбаа тэр өдрөөс хойш өөрөөсөө олон эгч, тэгээд бас ”явдаг хүн”-тэй тэр хүүхнийг мартаж санаатай хэд хоног тэдний цонх руу ч харсангүй, хичээл номоо бодон, хааяа найзуудтайгаа шоудчихаад л яваад байлаа. Энэ хооронд сонгинон цэцгээ ч услахаа мартжээ.

Хаврын шалгалтууд дуусч ээжийнхээ захиснаар тэр банк санхүүгийн мэргэжлээр улсын нэгэн их сургуульд элсч чадлаа.

Цэцэрлэгийн багшаар ажиллаж байгаад 90-ээд оны дундуур аавынх нь наймаа бүтэлгүйтэхэд банкинд үйлчилгээний ажилтнаар орсон ээжийнх нь ганц харамсал банкны эдийн засагч болж чадаагүй нь байсан юм. Тэгээд юм л бол хоёр хүүгээ заавал банкны мэргэжил эзэмшиж, том банкир болоорой хэмээн сургадаг байв.

-Хар л даа, миний хүү. Банкны захирлууд хичнээн гоё машин унаж байна. Хичнээн сайхан залуучууд банкинд ажиллаж байгааг. Цэвэрхэн гоё костюмтай, гял цал буусан.Тэгээд хичнээн сайхан тохилог орчинд ажиллаж байдаг гээч гээд л ээж нь хааяа Бямбаагаа дагуулан ажил дээрээ очихдоо хэлдэг сэн.

Ууганаа ах нь жаахандаа ээжийнхээ үгээр “Би том болоод банкны захирал болно” гэж баярлуулдаг байснаа одоо болиод бизнесийн удирдлагаар сурч байгаа ч ээж нь сэтгэл хангалуун л байдаг юм.

Харин пуужинт цэргийн инженер мэргэжилтэй аав нь эр хүн цэргийн албаа заавал хаагаад дараа нь инженерийн мэргэжилтэй болбол зүгээр хэмээн ээжээс нь тэс өөрийг зөвлөдөг ч хүү угаас эцгээсээ хөндий, тэгээд ч дэндүү балчир байсан болохоор юмны учир нарийн ойлгодоггүй байжээ.

-Эрэгтэй хүүхдүүд хэцүү гэдэг ч миний хоёр хүү эцгээ дууриагаагүй. Манайхныг дууриасан дүн нуруутай, хүмүүжилтэй, санаа зовоодоггүй хүүхдүүд гэж ээж нь заримдаа магтдаг юм.

Бямбаагийн хувьд өдий хүртэл ийм тийм мэргэжилтэй хүн болно гэсэн онцгой хүсэл тэмүүлэлгүй, урсгалаараа явснаа сургууль төгсч мэргэжил сонгох цаг тулсан хойноо л ойлгожээ. Шалгалт эхлэх гэж хөл үймээн дэгдсэн үеэр болсон төрсөн өдөр нь чимээгүйхэн өнгөрч, хонхны баяр, ангийнхны үдэшлэг, аялалд сэтгэл нь төдийлөн хөдөлсөнгүй. Бямбаа хүссэн сургуульдаа тэнцсэнээ хэлж ээжийгээ баярлуулчихаад Хатнаа, Байка хоёртой Сүхбаатарын талбайн зүүн тал дахь усан оргилуурын хажуугаар явж байгаад ангийнхаа Номиотой халз тааралдчихав.

Усан оргилуурын захад бодлогошрон суусан охин ангийнхаа хоёр бандитай тааралдан, ялангуяа өөрийг нь халти харангуут царай нь хувьсхийхийг Бямбаа анзаарчихлаа.

Номио үсээ бүүр богинохон тайчихаж.

-Чи анагаахдаа орж чадсан уу? гэж Хатнаагийн асуухад:

-Үгүй ээ. Ганцхан л оноо дутсан. Аав ээж хоёр хувийн анагаахын дээд сургуульд оруулж өгье гэхээр нь үгүй гээд эм найруулагч болох гэж байгаа. Хувийн сургуульд орсноос эртхэн цалинтай болсон нь дээ биз дээ гэснээ:

-Харин та хоёрт баяр хүргэе! гэж тэр даруухнаар хэлээд үсээ чихнийхээ араар хийв. Охин харахаараа дуугүй өнгөрдөггүйгээрээ Хатнаа:

-Хамт явж “Тэнгис”-т кино үзье л дээ. Чи энд ганцаараа юу хийж байгаан? Чам шиг

хөөрхөн охин ингэж ганцаараа усан оргилуур энэ тэртэй газраар зугаалаад байж болохгүй шүү. Цаана чинь хүний наймаа дэлгэрээд Хонконг, Макао охидыг зардаг болсныг мэдэж байна уу? гэхчлэн элдвийг урсгахад Номо юу ч хэлсэнгүй чимээгүй инээмсэглэн зогсч байснаа:

-Юун хүний наймаа вэ. “Тэнгис”-т гоё кино байхгүй л байна лээ ш дээ. Би хөдөөнөөс ирсэн хамаатнаа хүлээж байгаам аа. За баяртай гээд яваад өгөв.

-Энэ Номо улам хөөрхөн болоод л байх юм. Чиний нүд сохор юм уу? Тэгээд ийм даруухан. Манай ангид Номоогоос өөр онгон охин байхгүй гээд мөрийцчих үү? гэж Хатнаа хэлэв.

-Чи Номогийн онгоныг яаж мэдээв? Охидын эмчийн үзлэгт оруулж шалгаа юу? гэж Бямбаа ундууцсан ч дотроо охиныг өрөвдөж л байлаа.

-Нээрээ энэ охин чамд харваас сайн юм аа. Одоо ч ийм хөөрхөн даруухан, саак охин ховор доо гэж Байка үг нэмнэ. Тэгэхэд нь Хатнаа:

-Наадхи чинь баян айлын хүргэн болох гээд Номог тоохгүй байгаан гэх нь албаар дургүйг нь хүргэх гэж байгаа бололтой.

Хүүгээ арван нэгдүгээр ангиа төгсөнгүүт буцаж ирнэ гэж олон жил амласан ээж нь гэнэт л “Хүүдээ санаа зовоод байсын. Хүссэн сургуульдаа орчихлоо. Аавыг чадалтай дээр нь эндээ дахиад ганц нэг жил ажиллахаас. Намайг очингуут л хураасан жаахан мөнгө хорогдож эхэлнэ.” гээд ирэхээ больчихсонд өвөө нь их л урамгүй байлаа.

-Муу эхийгээ өнгөрөхөд ч гэрийн бараа хараагүй энэ хүн ирэхээсээ өнгөрчээ. Би ч амьддаа зүсийг нь харахгүй дэг ээ. Отгон охин минь хөл хучна гэж л боддог байсан. Намайг нүд аньсан хойно л оршуулган дээр ирж орилох хүн бололтой дог хэмээн гомдоллох аж.

Ээж нь тийнхүү буцаж ирэхээ хойшлуулсанд Бямбаа нэг их гонсойсонгүй. Харин долдугаар сарын эхний нэг өдөр Хатнаагийн аавтай гурвуулаа Дархан руу хамт явж байгаад даваан дээрх замын гуанзанд гэнэтийн явдалтай тулгарч билээ. Үеэл эгч Заяагийнх нь хэлснээр аав нь тэдний хэнд нь ч хэлэлгүй Монголдоо буцан ирсэн нь үнэн байжээ.

Хатнаагийн аав Долгион Дарханд барилга барих газар үзэх гэж явахад нь жолоо барих хорхой нь ид асч байсан мань хоёр дагаад гарсан хэрэг.

Тэр гурав замын гуанзанд үдлэх зуур Бямбаа хоолоо идчихээд хүйтэн юм нэмж уух санаатай лангуу руу очингоо мессежээ шалгаж байтал :

-Хоёр цуйван. Нэгийг нь тос багатай өгөөрэй, ахын дүү гэх хачин танил дуу сонсогдоход өөрийн мэдэлгүй цочин тэр зүг рүү харж билээ. Яг л аавынх нь дуу...

“Ахын дүү” гэж аав нь өөрөөсөө ялимгүй дүү хүмүүсийг хүртэл дуудах дуртайг тэр хараахан мартаагүй байлаа. Тэгээд царгиа чанга, аргагүй л цэрэг командалж явсан захирангуй дуу нь

яг хэвээрээ.

Өндөр янхигар нуруу, өргөн цээж, буурал орж яваа долгионтой үс, зүүн чихэн дээрх сорви, баруун гарын бугуйн дээрх хос загасны шивээс...Яг мөн.

-Даагий, би нойл орчоод ирье гэсэн залуу бүсгүй рүү аав нь эргэн харахдаа хүүтэйгээ харц тулгарчихлаа.

-Энэ чинь миний хүү юу даа?

-Аав..

-Сайн уу? Миний хүү!

-Та энд ирчихсэн байсым уу?

-Алив хүүгээ үнсье дээ...

Тэгэхэд нь үгүй ээ, үнсүүлэхгүй гэж цахдан зугталтай нь биш.

Баруун хацраа өглөө. Аавынх нь танил үнэр...Хүн эцэг эхээ сонгох биш дээ. Одоо тэр жаахан хөвгүүн биш, нусгай жаал биш. Тэд ярилцсаар л байлаа. Тэгсээр нөгөө нойл явсан залуу хүүхэн хэдийнээ орж ирээд хоолоо идэж дуустал, аавынх нь тавагтай цуйван хэдийн хөрч царцтал, гадаа тамхи татах гэж гарсан аавтайгаа хамт өөрийг нь хүлээж байсан Хатнаа ч гайхтал удаан ярьж суулаа.

-Аав нь хүүтэйгээ уулзах гээд зүрхлэхгүй л өдий хүрчихлээ. Миний хүү яасан ч том эр болоов дээ. Би та нарынхаа өмнө буруутай...хүн.Гэхдээ төрсөн үр хүүхдээ гэдэггүй эцэг хүн гэж хаа байхав дээ. Чамайг өвөөтэйгээ хамт ажрахгүй байгааг чинь алсаас харж сураг тавиад л явсан. Хүний нутагт ээжийг чинь орхиод ирсэнд мэдээж миний буруу бий. Тийм юм хийсэн хүн өвөөгийн чинь царайг ч яаж харахав. Ууганаад ч энд байгаагаа хэлээгүй. Гэхдээ чи том болж амьдралын цаад наадхийг гадарлахтай болсон хүн. Нэгэнт сэтгэлгүй болсон хүмүүс бие биеэ зовоож явснаас салсан нь дээр байсан юм...Аав нь хүүдээ хөндий байсан бол уучлаарай гээд л олныг ярив.

“Хөндий байсан бол уучлаарай” гэнэ шүү. Хөндийгөөр барах уу даа. Ууганаа ах нь өврөөс нь, Бямбаа ар нуруунаас нь унасан юм уу, ээжийгээ дагаж ирсэн аятай л ялгадаг байсан биш үү? Энэ тухай бодонгуут цээжээд нь нэг юм огшоод ирсэн ч биеэ барьж чадлаа. Гэхдээ л хэдийнэ хоёр санчигнаасаа бууралтаж эхэлсэн энэ өндөр янхир хүн бол түүний төрсөн эцэг нь. Хүн хичнээн гомдлоо ч төрсөн аавдаа өширч болдоггүйг тэр ухаарав. Энэ л хүн байгаагүй бол ВД гэж чамин ганган нэртэй, 17-той сайхан залуу амьдарч, хайрлаж явах уу даа гэвэл үгүй. Хэдэн жилийн өмнө Солонгост ээжийг нь хаяад явсныг анх сонсонгуут том болоод аавтай тааралдах л юм бол нам цохино доо гэж зандаг байсан нь ч яалаа. Аав нь гэмшсэн ч юм шиг харцаар хүүгээ ширтэн хацрыг нь үнэрлэх тэрхэн мөчид багынх нь дурсамжууд гэнэт сэргэж, аавдаа наалдан хэвтээд “Дээвэр дээр суудаг Карлсон”, “Бөгтөртэй морьхон” гэх мэтийн ном уншуулж, хааяа “Нохойтой дөрвөн танкчин” гэдэг киног дууриан байлдаж тоглодог байсан нь

санагдан танил дотно үнэрийг нь аваад уярсандаа нулимс цийлэгнүүлэх дөхөв. Нэлээд тайвширсан хойноо аавыгаа битүүхэн ажиглавал түүнийг дөнгөж цэцэрлэгт байхад анх Солонгос явахдаа тас хар байсан ширүүн долгиолог үс нь шанхаараа цайж , нүд нь цагираглаад нэлээд өтлөх янз оржээ.

Түрүүхэн аавыг нь Даагий хэмээн дуудаад байсан хүүхэн тэр хоёрыг дуугүйхэн ажиглан зогсоно. Бодвол шинэ эхнэр нь бололтой. Аав нь тэр хүүхнийг түүнтэй арай ч танилцуулж түвдсэнгүй болтой. Харваас тэр нь гуч хүрээ ч үгүй залуухан бүсгүй байлаа. Бүхэл бүтэн арван жил учраагүй аав, хүү хоёр тийнхүү замын гуанзанд хориодхон минут уулзаад салав.

Яг салах мөчид аав нь “Миний хүүд мөнгө хэрэгтэй юу?” хэмээн асуухад Бидигийн гэжүүн зан нь хөдөлж, “Үгүй. Надад мөнгө байгаа.” гэхчлээ. Уг нь “Ээж намайг мөнгөөр дугаадаггүй юм” гэх гэснээ болив. Эцэг хүү хоёрын энэ санаандгүй уулзалтыг мөнгөний тухай яриа гутаачих ч юм шиг санагдаад явчихжээ.

-За баяртай! Миний хүү.

-Баяртай!

Тэгээд аав нь хамт яваа хүүхнээ сугадахын өмнө эргэж нэг харснаа “Ямар нэгэн юм болбол аавдаа хэлж байгаарай, миний хүү!” гэв.

”Ямар нэгэн юм” гарвал гэнэ шүү. Гэвч өөр тэгээд юу гэх байсан ч юм дээ, мэдэхгүй. Хүний эцэг л юм чинь хүүдээ чадах юмаараа нэмэр болчих санаатай л явдаг байх даа.

Гэвч тэр хоёр дэндүү олон жил уулзаагүйгээс үнэхээр хөндий хүйтэн хүний хүмүүс шиг болцгоосноо хэн хэн нь ухаарчээ.

Замын хүмүүс холхилдсон тохь муутай, дуу шуугиантай гуанзанд аавтайгаа гэнэт уулзсан нь хүүгийн сэтгэл дэх нэгэн хуучин шархыг сэдрээчихэв бололтой. Дархан хүртэлх замд цээж хөндүүрлэн дотор нь бачуурсаар явжээ. Аавтайгаа уулзсан энэ санаандгүй учралаас улбаалан энэ өдөр түүний хувьд дэндүү хүнд өдөр болж өнгөрчээ. Аав нь аль хэдийн Солонгосоос хэл чимээгүйхэн ирж Дарханд шинэ авгайтайгаа амьдарч байсныг зөвтгөх ганц ч шалтгаан байхгүй шиг атал энэ тухай шууд өвөөдөө хэлмээргүй, дотроо өмөөрөх ч биш, хаацайлах ч биш эцгийнхээ өмнөөс нэг муу нэрэлхэх ч гэмээр сэтгэгдэл төрөөд хэлэлгүй дуугүй өнгөрөв.

Бямбаа Дархан явж ирээд цонхоороо харан зогсч байснаа Од хүүхдүүдтэйгээ гадаа явааг үзэнгүүт хөөрхий муу зүрх нь цээжээ нижигнэтэл бөмбөрдөж гарах нь тэр. Зөрүүд муу зүрх нь тэр хүүхнийг гарган хаячихаж чадахгүй л байгаа бололтой. Зуны намуухан орой байлаа. Гэтэл нөгөө албаны дугаартай “Sonata” ирж зогсов. Дөч гарч яваа болтой нөгөө л бүдүүн эр машинаасаа гарч ирэн Од руу очиж хойноос нь дуудав. Хүүхэн хүүгээ хөтлөн явж байснаа эргэж хараад зогтусав.

“Муу гахай “ гэж Бямбаа амандаа хараагаад тэр хоёрын яриаг сонсох санаатай цонхоо нээв. Од:

-Би танд хэлдгээ хэлсэн ш дээ. Нөгөө бүдүүн эр бүсгүй рүү ойртон:

-Чи энийг юунд манай ажил руу явуулчаа вэ? Хүний сэтгэлээсээ л өгсөн юмыг? гэхэд гарт нь нэг жижигхэн төмөр юм үзэгдсэн ч юу гэдэг нь сайн харагдахгүй байлаа.

-Наадхи чинь надад хэрэггүй ээ. Та намайг юу гэж бодсын? гэхэд бүдүүн эр хүүхний дэргэд очин мөрөөр нь тэврэх гэтэл цаадхи нь гарыг нь мөрнөөсөө авч хаяад:

-Боль л доо. Байрныхан хараад байна...

-Чи тэнэг л байна даа... машин өгье гэхэд гүйгээд ирж хүүхнүүд гудамжаар нэг байдаг юм даа... Хэдий аяархан боловч заналтай хоолойгоор хэлсэн тэр үгийг Бямбаа сайн сонсчээ. Аан, Од өгсөн машиных нь түлхүүрий нь буцаачихсан байх нь.

-Та яв л даа. Надад таны машин хэрэггүй, за юу! Алив миний хүү гэртээ орьё гээд бүсгүй хүүгээ тэвэрч, охиноо хөтлөн орц руугаа гүйчихэв. Нөгөө бүдүүн хойноос нь гар зангасаар хоцордог байгаа.

Бидигийн сэтгэл сая л нэг онгойв. Одын тухай муу муухай бодол нь хийсэн арилж, бүдүүн эрийг машин руугаа ууртай алхлахыг харан хөх инээд нь хүрнэ. Ийм сайхан хүүхнийг татаж чангаах, машины түлхүүр бэлэглэх эрчүүд зөндөө байдаг нь мэдээж. Гэтэл тэр? Муугаа мэдэхгүй бас хардаад байгаам аа. “Би танд хайртай!” гээд хэлчих ч зүрхгүй нэг муу банди байж. Үгүй тэгээд хайртайгаа хэллээ гээд ч яах юм билээ. Шалдан гуяа ганзагалсан дөнгөж нэгдүгээр курсыг оюутан болох гэж байгаа амьтан. Тэр бүдүүн эрийн өгсөн машины түлхүүрийг буцаагаад шидэж байгаа энэ бардамхан гоо бүсгүйд Бямбаа харин юу өгч чадах билээ? Ерөөсөө л мөнгөтэй больё. Харин яаж? Цонхны дэргэд тийнхүү санаашран зогсоо Бидигийн хажууд өвөө нь ирж:

-Миний хүү нэг царай алдаад байх чинь, яагаав? Ер нь шалгалтнаасаа хойш царай чинь нэг л биш. Хэд хоног хөдөө явж Балсан ахындаа амарвал яасын? гэхэд л сая нэг сэхээ орсон ч өнөөдрийн аавтайгаа тааралдсан гэнэтийн уулзалт, Одын тухай бодол, хэрхэн яаж мөнгөтэй болох вэ? гэсэн шаналал давхцан юу хэлэхээ ч мэдэхгүй гөлрөн зогссоор байлаа.

Балсан гэдэг нь энүүхэн Төв аймгийн Эрдэнэ сумын ойролцоо нутагладаг эмээгийнх нь дүүгийнх. Тэдний хэдэн номхон морийг ээлжлэн унаж Туулыг өгсөн уруудан давхиж, хаяа нь шуулттай сэрүүхэн гэрт хонох ч сайхан л даа. Тэднийд хоноод сэрэхэд зуны өглөө гэрийн шуулттай хаяагаар сэрүүн салхи үлээн, өвсний шүүдэр мөнгөрөн, сүү цагааны зөөлөн аятайхан үнэр хамар цоргихыг мэдрэн толгой ер бусын сэргэг байдаг сан... Одоо тэгээд урьдынх шигээ бодох санах юмгүй тийнхүү айл хэсэн амарч явах цаг ч биш болжээ. Сэтгэлд нь ирээдүйн тухай түмэн бодол эргэлдэх нь амьдрал хүнд буулгаа хэдийнээ хүзүүнд нь хүссэн хүсээгүй углаад авч байгаагийнх биз ээ.

Найзууд нь оюутан болохын өмнөх сүүлчийн зуны амралтаа зусланд өнгөрүүлнэ хэмээн “Найрамдал”-д амрахаар ярилцаж байхад тэр аавынхаа цэрэг байсан нэгэн эрийн алтны уурхайд туслах ажилчнаар яваад өгөв.

Хүүгээ ажилд явах гэж байгааг өвөөгөөс нь сонссон ээж нь утсаар ярихдаа:

-Яах нь вэ, миний хүү. Сайхан амраад авахгүй. Ээж нь мөнгө явуулъя л даа гэхэд:

-Зүгээр ээ. Алийн болгон танаар тэжээлгэх юм бэ. Надад өөрийн гэсэн мөнгө хэрэгтэй байна гэжээ.

Хэнтийн хөглөрсөн их хөвчид өнгөрүүлсэн зуны хоёр сард хүү гэрээ нэг их санасан ч үгүй. Харин тайгын хөх манан дунд гагцхүү Одын хонгорхон царай, нөгөө бүдүүн эрд “Та яв л даа!” гэж байсан тэр дотнохон дүр төрх л сэтгэлд нь урган ирдэг байлаа. Тэгээд бүсгүйг санахаараа аль хаврын нэг өглөө түүнийг орцных нь харуулдан гадна сууж байж гар утсаараа авсан бүдэгхэн зургийг нь л харж сэтгэлээ тайтгаруулна. Тэр бүсгүйг сэтгэлээсээ яагаад ч зайлуулж чадахгүй гэдгээ хүнд хүчир ажил хийж амьдралыг таних анхны аянд гарсан энэ л зун тэр ясандаа тултал ухаарчээ. Бас нэг олзуурхууштай нь Бямбаа тэнд машин сайн барьж сурав. Мань эр балар их тайгын дундхи энхэл донхол замаар хуучин орос “аавын цээжээр” сэгсчүүлэн давхисаар хоёрхон сарын дотор хуучны хашир жолоочоос дутахгүй догь жолооч болж, хий гэснийг нь гололгүй хийсээр гайгүй хэдэн төгрөгтэй гэртээ буцаж иржээ.

Наймдугаар сарын дундуур тэр хотод буцан ирж билээ. Манан будан хөшиглөсөн нэвсгэр их тайгад байсаар ирэхэд төрж өссөн гудамжных нь хуучин байшингууд, навчис нь алаг цоог шарлаж эхэлсэн хөгшин улиаснууд яг л нүүрээ угаасан гоо бүсгүй шиг л цэмцгэр ганган, өнгөлөг болчихсон юм шиг санагдаж байлаа..

Түүнийг эзгүйд өвөөд нь Заяа хань болж байжээ.

Зээ хүүгээ ирэх сургаар өвөө нь Заяагаар банштай цай, нийслэл салат хийлгэсэн байв.

-Хүүеэ, манай Бямбаа чинь бүүр булиа лаг залуу болчихсон байна ш дээ гэсээр үеэл эгч нь үүдэн дээр гарч ирэв.

-Муу түнжгэр хүү минь бүүр турчаа юу даа? Үгүй юу. Эр хүн, амьдрал үзэлгүй яахав. Түнжийгээд...гэсээр өвөө нь духыг нь үнэрлэв.

Усанд орж, хоолоо идсэний дараа өрөөндөө орж Одын цонх руу харвал хөшиг нь таг хаалттай байлаа. Хороон дээрээс гар утасных нь дугаарыг олж авсны хэрэг юу билээ. Залгаж үзлээ. Дуудаж байнаа...Мэдээж танихгүй, нэг муу картны дугаарыг авсангүй ч санаа нь амрав.

Тэгтэл өрөөнийх нь хаалгыг ёс болгон тогшсон болоод Заяа ороод ирэв.

-За миний дүү, мөнгө ихтэй болов уу?

-Яахав дээ. Сургалтын төлбөрт хүрэхээр юм. Шалихгүй ээ.

-Отгоо эгч над руу хэд хэд ярьсан. Чамайг л асуугаад байна лээ. Цаадхи чинь заавал мөнгөтэй болох гээд байгааг бодоход найз охинтой болсон юм байх даа? Чамд сонссон юм байна уу? энэ тэр гээд чиний тухай баахан юм асууж байна лээ.

-Ээж балай юм асуугаад л.Та юу гэв?

Тэр мөрөө хавчин хоёр гараа дэлгэснээ:

-Би юу гэхэв дээ. Мэдэхгүй ээ л гэхгүй юу. Гэхдээ чи чинь хавраас хойш хувцасныхаа стилийг өөрчлөөд л манай сургуулиар эргэлдээд л. Эмэгтэй хүнд ямар бэлэг өгөх вэ? ч гэх шиг юм асуугаад л сонин сонин болоод байгаа хүн шүү дээ гэснээ нүүр рүү нь сүрхий ширтэв.

-За сүртэй ш дээ.

-Хэрэв Ууганаа байсан бол өөр хэрэг л дээ.Тэр чинь цэцэрлэгээсээ авахуулаад л алхам тутамдаа дурлал хайр зарлаж явсан амьтан. Харин чи бол тийм хүн биш. За, чи эгчдээ үнэнээ хэлчих л дээ. Би чамайг зүгээр нэвт шувт харж байна гэж худлаа яриад яахав. Гэхдээ л чи нэг л биш байна даа.

-...

-Отгоо эгч сургалтын төлбөрийг чинь чамаар төлүүлэх ч үгүй. Чи ч гэсэн урьд нь ээжийнхээ явуулсан мөнгийг яаж үрэх вэ л гэсэн шиг явдаг байснаа одоо гэнэт ажил мажил хийгээд ч байх шиг. Наад харц чинь бүүр гунигийн мананд уначихсан.

-За тэр яахав ээ.Та зүгээр шал хачин юм ярьж байхым аа. Би харин Хэнтий явахынхаа өмнө хэнтэй тааралдсан гэж бодож байна? Өвөөд ч хэлээгүй байгаа. Аав аль хэдийн ирчихсэн Дарханд байгаан байна лээ.

-Юу вэ? Намайг бариад аваарай. Ухаан алдах нь ээ.Тэгээд их дэлгүүрт явж байсан тэр хүн чинь Дансран ах мөн байсан гэж үү?

-Мөөн. Мөн.

-Тэгээд юу гэж байна?

-Юу гэхэв дээ. Улаан халз тааралдсан юм чинь. Дархан явах замд байдаг “Урьхан” кафед.

-Арай нэг хүүхэнтэй хамт явж байсан л гэж битгий хэлээрэй.

-Явж л байна лээ.

-Тэгээд юу гэж байна? Хөөрхий муу Отгоо эгч минь...

-Юу гэхэв дээ. Эхлээд жоохон бантсанаа намайг үнсээд.

-Зө зө...Алчих юм аа. Манай аав ээж хоёр ямар азаар Солонгос яваагүй юм бэ?Ээжийг явах гэхээр аав уурлаж “Намайг үхэхээр миний хүүрэн дээгүүр хөндлөн гишгээд тэр Солонгос руугаа яваарай” гээд байдаг байсын. Заяа санаа алдав. Бямбаа ч санаа алдлаа.

Ашгүй, үеэл эгч нь түүний дурлал хайрын тухай шалгаахаа болив бололтой.

-Аавтай уулзсанаа өвөөд хэлээгүй байгаа шүү.

-Хэлээд дэмий, дэмий. Бас даралт нь ихэсчихнэ. Хүүеэ, танай байрны Од хатагтай зусланд гарчихсын байх даа?

-Мэдэхгүй ээ. Тийм байлгүй. Би жорлон орчоод ирье.

Түүний нэрийг Заяагийн амнаас сонсонгуут нүүр нь мэлсхийгээд явчихсан тул ийнхүү жорлон явах шалтгаар угаалгын өрөөнд орон түгжчихэв.

Хүйтэн ус гоожуулан цээжээ хэд шавшаад бие засчаад өрөөндөө орвол Заяа уйдсан бололтой мессенжерт орчихсон чааталж инээд алдан сууж байв.

-Тэр Одын хойноос эрчүүд их гүйчих юм аа. Юунд нь болдог байнаа. Өчнөөн гоё залуу охид зөндөө байхад чинь хоёр хүүхэдтэй хөгшин хүүхнийг хаданд гаргаад л. Тэрийг зусланд гарах гэж байгаа гэсэн чинь манай ангийн хоёр гурван банди гэрийг нь нүүлгэлцэж өгье энэ тэр гээд л гүйцгээж гэнэ. Төрсөн өдрөөр нь нэг явдаг хүн нь машин өгсөн чинь онгон царайлаад буцаагаад өгчихсөн гэсэн. Яаж байгаан тэр одоо?

-Өө за за. Та тэгээд тэр хүүхэнд юундаа дургүйцээд байдаг юм бэ?

-Яахав дээ. Манай ангийн Оргио гэж ганц олигтой банди тэрэнд хайр зарлаад...

-Та өөрөө тэр залуудаа сайн юм биш үү? Заяагийн царай хачин болж:

-Хэн? Би юу? За юу гэж дээ. Тэнэг юм гэчихээд тэр өрөөнөөс нь шурдхийн гарлаа.

-Хаягий чинь хаалаа шүү?

-Тэг ээ тэг.

Биди хотод ирснийхээ нөгөөдөр нь гадаа найзуудтайгаа сууж байтал Одынх зуслангаас нүүж ирэв. Байка, Хатнаа, хажуугийн байрны Зоза гурав ч “Юмыг нь зөөлцөх үү” хэмээн ухасхийн босоцгоохыг бодоход тэр аятайхан хүүхнийг бүгд шохоорхон харж явдаг нь илт.

Од бариу цэнхэр жийнс, хар футболк өмсч үсэндээ хар тасам зүүсэн нь хараад л баймаар. Ямар ч загвар өмсөгчөөс илүү гоёмсог, дэгжин харагдана. Хөдөөний бололтой нэг охин, аав нь гээд буурал хүн, бас нэг хамаатны дүү нь гэх бандитай хамт мань дөрөв юмыг нь гуравдугаар давхар руу зөөлцлөө.

Ганцаараа орохоос нүүрэнд нь гал авалцаад байдаг айлынхаа босгыг Бямбаа тийнхүү найзуудтайгаа анх алхаж үзэв.

Цэнхэр хөшиг, цэнхэр тавилгатай жижигхэн гал тогооны өрөө. Дундуураа арктай цав цагаан тавилгатай ганцхан өрөө байртай айл ажээ. Аркны цаана өргөн цагаан ор, тавиур дүүрэн

зөөлөн тоглоом байх нь унтлагын хэсэг, шүрэн хөшгөөр тусгаарласан зочдын өрөөнд цагаан буйдан, нөгөө ханаар нь дүүрэн номтой тавиур, цонхон дээрээ ногоон ваартай хэдэн хатсан сараана цэцэг...Цомхон бөгөөд цэмцгэр айл юм. Од саяын зөөж оруулан шалаар ундуй сундуй хөглөрөх юмсаа цэгцлэх зуур:

-Миний дүү нар хүйтэн юм уух уу. Манай байрных хүүхдүүд тусархаг байгаа биз аав аа? гэнгээ хөргөгчнөөсөө хүйтэн аньсны шүүс гарган аягалж өгөхөд нь Бямбаа царай руу нь сэм сэм хэд хараад авлаа. Үнэндээ бүтэн жилийн турш сэтгэл зүрх алдран явсан энэ бүсгүйг тэр анх удаа л ганцхан алхмын ойрхноос харж байгаа нь тэр билээ.

-Биди ахтайгаа гадаа тоглоноо хэмээн царай нь наранд борлон хүв хүрэн болж, нэлээд өссөн хүү нь дагав.

-Миний хүү одоо усанд орно.Хэн...ахтайгаа дараа нь гадаа гар, за юу хэмээн хүүхэн нэрийг нь хэлэхдээ ялимгүй түгдэрснээ:

-Анар, Ану хоёр дандаа Бийдий гэнэ үү нэг сонин нэр хэлээд байдгийн. Тэгсэн чинь чамайг хэлдэг юм аа даа? гээд өөдөөс нь харахад түүнтэй харц тулгарахаас ичин дальдчих Биди:

-Уг нь намайг Бямбаа гэдгийм аа гээд :

-За гарах уу? хэмээн найзууддаа хэлээд түрүүлэн гарлаа.

-Баярлалаа хүүхдүүд ээ гэх ялдамхан дуу хойноос нь уянгалж, хаалга нь тасхийлээ.

-Манай Биди сэргэлээн. Хүүтэй нь танилцчихсан байгаан. Энэ ёстой лаг гоё хүүхэн шүү, тийм үү? Бид хэдийг бас миний дүү нар гэгчхжээ. Ийм насны, нөхөргүй хүүхнүүд чинь бид нар шиг банди нарыг нялх ногоо гээд дуртай байдаг байхгүй юу. Бөгс нь ёстой базаад авмаар янзтай байгаа биз... хэмээн Зоза орцноос нь гарч амжилгүй л чалчиж гарав. Зоза ч гэж жинхэнэ нэр нь Золзаяа юм. Одыг доромжилсон аястай сүүлчийн үгэнд уур нь дүрсхийсэн BD хөл дээр нь гишгэснийг далимдуулан Золагийн хажуугаар гарахдаа харти руу нь өшиглөөд авав.

-Яаж байнаа п... чинь?

Гадаа гараад юу юугүй гар зөрүүлээд авсан тэр хоёрыг Хатнаа, Байка хоёр шууд салгаж дийлсэнгүй.

Хаваржин бялдаржуулах клубт явж, зунжин хар ажил хийсэн BD-ийн булчин гэж төмөр шиг л болжээ. Золаг дэмийртэл нь хоёр сайн цохиж аваад санаа амрав. Гэхдээ Золаг шанаадуулсан толгой нь дүйнгэтэн хамраас нь цус садрахад, Золаг нэг талаас нь барьсан Хатнаа Байкад:

-Чи наадхаа гэрт нь оруулчих. Би энүүнийг хүргэчихээд ирье гэж байсныг л бүүр түүрхэн санаж байв.

Баруун нүд нь булуу болтол хавджээ.

-Хоёулаа эхлээд манайд орж наад нүдэнд чинь жин тавья.Чи ч Золаг ганган цохисон шүү. Би ч заримдаа тэрийг шаагаад авмаар болж л байдгийн... Санаа зовох хэрэггүй. Манайхан эзгүй байгаа хэмээн Байка ярина.

Ашгүй тэдний аав, ээж нь хөдөө яваад ирээгүй. Дүү нар нь өвөөгийн дөө байгаа гэнэ. Үүднийх нь толинд нүүрээ зэрвэсхэн хараад тэр өөрийгөө таньсангүй. Баруун нүд нь мантайтлаа хавдан хамартайгаа тэгширчээ.

-Чи чинь юундаа тэгж уурласан бэ? Одоо тавхан хоногийн дараа хичээл эхлэх гэж байхад наад нүдээ хар. Май, энэ мөс сайн тавь гэнгээ Байка хөргөгчнөөсөө бөөн мөс гаргаж ирэв.

-Өвөөг унтсан хойно орохгүй бол...Яаая, мангар лугшиж байна хэмээн Бямбаа асуултыг нь булзааруулна.

-Чи тэр хүүхэнд арай сайн юм биш биз дээ?

-...

-Тэгээд л Золаг уурласан юм биш үү?

-Яаж байна?

-Чи сүүлийн үед нэг л өөр болоод байгаам биш үү?

-Яаж байна?

-Яаж байна, яаж байна ч гэх шиг. Харваас илт байхад. Би Хатнаа шиг үргэлж чамтай хамт байдаггүй ч гэсэн мэдэгдээд байна ш дээ. Хичээлээ тараад ганцаараа алга болчихно. Зуны амралтаараа ажил хийнэ гээд явчихсан....

-Эмэгтэй нь олон насаар эгч хосууд яадаг бол?

-Мэдэхгүй ээ. Уг нь эмэгтэй нь эрээсээ дүү л байх ёстойм биш үү?

-Яадгийн эмэгтэй нь эгч байхад.

-Мэдэхгүйм аа. Гэхдээ тэр ч үнэндээ гоё хүүхэн шүү...

-Хатнаад битгий хэлээрэй.

-Аанхаан...мэдээж.

Хэд хоногийн дараа дээд сургуулийнхаа хичээлийг эхлэхэд Биди бага зэрэг хөхөрсөн нүдтэй зогсож байлаа.

Тийнхүү BD оюутан боллоо. Хичээл эхэлсний эхний өдрүүдэд тэр нэг хэсэгтээ л Одтой

тааралдсангүй. Бямбаа түүнийг ноднингийнх шигээ өглөө эрт гадаа хүлээж зогсохоо больсон ч цонхоороо харуулддаг хэвээрээ. Гадаа хүүхдүүд нь тоглож байвал зайрмаг авч өгөн, хүүг нь гулсуураар гулгуулна.

Харин бүсгүйн бараа харагдвал яахаа мэдэхээ больж мэндэлсэн болоод л таг болно. Модод шаргал навчсаар уйлсан уйтай намар ирдгээрээ л иржээ.

Оюутан цагийн анхны намар...Анги нь эрэгтэй цөөхөнтэй, ердөө л тавуулаа.Тэгээд л анги дүүрэн шаагилдсан охид. Охид хичээл эхэлсэн анхны өдрөөс л түүнд илт сээтэгнэж эхэлсэн ч Одтой харьцуулбал бие галбир нь гүйцэд хөгжөөгүй, харц нь гэнэн тэнэг хэвээр атал, нүд амаа халтар хултар будаж, тамхи зуун аалиггүйтэх үеийнх нь бүсгүйчүүд сэтгэлийг нь огтхон ч татахгүй харин ч түлхэх аж.

Шинэ жил, дараа нь цагаан сар болдгоороо л боллоо. Гэгээн валентиний өдрийн урьд орой. Тав дахь өдөр байсныг хэлэх үү, ангийнхантайгаа шоудаж тасарсан Биди зүрх зориг гэж арслан болчихсон амьтан Одын хаалган дээр очиж хонхыг нь зоригтой нь аргагүй чарлууллаа.

-Хэн бэ? гэх түүний зөөлөн хонгор дуунаар уусан архи нь гарч, нөгөө арслангийн зүрх нь ч шалчийн шатаар доошоо пижигнэтэл гүйлээ. Тэгээд Байкаг гэрээс нь дуудаж гаргаад “Би Одод хайртай. Намайг харваас нусгай бацаан гэж бодоод байгаа тэр хүүхнийг би яахын бэ?” гэж ирээд л асгартал уйлсан гэж байгаа. Маргааш нь шартаж, дотор нь муухай оргин толгой нь ангалзахын хажуугаар, голоо эргэтэл бөөлжиж, өвөөдөө тархиа гашилтал загнуулав.

“Hi. Dotor gaigui yu? Yesterday chi mun ih uusan bn lee shuu. Tuslaltsaa heregtei bol bi belen” гэсэн мессеж Байкагаас иржээ.

-Багаахан галзуураарай.Түнжийсэн хог минь. Хүний газар муу эх нь нуруугаа тахийтал ажил хийж явахад арван найм ч хүрээгүй байж архидна гэнээ чи. Муу эмээ нь энэний согтуу байхыг хараагүй нь яамай. Май энийг гудар чи! хэмээн өвөө нь зандчингаа бантан авчирч ширээн дээр тавиад цаашаа явахдаа “Бяруу болоогүй байж бухын баадлаар баасан муу хог...” хэмээн үглэсээр байлаа.

Царай нь хөрзийсөн Бямбаа “За өвөөгийн хажууд л хайр майр гэж дөвчигнөөгүй нь яамай” хэмээн ханцуйдаа залбиран өнөө бантанг нь идэх гэж хэд халбагадсан ч олигтойхон хороож чадсангүй. Үе үе дуу алдтал толгой нь ангалзан өрөөн доторхи юмнууд дайвалзах шиг болж, хүйтэн хөлс чийхарна.Цагаан архи, бас охидын ууж байсан дарс, монгол, гадаад пиво холин уусаар арай л хэтрүүлчихжээ.

-Эрийн хугархай ухаантай юм бол наад бантангаа дуустал нь ид чи. Шарталт даахгүйгээ мэдэхгүй яах гэж уусын чи! хэмээн өвөө нь гал тогооны өрөөнд сав суулга хангинуулангаа үглэх нь дуулдана. “ Эрийн хугархай...” Нээрээ л эр хүн болох гэж байгаа бол аяга бантан идчихэж чадахгүй...Дунд гарын шаазан дүүрэн бантан нэг л мэдэхэд дуусч хөлс чийхран дотор нь онгойгоод ирмэгц өнөөдөр гэгээн хайрын өдөр гэдгийг санаж сандрав.

Босч усанд ороод хувцаслан цэцгийн дэлгүүр рүү гүйлээ. Таван ширхэг цагаан лили авч таксидан буцаж ирлээ. Тэгээд байрныхаа хажуугийн гудамжинд бууснаа урьд нь өглөө эртээ

гэгч нь Одын хаалганд цэцгээ зүүчихдэг байсан бол одоо үд хэвийчихсэн хойно айлын хаалганд цэцэг уяад зогсч байлтай нь биш дээ. Гадаа гүйж явсан жаалхүүг дуудан таван зуун төгрөг өгөн “Энэ цэцгийг хажуугийн байрны 34 дугаартай хаалганы эгчид өгчихөөд ир. Буцаад ирэхэд нь мянган төгрөг өгье” гээд гүйлгэчихэв.

Орой нь цонхоороо харвал Од ашгүй цэцгий нь ногоон ваарандаа хийн тавцан дээрээ тавьсан байлаа.

Мартъя гээд мартагддаггүй, халдъя халдаж үл болох эгчмэд бүсгүй...

Цонхон дээрээ тэр удтал зогсов. Аз жаргалтай хосууд баяраа тэмдэглэн, амттайхнаар үнсэлцэн, зүрхэн шоколад солилцох энэ үдэш тэр л ганцаараа хөшиг нь хаалттай цонх ширтэн зогсох гэж дээ.

Ер нь түүнд хайраа илчилбэл яасын бэ?

“Миний дүү нусаа арч даа” гээд алгадаад авах болов уу? Эсвэл өнгөрсөн хавар нөгөө бүдүүн амьтанд хэлсэн шигээ ”Яваач ” гэх юм уу, бүү мэд дээ.

Сонгинон цэцгийн шороон дээгүүр нөгөө цоохор цох явж л байх аж. Гайхмаар юм. Бүтэн хоёр жил өнгөрч байхад энэ цох л үхэхгүй энэ цэцгийн шороонд амьдарсаар байх гэж үү? Хорхой шавьж хүртэл өөрийн гэсэн амьдралын зорилготой төрдөг болов уу ч гэх шиг тэнэг бодол орж ирэх аж.

Зун ажил хийж олсон сая гаруй төгрөгөөрөө аавынхаа зөвлөснөөр нэгэн сүүний үйлдвэрийн хувьцаа авчихсан нь хоёр сарын дотор хятад сүү меламинай гэсэн шуугианы ачаар гурав дахин илүү үнэ хүрч мөнгөө хэд нугалаад авчихав.

Эр хүн болно гэдэг өөрийн гэсэн мөнгөтэй байхаас л эхэлдэг бололтой. Урам орж махны үйлдвэрийн хувьцаа авчихлаа. Тэр нь хавартаа бас л овоо өсчихсөн байв.

Тавдугаар сар хаяанд ирлээ. Маргааш Одын төрсөн өдөр.

Нөгөө л хэдэн лилигээ хаалганаас нь уях хэрэг үү? Эр хүн юм бол дүүрсэн хэрэг , түүнд хайраа илчлээд л үздэг хэрэг. Байкатай нэг зөвлөх гэснээ болив.” Уг нь эмэгтэй нь эрээсээ дүү л байх ёстойм биш үү?” гэж байсан нь санаанд орж тийнхүү цаагалжээ.

Хичээлээ тараад ганцаараа нэг ресторанд орж зоригоо чангалах санаатай зуун грамм виски татаад сагстай цагаан лили авч орой долоо өнгөрч байхад бүсгүйн хонхыг дарлаа.

-Хэн бэ? гэх нөгөө л хонгорхон дуугаар нь Одыг таньж толгойтой үс нь бүгд өндийн босох шиг л болж шат руу уруудан зугтах гэснээ болив.

-Би...

-Би гэж хэн юм?

-Биди..Бямбаа байнаа...

-Хэн гэнээ?

Хаалганы цоож торхийн нээгдэхэд тэр богинохон ягаан халаадтай зогсч байв.

-Сай...сайн байна уу?

-Сайн...Яасан? Чи манай Солонгоотой уулзах гэж байгаам уу?

-Үгүй..тантай

-Юу гэнээ! Эгчтэйгээ тоглох гээд байна уу чи, битгий маяглаад байгаарай миний дүү гээд хаалгаа хаах гэхэд нь Биди хөлөө хавчуулчихав. Дүүрсэн хэрэг.

-Намайг оруулчих л даа.

Цаанаас нь хүү, охин хоёр нь гүйлдэн ирэв.

-Биди ахаа!

-Манайд орооч гэцгээхийг далимдуулан мань эр хэдийнээ гэрт нь орчихсон зогсч байлаа.

-Солонгоо эгч ээ, манайд Биди ах ирсэн гэж бяцхан хүү нь шулганахад цаанаас нь хөдөөний байрын улаан хацартай охин гарч ирэв.

-Энийг танд гээд Биди сагстай цэцгээ хүүхэнд өгөв.

-Юу болоод байнаа, энэ чинь? Алив, та нар цаашаа орцгоо.Солонгоо, наад хоёрыгоо аваад том өрөөнд орж бай даа. Чи алив ийшээ ороод ир гээд бүсгүй түүнийг гал тогооны өрөөндөө оруулав.

-Яалаа яалаа гэнээ.Чи чинь манай захын орцны хүүхэд мөн биз дээ? Манай хоёр Биди ах гээд л сүйд болоод байдаг. Юу болоод эгч рүүгээ цэцэг барьж гүйгээд байгаан?

-Би танд... хайртай!

-Миний дүү,чи хэдэн настай юм? Арван зургаа юу, долоо юу?

-Арван найм...

-Би тэгвэл гуч хүрч байна.За юу.Чамд үеийн чинь охид олдохгүй байна гэж үү? Би чамайг манай Солонгоотой уулзах гэж байгаан байх гэж бодлоо ш дээ.

-Дөч хүрэх гэж байсан ч яадгийн. Нас, нас энд ямар хамаатай юм бэ? Нас бол зүгээр л тоо. Би танд хайртай.Танай энэ улаан хацартай охиноор чинь би яадгийн. Би чинь эр хүн.

Муу ч гэсэн эр хүн. Таныг хоёр хүүхэдтэй чинь хайрлаад явж чадна, за юу. Нөхрөөсөө өчнөөн эгч хүмүүс зөндөө л байдаг биз дээ? Би таныг хоёр жилийн өмнө анх хараад л хайртай болсон. Би танд хайртай. Өөрөөсөө эгч хүнд хайртай болно гэдэг чинь гэмт хэрэг юм уу?

Уусан ганц хундага хатуу виски нь түүнд ийнхүү нэг амьсгаагаар сэтгэл доторхио бага ч гэсэн онгойлгох зориг хайрлажээ.

-Чи чинь халамцуу юм уу даа?

Тэр дуугарсангүй.

-Та энэ цэцгийг авчих л даа гэж л хэлэв.

-Ямар хэцүү хүүхэд вэ, чи. Алив энэ халуун цай уу. Би цэцгий чинь авахаас даа. Даанч манай хаалганд миний төрсөн өдрөөр ийм цагаан лили зүүчихсэн байдаг юм. Эзэн нь чи байсан юм бий.

Ягаан халаадтайгаа ижил өнгийн тасам толгойдоо зүүж будаг шунхаа арилгасан Одын царай өглөөний нарны туяа мэт тунгалаг, өөрийнх нь үеийн охидоос дутахгүй залуухан, хараад л баймаар цаанаасаа гэрэлтэнэ. Од Бидигийн нүүр рүү эгцлэн учирлах мэт ширтсэнээ санаа алдан:

-Чи аан гэж бай л даа. Юм бүхэн цаг үедээ л сайхан. Аанхан, наад халуун цайгаа ууж тайвшир. Миний дүү...

-Намайг битгий дүү гээд доош нь хийгээд бай л даа.

-За за. Биди бил үү? Биди...юм бүхэн цаг үедээ л сайхан. Одоо тавдугаар сар гарчихлаа. Би чинь дээр үеийнхээр майн баяраар төрсөн байхгүй юу. Наян онд. Чи тэгэхэд хэдэн онд төрсөн байна? Ерэн хоёр онд. Чи бид хоёрын хооронд хичнээн жилийн зөрүү байна? Удахгүй зургаан сар гарна. Зургаан сард цас ордог уу? Чи хэл дээ. Ордоггүй л биз дээ? Тэрэн шиг гучтай, арван наймтай хоёр хүн, тэгээд эмэгтэй нь 12 насаар эгч бол хосууд байж болохгүй, за юу. Хэзээ ч бүтэхгүй. Юм бүхэн цаг хугацаатай.

Намайг 2 настай байхад зургаан сард битүү цас орсон юм гэсэн. Аав маань ярьдаг юм. Хүмүүс зусланд гарчихсан. Зуны онгорхой сандаалтай, нимгэн цамцтай ажилдаа гарсан чинь орой нь цас битүү дарчихсан байсан гэсэн. Тэгээд маргааш нь зарим айлын эрх хүүхдүүд аав ээждээ чарга, бээлий энэ тэр захиж хотын байшингаасаа авчруултал нөгөө их цас нь хайлчихсан юм гэнэ лээ. Байгалийн жамыг хэн ч сөрж чадахгүй. Би чамаас түрүүлж хөгширнө.

Тэр ширээний араас босч санаа алдсанаа:

-Чи өөрийнхөө үеийн сайхан охинтой учирна. Харин намайг одоо март, за юу гээд толгойг нь илэв.

-Таныг март гэхээр л би мартчих юм гэж үү? Чадахгүй ээ, чадахгүй.

-Чи эхлээд эр хүн болчих.

-Би эр хүн биш юм уу?

-Чи эр хүн болоогүй л байна даа. Ядаж цэрэгт явчих. Сахлаа ургуулчих...

-Тэгж март гэхийн зоргоор хүнийг мартаж болдоггүй юм за юу!

Биди нэг л мэдэхэд тэднийхээс гарч явлаа.”Эхлээд цэрэгт явчих, сахлаа ургуулчих гэнэ үү?”

Тэр намайг цэрэгт явж чадахгүй нусгай бацаан гэж бодсон юм байх даа?

Энэ ярианаас хойш яг арван зургаа хоногийн дараа, дөнгөж арван найман нас нэг хоногтой BD саналаараа цэрэгт явсан юм. Эхлээд цэрэгт явчих, сахлаа ургуулчих гэсэн Одын үг хор шарыг нь үнэхээр хөдөлгөжээ.

Явахынхаа өмнө тэр Дархан орж, аавдаа цэрэгт явах болсноо дуулгав.

-Зөв, миний хүү. Эр хүн болж байгаа нь энэ дээ. Цэрэгт явж эр хүн болдог юм гэж аав нь та хоёрт хэлдэггүй юу. Албаа сайн хаагаад ирээрэй. Харин ээж чинь мэдсэн үү? гэж аав нь асууснаа зүүн хацар дээр нь үнсэж, цэргээс ирэхээр нь үнсэнэ хэмээн баруун хацрыг нь үлдээв.

-Ээжид хэлээгүй байгаа. Явчихсан хойно л мэднэ биз.Та намайг гаргаж өгөөд хэрэггүй шүү. Тэгээд л би ирж байгаан. Би хилийн цэрэгт явна гээд саналаа өгчихсөн. Намайг явсан хойно өвөөтэй уулзаарай. Би таныг энд байгаа гэж хэлээгүй. Та саяхан ирсэн гээдл уулзчихна биз гэж аавдаа хэлэв.

Тэгээд Одыг харж хандаж, тусалж байхыг хамгийн итгэлт анд Байкадаа захиад, хамгийн гол нь валентиний өдөр, мартын 8, төрсөн өдрөөр нь цагаан лили авч миний өмнөөс өгч байгаарай хэмээн хичээнгүйлэн гуйв.

Нэгэнт анхны хайр нь бүтэлгүй, дээрээс нь мэргэжилдээ сонирхолгүй тул дээд сургуульд сурсан болж суудал бөглөн, өдөр хоногийг хий дэмий өнгөрөөж байснаас цэрэгт явж, хилээ хамгаалж байгаад ирье гэж тэр нэгэнт зориг шулууджээ.

-Хичээл номоо хаяад гэнэт цэрэгт явна гэдэг чинь юу болж байгаа нь энэ вэ? Дураараа дураараа гэхэд энэ түнжийсэн хог чинь дунд чөмгөрөөрөө жиргэх нээ одоо!Тэр хүний газар мөнгө олох гэж махаа идэж байгаа эхэд чинь би юу гэж хэлэх болж байнаа энэ чинь!Одоо очиж салгаж авдаг хэрэг ээ.

-Өнгөрсөөн.Өвөө би эрүүл мэндийн үзлэгт нь тэнцээд Сулинхээрт явахаар болчихсон ш дээ.

-Юу юу гэнээ?Яадаг тархи вэ? Үнэн юм уу тэгээд?

-Та цэрэг татлагын комисст очоод асуухгүй юу.Тэгээд ч одоо цэрэгт яваагүй хүн

төрийн албанд ажиллаж ч болохгүй болсон гэсэн. Хэрэв цэрэгт явахгүй бол дараа нь дүйцүүлэх алба гэж хоёр гурван сая төгрөг тушаах болно. Эртхэн явчихсан нь дээр ш дээ.

-Гүй тэгээд миний хөө!Хичээл номоо яах болж байна?

-Би цэргээс ирээд геологт орноо. Банкинд сонирхолгүй.

-Гүй ер!

Түүнийг цэрэгт үдэхээр өвөө, үеэл Заяа нь, хоёр нагац эгч, хүргэн ах нар, бас аавынх нь дүү, Байка, Хатнаа хоёр тэгээд хэнээс ч мэдсэн юм, ангийнх нь Номин-Эрдэнэ ирчихсэн байлаа.

“Намайг явчихсан хойно л ээжид хэлээрэй” хэмээн тэр өвөөгөөсөө гуйсан байлаа.

-Миний дүү хөөрхөн цэрэг болж хэмээн том нагац нь хацар дээрнь үнсэхдээ хэлсэн ч тэр дорхноо уйлчихав.

Ээж нь байсан бол бас л ингээд уйлах байсан байх даа.

Хүүгээ долоохон настай, цүнхээ даахгүй жаал байхад нь орхин одсон ээж нь хүүгээ эр цэрэг болж, ийнхүү дархан хилийн зүг одоход нь ч эзгүй л байлаа.

Цэрэгт ирээд Бямбаа огт газардсангүй ээ. Машин сайн барьдагтул заставын даргын жолооч хийсээр ганц жил нүд ирмэхийн зуур л өнгөрчээ.Нүд алдам уудам цагаан талд дархан хилийн сүлдэт багананууд алсран, нүдэнд дасал болсон заставынх нь хэдхэн байшин тэртээд торойн хоцроход төрж өссөн газар нь юм шиг сэтгэл хоргодно.Өвөө нь эргэж очих санаатай байсан ч “Ганцхан жилийн алба юм чинь. Та хол газар наашаа яваад хэрэггүй.Би энд дажгүй.Сайхан байна” гэсээр ирүүлсэнгүй. Харин аав нь л нэг эргэж ирсэн билээ..

Цэргийн албаа дархан хил дээр хаагаад ирсэн Бямбаа одоо эр хүн болоогүй гэж үү?

Хил дээр өнгөрүүлсэн бүтэн жилийн турш Одыг тэр бас л мартаж чадсангүй. Тэр хоёрын арван хоёр насны зөрөө юу юм бэ? Хайрлаж дурласан хүүхнийхээ хойноос ёстой л эр хүн шиг гүйсээр байгаад авч суудаггүй юм бол хэний хүү болох бол доо гэсэн бодолтой хотод иржээ.

Төрж өссөн Г хэлбэрийн хуучин байр нь сэтгэлд юутай дотно вэ? Бямбааг байрныхаа гадаа таксинаас буухад эмээгийнх нь найз хэдэн хөгшин гадаа нарлаж сууснаа түүнийг үзээд дуу алдан шавцгаав.

-Батсайхан гуайн зээ хүү цэрэгт яваад ирээ юү?

-Цэргийн алба хаасан хүн одоо санаа амар.

-Аль эмээ нь үнсье!

-Муу эмээ нь амьд сан бол...гэцгээнэ.

Ганцхан жилийн дотор өвөө нь улам хөгширчээ.

-Миний түнжгэр хүү ингээд хүрээд ирдэг... Алив банштай цай хийж өг хэмээн хөл хөөрцөг болно. Түүний эзгүйд Заяа өвөөтэйгээ хамт нэг жил тэднийд амьдарчээ. Бас найз залуутай болсон гэнэ.

Бямбааг ирснийг сонсоод найзуудаас нь хамгийн түрүүн Байка хүрч ирэв.

-Чиний захиснаар Одод чинь баяр болгоноор цэцэг авч өгч байсан шүү. Тэр чинь хүн амьтантай суугаагүй байж л байгаа. Санаа зоволтгүй. Хүү нь чамайг дандаа асуудгийн. Өчигдөр харин эмнэлэгт хэвтсэн гэнэ лээ. Манай Хатнаа герман явчихсан ш дээ.

-Хэн эмнэлэгт хэвтсэн гэж?

-Од л байхгүй юу. Гэхдээ бие нь гайгүй байгаа гэсэн. Би эмнэлгийн хаягийг нь асуучихсан.

BD том сагсанд 21 дарь эхийн тоогоор цагаан лили хийлгэж барьсаар Одын хэвтэж байгаа хувийн эмнэлэгт хүрч очлоо. Мухар олгойн хагалгаанаас дөнгөж өчигдөр гарсан гээд тэр өрөөндөө ганцаараа хэвтэж байлаа. Хажуугийн ор нь харин эзгүй байв.

Бямбаа хайртай түүнийхээ хэвтэж буй өрөөний хаалган дээр ирэнгүүт булгилан цовчих зүрхээ намжаах санаатай хэсэг зогссоноо хаалганы завсраар сэмхэн шагайлаа.

Цасан цагаан даавуун дээр бүсгүйн задгай хонгор хүрэн үс нь задран унжиж, нүүрээ хана руу харуулан хэвтэж байв. Бямбаа хаалгыг зөөлхөн татан орж явчихлаа. Тэгээд сагстай цэцгээ тавих гэснээ больж:

-Од оо! хэмээн нэлээд чанга дуудсанаа амандаа аяархан гэгч нь:

-Хайрт минь...гэхэд тэр гэнэт эргэж харлаа.

-Хэн бэ?

-Би байна. Биди... Бямбаа

-Хүү? Ямар сонин хүн бэ? Сайн уу?

-Сайн. Би цэргээс өнөөдөр ирлээ...

-Мэдсэн... Тэгээд чи сайн явж ирэв үү?

-Сайн явсан.... Бие чинь яаж байна? гэж асуухдаа Бямбаагийн хоолой нь цахиртаад явчихжээ.

Бүсгүй дэрээ тохойлдон өндийснөө цонхигор царайдаа сулхан инээмсэглэл тодруулж:

-Зүгээр ээ... Томоогүй жаал... Цэрэгт яваад өгдөг гэснээ цас шиг цагаан гараараа нүүр рүүгээ орж ирэх хэсэг үсээ илэн хойшлуулаад сормосоо буулган “Алив, тэгээд наашаа ойртоод суугаач дээ” гэж аярхан хэлэв. Бямбаа ор руу нь дөхсөнөө нөгөө талын эзгүй ор руу нэг харж:

-Энэ цэцгийг хаана тавих вэ? хэмээн өрөөний голд хөшөө шиг зогсчихов.

-Энэ түмбүүшиг дээр тавьчих аа.

-За...

Тэр нэг л мэдэхэд бүсгүйн цэл хүйтэн духан дээр гараа тавьж байлаа.

-Гар чинь яасан халуун юм бэ дээ.Би халуураагүй ээ...

Тэгэнгүүт мань эр бүсгүйн мөс шиг хүйтэн гарыг атган авч хацартаа наачихлаа.

-Гар чинь даарчихаж...

Бүсгүй гараа татаж авах гэж оролдлоо.

-Гары чинь тавихгүй шүү. Би цэрэгт яваад ирсэн.Эр хүн болсон.Таныг...Чамайг мартаж чадахгүй нь...Намайг битгий хөөгөөч дээ...

Энэ үеэр сувилагч ороод ирэв.

-Гадны хувцастай хүн энд юу хийж байгаан бэ? Мэс заслын тасаг шүү дээ. Хайртай дуртай чинь тэндээ л юм байгаа биз.Одоо дусал хийх гэж байна, наад хүнд чинь хэмээн залуухан сувилагч бүсгүй тачигналаа.

-Би маргааш ирнээ гээд Биди өрөөнөөс нь гарлаа. Гэр рүүгээ харьж явахдаа сэтгэл нь баяр хөөрөөр дүүрэн байлаа.

Хайртай түүнийхээ гараас нь барьсан.Тэр өөрийг нь хөөгөөгүйгээр барахгүй, гараа атгуулаад л байсан...Одоо түүнээсээ яасан ч салахгүй дээ. Бас тэр сувилагч хүүхэн юу гэлээ. “Хайртай дуртай чинь тэндээ л юм байгаа биз” гэсэн шүү дээ. Тэгэхээр Бямбаа, Од хоёр мэдэхгүй хүнд бол хайртай хосууд шиг л харагддаг байх нь.

Орой нь тэр өөрийн гараар тахианы тунгалаг шөл хийж барин эмнэлэг рүү гарлаа.

Түүнийг халуун савтай шөл аваад гарахад нь Заяа ороод ирэв.

-Хоол унд бариад хаачих нь вэ?

-Хүн эргэнээ.

-Хэнийг?

-Хэрээг гэгчхээд Бямбаа инээд алдан гарч алга болов. Эмнэлэг дээр түүнийг очиход Одын ээж нь ирчихсэн байсан тул олигтой дотно үг сольж чадсангүй ч бүсгүй түүн рүү дотно дулаан инээмсэглэл илгээж, ээждээ “Таньдаг хүүхэд” хэмээн хэлэхийг үзэхэд түүнд талтай ч юм шиг.

Зургадугаар сарын эхний дулаахан сайхан орой. Эмнэлгээс харьж явахад нь цээж дүүрэн баяр хөөр оволзон, зүгээр байж байхдаа л тэнэг юм шиг инээмээр санагдаад байв. Гэртээ ирээд догдолсондоо тэр удтал унтаж чадсангүй. Ирсэн өдрөө л тэр өнгөрсөн зун ажил хийсэн компанийхаа захиралтай утсаар ярьжээ. “Чамайг компанидаа менежерээр шууд л авна. Ах дээрээ хүрээд ир” гэсэн. Банкинд байгаа мөнгөөрөө гайгүй хямд машин авчихна. Тэгээд л Одынхоо төлөө зүтгэнэ дээ. Сургуульд орохын тухайд дараагийн асуудал.

Маргааш нь тэр гадаа Одын хүүтэй тааралдлаа.

Хүү овоо том болж, ганцаараа гулсуур дээр тоглож байв.

-Анар аа!

-Биди ах аа! Та ирчихсэн юм уу? гээд хүү инээмсэглэн гүйгээд ирэв. Ингээд Бямбаа бүсгүйг эргэж тойронгоо хүүг цэцэрлэгээс нь орой бүхэн авах боллоо.

-Чи чинь Одын хойноос гүйгээд байгаа юм уу даа? гэж тэр нэгэн орой Заяа асуулаа.

-Тийм бол яахнав?

-Арай үгүй байлгүй дээ. Чамд дэндүү хөгшиднө.

-Танд ямар хамаатай юм? гэж тэр хэгжүүн хэлээд өрөөндөө орлоо.

Од эмнэлгээс маргааш гарна гэж байхад тэр эргэж очив.

“Чи ингээд над руу гүйгээд байхын хэрэг байна уу? Бид хоёр дэндүү их насны зөрөөтэй. Амьдрал тэгж санаснаар болдоггүй л юм даа” гэж түүний болгоомжлонгуй хэлэхэд Биди:

-Юмыг болгоноо л гэвэл болдог гэж би боддог. Би чамд хайртай. Насны зөрөө хайр сэтгэлд ямар хамаатай юм бэ? Нас бол зүгээр л тоо гэж би боддог. Эмнэлгээс гарангуут чинь би танайд очноо гэнгүүтээ зориг орж хүзүүгээр нь тэвэрч аваад уруул дээр нь үнсчихээд гүйн гарчээ. Уруулд нь гал ассан мэт халуу шатна. Ийм амттай, ийм халуухан үнсэлтийг тэр урьд өмнө нь хэзээ ч амсч мэдэрч байгаагүй мэт. Гайхалтай юм.

Түүнийг тэр өдөр гадуур ажил хөөцөлдөж яваад орой харихад ээж нь гэнэт Солонгосоос нисээд ирчихсэн байлаа. Долоон настайд нь явсан ээж нь хүүгээ 19-тэй, цэргийн алба хаасан хархүү болсон хойно ийнхүү гэнэт хэл чимээгүй ирчихдэг.

Яагаад ч юм ээжийгээ ирээсэй хэмээн элгээ бэтгэртэл хүлээдэг асан хүүхэд ахуйн гал халуун мөрөөдөл нь энэ арван хоёр жилийн уртад хөрөн хөрсөөр нэгэнт унтарч, өнөөдөр насанд хүрсэн хүмүүсийн хүйтэн, ёс төдий уулзалт болж өнгөрчээ. Тэр жаахандаа ээж нь гэнэт

хүрээд ирвэл “Ээж ээ, би таныг зөндөө их санасаан...” гээд хүзүүгээр нь тас тэвэрнэ. Үгүй ээ “Ээж ээ, та дахиж намайг хэзээ ч орхиж явахгүй биз дээ?..” хэмээн хацар дээр нь үнсэнэ гэх мэтээр ээжийгээ ирэхийг зүйл бүрээр төсөөлөн мөрөөдөлдөө умбадаг сан.

-Өө, ээж ирээ юу?

-Миний хүү!Алив, ээж нь үнсье...

-Сайн явж ирэв үү?

-Сайн. Миний хүү ямар том болоо вэ?

-Хүү цэрэгт яваад ирсэн. Дансран надтай ирж золгосон доо...хэмээн хөөрөх өвөөгийнх нь магнай л нэг тэнийсэн харагдана.

Харин Бямбаа?

Ээж нь их л турж нүднийх нь эргэн тойронд нарийхан нарийхан үрчлээ суусан атал үсээ хэтэрхий цайвар шар өнгөөр будсан нь, нэг л этгээд бариу, жадайсн хувцас өмссөн нь дэндүү харь, хөндий, танихгүй авгай мэт харагдуулна. Хүнд хүчир ажилд нухлагдан турж эцээд, харц нь зүрх шимшрэм гуниг дүүрэн харагдах авч, дандаа л мөнгө төгрөг ярих нь гайхмаар.

-Энэ байрны засвар мууджээ.Би мөнгий нь гаргая, сайхан засуул аав минь.

-Мөнгий нь өгөөд байхад сургуулиа хаяад цэрэгт явж байдаг яасан эргэсэн дотортой хүн бэ, чи!

-Би та нарыг мөнгөөр дутаагаагүй байх шүү...

Энэ хүн арван хоёр жилийн өмнө Солонгос руу үдсэн энхрий хайрт ээж нь мөн гэж үү?

Нагац эгч нар нь ирж, гэрээр нь дүүрэн хөл үймээн. Тэр хөл үйлмээнээс зугтан тагтан дээрээ гарч байгаад Од руу залгалаа.

“Намайг гарахад ирээд хэрэггүй ээ. Дүү нар ирж гаргаж авна. Баяртай” гэж байна. “Уулзах хүртлээ баяртай!” Түүнийхээ хонгорхон дууг сонсоод сэтгэл нь сэтгэчихлээ.

Маргааш нь өвөөгийнх нь даралт ихсэж, эм тарианд гүйсээр өдөр л нэг сэхээ орж, Од руу залгатал утсаа шууд салгачихлаа.

Гайхсаар элдэв ажил хөөцөлдөж яваад түүн рүүгээ дахин нэг залгавал бүүр салгаатай байх нь тэр. Зүрх нь нэг л муу ёр зөгнөх мэт эвгүй сулраад явчихлаа.

Орой Одын гэрт нь очвол эзгүй байв. Эмнэлгээс нь сураглавал гараад явчихсан байлаа.

Хүүгийнх нь цэцэрлэгийг мэддэгийн хэрэг юу билээ тийшээ харайлгаж хүрлээ. “Манайх зургаан сарын 5 хүртэл ажиллаад хаасан” гэсэн хариу сонссон Бямбаагийн цус нь царцах мэт

болов. Одыг ажлаас нь очин сураглавал гэнэт гарчихсан байлаа.

Хэд хоногийн дараа Заяагаас Одынх байраа зараад нүүснийг сонсов. Юу гэсэн үг вэ? Тэр яагаад гэнэт хэл чимээгүй усанд чулуу шидэхэд үүсээд хоромхон зуур замхран оддог дугуй дугуй долги мэт сураг ажиггүй зугтан алга болов оо?

Бямбаа Одтой холбоо тасарснаас хойш машин тэрэг авах, ажил төрөлд орох бодлоо орхиж, хоол унд ч хоолойг нь давахгүй хэдэн өдөр мэлэрч байснаа, нэг өдөр аавыгаа утсаар ярихад сая нэг сэхээ оров.

-Аав нь охинтой болсоон. Тэгээд хүүтэйгээ баяраа хуваалцах гээд л...

Бямбаа өөртөө тохиолдсон явдлыг аавдаа хагас дутуу ярьж дотроо жаахан онгойлгов.

-Зүгээр ээ, миний хүү. Амьдрал их баян шүү дээ...

Нээрээ л амьдрал баян. Бүтээгүй хайр алийг тэр гэхэв дээ. Намар нь тэр хүсээд байсан геологийн сургуульдаа орж, ангийнхаа Номинтой үерхэж эхлэв. Гэхдээ л сэтгэлд нь од шиг гэрэлтэн орж ирчихээд од шиг харван одсон Од бүсгүйг яагаад ч мартаж чадаагүй юм.

...Тэр явдлаас хойш долоон жил өнгөрсөн хойно Бямбаа эмнэлэгт хэвтсэн бяцхан охиндоо тариа авах гэж явж байгаад Одтой санаандгүй тааралдаж билээ. Эмийн санд шилэн хоргонд тавьсан эм тарианы үнийг харж зогстол ард нь зүрхний гүнд нэвтрэх мэт нэг л танил дотно хоолой сонсогдоход цочин эргэж харвал Од зогсож байлаа. Гайхалтай нь он жил түүний хажуугаар урсан өнгөрдөг юм уу гэлтэй. Яг л арван жилийн өмнө 16-тай жаал байхдаа байрныхаа гадаа бөмбөг хөөж яваад олж харсан тэр л гоо бүсгүй хэвээрээ. Одоо 37 хүрсэн байх ёстой доо. Гэвч нүүрэнд нь ганц ч үрчлээс нэмэгдсэнгүй.

-Сайн байна уу?

-Хүүе сайн уу? Ямар сонин хүн бэ?

Ганц л удаа үнсч үзсэн тэр л бумбагар уруул, ялдамхан харц, урт ч биш богино ч биш хүрэн үс нь мөрөө даван намирна. Бариу цагаан цув өмсчээ.

-Усанд хаясан чулуу шиг алга болсон хүнтэй ингэж тааралдах гэж!

-Зарим үед алга болох хэрэг гардаг юм аа. За тэгээд амьдрал сайн уу?

Тэр хоёр эмийн сангийн зэргэлдээх нам гүмхэн кафед орж хэсэг ярилцав.

-Хэл чимээгүй хаашаа алга болчихсон юм бэ? гэж Бямбааг олон жил сэтгэлд нь эргэлдсээр асуусаар явсан тэр асуултаа тавихад Од савхан хуруутай цагаахан гараараа үсээ илснээ сормуусаа буулган санаа алдаж:

-Тэгсэн нь дээр байсан юм аа. Чи эхнэр авсан биз дээ?

-Авсаан. Охинтой болж чиний дурсгалд Од гэж нэр өгсөн. Би тэгэхэд чиний хойноос галзууртлаа гунигласан шүү. Чамайг тэгж ганц ч үг хэлэлгүй алга болчихно гэж санаагүй...

-Гуниг яахав дээ...Ямар ч зовлонг хүн даваад л гардаг...

-Гэхдээ яагаад тэгж гэнэт явчихсан юм бэ?

-Ээж чинь эмнэлэг дээр ирсэн. Хүүхдийн толгой эргүүлсэн хөгшин хүүхэн гээд л намайг хэлэх хэлэхгүй үгээр зөндөө дайрсан даа. Эх хүн тэгэх нь аргагүй биз дээ. Би ч хүүтэй хүн болохоор ойлгож л байна. Уг нь би биш чи л намайг эргүүлдсэн шүү дээ. Би амьдралдаа тийм аймаар үгээр хэзээ ч хэнд ч хэлүүлж яваагүй. Гэхдээ одоо бодоод байхад ээжийн чинь зөв байж...

-Чи хүнтэй суусан уу? гэж Бямбааг зүрх алдан асуухад:

-Үгүй ээ. Айлын хүүхдүүдийн толгой эргүүлсэн хэрэгт ороод яахав дээ гээд тэр гунигтай инээмсэглэв.

-Чи ерөөсөө өөрчлөгдөөгүй байна...Би өөрийг чинь... мартаж чадаагүй л явна. Гэхдээ ангийнхаа нэг охинтой суусан. Надад их хайртай бүсгүй. Номин гэдэг...

-Тийм үү? Яамай даа. Би чамд нэг сонин юм ярих уу?.Миний тарьсан цэцэгний эргэн тойронд нэг цоохор цох яваад л байдаг байсан. Хичнээн жилийн турш. Гэтэл нэг л өдөр нөгөө цох маань миний гар дээр гарч ирээд үхчихсэн. Тэгэхэд л би яагаад ч чамайг эхнэр авч дээ гэж таасан.

-Миний тухай бас боддог байх нээ?

-Хааяа бодолгүй дээ.

-Цох гэснээс...Нээрээ ямар сонин юм бэ! Миний өрөөнд байсан сонгинон цэцэгний шороонд бас алтан тэмээ гэдэг бил үү, нэг тийм цоохор цох байдаг байсан...

-Үхчихсэн үү?

-Мэдэхгүй ээ. Харагдахаа больчихсон байна лээ.

-Үхчихсэн биз дээ.Минийх шиг л...Хорхой шавьж хүртэл хувь тавилантай л байдаг байх даа...Чиний надад өгсөн цагаан лили цэцэгнүүд одоо бүгд бий. Би цөмий нь хатаагаад хадгалчихсан.

-Сэтгэлээсээ л өгч байсан даа. Анар, Ану хоёр том болсон уу?

-Том оо том. Анар чамайг яриад л байдаг юм. Ану энэ жил 11-р анги төгсөх гэж байгаа. Сониноос аав нь эргээд ирсэн.

-Нөхөр чинь үү?

-Тийм ээ. Бие нь их муу байгаа. Элэгний хатуурал гээд. Би асарч тойлоод завгүй л явна даа. Сая эмийг нь авах гэж эмийн санд явж байсан юм. Харин манайд байсан Солонгоо л намайг чамтай суусан бол жаргах байсан гэж их зэмлэдэг юм. Тэр бүх хэл амыг давж гараад чиний зүтгэснээр бид хоёр суусан бол, магадгүй чи өнөөдөр харамсах ч байсан юм бил үү? Тэгээд ч юм бүхэнд эмэгтэй хүн л дандаа буруутан болдог... Ер нь ч амьдралд санаснаар болох биш дээ.

-Зургадугаар сарын цас шиг үү?

-Би нээрээ чамд тийм юм ярьж байл уу?

-Сэтгэлдээ хүн хэзээ ч цас бороо оруулж болдог юм биш үү? гээд Бямбаа ууж байсан жүүснийхээ мөсийг соруулаар нааш цааш тачигнуулан хутгалаа.

-Ямар өнгөрснийг өөрчилж болох биш дээ гээд Од бослоо.

-Утасныхаа дугаарыг өгөөч гэж Бямбааг зүрхшээнгүй гуйхад:

-Зургадугаар сард цас ордоггүй юм гэснээ тэр гунигтай инээмсэглэв.

-Хааяа дууг чинь сонсч баймаар байна. Би чиний л ачаар замаа алдчихалгүй хүн болж, өдий зэрэгтэй яваа гэж боддог. Чиний л төлөө цэрэгт явж, чиний л төлөө бэрхшээл бүхнийг давж сурсан даа. Би тэгэхд чамд дурлаагүй бол...

-Харж байнаа. Чи их сайн яваа юм байна. Би баярлаж байна, чиний өмнөөс.Эхнэрээ, охиноо, гэр бүлээ хайрлаж яваарай, жаал минь.Харин над руу утасдаад хэрэггүй биз дээ гэчихээд тэр эргэж ч харсангүй салан одлоо. Цагаахан цэцэг дэлгэрүүлсэн монос моддын завсраар цагаан цув нь цайвалзан харагдсаар бүсгүйн бараа тасрав.

Ай хөөрхий эгчмэдхэн бүсгүй, сэтгэлд харвасан Одхон минь!

2008 он

Table of Contents

[Сувдан даруулга](#)

[Хойд эцэг](#)

[Минийх](#)

[Явахын өмнө...](#)

[Сүүлчийн өртөө](#)

[Бэр](#)

[Цэцгэн титэмт бүсгүй](#)

[Цэцэгсийн ертөнц дэх би...](#)

[Цагаан уул](#)

[Жамьянмядаг цэцэг болон таржээ](#)

[Яргуй](#)

[Нарцисс](#)

[Сарнай](#)

[Сараана](#)

[Бадамлянхуа](#)

[Гэсэр цэцэг](#)

[Бэрцэцэг](#)

[Амрагаасаа хагацсан бэрийн нулимс](#)

[Цахирмаа](#)

[Малчин хүү цахирмаа цэцэг олсон нь](#)

[Зургадугаар сарын цас](#)